

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН ЯАМНЫ  
2019 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ /ямар бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ/	Гүйцэтгэлийн зорилтыг хэмжих шалгуур үзүүлэлт /тоо, хувь, чанар.../	Хэрэгжилтийн тайлан (2019 оны жилийн эцсийн байдлаар)	Өөрийн үнэлгээ
<b>СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БОДЛОГЫН ГАЗАР</b>				
Засгийн газрын 2017 оны 267 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт: 2.2.1.Сургуулийн өмнөх болон бага, дунд, дээд боловсролын сургалтын чанарыг дээшлүүлэх, өрсөлдөх чадвартай хүний нөөц бэлтгэх, багш бэлтгэх тогтолцоог хөгжүүлэх				
Нэг. Хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр				
1.	1.1 Сургуулийн өмнөх боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, УИХ-д өргөн барина. /Хууль тогтоомжийн тухай хууль/	Салбарын тулгамдсан асуудлын эрх зүйн зохицуулалт тодорхой болсон байна.	<p>Боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалд Бага, дунд боловсролын тухай хууль, сургуулийн өмнөх боловсролын тухай хуулиудыг нэгтгэн нэгдмэл хуультай байх үндсэн томъёоллыг тодорхойлсон бөгөөд дараах өөрчлөлтүүдийг оруулахаар төсөлд тусгасан болно.</p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хэв шинжийн “асрамжийн” гэдгийг хасах, байгууллагын цэцэрлэгийн хууль эрх зүйн зохицуулалтыг бий болгох;</li> <li>✓ Цэцэрлэгийн байршил, хэв шинж, хүчин чадлаас хамааруулан ажиллах албан тушаалыг тогтоох орон тооны нормативыг шинэчлэх, багшийн ажлын ачаалал, чиг үүрэг, хөдөлмөрийн үнэлэмжийг бодитой тогтоох;</li> <li>✓ Цэцэрлэгт хамрагдах насыг дэлхий нийтийн чиг хандлага, өөрийн улсын ард иргэдийн амьдралын хэв маягт нийцүүлэн уян хатан байхаар зохицуулах;</li> <li>✓ Бүх шатны сургалтын хөтөлбөрийн агуулгыг зөвхөн боловсролын тухай хуулиар зохицуулах;</li> <li>✓ Боловсролын байгууллагын засаглалыг боловсронгуй болгож удирдах албан тушаалд томилогдох шалгуурт мэргэшсэн, мерит зарчмыг баримтлах зэрэг өөрчлөлтүүд оруулахаар тодорхойлсон болно.</li> </ul>	70%

2.	<p><b>1.2 Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд шаардагдах ном, гарын авлага, сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоомын талаар баримтлах бодлого боловсруулж, батлуулна. ***</b> /Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 6.2/</p>	<p>Бодлогын баримт бичиг батлагдсан байна.</p>	<p>БСШУС-ын сайдын 2019 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/696 дугаар тушаалын хавсралтаар цэцэрлэг, ЕБС-ийн эрүүл мэндийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх багшид зориулсан зөвлөмж, сургалтын хэрэглэгдэхүүний агуулга, загвар боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн батлагдсан. Энэхүү тушаалын хэрэгжилтийн хүрээнд цэцэрлэг, ЕБС-ийн эрүүл мэндийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх багшид зориулсан зөвлөмж, сургалтын хэрэглэгдэхүүний агуулга, загвар боловсруулж, туршина.</p> <p>Азийн хөгжлийн банкны “Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Боловсролын зөвлөх үйлчилгээний компани шалгарсан;</li> <li>✓ Сургуулийн өмнөх боловсролын ном, сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоомын хэрэглээний өнөөгийн байдал, хэрэгцээний талаарх түүвэр судалгаа хийх;</li> <li>✓ Сургалтын хэрэглэгдэхүүний багцад тулгуурлан сургуулийн өмнөх боловсролын сургалтын хэрэглэгдэхүүний эх бэлтгэл, биет хэрэглэгдэхүүнд тавигдах шаардлагыг боловсруулж, хэлэлцүүлэх;</li> <li>✓ Цэцэрлэгүүдэд сургалтын багц хэрэглэгдэхүүн нийлүүлэхээр боловсролын зөвлөх үйлчилгээний компанийн ажлын даалгаварт тусгагдсан болно.</li> <li>✓ Сургуулийн өмнөх боловсролын салбарт хэрэглэж буй ном, гарын авлага, сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоом наадгайн хангамжийн өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлох судалгааг Боловсролын удирдлагын мэдээллийн системийг ашиглан Үндэсний хэмжээнд зохион байгуулах бэлтгэл ажлыг хангалаа. Энэхүү үнэлгээний үр дүнд үндэслэн Сургалтын хэрэглэгдэхүүнд тавигдах шаардлагын төслийг эцэслэн боловсруулна.</li> </ul>	70%
3.	<p><b>1.3 Цэцэрлэгийн үйлчилгээний чанарыг үнэлэх журам боловсруулж, батлуулна. ***</b></p>	<p>Журам батлагдсан байна.</p>	<p>БСШУС-ын сайдын 2019 оны 12 сарын 10 өдрийн А/803 дугаар тушаалаар цэцэрлэг, сургуулийн үйл ажиллагааг үнэлэх журам, шалгуурыг баталсан болно.</p> <p>Цэцэрлэг, сургуулийн үйл ажиллагааг үнэлэх үнэлгээний журам нь байгууллага дэвшүүлсэн үнэт зүйл, эрхэм зорилго, зорилтдоо хүрч буй эсэхээ багш, суралцагч, эцэг эх, асран хамгаалагчийн оролцоотой үнэлж, байгууллагын менежмент, сургах, сурах үйл ажиллагааны чанар, үр дүнг</p>	100%

	/Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 7.2 дахь заалт/		сайжруулахад авч хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэлээ тодорхойлон хэрэгжилтийг ханган, байнга үнэлж сайжруулдаг эргэх холбоо бүхий үйл явц байхаар боловсруулсан. Үнэлгээний шалгуурыг сургуулийн өмнөх боловсролын талаарх олон улсын чиг хандлага, хөгжлийн бодлогод үндэслэн, хүүхэд, багш ажилтны хөгжлийг дэмжсэн, үйлчилгээний чанар үр дүнг тооцож үнэлэх зарчмыг баримтлан боловсруулсан нь тогтвортой, үр дүнтэй хэрэгжих боломжтой юм. Цэцэрлэгийн үйл ажиллагааны үнэлгээ нь 5 чиглэл 14 үзүүлэлтийн 57 шалгуур багтсан.	
4.	1.4 Цэцэрлэгийн аюулгүй байдлын дүрмийг шинэчлэн боловсруулж, батлуулна. Тусгай цэцэрлэгийн дүрэм боловсруулж, батлуулна. Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх хувилбарт сургалтыг зохион байгуулах журмыг шинэчлэн боловсруулах. /Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 8.5, 8.6/	Дүрэм, журам боловсруулагдан батлагдсан байна.	<p>БСШУС-ын сайдын 2019 оны “Дүрэм шинэчлэн батлах тухай А/118 дугаар тушаалын хавсралтаар “Хүүхдийн цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрэм” батлагдсан бөгөөд хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.</p> <p><b>“Аюулгүй байдлын дүрэм”-ийн төслийг боловсруулж байна. Үүнд:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>✓ СӨББ-ын сургалтын орчны стандарт (MNS 6558:2015), Сургалт, хүмүүжлийн орчны эрүүл ахуйн шаардлага (MNS 6799:2019) стандартын хэрэгжилт;</li> <li>✓ Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр зэрэг эрх зүйн баримт бичгийн зохицуулалт зэрэг асуудлыг судалж, дүрмийн төслийг боловсруулж байна.</li> </ul> <p><b>“Тусгай цэцэрлэгийн дүрэм”-ийн төслийг боловсруулахад дараах судалгааг хийж байна. үүнд:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Тусгай хэрэгцээт боловсролын талаарх эрх зүйн орчны шинэчлэл;</li> <li>✓ Тусгай цэцэрлэгийн өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ;</li> <li>✓ СӨББ-ын сургалтын орчны стандарт хэрэгжилт;</li> <li>✓ Тусгай цэцэрлэгийн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө зэрэг асуудлыг судалж, дүрмийн төсөл боловсруулж байна.</li> </ul> <p><b>“Хувилбарт сургалтыг зохион байгуулах журам”-ын төслийг шинэчлэн боловсруулахад дараах судалгааг хийж байна. Үүнд:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Хувилбарт сургалтын хүртээмж, сургалтын чанарыг үнэлж буй өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал, цаашид сайжруулах арга зам;</li> <li>✓ Хувилбарт сургалтын орчинд тавигдах шаардлага;</li> </ul> <p>Хувилбарт сургалтыг зохион байгуулахад шаардлагатай санхүүжилтийн хүрэлцээ хангамж зэрэг асуудлыг судалж, журмын төслийг боловсруулж байна.</p>	70%

5.	1.5 Цэцэрлэгийн багшийн ажлыг үнэлэх, дүгнэх журмыг шинэчилж, батлуулна. /Боловсролын тухай хуулийн 28.1.22/	Журам батлагдсан байна.	<p>Журмын төсөл боловсруулах ажлын хэсгийг БСШУС-ын сайдын 2019 оны 11 сарын 29-ний өдрийн А/764 дүгээр тушаалаар байгуулж Цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч, багшийн ажлыг үнэлэх дүгнэх журмын төсөл боловсруулах ажил төлөвлөгөөний дагуу хийгдэж байна.</p> <p>Ажлын хэсэг журмын төслийг боловсруулахад шаардлагатай судалгааг дараах чиглэлээр хийлээ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Багшийн ажлыг үнэлж дүгнэж буй өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудал бэрхшээл, цаашид сайжруулах хэрэгцээ;</li> <li>✓ Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багшийн ажлыг үнэлж дүгнэж буй олон улсын туршлага;</li> <li>✓ Багшийн ажлыг үнэлж дүгнэх асуудал нь багшийн цалин, хөдөлмөрийн хөлсний нэмэгдэл, нэмэгдэл хөлс олгох эрх зүйн зохицуулалтуудтай холбогдох шаардлага;</li> <li>✓ Багшийн цогц хөгжил, нийгмийн хамгааллын асуудлын эрх зүйн орчны зохицуулалт, түүнд тавигдах шаардлага, хэрэгцээ;</li> <li>✓ Хүүхдийн хөгжлийн үнэлгээ болон цэцэрлэгийн үйл ажиллагааны үнэлгээтэй холбогдох шаардлага зэргийг судалж журмыг шинэчлэх чиглэлийг тогтож, төслийг боловсруулж байна.</li> </ul>	70%
6.	1.6 Цэцэрлэгийн багшид мэргэжлийн зэрэг олгох, хасах журмыг шинэчлэн боловсруулж, батлуулна.	Журам батлагдсан байна.	<p>“Цэцэрлэгийн багш, арга зүйч, эрхлэгчид мэргэжлийн зэрэг олгох, хасах журам” боловсруулж, БСШУС-ын сайдын 2019 оны 12 сарын 31-ний “Журам батлах тухай” А/854 дугаар тушаалаар батлагдан аймаг, нийслэлийн Боловсролын газруудад хүргүүлжээ. Энэхүү журам нь 6 зүйл, 36 заалт, 29 дэд заалтаас бүрдсэн.</p>	100%
7.	1.7 Хүүхдийн хөгжлийн ахицыг үнэлэх журам боловсруулж, батлуулна. /Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 7.1/	Журам батлагдсан байна.	<p>Сургуулийн өмнөх насны хүүхдийн хөгжлийн болон сургуульд бэлтгэгдсэн байдлыг үнэлэх журмын төсөл боловсруулан хэлэлцүүлэх, турших ажлыг зохион байгуулж байна.</p> <p>Журмын төслийг боловсруулахад дараах чиглэлээр судалгаа хийж судалгааны дүнд тулгуурлан төслийг боловсруулсан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Хүүхдийн хөгжлийг үнэлж дүгнэж буй өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудал бэрхшээл, цаашид сайжруулах хэрэгцээ</li> <li>✓ Хүүхдийн хөгжлийг үнэлж дүгнэж буй олон улсын туршлага</li> <li>✓ Сургуульд элсэх насны хүүхдийн хүүхдийн хөгжлийн онцлог, сургуульд бэлтгэгдсэн байдлын шалгуурт тавигдах шаардлага,</li> </ul>	70%

			✓ Цэцэрлэгийн үйл ажиллагааны үнэлгээтэй холбогдох шаардлага зэргийг судалж журмыг шинэчлэх чиглэлийг тогтож, төслийг боловсруулж байна.	
8.	1.8 Сургуулийн өмнөх боловсролын сургалтын цөм хөтөлбөрийн хэрэгжилтэд үнэлгээ хийх ажлыг зохион байгуулна. /Боловсролын тухай хуулийн 28.1.8, ЗГҮАХ-ийн 3.2.15/	Үнэлгээ хийгдсэн байна.	СӨБ-ын сургалтын цөм хөтөлбөр, хөтөлбөрийн хэрэгжилтэд Боловсролын хүрээлэнгээс 2018-2019 онд хийсэн үнэлгээ, судалгаа, 2019 оны 3 дугаар сард БСШУС-ын яамнаас зохион байгуулсан үндэсний хэлэлцүүлгийн үр дүнд тус тус үндэслэн сургуулийн өмнөх боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг сайжруулах асуудлыг тодорхойлсон. Дээрх дүгнэлтэд тулгуурлан сайжруулалтыг хийж БСШУС-ын сайдын 2019 оны 08 сарын 2-ны өдрийн “Хөтөлбөр батлах тухай тухай” А/494 дүгээр тушаалаар сургуулийн өмнөх боловсролын сайжруулсан сургалтын хөтөлбөрийг баталсан. Сургалтын хөтөлбөрийг сайжруулснаар багшийн төлөвлөх боловсруулах ажлын ачаалал багасаж хүүхэдтэй ажиллах цаг нэмэгдэн, төлөвлөх, боловсруулах, хэрэгжүүлэх, хянаж үнэлэх ажил уялдаа холбоотойгоор хэрэгжих боломжтой боллоо. СӨБ-ын сургалтын хөтөлбөр, хэрэгжүүлэх зөвлөмжийг боловсруулан хэвлүүлж 12800 гаруй багш ажилтан, мэргэжлийн байгууллагууд, багш бэлтгэдэг сургуулиудад хүргэснээр багш нар хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүйн зөвлөмжөөр хангагдсан.	100%
9.	1.9 Цэцэрлэгийн хүүхдийн хоол хүнсний үйлдвэрлэл, худалдан авалт, түгээлт, хадгалалт, боловсруулалт, эрүүл ахуйн талаар баримтлах чиглэл боловсруулж, батлуулна.*** /Хүнсний аюулгүй байдлын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын	Чиглэл боловсруулагдсан байна.	Эрүүл мэндийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтран “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, түүний дотуур байрын орчны эрүүл ахуй” MNS 6799:2019, Ерөнхий шаардлага”-ыг баталсан. Стандарт хэмжилзүйн газрын “Хүүхдийн техникийн хороо”-ны 2019 оны 9 сарын 20 өдөр, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн “Эрүүл мэндийн техникийн хороо”-ны 2019 оны 10 сарын 18 өдрийн хурлын хэлэлцүүлгээр тус тус дэмжигдэж, Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2019 оны С/40 дүгээр тушаалаар батлагдсан. Энэхүү стандарт батлагдсанаар сургуулийн өмнөх боловсролын байгууллагад хүүхдийг эрүүл ахуйн хувьд аюулгүй орчинд сурч хөгжих, аливаа халдварт өвчлөлөөс хамгаалагдах боломжийг бүрдүүлж өгч байгаагаараа ач холбогдолтой юм.	70%

	сургалтын орчин. MNS 6558:2015/			
10.	1.10 Боловсролын салбарын хөгжлийн мастер төлөвлөгөө боловсруулахад шаардагдах хүртээмж, чанар, хүний нөөцийн талаарх судалгаа хийнэ. /Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 8.5/	Судалгаа хийгдсэн байна.	<p>Боловсролын салбарын хөгжлийн Мастер төлөвлөгөө боловсруулахад шаардагдах хүртээмж, чанар, хүний нөөцийн талаарх дараах судалгаа хийгдсэн.</p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Сургуулийн өмнөх боловсролын салбарын дүн шинжилгээ;</li> <li>✓ Боловсролын бодлогын тойм шинжилгээний тайлан;</li> <li>✓ Азийн хөгжлийн банкны боловсролын салбарын мастер төлөвлөгөө боловсруулахад дэмжлэг үзүүлэх техник туслалцааны төслийн судалгаанууд хийгдсэн.</li> </ul> <p>Судалгааны зөвлөмж, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагаа:  <u>Сургуулийн өмнөх боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх</u></p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Сургуульд орох насны хүүхдийн хөгжлийн ялгааг бууруулах, бага боловсролын сурлагын амжилтыг дээшлүүлэх зорилгоор 5 настай хүүхдийн хамран сургалтыг 99% хүргэх;</li> </ul> <p><u>Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний чанарыг сайжруулах</u></p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Төсвийн зарцуулалтын үр дүнтэй байдал, үр ашгийг нэмэгдүүлэх сургуулийн өмнөх боловсролын салбарын норматив, үйлчилгээний хэлбэрийг шинэчилж өөрчлөх;</li> <li>✓ Хувийн өмчийн цэцэрлэгт зарцуулж буй санхүүжилтийн үр ашгийг нэмэгдүүлэх;</li> <li>✓ Хөрөнгө оруулалтын төсвийн зарцуулалтын үр ашгийг нэмэгдүүлэх;</li> <li>✓ Цэцэрлэгийн багш бэлтгэж буй их дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрийг магадлан итгэмжлэх, чанарыг сайжруулах;</li> </ul> <p>Судалгаанд тулгуурлан “Боловсролын салбарын мастер төлөвлөгөө 2020-2030”-ний эхний төслийг боловсруулж салбарын багш, ажилтнуудын саналыг авч хэлэлцүүлэг зохион байгууллаа.</p>	100%
11.	1.11 Цэцэрлэгт нийлүүлэх ном, гарын авлага, сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоом наадгайн жагсаалт,	Цэцэрлэгт нийлүүлэх ном, гарын авлага, сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоом наадгайн	<p>БСШУС-ын сайдын 2019 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/696 дугаар тушаалын хавсралтаар “Цэцэрлэг, ЕБС-ийн Эрүүл мэндийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх багшид зориулсан зөвлөмж, сургалтын хэрэглэгдэхүүний агуулга, загвар боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн” батлагдсан. Энэхүү тушаалын хэрэгжилтийн хүрээнд цэцэрлэг, ЕБС-ийн эрүүл</p>	70%

	<p>бүтээгдэхүүнд тавигдах шаардлага боловсруулж, батлуулна. Ном, гарын авлага, сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоом наадгайн эх боловсруулах үйл ажиллагаа зохион байгуулна. /Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 7.2 дахь заалт/</p>	<p>жагсаалт, бүтээгдэхүүнд тавигдах шаардлага боловсруулсан байна.</p>	<p>мэндийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх багшид зориулсан зөвлөмж, сургалтын хэрэглэгдэхүүний агуулга, загвар боловсруулж, туршина. Азийн хөгжлийн банкны “Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Боловсролын зөвлөх үйлчилгээний компани шалгарсан.</li> <li>✓ Сургуулийн өмнөх боловсролын ном, сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоомын хэрэглээний өнөөгийн байдал, хэрэгцээний талаарх түүвэр судалгаа хийх;</li> <li>✓ Сургалтын хэрэглэгдэхүүний багцад тулгуурлан сургуулийн өмнөх боловсролын сургалтын хэрэглэгдэхүүний эх бэлтгэл, биет хэрэглэгдэхүүнд тавигдах шаардлагыг боловсруулах, хэлэлцүүлэн хийж, эцэслэх;</li> <li>✓ Цэцэрлэгүүдэд сургалтын багц хэрэглэгдэхүүн нийлүүлэхээр боловсролын зөвлөх үйлчилгээний компанийн ажлын даалгаварт тусгагдсан болно.</li> </ul> <p>Сургуулийн өмнөх боловсролын салбарт хэрэглэж буй ном, гарын авлага, сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоом наадгайн хангамжийн өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлох судалгааг Боловсролын удирдлагын мэдээллийн системийг ашиглан Үндэсний хэмжээнд зохион байгуулах бэлтгэл ажлыг хангалаа. Энэхүү үнэлгээний үр дүнд үндэслэн Сургалтын хэрэглэгдэхүүнд тавигдах шаардлагын төслийг эцэслэн боловсруулна.</p>	
<p>Хоёр. Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр:</p>				
12.	<p>2.1 “Төрийн бус өмчийн цэцэрлэгт төрийн өмчийн цэцэрлэгийн нэмэлт бүлэг байгуулах тухай” Засгийн газрын хуралдаанаар оруулж, хэлэлцүүлнэ. /МУТХҮБ-2030-ын 2.2.3, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 3.2.2 дахь заалт/</p>	<p>Холбогдох дүрэм журмын дагуу боловсруулсан байна.</p>	<p>Тус ажлын хүрээнд Засгийн газраас “Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 2019 оны 05 сарын 01-ний өдрийн 183 дугаар тогтоол батлуллаа.</p> <p>Тус тогтоолд сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний оновчтой шинэ, арга технологи, шинэлэг хэлбэрүүдийг бий болгох, дэмжих асуудлуудыг тусгасан бөгөөд тухайлбал, төрийн бус өмчийн цэцэрлэг дээр төрийн өмчийн нэмэлт бүлэг, байгууллагын дэргэдэх цэцэрлэг, зуны цэцэрлэгийн эрх зүйн орчин, зохион байгуулалт, санхүүгийн асуудлыг оновчтой болгох талаар тусгасан болно.</p>	<p>100%</p>

			Нийслэлд анги дүүргэлт өндөр байгаа цэцэрлэгүүдийн ачааллыг бууруулах зорилгоор Нийслэлийн Засаг даргын 2019 оны "Сургуулийн өмнөх боловсролд хамрагдах хүүхдийн тоог нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай" А/16 тоот захирамжаар 7 дүүргийн төрийн бус өмчийн 130 цэцэрлэгт 2019-2020 оны хичээлийн жилд нэмэлт элсэлтээр 3087 хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол олгож байна.	
13.	2.2 “Байгууллагын цэцэрлэгийн хууль, эрх зүйн орчинг бүрдүүлж, цэцэрлэг, салбар бүлэг ажиллуулж байгаа хувийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагад үзүүлэх татварын хөнгөлөлтийн хувь хэмжээг тогтоох тухай Засгийн газрын хуралдаанаар оруулж, хэлэлцүүлнэ. /ЗГҮАХХАХТ-ний 3.2.5 Байгууллагын цэцэрлэгийн эрх зүйн орчныг бүрдүүлж, татварын бодлогоор дэмжинэ./	Холбогдох дүрэм журмын дагуу боловсруулсан байна.	БСШУС-ын сайдын 2019 оны Дүрэм шинэчлэн батлах тухай” А/118 дугаар тушаалын хавсралтаар “Хүүхдийн цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрэм”-ийг баталсан бөгөөд тушаалын 2.5.4-т байгууллага, аж ахуйн нэгж өөрийн санхүүжилтээр Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.11-д заасны дагуу ажилтан, албан хаагч, оюутан суралцагчийнхаа нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор бие даасан цэцэрлэг байгуулан ажиллуулах асуудлыг тусгасан. Түүнчлэн “Цэцэрлэгийн дэргэд аж ахуйн нэгж, байгууллагын санаачилгаар “салбар бүлэг” ажиллуулахад хамтран ажиллах гэрээний үлгэрчилсэн загвар”-ыг БСШУС-ын сайдын 2019 оны А/804 дүгээр тушаалаар баталж эрх зүйн орчныг бүрдүүлэх ажлыг зохион байгууллаа. Гэрээнд цэцэрлэг, аж ахуйн нэгжийн хүлээх үүрэг хариуцлага, өмч хөрөнгө, санхүүжилт, ажиллах хуваарь зэргийг харилцан зөвшилцөх тухай асуудлыг тусгаж, цаашид байгууллага өөрсдөө санаачлан цэцэрлэгийн салбар бүлэг ажиллуулах асуудлыг дэмжсэн ажил боллоо.	70%
14.	2.3 Цэцэрлэгийн барилга /байршил, хүчин чадал/, хүний нөөц, хүн ам, гамшгийн эрсдэлийн /байгалийн гамшгийн эрсдэл, орчны бохирдлоос /хөрс, ус, агаар/ цэцэрлэгийн хүүхдийн эрүүл мэндэд нөлөөлж буй нөлөөллийг тооцох/	Судалгааг хийж чиглэл боловсруулагдсан байна.	“Байгалийн гамшигт үзэгдэл (газар хөдлөлт)-ийн нөлөөгөөр нийгмийн үйлчилгээний салбарт (цэцэрлэгт) үүсч болзошгүй эрсдэлийг тооцох боломж” судалгааг Газарзүй-Геоэкологийн хүрээлэн, Одон орон геофизикийн хүрээлэнтэй хамтран хийлээ. Газар хөдлөлтийн идэвхтэй мужлалыг сургуулийн өмнөх боловсролын байгууллагын барилга байгууламж, цэцэрлэгийн байршилтай холбон гаргасан судалгаанаас дурдвал: рихтерийн шатлалын: <ul style="list-style-type: none"> <li>• 5 баллд 90 барилга,</li> <li>• 6 баллд 71,</li> <li>• 7 баллд 890,</li> </ul>	100%



	судалгаанд суурилсан хүртээмжийн төлөвлөлт хийх. /МУТХУБ-2030-ын 2.2.3, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 3.2.2 дахь заалт/		<ul style="list-style-type: none"> <li>• 8 баллд 306,</li> <li>• 9-өөс дээш баллд 221 цэцэрлэг өртөхөөр тооцоолол гарсан.</li> </ul> <p>Барилгын насжилтыг 4 үечлэлээр гаргахад:</p> <ul style="list-style-type: none"> <li>• 0-15 жилийн насжилттай 1005,</li> <li>• 16-30 жилийн насжилттай 117, 3</li> <li>• 0-45 жилийн насжилттай 289,</li> <li>• 45-аас дээш жилийн насжилттай 167 барилга байна гэсэн судалгаа гаргаж мэдээллийн сан бүрдүүлсэн.</li> </ul>	
15.	2.4 Байгууллагын цэцэрлэгийн эрх зүйн орчныг бүрдүүлж, татварын бодлогоор дэмжинэ. Байгууллагын цэцэрлэгийн дүрэм боловсруулж, батлуулна. /ЗГҮАХХАХТ-ний 3.2.5/	Холбогдох судалгаа хийсэн байна.	<p>БСШУС-ын сайдын 2019 оны Дүрэм шинжлэх батлах тухай” А/118 дугаар тушаалын хавсралтаар “Хүүхдийн цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрэм” батлагдсан бөгөөд тушаалын 2.5.4-т байгууллага, аж ахуйн нэгж өөрийн санхүүжилтээр Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.11-д заасны дагуу аж ахуй, нэгж байгууллагууд ажилтан, албан хаагч, оюутан суралцагчийнхаа нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор бие даасан цэцэрлэг байгуулан ажиллуулах асуудлыг тусгасан.</p> <p>Түүнчлэн “Цэцэрлэгийн дэргэд аж ахуйн нэгж, байгууллагын санаачилгаар “салбар бүлэг” ажиллуулахад хамтран ажиллах гэрээний үлгэрчилсэн загвар”-ыг БСШУС-ын сайдын 2019 оны А/804 дүгээр тушаалаар баталж эрх зүйн орчныг бүрдүүлэх ажлыг зохион байгууллаа. Гэрээнд цэцэрлэг, аж ахуйн нэгжийн хүлээх үүрэг хариуцлага, өмч хөрөнгө, санхүүжилт, ажиллах хуваарь зэргийг харилцан зөвшилцөх тухай асуудлыг тусгаж, цаашид байгууллага өөрсдөө санаачлан цэцэрлэгийн салбар бүлэг ажиллуулах асуудлыг дэмжсэн ажил боллоо.</p>	100%
16.	2.5 Сургуулийн өмнөх боловсролын стандартыг шинэчлэн боловсруулах чиглэлээр судалгаа хийж, стандартын төслийг боловсруулна. 5 настай хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдлын шалгуур үзүүлэлт боловсруулж, туршина.	Судалгаа хийгдэж, шалгуур үзүүлэлт боловсруулагдсан байна.	<p>СӨБ-ын сургалтын цөм хөтөлбөр, хөтөлбөрийн хэрэгжилтэд Боловсролын хүрээлэнгээс 2018-2019 онд хийсэн судалгаа, 2019 оны 3 сард БСШУС-ын яамнаас зохион байгуулсан үндэсний хэлэлцүүлгийн үр дүн зэрэгт үндэслэн сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөрийг сайжруулах асуудлыг тодорхойлж, Боловсролын хүрээлэнгийн захирлын тушаалаар томилогдсон ажлын хэсэг хөтөлбөрийг сайжруулалтыг хийж БСШУС-ын сайдын 2019 оны 08 сарын 02-ны өдрийн А/494 дүгээр тушаалаар батлан хэрэгжүүлж байна.</p> <p>Сургуулийн өмнөх насны хүүхдийн хөгжлийн үнэлгээний журмаар 5 настай хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдлыг үнэлэх үйл ажиллагааг зохицуулахаар журмын төсөл боловсруулж байна.</p>	70%

	/Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.4, ЗГҮАХ-ийн 3.2.10.1/		Сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээний шалгуурыг боловсруулахад сургуульд элсэх насны хүүхдийн хөгжлийн онцлог, сургуульд бэлтгэгдсэн байдлын шалгуурт тавигдах шаардлагыг судлан судалгааны дүнг харгалзан шалгуурыг боловсрууллаа.	
Гурав. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл				
17.	3.1 Цэцэрлэгийн багш, бусад ажилтны албан тушаалын ангилал, зэрэглэл, цалин хөлсийг нэмэгдүүлэх эрх зүйн орчин бүрдүүлнэ. /ЗГҮАХ-ийн 3.3.11 дэх заалт, МУ-ын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл/	Судалгаа хийсэн байна.	Цэцэрлэгийн багш бусад ажилтны албан тушаалын ангилал зэрэглэл, цалин хөлсийг ЗГ-ын 2018 оны 382 дугаар тогтоол, БСШУС-ын сайд, НХХ-ийн сайд, Сангийн сайдын 2010 оны хамтарсан 362/112/183 дугаар тушаалаар зохицуулж байгаа бөгөөд ЗГ-ын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтад заасны дагуу цэцэрлэгийн багш, туслах багш, бусад албан хаагчдад улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгохоор шийдвэр гарсныг хэрэгжүүлэн ажиллаж байна. Цэцэрлэгийн багшийн илүү цагийн хөлсийг тооцож олгох талаар 2018 оны Засгийн газрын 382 дугаар тогтоолд цэцэрлэгийн багшийн илүү цагийн хөлс олгох боломж хууль, эрх зүйн хүрээнд зохицуулалтгүй байсныг өөрчлөн ЗГ-ын 2019 оны 04 сарын 03 өдрийн 126 дугаар тогтоол батлагдсанаар цэцэрлэгийн багшид илүү цаг ажилласныг тогтоох эрх зүйн зохицуулалттай болсон. Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.5, 57.8 дахь хэсэгт зааснаар үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалин хөлс, зохих нэмэгдлийг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтоохоор зохицуулагдсан тул цэцэрлэгт ажиллаж байгаа төрийн үйлчилгээний бусад слесарь, жижүүр үйлчлэгч зэрэг ажилтны цалин хөлсийг нэмэгдүүлэхтэй холбоотой асуудлаар Хөдөлмөр нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн.	100%
Дөрөв.Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030" хөтөлбөрийн хүрээнд:				
18.	4.1 Цэцэрлэгийн тогооч нарын мэргэжил дээшлүүлэх давтан бэлтгэх журам боловсруулж, батлуулна.	Цэцэрлэгийн тогооч нарын мэргэжил дээшлүүлэх давтан бэлтгэх журам боловсруулсан байна.	Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн бус өмчийн 1439 цэцэрлэгт 2752 цэцэрлэгийн тогооч ажиллаж байна. Цэцэрлэгийн тогооч нарын мэргэжил дээшлүүлэх сургалтын загварыг "Монгол ногоо төсөл"-ийн багтай хамтран гарган улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 1439 цэцэрлэгийн 2142 тогооч нарын мэргэжил дээшлүүлэх сургалтыг сум орон нутаг, тухайн байгууллага, төслийн	40%

	/“Тогтвортой хөгжил-Сургуулийн өмнөх боловсрол” Үндэсний чуулганы зөвлөмж /		санхүүжилтээр зохион байгууллаа. Үүнд нийт 57,3 сая төгрөгийн хөрөнгө зарцуулсан. Мөн 4 аймагт “Хүүхдийн хоолыг хүнсний ногоогоор баяжуулъя” сургалтыг зохион байгуулж цэцэрлэгийн 150 тогооч хамрагдсан бол нийслэлийн 9 дүүргийн 209 цэцэрлэгийн 230 тогооч нарт тус сургалтыг хийсэн.	
19.	4.2 Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлж, хүүхдэд ээлтэй аюулгүй орчныг бүрдүүлнэ. /МУТХУБ-2030-ын 2.2.3, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 3.2.2, МУ-ын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл/	Хамран сургалт нэмэгдсэн байна.	Улсын хэмжээнд 2-5 настай 312,802 хүүхэд байгаагаас 2019-2020 оны хичээлийн жилд нийт 1,439 цэцэрлэгт 263,333 хүүхэд сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж, хамран сургалт 84,1 хувьд хүрч, өмнөх оноос 2,2 хувиар өссөн байна. Хүүхдэд ээлтэй аюулгүй орчныг бүрдүүлэх ажлын хүрээнд улсын төсвийн хөрөнгөөр 2,4 тэрбум төгрөгний тоног төхөөрөмж, гал тогооны хэрэгсэл нийлүүлсэн. Давхардсан тоогоор төрийн өмчийн цэцэрлэгийн 47,2%-ийг гал тогооны иж бүрэн тоног төхөөрөмжөөр хангалаа. Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй турийн болон төрийн бус өмчийн цэцэрлэгийн камержуулалт 93,4%-тай байна. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтын орчны (MNS 6558:2015) стандартын хэрэгжилтийн өөрийн үнэлгээний шалгуур үзүүлэлтийг шинэчлэн боловсруулж, улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 1439 цэцэрлэгээс судалгаа авах асуулгыг Боловсролын удирдлагын мэдээллийн системд байршууллаа.	100%
Тав. Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний хэвийн, тасралтгүй байдлыг хангах, хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр				
20.	5.1 ЗГҮАХХАХТ -3.2.14-3 Ердийн хэв шинжтэй цэцэрлэгт хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцах нийгэм, сэтгэл зүй, боловсрол, сургалтын таатай орчныг бүрдүүлэх талаар холбогдох арга хэмжээг хэрэгжүүлнэ. Цэцэрлэгийн багш нарт хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах	50 багш сургалтад хамрагдсан байна.	Монгол Улсын Засгийн газрын 2019 оны "Багшийн хөгжлийг дэмжих талаар авах зарим арга хэмжээний тухай" 145 дугаар тогтоол батлагдсан. Энэхүү тогтоолоор "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа ердийн сургууль, цэцэрлэгийн багшид 2019 оны 9 сарын 1 өдрөөс урамшуулал олгох асуудлыг судалж шийдвэрлэх" гэсэн заалт тусгагдсан. Тогтоолын хэрэгжилтийн хүрээнд "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа ердийн сургууль, цэцэрлэгийн багшид 10 хувийн нэмэгдэл олгох тухай санал боловсруулж, ХНХ-ын яам руу хүргүүлсэн. Багш нарт нэмэгдэл урамшуулал олгоход нийт 5 тэрбум төгрөг шаардлагатай байна. ✓ Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2013 оны Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх журмын 4.1-т заасны дагуу БМДИ	100%

	<p>сургалт зохион байгуулж, гарын авлагаар хангана.</p>		<p>2019 онд СӨББ-д эхний болон тав, арав дахь жилдээ ажиллаж буй багш, ажилтанд зориулсан үндсэн сургалтад нийт 1316 багш, арга зүйч, эрхлэгч хамрагдсан бөгөөд сургалтын хөтөлбөрт “Хэлний бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүй”, “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрх, оролцоо, хөгжлийг дэмжих” арга зүй сэдвийг сургалтын хөтөлбөрт тусган хэрэгжилтийг ханган ажилласан байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>✓ 17 аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар БМДИ, СӨБС зэрэг 8 байгууллагатай хамтран "Хөгжлийн бэрхшээлийн тухай ойлголт /нийгмийн загвар/", "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга барил", "Хөгжлийн бэрхшээлтэй байж болзошгүй, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг гэр бүлд нь хөгжлийг дэмжих Портеж хөгжлийн зориулалт, ажиллах арга зүй" сэдвээр 1584 багш, туслах багш, эцэг эхэд зориулсан сургалтыг 4,9 сая төгрөгийн санхүүжилтээр зохион байгуулсан.</li> </ul> <p>Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллагаас “Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл”-ийн хүрээнд СӨБ-ын багш, эцэг эхэд зориулан дараах гарын авлагыг боловсруулж, гаргасан.</p> <ul style="list-style-type: none"> <li>✓ ХБХ-ийн хөгжлийн түвшинг тодорхойлох, багшлах арга зүй</li> <li>✓ Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд цогц дэмжлэг үзүүлэх нь</li> <li>✓ Суралцахуйн бэрхшээлтэй, зан үйлийн асуудалтай хүүхдэд дэмжлэг үзүүлэх арга зүйн зөвлөмж</li> <li>✓ Эх хүүхдийн хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлэх зөвлөмж</li> <li>✓ Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр зэрэг болно.</li> </ul>	
21.	<p>5.2 Аймаг, нийслэлийн Боловсролын газар, цэцэрлэгийн эрхлэгч, багш нарт зориулсан “Сургуулийн өмнөх боловсролын эрх зүйн шинэчлэл” сургалт зохион байгуулна.</p>	<p>Сургалтыг төлөвлөлтийн дагуу хийсэн байна.</p>	<p>Сургуулийн өмнөх боловсролын сургалтын сайжруулсан хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор 2019 оны 08 сарын 15-30-ны өдрүүдэд “Сургалтын хөтөлбөрт дэмжлэг үзүүлэх арга зүй” сургалтыг улсын хэмжээнд зохион байгуулж, нийт 10081 цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч, багш хамрагдаж хөтөлбөрийг хэрэгжүүлэх нэгдсэн ойлголттой болж, хэрэгжүүлэх арга зүйд суралцлаа.</p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Цэцэрлэгийн арга зүйчийн манлайлах ур чадвар, менежментийн чадавхыг дээшлүүлэх, багшид мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх ажлын чанарыг сайжруулах зорилгоор “Багшид үзүүлэх мэргэжил арга зүйн дэмжлэг, манлайлал” сургалт-зөвлөгөөнийг</li> </ul>	<p>100%</p>

	/Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 5.2 дахь заалт/		<p>үндэсний хэмжээнд нийт аймаг, нийслэлийн дүүргүүдийг хамруулан 5 бүсээр зохион байгуулж 934 эрхлэгч, арга зүйч хамрагдаж багшид мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх менежментийн арга зүйд суралцлаа.</p> <p>✓ Аймаг, нийслэлийн БСУГ-ын дарга, СӨБ хариуцсан мэргэжилтнүүдийн сургалт зөвлөгөөнийг 2019 оны 11 сарын 7-8 өдрүүдэд зохион байгуулж Боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн өөрчлөлтийн төсөлд тусгасан зохицуулалтууд, Шинээр батлагдаж гарсан дүрэм, журмын хэрэгжилтийг хангах тухай, хүүхдийн цэцэрлэгийн багшлах хүний нөөцийн талаар баримтлах бодлого, цаашид авах арга хэмжээ, цэцэрлэгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх талаар авч хэрэгжүүлж буй бодлого шийдвэрүүдийг танилцуулж, мэдээлэл өглөө</p>	
22.	5.3 Сургуулийн өмнөх боловсролын багш нарын туршлага судлах ажлыг зохион байгуулна.	Багш нарыг гадаад улс оронд болон орон нутагт тэргүүн туршлага судлах арга хэмжээг зохион байгуулсан байна.	<p>Сургуулийн өмнөх боловсролын салбарын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх зорилгоор дараах гадаад улсад туршлага судлах сургалтыг зохион байгуулж явууллаа. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Эрхүү хотын "Байкальский Государственный Университет"-д Орос Монголын хамтын үйл ажиллагааны үндэсний төвтэй хамтран "Сургуулийн өмнөх насны хүүхдийн хөгжлийг дэмжих орчин үеийн арга, хандлага" сэдэвт 26 цагийн сургалтад СӨБ-ын 16 мэргэжилтэн, арга зүйч, багш хамрагдсан. Сургалтад хамрагдсанаар "Led book" номыг багш нар өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглах, номын сангийн үйл ажиллагааг олон төрлөөр баяжуулан сургалт зохион байгуулах, Эрхүү хотын хүүхдийн номын сангийн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, ХБХ-ийн захын булчингийн үйл ажиллагаанаас хамаарсан хэл засал сайжруулах ажлыг шинжлэх ухааны үндсийг нарийвчлан судалж, хүүхдийн захын мэдрэлийн цэгүүдийг сэргээх Жонсуны аргыг цэцэрлэгүүд нэвтрүүлж эхлээд байна.</li> <li>2. МУБИС-ийн сургуулийн өмнөх боловсролын сургуулийн багш, цэцэрлэгийн багш, эрхлэгч, сургуулийн багш нарын 40 хүний бүрэлдэхүүнтэй баг Япон улсын Токио хот, Ибараки мужид 2019 оны 8 сарын 5-10-ны өдрүүдэд зохион байгуулсан "Тогтвортой хөгжлийн боловсрол" сэдэвт сургалтад тус тус хамрагдлаа.</li> </ol>	100%

			Сургалтад хамрагдсанаар эцэг эхтэй хамтран ажиллах, харилцан үүрэг хүлээх, хүүхдийг хайрлаж хөгжүүлэх аргуудыг багш нарт эзэмшүүлэх, эрүүл, зөв хооллох дадал хэвшилтэй болгоход анхаарах, бүх шатны боловсролын байгууллагад эрүүл мэндийн сургалтыг түлхүү зохион байгуулах, цэцэрлэгийн хүүхдийн ганцаарчилсан уралдаан тэмцээнийг зохион байгуулахгүй байх зэрэг асуудлын талаар мэдээлэл солилцож, туршлагыг судлан үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байна.	
<b>ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН БОДЛОГЫН ГАЗАР</b>				
<b>Нэг. “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” хөтөлбөрийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:</b>				
23.	Боловсролын бодлогын шинжилгээ (2006-2018)-г ЮНЕСКО-той хамтран хийнэ.	Тайлан гарсан байна.	Монгол Улсын боловсролын бодлогод шинжилгээ хийх ажлын хүрээнд “Боловсролын суурь мэдээллийн тайлан”-г эрдэмтэн, судлаачдын оролцоотой боловсруулж, ЮНЕСКО-гийн талд 2019 оны 4 сард хүргүүллээ. Энэхүү тайлан нь 2006 оноос өнөө хүртэл Монгол Улсын боловсролын салбарт авч хэрэгжүүлсэн бодлого, стратеги, арга хэмжээ, тэдгээрийн үр дүн, үр нөлөөг авч үзсэн бөгөөд тайлан боловсруулахад 62.2 сая төгрөгийг зарцууллаа. Дээр дурдсан тайланд үндэслэн ЮНЕСКО-гийн тал манай улсын боловсролын бодлогын тойм шинжилгээг (i) бүх түвшинд боловсролын тэгш байдал, тэгш хамрагдалтыг сайжруулах, (ii) боловсролын чанар, нийцийг сайжруулах, (iii) салбар дамнасан бодлого, засаглал гэсэн 3 багц асуудлын хүрээнд хийж, тайланг баталгаажуулах эцсийн хэлэлцүүлгийг 2019 оны 12 сарын 3 өдөр зохион байгууллаа. Тойм шинжилгээний үр дүнгээр Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030 болон дэлхийн Тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөрт нийцүүлэн боловсролын салбарыг сайжруулах арга замыг тодорхойлсон бодлогын зөвлөмж (11 чиглэл)-ийг санал болгосон. “Боловсролын суурь мэдээллийн тайлан”, “Монгол Улсын боловсролын бодлогын тойм шинжилгээний тайлан”-г яамны сайтад <a href="https://mecss.gov.mn/news/2167/">https://mecss.gov.mn/news/2167/</a> тус тус байршууллаа.	100%
24.	“Сурлагын амжилтыг үнэлэх олон улсын судалгаа PISA 2021”-нд хамрагдах бэлтгэл	Асуулга, судалгаа, материалууд судалгаа зохион	Эдийн засгийн хамтын ажиллагааны хөгжлийн байгууллага (OECD)-аас хариуцан 3 жил тутамд зохион байгуулдаг PISA (Programme for International Student Assessment) олон улсын судалгаанд манай улс 2021 онд хамрагдахаар 2018 оны 7 дугаар сард тус яам зохион байгуулагч	100%

	хангах ажлыг удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллана.	байгуулах нэгжид хүргэгдсэн байна.	талтай гэрээ байгуулсан. Энэхүү судалгааг зохион байгуулахад шаардагдах зардлыг Дэлхийн банкны “Бага боловсролын чанарын шинэчлэл” төслөөс санхүүжүүлэхээр талууд тохиролцож, гүйцэтгэгчээр Боловсролын үнэлгээний төвийг сонгон гэрээ байгууллаа. Гэрээний дагуу судалгаа зохион байгуулах хүрээнд хийх ажлын төлөвлөлтийг бэлтгэл ажил, туршилтын судалгаа, үндсэн судалгаа гэсэн 3 багцад хамруулан хийж, санхүүжүүлэгч талын зөвшөөрлийг авсан. Эдийн засгийн хамтын ажиллагааны хөгжлийн байгууллагаас судалгаанд оролцох улс орнуудаас 2019 онд цуглуулах нийт 25 асуулга, мэдээллийг Боловсролын үнэлгээний төв боловсруулсныг хянаж зохион байгуулагч талд хүргүүллээ.	
25.	“Бага боловсролын суралцагчдын сургалтын математикийн суурь чадварыг дэмжих арга зүй” боловсруулж туршина./2.2.3,Зорилт-2	Арга зүй боловсруулагдсан байна.	“Бага ангийн суралцагчдын математик чадварыг хөгжүүлэх арга зүй боловсруулах” багийг шалгаруулж, бага боловсролын математикийн сургалтын хөтөлбөрт дүн шинжилгээ хийж, EGMA судалгааны үр дүнд суурилсан математикийн суурь чадварыг дэмжих арга зүйн зөвлөмж, цахим сургалтын модуль, цахим хичээлүүд, явцын үнэлгээний тодорхой сэдвийн аргачлалуудыг боловсруулж туршлаа.	100%
26.	Бага, суурь, бүрэн дунд боловсролын чанарын судалгааг зохион байгуулна.	III, X ангийн нийт сурагчдын 12%, IX ангийн сурагчдыг 100% хамруулна.	БСШУС-ын сайдын 2018 оны А/425 дугаар тушаалд заасны дагуу бага, дунд боловсролын чанарыг үнэлэх судалгааг 2019 оны 3 сарын 20 -оос 21-ний өдрүүдэд зохион байгуулж ажиллалаа. Энэхүү судалгаа нь бага, суурь, бүрэн дунд боловсролын чанарыг оновчтой боловсруулсан даалгавраар үнэлэх, боловсролын чанарт нөлөөлж буй хүчин зүйлсийг илрүүлж, тэдгээрийн хоорондын хамаарлыг тогтооход чиглэсэн.	100%
27.	Чанарын үнэлгээний үр дүнд суурилсан багшид зориулсан арга зүйн зөвлөмж боловсруулна. Чанарын үнэлгээний судалгааны статистик тайлангийн систем нэвтрүүлнэ.	Зөвлөмж боловсруулагдсан байна.	Энэ удаагийн үнэлгээнд III, X ангийн сурагчдын 12 хувь, IX ангийн сурагчдыг 100 хувийг хамруулж, шалгуулагчид 4 хичээлийн агуулгаар даалгавар гүйцэтгэн үр дүнг гаргалаа. Судалгааны үр дүнгээр IX ангийн сурагчдын шалгалтын дундаж гүйцэтгэл 37.1 хувь (математик 34.8%, монгол хэл 50.5%, физик 26.1%, англи хэл 26.3%)-тай дүгнэгдсэн бол III анги 49.9%, X анги 31.9%-тай гарсан байна. Суурь боловсролын чанарын үнэлгээний судалгааны үр дүнгээр тэргүүлэх амжилт үзүүлсэн ерөнхий боловсролын 40 сургуулийг тодруулж батламж олгов. Чанарын үнэлгээний үр дүнд суурилсан багшид зориулсан арга зүйн зөвлөмж боловсруулж үндэсний хэмжээнд түгээсэн.	100%
<b>Хоёр. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл-2019"-ийн зорилтыг хангахад чиглэсэн арга хэмжээ</b>				

28.	Сурах бичгийн талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ.*** /11.3/	Асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн байна.	<p>Засгийн газрын 2019 оны 3 сарын 06-ны өдрийн хуралдаанаар “Сурах бичгийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 98 дугаар тогтоолыг батлуулсан.</p> <p>Тус тогтоолоор i) сурах бичиг төлбөртэй ашиглуулах үйлчилгээг ерөнхий боловсролын сургуульд нэвтрүүлэх, ii) 2019 онд нөхөн хангалтаар хэвлэн нийлүүлэх сурах бичгийн зардлыг өмнө хэрэгжсэн сурах бичгийн түрээсийн туршилтын төслийн хүрээнд хуримтлагдсан хөрөнгөөр санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн.</p> <p>Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд:          АХБ-ны туслалцаатай хэрэгжүүлж буй "Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл"-ийн хүрээнд 3.1 сая ам долларыг санхүүжүүлэхээр АХБ-тай тохиролцож, төлбөртэй ашиглуулах сурах бичиг хэвлэн нийлүүлэх 3 тендерийг зохион байгуулж, дунд, ахлах ангийн 98 нэрийн нийт 1,789,030 ширхэг сурах бичгийг хэвлэн сургуулиудын номын санд нийлүүлсэн.</p> <p>Өмнө хэрэгжсэн сурах бичгийн түрээсийн туршилтын төслийн хүрээнд хуримтлагдсан 3,960 сая төгрөгийн хөрөнгөөр санхүүжүүлэн I-XII ангийн 146 нэрийн нийт 1,125,020 ширхэг сурах бичиг нөхөн хангалтаар, 23 нэрийн сурах бичиг шинэчилж зохион 576,547 ширхэг хэвлэн нийлүүлсэн.</p>	100%
29.	Сурах бичгийг зохиох, хэвлүүлэх, түгээх журмыг өөрчлөн шинэчилж, батлуулна. /11.3/	Журам батлагдсан байна.	<p>Журмын төслийг боловсруулж, боловсролын салбарын судлаачид, багш нар, номын санчдын төлөөллөөр хэлэлцүүлсэн. Хэлэлцүүлгээс гарсан санал зөвлөмжийг журамд тусгах ажил хийгдэж байна. Азийн хөгжлийн банкны “Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах” төслөөр зөвлөх үйлчилгээний хүрээнд журмын төслийг олон улсын жишиг, загварын дагуу сайжруулахаар ажиллаж байна. Зөвлөх компанитай байгуулах гэрээний хэлэлцээрийг 2019 оны 12 сарын 12 өдөр хийсэн.</p>	70%
30.	Сурах бичгийн түрээс, эргэлтийн сангийн журмын төсөл боловсруулж, батлуулна. /11.3/	Журмын төсөл боловсруулагдсан байна.	<p>“ЕБС-ийн сурагчдад сурах бичиг төлбөртэй ашиглуулах үйлчилгээний журам”-ыг БСШУС-ын сайдын 2019 оны 5 сарын 14 өдрийн А/302 дугаар тушаалаар, “Ерөнхий боловсролын сургуулийн 6-12 дугаар ангийн сурагчдад тухайн ангийн сурах бичгийг сургуулийн номын сангаар дамжуулан хичээлийн жилийн турш төлбөртэй ашиглуулах төлбөрийн хэмжээ”-г мөн сайдын 2019 оны 10 сарын 7 өдрийн А/624 дүгээр тушаалаар баталсан.</p>	100%



			ЕБС-ийн VI-XII ангийн 178,719 сурагчид төлбөртэй ашиглуулахаар VI, VII ангийн 29 нэрийн 1,042,000 ширхэг, VIII, IX ангийн 34 нэрийн 946,000 ширхэг, X-XII ангийн 35 нэрийн 747,030 ширхэг сурах бичиг, нийт давхардсан тоогоор 98 нэрийн 2,735,030 сурах бичгийг сургуулийн номын санд нийлүүллээ. Үүний үр дүнд ЕБС-ийн сурагчид сурах бичгээр 100 хувь бүрэн хангагдсан.	
31.	Цахим сурах бичиг, сургалтын нээлттэй хэрэглэгдэхүүн боловсруулах, хөгжүүлэх, ашиглах журмын төслийг боловсруулж, хэлэлцүүлнэ. /11.3/	Журмын төсөл боловсруулагдсан байна.	Цахим сурах бичигт тавигдах техникийн болон арга зүйн шаардлагыг боловсруулан ажиллаж байна. Энэ шаардлага нь “Сургалтын цахим объектын ерөнхий болон тусгай шаардлага”, “Сургалтын цахим объектын дидактикийн шаардлага” болон агуулгын форматын стандарт /Веб агуулга – мэдээлэл, хэв загвар, хэлбэржүүлэлт, зураг, аудио, видео, текстэн баримт бичиг (засвар хийх боломжтой, боломжгүй), цахим ном, хэрэглэгчийн талын скрипт хэл/ гэсэн хэсэгтэй. Уг шаардлагыг “Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд ажиллах зөвлөхийн туслалцааг авсны үндсэн дээр эцэслэнэ.	70%
32.	Бага, дунд боловсролын хэвлэмэл сурах бичигт тавигдах шаардлага MNS 5418:2008 стандартын шинэчилсэн төслийг боловсруулна. /11.3/	Стандартын төсөл боловсруулагдсан байна.	Ерөнхий боловсролын сургуулийн сурах бичгийн чанар, стандартын талаар сүүлийн жилүүдэд хийгдсэн зөвлөх үйлчилгээний тайлан, санал зөвлөмжид үндэслэн “Бага, дунд боловсролын хэвлэмэл сурах бичигт тавигдах шаардлага MNS 5418:2008” стандартыг шинэчлэн боловсруулсан. Шинээр боловсруулж байгаа стандартын төсөлд сурах бичгийн агуулга, арга зүй, хэл, найруулга, дизайн болон сурах бичгийн хэмжээ, жин, эдэлгээний чанарт тавигдах шаардлагыг илүү тодорхой болгож олон улсын жишигт нийцүүлэхээр тусгаж байна. Азийн хөгжлийн банкны “Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар хүртээмжийг дээшлүүлэх төсөл”-ийн хүрээнд зөвлөх эцсийн редакци хийж байна.	70%
33.	Ерөнхий боловсролын сургуульд суралцагчдын дотуур байрын орчин үйлчилгээний стандартыг батлуулах, зөвлөмж боловсруулж, арга зүйн сургалт	Стандарт батлагдсан байна.	Стандартын төслийг холбогдох газруудын саналыг авч тусган сайжруулж, сургуулийн шат шатны төлөөллийг оролцуулан 3 удаагийн нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамаар ахлуулсан “Хүүхдийн техникийн хороо”-ны 2019 оны 4 сарын 19-ний өдөр болон 9 сарын 20 өдрийн хурлаар тус тус хэлэлцүүлж дэмжигдсэн. Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2019 оны 9 сарын 30 өдрийн С/40 дүгээр тушаалаар “Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрын	100%

	<p>зохион байгуулна.*** /11.4/</p>		<p>орчин, үйлчилгээ MNS 6781:2019, Ерөнхий шаардлага” болон “Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал MNS 6782:2019, Ерөнхий шаардлага” батлагдсан. Дээрх стандартууд нь сургалтын байгууллагын гадаад, дотоод орчны аюулгүй байдлыг багш, ажилчид, сурагч, эцэг эхийн оролцоотой үнэлж, аливаа болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хүүхдийг сэтгэл хангалуун, амжилттай сурч хөгжих орчин нөхцөл боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн баримт бичиг юм. НҮБ-ын Хүүхдийн сангийн техникийн дэмжлэгтэйгээр “Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал MNS 6782:2019, ерөнхий шаардлага”-ыг хэрэгжүүлэх зөвлөмжийг боловсруулах ажлын хэсгийг БСШУС-ын сайдын 2019 оны 11 сарын 01-ний өдрийн А/695 дугаар тушаалаар байгуулан ажиллаж байна.</p>	
34.	<p>Нийтийн тээврийн үйлчилгээ нэвтэрсэн хот, суурин газрын ерөнхий боловсролын сургууль, насан туршийн боловсролын төвийн сурагчид гэр, сургуулийн хооронд нийтийн тээврээр үнэгүй зорчих эрх зүйн орчныг бүрдүүлэх санал боловсруулна. /11.2/</p>	<p>Холбогдох хуулийн төсөлд тусгагдсан байна.</p>	<p>Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчуулах асуудлыг Боловсролын тухай хуульд шинэчилсэн найруулгын үзэл баримтлалын төсөлд тусган ажиллаж байна. Тус яамнаас 2019 онд тусгай хэрэгцээт боловсролын 5 сургууль, 1 цэцэрлэгт нийт 6 автобус олгосноор 2019 оны 10 сарын байдлаар нийслэлд төрийн өмчийн 33 сургууль, 1 цэцэрлэгт 41 автобус, төрийн бус өмчийн 25 сургуульд 127 автобус, нийт 58 сургууль, 1 цэцэрлэгт 168 автобусаар 7209 суралцагчид үйлчилж байна. Энэ нь өмнөх 2018 оны мөн үеийнхтэй харьцуулбал 11 автобусаар нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Орон нутагт 8 аймгийн 30 сургууль 26 автобусаар давхардсан тоогоор 4377 суралцагчийг тээвэрлэж байна. Үндэсний хэмжээнд нийт 88 сургууль, 1 цэцэрлэг 194 автобусаар 11586 суралцагчид үйлчилгээ үзүүлж байна. Үүнээс гадна 2019 оны 11 дүгээр сараас эхлэн Нийслэлийн авто замын ачаалалд нөлөө бүхий их тойруу дахь сургуулиудад 26 автобус, хотын төвөөс алслагдсан, гэр сургуулийн хооронд олон км алхаж ирдэг ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын аюулгүй байдлыг хангах зорилгоор 14 автобус, нийт 29 сургуулийн 33 чиглэлд 40 автобус суралцагчийг тээвэрлэх үйл ажиллагаа зохион байгуулж байна.</p>	100%

Гурав. “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн зорилтыг хангахад чиглэсэн арга хэмжээ:

35.	Боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсэгт ажиллана.	Хуулийн төсөл боловсруулах багт дэмжлэг үзүүлж ажилласан байна.	Боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсгээс өгсөн чиглэлийн дагуу ерөнхий боловсролын асуудлаар “Боловсролын тухай хуульд тусгах асуудлын зураглал”, Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгааны тайлан болон хуулийн үзэл баримтлалын төсөлд тусгах асуудал (12 багц)-ыг тус тус боловсруулж ажлын хэсэгт хүлээлгэн өгсөн болно.	70%
36.	Бага, дунд боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулна.		Түүнчлэн хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулж байгаатай холбогдуулан “Бүх нийт боловсролын төлөө, иргэний нийгмийн үндэсний эвсэл” /иргэний нийгмийн 28 байгууллагыг нэгтгэсэн/-ээс хос хэлний боловсрол, хувийн сургуулийн зохицуулалт, боловсролын үйл ажиллагаанд эцэг, эх, асран хамгаалагч, иргэний нийгмийн байгууллагын оролцоо, төсөв, санхүүжилт зэрэг асуудлаар албан бичгээр саналыг авсан. Мөн Бага, дунд боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал, тандан судалгааг тус тус хийсэн.	70%
37.	Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааг үнэлэх журмын төсөл боловсруулна.	Журмын төсөл боловсруулсан байна.	Хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааг үнэлэх журмыг БСШУС-ын сайдын 2019 оны А/803 дугаар тушаалаар батлав. Энэхүү журмын үзэл баримтлал нь байгууллагын тасралтгүй хөгжлийг хангах, үйл ажиллагааны чанар, үр дүнгээ байгууллага нотолгоонд суурилан багш, ажилтан, суралцагч, эцэг эх, асран хамгаалагчийн оролцоотой өөрөө үнэлж, бодит байдлаа мэдэх, хариу арга хэмжээ авах, өөрийн үнэлгээний дүн, дүгнэлт бодитой эсэхийг хөндлөнгийн байгууллага баталгаажуулж, цаашид сурах, сургах үйл ажиллагаанд үзүүлэх дэмжлэгийг тодорхойлох, үнэлгээний үр дүнг бусадтай харьцуулах, эрэмбэлэн жагсаах шинж агуулахгүй, үнэлгээ нь тухайн байгууллагын үйл ажиллагааны ахиц, дэвшлийг үнэлэхэд чиглэгдэв.	100%
38.	“Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-3”-ийн төслийг боловсруулж, Засгийн газарт хүргүүлнэ. *** /3.2.8/	Хөтөлбөр батлагдсан байна.	БСШУС-ын сайдын “Ажлын хэсэг байгуулах тухай” 2018 оны А/738 дугаар тушаалаар батлагдсан “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-3”-ийн төсөл боловсруулах Ажлын хэсэг “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-3”-ийн төсөлд яамдаас санал авч, Засгийн газрын хэрэг эрхлэх газарт “Хүсэлт уламжлах тухай” албан бичгээр уламжлав. Засгийн газрын хэрэг эрхлэх газраас “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэгт “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 онд шинээр боловсруулах болон	100%

			<p>үргэлжлүүлэн хэрэгжүүлэх үндэсний хөтөлбөрийн жагсаалтыг Засгийн газар батална” гэж заасан. Иймд БСШУС-ын сайдын 2019 оны 1а/8774 дугаар “Хүсэлт уламжлах тухай” албан бичгээр “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III”-ийн төслийг дээрх жагсаалтад нэмж тусгахыг зөвшөөрч, Засгийн газрын хурлаар хэлэлцүүлэхэд дэмжлэг үзүүлэхийг хүссэн албан бичиг илгээсэн.</p> <p>Хөтөлбөр Засгийн газрын 2019 оны 12 сарын 18 өдрийн хуралдаанаар “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-3”- хэлэлцэн батлагдлаа.</p>	
39.	Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын бодлогын төсөл боловсруулна. /3.2.8/	Бодлогын төсөл боловсруулсан байна.	<p>“Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын үйл ажиллагаанд баримтлах чиглэл”-ийн төслийг боловсруулж, БСШУС-ын сайдын 2019 оны А/528 дугаар тушаалаар баталлаа.</p> <p>Энэхүү чиглэлийг ерөнхий боловсролын сургууль хичээл, хичээлээс гадуурх сургалтын ажлыг төлөвлөх, зохион байгуулахад баримтална. Чиглэл 4 бүлэгт хамаарах 57 заалтаас бүрдэж байгаа бөгөөд сургуулийн зорилго тодорхойлох, хичээл, хичээлээс гадуурх сургалтын ажлыг зохион байгуулах, үнэлэх, багшийн мэргэжлийн хөгжлийг хангах, сургалтын эрүүл, аюулгүй, хүртээмжтэй орчин бүрдүүлэх асуудлыг хамарсан болно.</p>	100%
40.	Дунд, ахлах ангийн монгол хэл, уран зохиол, монгол бичгийн сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгоно. /3.2.8/	Сургалтын хөтөлбөрийг сайжруулах санал боловсруулж холбогдох шийдвэр гарсан байна.	<p>БСШУС-ын сайдын “Сургалтын төлөвлөгөө шинэчлэн батлах тухай” 2019 оны А/491 дүгээр тушаалаар 2019-2020 оны хичээлийн жилээс эхлэн 10-12 дугаар ангийн “Монгол бичиг” хичээлийн цагийг тус бүр 35 цагаар нэмэгдүүлж, нэг ангид нийт 70 цагаар судлах эрх зүйн орчныг бүрдүүллээ.</p> <p>Бага, дунд, ахлах ангийн монгол хэл, уран зохиол, монгол бичгийн сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгож, БСШУС-ын сайдын 2019 оны А/492 дугаар “Хөтөлбөр батлах тухай” тушаалаар баталж, 2019-2020 оны хичээлийн жилээс эхлэн ерөнхий боловсролын нийт сургуулийн сурагчид судалж байна.</p> <p>Мөн 1-12 дугаар ангид монгол хэл, бичиг, уран зохиолын хичээл зааж буй нийт багш нарт зориулан “Сайжруулсан сургалтын хөтөлбөрийн арга зүй” сэдэвт сургалтыг 2019 оны 8 сард зохион байгууллаа.</p> <p>Түүнчлэн 1-12 дугаар ангид монгол хэл, бичиг, уран зохиолын хичээл зааж буй бүх багш нарт зориулан сайжруулсан сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүйн зөвлөмж бичиж, хэвлэн түгээлээ.</p>	100%

41.	Бага, дунд, ахлах ангийн сургалтын цөм хөтөлбөрт хийсэн үнэлгээ, дүгнэлтэд үндэслэн сургалтын цөм хөтөлбөрт өөрчлөлт оруулах санал боловсруулна. /3.2.10/	Судалгаанд үндэслэн сургалтын цөм хөтөлбөрт тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэж, засаж, сайжруулна.	<p>Бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөрт дараах үнэлгээ хийж, хэлэлцүүлээ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Монголын багш нарын VII их хуралд оролцогчдоор хэлэлцүүлээ /2019 онд/.</li> <li>✓ Монголын багш нарын улсын II зөвлөгөөнд оролцогчдоор хэлэлцүүлээ /2018 онд/</li> <li>✓ Монголын багш нарын “Бага, дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөр” үндэсний удаа дараагийн хэлэлцүүлэгт оролцогчдоор хэлэлцүүлээ /2019 оны 4, 5, 6 дугаар сард/</li> <li>✓ Боловсролын хүрээлэнгийн “Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, түүнд нөлөөлж буй хүчин зүйл” сэдэвт үндэсний судалгааны дүгнэлт, санал</li> </ul> <p>Дээр дурдсан Монголын багш нарын их хурал, зөвлөгөөн, үндэсний удаа дараагийн хэлэлцүүлэгт оролцогчдын санал болон үндэсний хэмжээний судалгааны дүгнэлтэд тулгуурлан бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг сайжруулан боловсронгуй болгож, БСШУС-ын сайдын 2019 оны А/492 дугаар “Хөтөлбөр батлах тухай” тушаалаар баталлаа.</p> <p>Тус сайжруулсан сургалтын хөтөлбөрөөр 2019-2020 оны хичээлийн жилээс эхлэн ерөнхий боловсролын нийт сургуулийн сурагчид хичээллэж байна.</p> <p>Сайжруулсан сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүйн сургалтыг 2019 оны 8 сард аймаг, дүүрэг бүрд зохион байгуулж ерөнхий боловсролын сургуулийн багш нарыг 100 хувь хамрууллаа.</p>	100%
42.	Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад бүрэн дунд боловсрол олгох сургалтын хөтөлбөрүүдийг шинэчлэн боловсруулна. /3.2.10/	Сургалтын хөтөлбөрүүдийг боловсруулсан байна.	<p>Мэргэжлийн боловсролын сургалтын 2.5 жилийн сургалтын төлөвлөгөөний “Ерөнхий суурь хэсэг”-ийн агуулгыг ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн “Заавал судлах цаг”-ийн агуулгатай харьцуулан тогтоох судалгааг хийлээ. Судалгааны дүгнэлт, саналд үндэслэн мэргэжлийн боловсролын сургалтын төлөвлөгөөний ерөнхий суурь хэсгийн агуулгыг шинэчлэн батлах асуудлыг шийдвэрлүүлээ.</p> <p>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, БСШУС-ын сайдын “Сургалтын төлөвлөгөөний ерөнхий суурь хэсгийн агуулгыг шинэчлэн батлах тухай” 2019 оны А/324/А/690 дүгээр тушаалаар мэргэжлийн боловсролын сургалтын 2.5 жилийн сургалтын төлөвлөгөөний “Ерөнхий суурь хэсэг”-ийн агуулгыг ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн “Заавал</p>	100%

			<p>судлах цаг"-ийн агуулгын 60-аас доошгүй хувь байхаар тогтоолоо. Мөн тушаалын хавсралтаар мэргэжлийн боловсролын 2.5 жилийн сургалтын төлөвлөгөөг ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн "Заавал судлах цаг"-ийн агуулгын 60-аас доошгүй хувьтай дүйцүүлэн шинэчлэн баталлаа.</p> <p>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын "Ажлын хэсэг байгуулах тухай" 2019 оны А/403 дугаар тушаалаар "Мэргэжлийн боловсролын сургалтын 2.5 жилийн сургалтын хөтөлбөрийн "Ерөнхий суурь хэсэг"-ийн агуулгыг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсан бөгөөд ажлын хэсэг мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад бүрэн дунд боловсрол олгох сургалтын хөтөлбөрүүдийн агуулгын хүрээг боловсрууллаа.</p>	
43.	"Ерөнхий боловсролын сургуулийн нэгдүгээр ангид хүүхдээ 6 настайд нь элсүүлэх боломжгүй малчин иргэний хүсэлтийг шийдвэрлэхэд баримтлах чиглэл"-ийн хэрэгжилтийг хангана. /3.2.1/	6-8 настай 1000-2000 хүртэлх хүүхдийн хүсэлтийг СЗ-өөр шийдвэрлэнэ.	<p>Улсын хэмжээнд 2019-2020 оны хичээлийн жилд нэгдүгээр ангид элсэх сурагчдын судалгааг аймгуудаас авч нэгтгэн, шинээр нээгдэх бүлэг, нэмж шаардагдах багшийн тоог гаргалаа.</p> <p>Судалгаагаар энэ хичээлийн жилд 75 мянга орчим хүүхэд элсэх бөгөөд 5 дугаар ангийг 1750 орчим бүлэг төгсөж, 200 орчим нэгдүгээр ангийн бүлэг шинээр үүснэ. 2019 оны 5 сард хүүхдээ 7 настайд нь элсүүлэх 2068 малчин иргэний хүсэлтийг шийдвэрлэсэн.</p>	100%
44.	Бага боловсролын математик, байгалийн ухааны сургалтыг дэмжих STEM /байгаль шинжлэл, технологи, инженерчлэл, математик/сургалтын явцад зөвлөн туслах, багшид арга зүйн дэмжлэг үзүүлэх ажлыг үндэсний хэмжээнд зохион байгуулна. /3.2.13/	Дэмжлэг үзүүлэх ажилд 1000 хүртэлх багшийг хамруулна.	<p>ЕБС-ийн бага боловсролын STEM сургалтын явц, үр дүнд үнэлгээ хийх, зөвлөн туслах ажлын хэсгийг сайдын 2019 оны 5 сарын 14-ний өдрийн А/291 дүгээр тушаалаар баталсан.</p> <p>Нийт 12 аймаг, 9 дүүрэгт бага боловсролын багш нарын явуулж буй хичээлд сууж зөвлөгөө өгөх, багш, хүүхдүүдтэй ярилцлага хийх, сургалтыг хэрэгжүүлэх боломж, сургуулийн дэмжлэг, суралцагчийн хөгжил, төлөвшилд гарч буй ахиц өөрчлөлтийн талаар хэлэлцүүлэг хийсэн.</p> <p>Үндэсний түвшинд цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэлийг тодорхойлж, зөвлөн туслах ажлаар 1380 бага ангийн багшийн хичээлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсэн байна.</p>	100%

45.	“Эрүүл мэндийн боловсрол” сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн явцтай танилцаж, зөвлөн туслах, арга зүйн удирдлагаар хангана. /3.2.11/	5 аймаг, нийслэлийн 9 дүүрэгт зөвлөн туслах үйл ажиллагааг зохион байгуулна.	<p>“Эрүүл мэндийн боловсрол” сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн явцтай танилцаж, зөвлөн туслах ажлыг 8 аймаг, 9 дүүргийн 35 сургууль дээр зохион байгууллаа. Эрүүл мэндийн багш нарын 62% нь өмнө нь сургалтад хамрагдсан, 38% нь огт хамрагдаж байгаагүй багш нар байсан байна.</p> <p>Эрүүл мэндийн багш нарыг</p> <ul style="list-style-type: none"> <li>✓ хоолны найрлага, илчлэг тооцох,</li> <li>✓ сэтгэцийн эрүүл мэнд, дасгал хөдөлгөөн, анхны тусламж буюу аюулгүй байдал, дадлагатай,</li> <li>✓ хорт зуршил, эрүүл мэндийн зөв дадалд суралцах,</li> <li>✓ эрүүл мэндийн тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх арга замууд, халдварт ба халдварт бус өвчний талаар,</li> <li>✓ нөхөн үржихүйн ба БЗДХ-ын талаар өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэх чиглэлээр давтан бэлтгэлээ</li> </ul> <p>БСШУС-ын сайдын 2019 оны А/62 дугаар тушаалаар “Эрүүл мэнд” хичээлийн сурах бичгүүдийг сургалтын хөтөлбөрт нийцэж буй байдалд үнэлгээ хийж, дүгнэлт гарган 4-12 дугаар ангийн “Эрүүл мэнд” сурах бичигт саналыг тусгууллаа.</p>	100%
46.	Аюулгүй амьдрах ухааны сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг арга зүйн удирдлагаар хангана. /3.2.14/	Арга зүйн дэмжлэг үзүүлэх 15 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг ажиллана.	<p>БСШУС-ын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны А/10 дугаар тушаалаар “ЕБС-ийн аюулгүй амьдрах ухааны сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх багшид зориулсан сургалтын багц боловсруулах ажлын хэсэг”-ийг байгуулсан.</p> <p>Аюулгүй амьдрах ухааны сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн чиглэлээр туршлага болохуйц үйл ажиллагаа явуулж буй байгууллагын ажилтай танилцан, хөтөлбөрт багц үзүүлэх, материал хийх агуулгыг тусгайлан боловсруулж гаргалаа. Багшид зориулсан арга зүйн зөвлөмжийг боловсруулж, 2800 ширхэг DVD хэвлүүлж, сургуулиудад хүргэсэн.</p>	100%
47.	Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын мэдлэг, чадварыг үнэлэх үнэлгээний шалгуур үзүүлэлтийн төсөл боловсруулна.	Шалгуур үзүүлэлтийн төсөл боловсруулсан байна. I-YIII cap	<p>Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн мэдлэг, чадварыг үнэлэх үнэлгээний шалгуур үзүүлэлтийг хичээл, анги тус бүрээр боловсруулах удирдамж, үнэлгээний шалгуурын зорилго, зорилтыг боловсруулах загварыг боловсролын түвшин бүрээр боловсруулсан.</p> <p>БСШУС-ын сайдын 2019 оны 8 сарын 02-ны өдрийн А/492 дугаар тушаалаар батлагдсан Бага, суурь, бүрэн дунд боловсролын сайжруулсан сургалтын хөтөлбөрийн дагуу түүний хэрэгжилтийг үнэлэх</p>	100%

			шалгуур үзүүлэлтийг хичээл, анги тус бүрээр боловсруулан хэрэгжүүлж байна.	
48.	Суурь, бүрэн дунд боловсрол эзэмшигчдэд боловсролын баримт бичиг олгох журмыг шинэчлэн батлуулна.	Журам батлагдаж улсын бүртгэлд бүртгэгдсэн байна.  I-IV сар	БСШУС-ын сайдын 2019 оны А/156 дугаар тушаалаар “Суурь боловсролын гэрчилгээ”, “Бүрэн дунд боловсролын үнэмлэх”-ийн загварыг тус тус баталж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2019 оны 4 сарын 19-ний өдрийн 4348 дугаарт бүртгүүлээ. Гэрчилгээ, үнэмлэхийг QR код баталгаажуулах, үнэлгээний дундаж хувь бичих зохицуулалтыг шинээр хийсэн нь өмнөх загвараас ялгагдах онцлог болов.	100%
49.	Суурь, бүрэн дунд боловсрол эзэмшигчдэд олгох боловсролын баримт бичгийн загварыг шинэчлэн батлуулна.	Загвар батлагдаж, улсын бүртгэлд бүртгэгдсэн байна.	БСШУС-ын сайдын 2019 оны А/156 дугаар тушаалаар “Суурь боловсролын гэрчилгээ”, “Бүрэн дунд боловсролын үнэмлэх”-ийн загварыг тус тус баталж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2019 оны 4 сарын 19-ний өдрийн 4348 дугаарт бүртгүүлээ. Гэрчилгээ, үнэмлэхийг QR код баталгаажуулах, үнэлгээний дундаж хувь бичих зохицуулалтыг шинээр оруулсан.	100%
50.	“Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам”-ын хэрэгжилтийг хангах чиглэлээр үндэсний сургагч багш бэлтгэх, багш, удирдах ажилтны чадавхийг дээшлүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулна. /3.2.9/	100-аас дээш багш, мэргэжилтнийг сургалтад хамруулна.	“Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам”-ын хэрэгжилтийг хангах хүрээнд Булган, Дархан-Уул, Сэлэнгэ, Орхон, Өмнөговь, Увс аймгийн Боловсрол, соёл, урлагийн газрын мэргэжилтэн, ерөнхий боловсролын сургуулийн сургалтын менежер, багш нарт үнэлгээний онол, арга зүйн сургалтыг тухайн аймгийн төвд төвлөрүүлэн Боловсролын үнэлгээний төвийн мэргэжилтний оролцоотой зохион байгууллаа. Энэхүү сургалтад 6 аймгийн 360 багш мэргэжилтэн хамрагдлаа. Ерөнхий боловсролын сургуулийн улсын шалгалтад зориулсан даалгаврын нээлттэй сан /itembank.eec.mn/ бүрдүүлэн, даалгаварт мэргэжлийн эксперт үнэлгээ хийж, шаардлагад нийцсэн даалгаврыг санд байршуулах ажил хийгдэж байна. Одоогийн байдлаар үнэлгээний даалгавар боловсруулах чиглэлээр ерөнхий боловсролын сургуулийн болон их дээд сургуулийн багш нарын төлөөлөл бүхий 100 гаруй багш мэргэжилтэн, 100 орчим мэргэжлийн эксперт бэлтгэгдэн ажиллаж байна.	100%
51.	Ерөнхий боловсролын сургуулийн сурах бичгийг мэдээлэл, холбооны хэрэгслээр ашиглах программ	Программ зохиогдсон байна.	Ерөнхий боловсролын сургуульд хэрэглэж байгаа I-XII ангийн бүх сурах бичгийг цахим хэлбэрээр <a href="http://www.econtent.edu.mn">www.econtent.edu.mn</a> , <a href="http://www.meds.gov.mn">www.meds.gov.mn</a> веб хуудсанд байршуулж, хэрэглэгчдэд нээлттэй ашиглуулж байна. Мөн андройд, ios үйлдлийн системтэй төхөөрөмжөөр сурах бичгийг ашиглах аппликейшн бий болгосон.	



	хангамжийг хөгжүүлж ашиглалтын хүртээмжийг нэмэгдүүлнэ. /3.2.10/		Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид сурах бичгийг тохиромжтой хэлбэрээр ашиглах боломжийг бий болгох чиглэлээр холбогдох төрийн бус байгууллагуудыг дэмжин хамтран ажиллаж байна. Харааны бэрхшээлтэй сурагчдад зориулан 1-3 дугаар ангийн сурах бичгийг брайль болон томруулсан үсгээр хослуулан хэвлэх талаар Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоо ТББ-тай, Ерөнхий боловсролын сургуулийн I-XII ангийн сурах бичгүүдийг DAISY E-pub хүртээмжит форматад шилжүүлж хараагүй болон харааны бэрхшээлтэй иргэд бусдын адил ашиглах боломжтой болгох талаар “Хараагүй хүмүүсийн инноваци хөгжлийн төв” ТББ-тай хамтран ажиллаж байна.	100%
52.	I-XI ангийн нөхөн хангалтын сурах бичгийг хэвлэн нийлүүлнэ. /3.2.10/	128 нэрийн сурах бичгийг нөхөн хангалтаар хэвлэн нийлүүлнэ.	2019 онд шинээр хэвлэх сурах бичгийн нэр, жагсаалт болон нөхөн хангалтаар хэвлүүлэх сурах бичгийн зардлыг сайдын тушаалаар баталсан. 2019 онд I-Y ангийн 39 нэр төрлийн сурах бичгийг 717,7 мянган ширхэг, YI-IX ангийн 63 нэр төрлийн сурах бичгийг 1,988,000 мянган ширхэг, X-XII ангийн 35 нэр төрлийн 747,030 ширхэг сурах бичиг, нийт 137 нэр төрлийн 3452730 сурах бичиг, багшийн журнал 172,2 мянган ширхгийг тус тус хэвлэн нийлүүллээ.	100%
53.	IV-XII ангийн “Эрүүл мэнд”, I-V ангийн “Эх хэл /казах/” сурах бичгүүдийг зохиож, хэвлэн нийлүүлнэ./3.2.10/	Эрүүл мэндийн 9, Казак хэлээр 5 сурах бичгийг шинэчлэн хэвлүүлсэн байна.	Ерөнхий боловсролын сургуулийн IV-XII ангийн “Эрүүл мэнд”-ийн 9 сурах бичгийг шинэчлэн 250250 ширхэг, I-V ангийн “Эх хэл /казах/”-ний 5 сурах бичгийг 13000 ширхэг, харааны бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажиллах багшийн “Яриа бичиг”, “Биет зүйл, “Айзам хөдөлгөөнт дасгал” номыг зохиож 300 ширхэг хэвлэн нийлүүлсэн.	100%
54.	Зах зээлд худалдан борлуулах сурах бичгийн гэрээг байгуулж, хэрэгжилтэд хяналт тавина. /3.2.10/	Дунд ахлах ангийн сурах бичгийн 60 хүртэл хувийг зах зээлд нийлүүлнэ.	Дунд, ахлах ангийн сурагчдыг сурах бичгээр бүрэн хангах зорилгоор сурах бичиг төлбөртэй ашиглуулах үйлчилгээг нэвтрүүлэх талаар Засгийн газрын шийдвэр гарч төлбөртэй ашиглуулах сурах бичиг хэвлэн нийлүүлэгдэж байгаа тул зах зээлд сурах бичиг борлуулах шаардлагагүй болсон.	100%
55.	Ерөнхий боловсролын сургуулийн сурах бичигт нээлттэй үнэлгээ хийнэ. /3.2.10/	128 нэр төрлийн сурах бичигт үнэлгээ хийнэ.	2019 онд сургалтын хөтөлбөрт сайжруулалт хийсэнтэй холбогдуулан ерөнхий боловсролын бүх сурах бичгийн агуулгад үнэлгээ хийлээ.  Одоо хэрэглэж буй 137 нэрийн сурах бичигт Боловсролын хүрээлэнгийн цахим хуудсаар багш нараас санал авч үнэлгээ хийж байна. Нөхөн хангалтын сурах бичигт эдгээр саналыг тусгах ажлыг хийлээ.	100%

56.	Ерөнхий боловсролын I-IX ангид хэрэглэх сургалтын хэрэглэгдэхүүний өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлох судалгаа хийнэ. /3.2.10/	Сургалтын 48 цөм хөтөлбөрийн түвшинд судалгаа хийнэ.	“Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд зөвлөх сонгон шалгаруулж, судалгаа хийгдэж байна.	70%
57.	Ерөнхий боловсролын сургуульд хэрэглэх сургалтын хэрэглэгдэхүүнд тавих шаардлага болон сургуулийн номын сангийн стандартын төсөл боловсруулна. /3.2.10/	Стандартын төсөл боловсруулсан байна.	“Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд хийгдэхээр төлөвлөсөн ажил бөгөөд зөвлөх сонгон шалгаруулж стандартын төслийг боловсруулан хэлэлцүүлж байна.	70%
58.	Хилийн чанадад байгаа хүүхдүүдийн нөхцөл байдлын судалгаа хийх, тэдний сурах үйл ажиллагааг дэмжих үйл ажиллагааг зохион байгуулна. /3.2.16/	Судалгаа, нэгдсэн мэдээлэлтэй болсон байна.	Хилийн чанадад ажиллаж, амьдарч буй монгол иргэдийн хүүхдэд монгол хэл соёлын мэдлэг, чадвар олгох үйл ажиллагаа явуулж буй сургууль, сургалтын төвийн сургалтад хэрэглэх "Монгол хэл, соёлын сургалтын жишиг хөтөлбөр"- ийг боловсруулж БСШУС-ын сайдын 2017 оны А/123 дугаар тушаалаар баталсан. Тус хөтөлбөрөөр 57 сургалтын төвд 1000 гаруй хүүхэд хичээллэн монгол хэл, соёлоо судалж байна. Хилийн чанад дахь монгол хэлний сургалтын төвийн багш нарыг монгол хэл заах арга зүйг чадавхжуулах сургалтыг 2018 оны 8 сард Улаанбаатар хотод зохион байгуулж, сургалтад АНУ, ХБНГУ, БНАСАУ, Япон, Чех, Швед, Швейцар, Канад, Бельги зэрэг оронд монгол хэл, соёлын сургалтын төвд ажиллаж буй 15 багш оролцлоо. Мөн 2019 оны 06 сард Шведийн Вант Улсын Стокхолм хотод болсон хилийн чанад дахь багш нарын “Гадаад хэлтэй орчинд монгол хэлийг заах онцлог” сэдэвт сургалтад 23 багшийг хамруулсан. БНСУ-ын "Монгол сургууль"-д БСШУС-ын яамнаас баталсан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу 300 сурагч суралцаж байгаа бөгөөд 2020 оны төсвийн төсөлд дээрх сургуулийн сурагчдад хувьсах зардлыг олгохоор төсөвт тусгаад байна.	100%

59.	Хүүхдийн хүмүүжил төлөвшлийн бодлогын төсөл боловсруулна. /3.2.4/	Бодлогын төсөл боловсруулсан байна.	<p>Нэг. “Иргэний ёс зүйн боловсролын жил”-д ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын судлах “Иргэний ёс зүйн боловсрол” сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэллээ.</p> <p>БСШУС-ын сайдын “Сургалтын төлөвлөгөө шинэчлэн батлах тухай” 2019 оны А/491 дүгээр тушаалаар бага, дунд, ахлах ангийн сурагчид “Иргэний ёс зүйн боловсрол” хичээлийг долоо хоногт тус бүр 2 цагаар судалж байна. “Иргэний ёс зүйн боловсрол”-ын хичээл зааж буй багш нарыг давтан сургах үндэсний 50 сургагч багшийг 3 үе шаттай сургалтаар бэлтгэлээ.</p> <p>Хоёр. Монгол Улсын Засгийн газрын “Үндэсний хөтөлбөр батлах тухай” 2019 оны 5 сарын 22-ны өдрийн 200 дугаар тогтоолоор “Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг Батлан хамгаалах яамтай хамтран баталлаа.</p> <p>БСШУС-ын сайд, Батлан хамгаалахын сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын “Үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” 2019 оны А/567/А227/А268 дугаар хамтарсан тушаалаар “Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хамтран батлаад ажиллаж байна.</p>	100%
60.	“Ерөнхий боловсролын сургуульд өдөр өнжүүлэх бүлэг ажиллуулахад тавигдах нийтлэг шаардлага”-ын төслийг боловсруулж, хэлэлцүүлнэ. /3.2.4/	Нийтлэг шаардлагын төсөл боловсруулсан байна.	БСШУС-ын сайдын 2019 оны А/582 дугаар тушаалаар “Өдөр өнжүүлэх үйлчилгээ эрхлэхэд тавих нийтлэг шаардлага”-ын төсөл боловсруулах ажлын хэсгийг холбогдох төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулан байгуулж, “Өдөр өнжүүлэх үйлчилгээ эрхлэхэд тавих нийтлэг шаардлага”-ыг боловсруулж, батлууллаа.	100%
61.	Дотуур байрны орчин, үйлчилгээг сайжруулах дунд хугацааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллана. /3.2.6/	Төлөвлөгөөний хэрэгжилт сайжирна.	<p>“Дотуур байрны орчин, үйлчилгээг сайжруулах дунд хугацааны төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангах хүрээнд дараах ажлуудыг зохион байгуулж байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>✓ “Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагаанд эцэг эх, асран хамгаалагч, иргэд, олон нийтийн оролцоо, хариуцлагыг нэмэгдүүлэхэд баримтлах үлгэрчилсэн чиглэл”-ийг баталсан.</li> <li>✓ “Боловсролын байгууллагын сургалтын орчин, дотуур байранд хүүхэд хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх” журмыг БСШУС-ын</li> </ul>	100%

			<p>сайдын 2018 оны 05 сарын 01-ний өдрийн А/239 дугаар тушаалаар баталлаа.</p> <ul style="list-style-type: none"> <li>✓ “Ерөнхий боловсролын сургуулийн орчин дахь хүүхэд хамгааллын бодлого”-ыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зөвлөмж боловсруулж, “Үндэсний сургалт” зохион байгуулан 1700 гаруй ерөнхий боловсролын сургуулийн захирал, нийгмийн ажилтныг хамрууллаа.</li> <li>✓ Стандарт, хэмжилзүйн газрын даргын 2019 оны 9 сарын 30 өдрийн 40 дүгээр тушаалаар “Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрын орчин, үйлчилгээ MNS:2019:6781 стандарт”-ыг батлууллаа.</li> </ul> <p>Сургуулийн дотуур байр, бага ангийн багш, нийгмийн ажилтанд зориулсан семинарыг 2019 оны 08 сард зохион байгууллаа.</p>	
62.	“Ерөнхий боловсролын сургуулийн аюулгүй байдлын дунд хугацааны төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангаж ажиллана. /3.2.7/	Төлөвлөгөөний хэрэгжилт сайжирна.  I-XII сар	<p>“Ерөнхий боловсролын сургуулийн орчныг аюулгүй байдлыг хангах дунд хугацааны төлөвлөгөө”-г БСШУС-ын сайдын 2018 оны А/398 дугаар тушаалаар батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>✓ БСШУС-ын сайдын баталсан удирдамжийн дагуу 2018-2019 оны хичээлийн жилд төрийн болон төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургуулийн гадна, дотор орчинд эрсдэлийн үнэлгээг зохион байгуулсан. Нийслэлийн ерөнхий боловсролын 102 сургууль өөрсдийн дотоод нөөцөд тулгуурлан 18.4 тэрбум төгрөгийн засвар үйлчилгээ, тохижилтын ажил хийлээ.</li> <li>✓ Нийслэлийн ерөнхий боловсролын 16 сургуулийн орчинд 850,0 сая төгрөг, 2019 онд нийслэлийн төсвийн 800 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар төрийн өмчийн 13 сургуулийн орчин дахь гэрэлтүүлэг, гарц, гэрлэн дохио, камер, хурд сааруулагчийг нэмэгдүүлсэн.</li> </ul>	100%
63.	3.28. Бага боловсролд хамрагдах хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсролын оношилгоо хийх арга зүйг боловсруулж туршина. /3.2.17/	Оношилгооны арга зүйг боловсруулсан байна.	<p>Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хэл ярианы хөгжлийн оношилгооны арга зүйг боловсруулж, адаптаци хийх зорилгоор туршиж байна.</p> <p>Танин мэдэхүйн хөгжлийг оношлоход шаардлагатай тестийн сан бүрдүүлсэн. Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хөгжлийн түвшинг тодорхойлох, багшлах арга зүйн хэрэглэгдэхүүн, “Суралцахуйн хоцрогдолтой, зан үйлийн эмгэгтэй хүүхдэд дэмжлэг үзүүлэх арга зүй, хэрэглэгдэхүүн” боловсрууллаа. Эдгээр оношилгооны аргуудыг Жайка төслийн хүрээнд туршилтын 10 сургууль дээр туршсан. 29.700 ширхэг гарын авлага, сургалтын хэрэглэгдэхүүнийг боловсруулж, 803 сургууль, насан туршийн боловсролын төвүүдэд хүргүүлээ.</p>	100%

64.	Эрүүл хүнсний орчин, дасгал хөдөлгөөн, хоол тэжээлийн боловсрол олгох чиглэлээр ЕБС-ийн эрүүл мэндийг дэмжих багийн ажиллах удирдамж боловсруулж батлуулна. /3.2.11/	Удирдамж батлагдсан байна. VI-IX сар	Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын Хүүхдийн сангийн 2017-2021 оны хамтарсан Улс орны хөтөлбөрийн хүрээнд эрүүл хоол үйлдвэрлэл, идэвхтэй дасгал хөдөлгөөний орчин бүхий жишиг загвар бий болгох ажлыг эхлүүлсэн. БСШУС-ын сайдын “Эрүүл хоол үйлдвэрлэл, идэвхтэй дасгал, хөдөлгөөнийг дэмжих орчинг цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулиудад нэвтрүүлэх жишиг загвар бий болгох” 2019 оны 5 сарын 29-ны өдрийн А/344 дугаар тушаалаар ажлын хэсэг болон ажиллах удирдамжийг баталсан. НҮБ-ын Хүн амын сангийн техникийн дэмжлэгтэйгээр Эрүүл мэндийн сургалтын хөтөлбөрийн багшид зориулсан зөвлөмж, хэрэглэгдэхүүн боловсруулах ажлыг хэсгийг БСШУС-ын сайдын 2019 оны 11 сарын 01-ны өдрийн А/696 дугаар тушаалаар байгуулан ажиллаж байна. Эрүүл мэндийн сургалтын хөтөлбөрийн гарын авлага, сургалтад ашиглах “Хооллолт ба хөдөлгөөн” агуулгаар 10 төрлийн хэрэглэгдэхүүний төслийг боловсрууллаа.	100%
65.	Газар хөдлөлт, гамшгаас хамгаалах чиглэлээр ерөнхий боловсролын сургуульд шаардлагатай багаж, тоног төхөөрөмжийн жагсаалт боловсруулж батлуулна. /3.2.1/	Жагсаалт батлагдсан байна. III-VI сар	Монгол Улсын Шадар сайдын “Заавар батлах тухай” 2018 оны 120 дугаар тушаалаар “Байгууллага, аж ахуйн нэгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар”-ыг батлахаар заасан бөгөөд Онцгой байдлын ерөнхий газраас 2019 онд зааврын төслийг боловсруулсан байна. Энэхүү зааврын төсөл батлагдсаны дараа цэцэрлэг, сургуулиудад аливаа болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн төлөвлөгөөний загвар, багаж, тоног төхөөрөмжийн жагсаалтыг хамтран батлахаар ажиллаж байна. Тус ажлын хүрээнд аймаг, нийслэлийн боловсрол, соёл урлагийн газрын дарга, дүүргийн боловсролын хэлтсийн дарга нарт “Сургуулийн цогц аюулгүй байдал” салбар дундын зөвлөлдөх уулзалтыг 2019 оны 6 сарын 28 өдөр зохион байгууллаа.	100%
66.	Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрын орчны эрүүл ахуйн стандартын төслийг боловсруулж, батлуулна. /3.2.7/	Стандарт батлагдсан байна. I-III сар	Стандартын төслийг Эрүүл мэндийн яамтай хамтран боловсруулж холбогдох газруудын саналыг авч тусган сайжруулж, “Хүүхдийн техникийн хороо”, “Эрүүл мэндийн техникийн хороо”-ны хурлаар тус тус хэлэлцүүлснээр дэмжигдсэн. Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2019 оны С/40 дүгээр тушаалаар “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, түүний дотуур байрын орчны эрүүл ахуй MNS 6799:2019, Ерөнхий шаардлага” батлагдсан.	100%

67.	“Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрын, ус, ариун цэвэр, эрүүл ахуйн норм, шаардлага”-ыг үнэлэх 3 одот аргачлалыг боловсруулж, туршиж, батлуулна. /3.2.6/	Үнэлгээний аргачлал батлагдсан байна.  III-VII сар	БСШУС-ын сайдын “Журам батлах тухай” 2019 оны А/803 дугаар тушаалаар батлагдсан “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааг үнэлэх журам”-ын шалгуур үзүүлэлтийн сургалтын орчны аюулгүй байдал бүлгийн 4.2.2-т сургалтын орчны аюулгүй байдал, ус ариун цэврийн байгууламж, үйлчилгээнд үзлэг шалгалтыг давтамжтай хийх нэгдсэн график түүний хэрэгжилт, үзлэг шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлсэн хариу арга хэмжээ 0-3 хүртэл үнэлэхээр зааж өгсөн. Байгууллагын өөрийн үнэлгээний болон хөндлөнгийн үнэлгээний аргачлалыг мөн дээрх тушаалаар баталсан.	100%
68.	УАЦЭА-н чиглэлээр багш, мэргэжилтэн, сурагчид, эцэг эхчүүдэд зориулсан ердийн болон онлайн сургалтын материал боловсруулна.	Сургалтын материал боловсруулсан байна.	Ус ариун цэвэр, эрүүл ахуйн чиглэлээр 2016 онд багш, мэргэжилтэн, сурагчид, эцэг эхчүүдэд зориулсан сургалтын модулыг боловсруулсан бөгөөд дээрх сургалтын модулыг шинэчлэх ажлыг хийж байна. Мөн НҮБ-ын Хүн амын сангийн техникийн дэмжлэгтэйгээр Эрүүл мэндийн сургалтын хөтөлбөрийн багшид зориулсан зөвлөмж, хэрэглэгдэхүүн боловсруулах ажлыг хэсгийг БСШУС-ын сайдын 2019 оны А/696 дугаар тушаалаар байгуулан ажиллаж байна. Эрүүл мэндийн сургалтын хөтөлбөрийн хэрэгжүүлэхтэй холбоотой багшид зориулсан аргачлал бүхий гарын авлага, сургалтад ашиглах 60 төрлийн сургалтын материал, хэрэглэгдэхүүний төслийг боловсруулаад байна.	100%
<b>Дөрөв. Хууль, дүрэм журам, бодлогын хэрэгжилт”-ийг хангахад чиглэсэн арга хэмжээ:</b>				
69.	Ерөнхий боловсролын сургуулиас эцэг, эхтэй ажиллах үлгэрчилсэн чиглэлийн төсөл боловсруулж батлуулна.	Үлгэрчилсэн чиглэл батлагдсан байна	“Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагаанд эцэг эх, асран хамгаалагч, иргэд, олон нийтийн оролцоо, хариуцлагыг нэмэгдүүлэхэд баримтлах үлгэрчилсэн чиглэл”-ийг БСШУС-ын сайдын 2019 оны А/119 дүгээр тушаалаар баталлаа. Үлгэрчилсэн чиглэлд ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагаанд эцэг эх, асран хамгаалагч, иргэд, олон нийтийн оролцоо, хариуцлагыг нэмэгдүүлэх, тэдэнтэй хамтран ажиллах төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэхийг нийт захирлуудад үүрэг болгосон. Түүнчлэн “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль- хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй байгуулах гэрээний үлгэрчилсэн загвар”-ыг БСШУС-ын сайдын 2019 оны А/508 дугаар тушаалаар баталлаа.	100%

70.	Багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн төслийг боловсруулж, Засгийн газарт хүргүүлнэ.***	Хөтөлбөрийн төслийг Засгийн газарт хүргүүлсэн байна.	Ерөнхий боловсролын сургуулийн багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн төслийг боловсруулж, багшийн мэргэжил дээшлүүлэх институтээс зохион байгуулсан 2019 оны үндсэн сургалтад хамрагдсан багш, удирдах ажилтнуудаар хэлэлцүүлсэн. Хуульд заасны дагуу Багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөр нь сургуулийн өмнөх, ерөнхий боловсрол, мэргэжлийн боловсрол, дээд боловсролын салбарын багш нарыг хамрах тул нэгтгэн боловсруулах ажил хийгдэж байна.	70%
71.	Ерөнхий боловсролын сургуулийн багшийн хөгжлийн төвд тавигдах шаардлага, ажиллах үлгэрчилсэн журмын төслийг боловсруулж, батлуулна.	Шаардлага болон журмын төсөл батлагдсан байна.	Багшийн хөгжлийн төвд тавигдах шаардлага, ажиллах үлгэрчилсэн журмыг нэгтгэн боловсруулсан. Журмын төслийг сайжруулан эцсийн хэлэлцүүлэг хийгдэж байна.	70%
72.	Ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлыг үнэлж дүгнэх журмын төслийг боловсруулж, батлуулна.	Журам батлагдсан байна.	Журмын төслийг 1000 орчим багш, сургалтын менежер, сургуулийн удирдах ажилтнуудад танилцуулж санал авсан. "Сургалтын байгууллагын ажлыг үнэлж, дүгнэх журам"-ыг(2019 оны А/803) шинэчлэн батлахтай холбоотойгоор багшийн ажлыг үнэлэх журмыг нийцүүлж, сайжруулан журам батлагдах шатандаа явж байна.	100%
73.	Ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх журмыг боловсруулж, батлуулна.	Журам батлагдсан байна.	Ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх журмын төслийг боловсруулан багш нарын дунд хэлэлцүүлэг зохион байгуулж, саналыг нэгтгэн журам боловсруулагдахаар танилцуулга мэдээлэл бэлтгэгдсэн.	100%
74.	Ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны албан тушаалын үлгэрчилсэн тодорхойлолт боловсруулж, батлуулна.	Албан тушаалын үлгэрчилсэн тодорхойлолт батлагдсан байна.	БСШУС-ын сайдын 2019 оны 5 сарын 03-ны өдрийн А/282 дугаар тушаалаар тус яамны харьяа Ерөнхий боловсролын лаборатори сургуулийн захирлын, Нийслэлийн тусгай сургуулийн захирлын, тусгай цэцэрлэгийн эрхлэгчийн албан тушаалын тодорхойлолтыг тус тус батлан, лаборатори 46 сургууль, 6 тусгай сургууль, 2 тусгай цэцэрлэгийн хэмжээнд мөрдүүлж эхэллээ. Төрийн албаны тухай хууль, Боловсролын тухай хууль, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолоор баталсан "Албан тушаалын	100%

			тодорхойлолт боловсруулах нийтлэг журмыг хэрэгжүүлэх зорилгоор БСШУС-ын сайдын 2019 оны "Албан тушаалд тавих нийтлэг шаардлага, үндсэн чиг үүрэг батлах тухай" А/692 дугаар тушаалаар ерөнхий боловсролын сургуулийн захирал, сургалтын менежерийн албан тушаалд тавих нийтлэг шаардлага, ажлын үндсэн чиг үүргийг тус тус баталлаа.	
75.	“Насанд хүрэгчдийн боловсролын хөтөлбөр”-ийг боловсруулж батлуулна.**	Хөтөлбөрийг батлуулсан байна.	БСШУС-ын сайдын 2019 оны “Хөтөлбөр батлах тухай” А/756 дугаар тушаалаар “Насан туршийн боловсрол” хөтөлбөр батлагдсан. Энэхүү хөтөлбөрийг Нийгмийн захиалга, хувь хүний хэрэгцээнд нийцсэн мэдлэг, ур чадварыг нээлттэй, хүртээмжтэй хэлбэрээр тасралтгүй эзэмшүүлэх насан туршийн боловсролын тогтолцооны чадавхыг нэмэгдүүлж, боловсронгуй болгох зорилгоор 2019-2021 онуудад хоёр үе шаттайгаар хэрэгжүүлэх юм.	100%
76.	Ердийн ерөнхий боловсролын сургууль, насан туршийн боловсролын төвд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг суралцуулах харилцааг зохицуулсан журмын төслийг боловсруулж, батлуулна.	Журам батлагдсан байна.	БСШУС-ын сайдын 2019 оны А/292 тоот тушаалаар “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд тэгш хамран сургах журам” -ыг баталлаа. Журмыг хэрэгжүүлэх зөвлөмжийг боловсруулан бүх аймаг, нийслэлийн БСУГ-т хүргүүлэн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100%
77.	Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн онцлог, суралцах чадамж, сонирхол, хэрэгцээнд тулгуурласан, эрүүл мэнд, хөгжлийн ахиц өөрчлөлтийг нь дэмжсэн, засан сайжруулах сургалтын хөтөлбөр боловсруулна.	Хөтөлбөр батлагдсан байна.	БСШУС-ын сайдын 2018 оны 173 дугаар тушаалаар Боловсролын хүрээлэнд хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн онцлог, суралцах чадамж, сонирхол, хэрэгцээнд тулгуурласан, эрүүл мэнд, хөгжлийн ахиц өөрчлөлтийг нь дэмжсэн, засан сайжруулах сургалтын хөтөлбөр боловсруулах чиглэлийг хүргүүлсэн. Боловсролын хүрээлэнгийн захирлын А/55 тоот “Хөтөлбөр боловсруулах баг”-ийн тушаалаар байгуулагдсан мэргэжилтнүүд тэгш хамруулан сургах боловсролын “Хэл засал” засан сайжруулах хичээлийн хөтөлбөрийн чиглэл, суралцахуйн удирдамжийг боловсруулсан.	100%



78.	Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн хөгжлийн ахиц, өөрчлөлтийг үнэлэхэд чиглэсэн үнэлгээний зөвлөмж гаргана.	Зөвлөмж гарсан байна.	Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн хөгжлийн ахиц, өөрчлөлтийг үнэлэхэд чиглэсэн үнэлгээний зөвлөмж гарган аймаг, нийслэлийн боловсролын газруудад хүргүүлсэн. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн хөгжлийн ахиц, өөрчлөлтийг үнэлэхэд чиглэсэн “Айзамт хөдөлгөөнт дасгал” хичээлийн багшийн ном, “Яриа бичиг” хичээлийн багшийн ном, “Биет зүйл” хичээлийн багшийн номыг тус тус боловсруулж хэвлүүллээ.	100%
79.	Брайль үсгийн стандартын төслийг боловсруулна.	Стандарт боловсруулсан байна.	Эрүүл мэнд эмнэлгийн тусламж, үйлчилгээний стандартчиллын техникийн хороогоор хэлэлцүүлэн “Монгол брайль үсгийн стандарт MNS 6800:2019” батлагдсан. “Монгол брайль бичгийн стандарт” батлагдаж байгаа нь хараагүй иргэд нийгмийн харилцаанд бусад хүмүүсийн нэгэн адил тэгш оролцох, бусад хүмүүс хараагүй болон харааны бэрхшээлтэй иргэдтэй брайль үсгээр дамжуулан харилцах, бие биедээ туслах, харилцан суралцах боломж бүрдэж, харилцааны чухал хэрэглүүр болох юм.	100%
80.	Ердийн ерөнхий боловсролын сургууль, насан туршийн боловсролын төвд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж буй багшид нэмэгдэл хөлс олгох эрх зүйн зохицуулалтыг бий болгоно.	Эрх зүйн зохицуулалт бий болсон байна.	Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 145 дугаар тогтоолд “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа ердийн сургууль, цэцэрлэгийн багшид 2019 оны 9 сарын 1-ээс эхлэн урамшил олгох асуудлыг судалж шийдвэрлэх”-ээр тусгасан. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа багшид 10 хувийн урамшил олгох тооцоо үндэслэлийг гарган БСШУС-ын сайдын 2019 оны 08 сарын 27-ны өдрийн 1а/7613 албан бичгээр ХНХЯ-нд хүргүүлсэн.	100%
81.	Монгол дохионы хэлний хэлмэрч, орчуулгын үйл ажиллагаа эрхлэх, үйлчилгээ үзүүлэх журмын төсөл боловсруулна.	Журам боловсруулсан байна.	Монгол дохионы хэлний хэлмэрч, орчуулгын үйл ажиллагаа эрхлэх, үйлчилгээ үзүүлэх журмын төслийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны саналыг тусган эцэслэн боловсруулаад байна. Дохионы хэлний хэлмэрч, орчуулагч гэсэн мэргэжил “Монгол улсын үндэсний ажил мэргэжлийн ангилал ба тодорхойлолт”-д байхгүй учраас хүлээгдэж байна.	100%
82.	Сургуулийн орчин дахь хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх зөвлөмж боловсруулна.	Зөвлөмж боловсруулсан байна.	БСШУС-ын сайдын 2018 оны А/476 дугаар тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургуулийн хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх зөвлөмж”-ийн гарын авлагыг боловсруулан, 2000 ширхэг хэвлүүлж ерөнхий боловсролын сургуулиудад хүргүүллээ.	100%

83.	Ерөнхий боловсролын сургуулийн хичээлээс гадуурх үйл ажиллагааны хүрээ, чиглэлийг тодорхойлно.	Үйл ажиллагааны чиглэл тодорхойлогдсон байна.	Ерөнхий боловсролын сургуульд секц, дугуйлан зохион байгуулах, санхүүжүүлэх аргачлалыг боловсруулж, БСШУС-ын сайдын 2019 оны 10 сарын 18 өдрийн А/659 дүгээр тушаалаар батлуулсан. “Хичээлээс гадуурх сургалтын ажлын үлгэрчилсэн хөтөлбөр”-ийг Боловсролын хүрээлэн, Багшийн мэргэжил дээшлүүлэх институттэй хамтран боловсрууллаа. Ерөнхий боловсролын сургууль дээр зохион байгуулж буй хичээлээс гадуурх ажлын хүрээ, чиглэл тодорхойлогдож байгаа юм.	100%
84.	ЕБС-ийн дотуур байрын өөрийн үнэлгээний аргачлалыг сайжруулж, батлуулна.	Аргачлал батлагдсан байна.	Дотуур байранд амьдарч буй хүүхдийн эрх, тэдний оролцоог хангах, дуу хоолойг сонсч, бодлого, үйл ажиллагаандаа тусгаж сайжруулах зорилгоор хүүхэд өөрийн амьдарч буй дотуур байрын орчин, үйлчилгээгээ үнэлэх шалгуур үзүүлэлтийг боловсруулж, БСШУС-ын сайдын 2019 оны А/803 дугаар тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааг үнэлэх журам”-ын үнэлгээний шалгуур үзүүлэлтэд орууллаа.	100%
85.	Цэцэрлэг, сургууль, дотуур байрны хүүхдийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд баримтлах стандарт, жор технологи боловсруулна.	Стандарт, технологийн горимын төсөл боловсруулагдсан байна.	БСШУС-ын сайдын 2019 оны А/695 дугаар тушаалаар Ажлын хэсэг байгуулж, 2014 онд гаргасан ерөнхий боловсролын сургуулийн тогооч нарт зориулсан жор технологийг шинэчлэх ажлыг НҮБ-ын Хүүхдийн сангийн техникийн дэмжлэгтэйгээр ШУТИС болон “Шим тэжээл судлалын төв”-тэй хамтран боловсруулсан. “Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэлийн жор технологи”-ын гарын авлага боловсруулан хэвлүүлж сургуулиудад хүргүүлэх ажил хийгдэж байна.	100%
86.	Дотуур байрны суралцагчийн хоолны нормативын төслийг шинэчлэн боловсруулж, Засгийн газарт хүргүүлнэ.	Норматив батлагдсан байна.	Засгийн газраас Монгол Улсын Их Хуралд 2019 оны 9 сард өргөн барьсан “Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хуулийн төсөлд цэцэрлэгийн хүүхдийн хоол болон ерөнхий боловсролын сургуулийн үдийн цай хөтөлбөр, дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг хүчин төгөлдөр мөрдөж байгаа нормативыг 50 хувиар тус тус нэмэгдүүлэхээр тусган баталсан. “Хоолны зардлын дундаж норматив батлах тухай” Засгийн газрын 2012 оны 106 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах тухай тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж батлууллаа.	100%
87.	Ерөнхий боловсролын сургуулийн 2019-2020 оны хичээлийн жилийн	Хичээлийн жилийн бүтцэд өөрчлөлт	БСШУС-ын сайдын “Хичээлийн жилийн бүтэц шинэчлэн батлах тухай” 2019 оны А/490 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаар 2019-2020 “Аймаг, сум, тосгон, багийн ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн	100%

	бүтцэд холбогдох өөрчлөлт оруулна.	оруулах шийдвэр гарсан байна.	жилийн бүтэц”, хоёрдугаар хавсралтаар “Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн жилийн бүтэц”-ийг тус тус баталлаа. 2019-2020 оны хичээлийн жилээс эхлэн энэхүү бүтцийг өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургууль тогтвортой мөрдөнө.	
88.	Олон улсын шалгаруулгад оролцох, бэлтгэх зардлыг санхүүжүүлнэ.	Олон улсын олимпиадад суралцагчид оролцсон байна.	БСШУС-ын сайдын “Зардал батлах тухай” 2019 оны А/79 дүгээр тушаалаар дээр дурдсан олимпиадад Монгол Улсын багийг оролцуулахаар 33.620 евро, 50.997 америк доллартай тэнцэх төгрөгийн зардлыг баталсан. 2019 онд нийт 12 сурагч олон улсын олимпиадаас медальт болон шагналт байрт шалгарлаа.	100%
89.	Бага, суурь, бүрэн дунд боловсролын агуулгыг нягтруулах, хичээлийн тоог цөөрүүлэх чиглэлээр судалгааны үндэслэл бүхий санал боловсруулна.	Холбогдох шийдвэр, чиглэл гарсан байна.	Бага, суурь, бүрэн дунд боловсролын агуулгыг нягтруулах, хичээлийн тоог цөөрүүлэх чиглэлээр судалгааны үндэслэл бүхий санал боловсруулах ажлын хэсгийг БСШУС-ын сайдын 2019 оны А/93 дугаар тушаал батлуулж, Үндэсний хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Хэлэлцүүлгийн үр дүнд бага боловсролын бүх судлагдахууны сургалтын хөтөлбөрийн агуулгыг нийт 1242 суралцахуйн зорилтоос 755 болгож 35.5%, суурь боловсролын агуулгыг 8.7%, бүрэн дунд боловсролын агуулгыг 9.2%-аар агуулга тус тус буурууллаа.	100%
90.	Бага боловсролын багш бэлтгэдэг сургуулийн математик, монгол хэлний сургалтын хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулж хүргүүлнэ.	Санал боловсруулсан байна.	Мэргэжлийн суурь хичээлийн сургалтын жишиг хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, заах арга зүй, үнэлгээний гарын авлага хэрэглэгдэхүүнийг хамтран боловсруулах, бэлтгэж буй багш нарынхаа чанарыг хөндлөнгөөс үнэлдэг байх, цаашид ЕБС-ийн бага ангийн хүүхдийн хөгжил, сурлагын ахиц амжилтаар өөрсдийн бэлтгэж буй мэргэжилтнүүдийн чанар, чансааг дүгнэдэг байх саналыг бага ангийн багш бэлтгэдэг их, дээд сургуулиудын удирдлагуудад хүргүүллээ.	100%
91.	Аймаг, нийслэлийн БСУГ-ын бага боловсролын мэргэжилтнүүдийн багшид зөвлөн туслах чадавхыг дэмжих ажлыг үе шаттай зохион байгуулна.	30 мэргэжилтнийг үе шаттай хамруулна.	“Сурлагын амжилтыг дэмжихэд сургалтын менежерийн чадавхыг дээшлүүлэх” зорилгоор 19 аймаг, 5 дүүргийн мэргэжилтнүүдэд 377,0 сая төгрөгийн санхүүжилт бүхий төсөл хэрэгжүүлэх эрх олголоо. 2019-2020 оны хичээлийн жилд аймаг, нийслэлийн БСУГ-ын бага боловсролын мэргэжилтнүүд багшид зөвлөн туслах ажлын чанарыг сайжруулахад ажлаа чиглүүлэн ажиллаж байна. Сургалтыг Дэлхийн банкны чанарын шинэчлэл төслийн хүрээнд зохион байгууллаа.	100%

92.	Бага боловсролын багш нарт зориулсан байгалийн ухааны туршилтын хичээлийн онол, арга зүйн хөгжлийг дэмжихэд чиглэсэн арга хэмжээ зохион байгуулна.	Багш нарын 30 хүртэлх хувийг тодорхой давтамж, үе шаттай арга хэмжээнд хамруулна.	Бага боловсролын багш нарт зориулсан байгалийн ухааны туршилтын хичээлийн онол, арга зүйн хөгжлийг дэмжихэд чиглэсэн ажлын хүрээнд сургалтын хөтөлбөрт дүн шинжилгээ хийж, байгалийн ухааны туршилтын хичээлийг анги тус бүрээр ялган, туршилтын хичээлийн явцын үнэлгээ хийж, зөвлөмж боловсруулсан. 2019 оны 8 сарын сургалтын сайжруулсан хөтөлбөрийн үндэсний сургалт, 10 сард “ЭГРА”-ийн сургалтад төрийн болон хувийн хэвшлийн ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн багш нарыг 100% хамрууллаа.	100%
93.	Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрийн шалгаруулалтыг зохион байгуулж, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлнэ.	520 сургуулийг сонгон шалгаруулна.	“Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрийг санхүүжүүлэх тухай” БСШУС-ын сайдын 2019 оны А/284 дүгээр тушаалаар 5 чиглэлд ирүүлсэн 1380 төслөөс 1.5 тэрбум төгрөгийн 351 төслийг шалгаруулж санхүүжилт олголоо. 2019-2020 оны хичээлийн жилд бага боловсролын суралцагчдын амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэх, дотуур байранд амьдарч буй бага боловсролын сурагчдын сурлагын амжилтыг дээшлүүлэх, багшийг ажлын байранд нь, хэрэгцээнд нь тулгуурлан хөгжүүлэх, бусдаас суралцах боломжийг нэмэгдүүлэх, бага ангийн багш, дотуур байрны багш, бусад ажилтнуудын хамтын ажиллагааг дэмжихэд чиглэгдэж байгаа юм.	100%
94.	Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгох, цуцлах үйл ажиллагааг зохион байгуулна.	Хүсэлт ирүүлсэн байгууллагуудад шинжээчийн ажлын хэсэг ажиллуулна.	Ерөнхий боловсролын лаборатори сургууль, Олон улсын хөтөлбөрийн сургалттай ерөнхий боловсролын сургууль, Их, дээд сургуулийн харьяа ерөнхий боловсролын ахлах сургууль зэрэг нийт 16 ерөнхий боловсролын сургалтын байгууллагад сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээг шинэчлэн олгосон.	100%
95.	Ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх ажлыг удирдлага, зохицуулалтаар хангаж, хэрэгжилтийг тайлагнана.	1, 5, 10 жилийн мэргэжил дээшлүүлэх сургалтад 7452 багшийг хамруулна.	Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын байгууллагын 1, 5, 10 дахь жилдээ ажиллаж буй нийт 6679 багш хамрагдлаа.	100%

96.	Бага, суурь, бүрэн дунд боловсролын улсын шалгалтын үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтыг хангана.	Шалгалт зохион байгуулагдсан байна.	2018-2019 оны хичээлийн жилийн Улсын шалгалтад: -5 дугаар ангийн 60431, -9 дүгээр ангийн 42123, -12 дугаар ангийн 16601 суралцагч, нийт 119155 суралцагч хамрагдсан байна. Улсын шалгалтад зориулсан даалгаврын санг баяжуулах, даалгаврыг сайжруулах ажлыг зохион байгуулж, шалгалтын блюпринт /төлөвлөлт/-ийг хичээл тус бүрээр боловсруулан, зөвлөмж, чиглэл өгч ажилласан. Энэхүү зөвлөмжийн дагуу сургууль бүр онлайн орчинд улсын шалгалтын сэдвийг даалгаврын нээлттэй сан ашиглан нэгэн ижил түвшинд боловсруулж, шалгалтыг Боловсролын үнэлгээний төвөөс тогтоосон хугацаанд нэгэн зэрэг зохион байгуулж дуусгалаа.	100%
97.	Суурь, бүрэн дунд боловсрол эзэмшигчдэд боловсролын баримт бичиг олгох ажлыг зохион байгуулна.	Боловсролын баримт бичиг олгогдсон байна.	Ерөнхий боловсролын сургууль, насан туршийн боловсролын төвд суралцан төгсөгчдөд суурь боловсролын гэрчилгээ, бүрэн дунд боловсролын үнэмлэх олгох ажлыг “Суурь, бүрэн дунд боловсрол эзэмшигчдэд боловсролын баримт бичиг олгох, дүйцүүлэх журам”-ын дагуу анх удаа боловсролын салбарын мэдээллийн системээр амжилттай зохион байгууллаа. Энэхүү журмыг хэрэгжүүлэх хүрээнд Боловсролын салбарын мэдээллийн системээр боловсролын баримт бичиг олгосон нь ерөнхий боловсролын сургуулийн багшид гэрчилгээ, үнэмлэхийг гараар бичих, монгол бичгээр зэрэгцүүлсэн бичилт хийхтэй холбогдон багшид үүсдэг техник ачааллыг арилгаж, техник алдаа гаргаснаас үнэт цаас хүчингүй болгож төлбөр төлөх эрсдэлгүй болсон, хөдөөгийн сум, алслагдсан дүүргийн сургуулийн удирдлага, багш нар аймгийн төв, дүүрэгт ирж хянуулах, гарын үсэг зуруулах гэх мэт ачаалал эрс буурч цаг хугацаа, санхүүгийн хэмнэлт гарсан зэрэг нь багш, боловсролын байгууллагын удирдлага, иргэдийн талархлыг хүлээсэн ажил боллоо.	100%
98.	Насан туршийн боловсролын сургалтын үйл ажиллагаанд үнэлгээ хийнэ.	Үнэлгээ хийгдсэн байна.	2019 онд 6 дүүрэг, 9 аймгийн Насан туршийн боловсролын төвүүдэд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж Насан туршийн боловсролын сургалтын үйл ажиллагаанд үнэлгээ хийж ажиллалаа. Уг ажлын хүрээнд сайн туршлагыг солилцох зорилгоор 2019 оны 5, 10 дугаар сард нийслэлийн Насан туршийн боловсролын төвийн захирал, менежерүүдэд сургалт зохион байгуулав.	100%
99.	Насан туршийн боловсролын багш	460 багшийг тодорхой давтамж,	Үндэсний хэмжээнд Насан туршийн боловсролын багш, захирал, сургалтын менежер, орон нутгийн удирдлага, шийдвэр гаргагчид нийт	

	нарын мэргэжил дээшлүүлэх сургалт зохион байгуулна.	үе шаттай хамруулна.	620 багш, боловсон хүчнийг чадавхжуулах, мэргэжил ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр 10 төрлийн сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулсан. 2019 оны 9, 10 дугаар сард насанд хүрэгчид, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах чадвар эзэмшүүлэх сургалтад давхардсан тоогоор 2905 багш, багшийн мэргэжил дээшлүүлэх институтын үндсэн сургалтад 312 багш тус тус хамрагдаж мэргэжлээ дээшлүүлээд байна. Аймаг, нийслэлийн Насан туршийн боловсролын төвийн захирал, сургалтын менежерүүдэд зориулсан “Насан туршийн боловсролын үйлчилгээний менежмент” сэдэвт сургалтыг 2019 оны 11 сард Улаанбаатар хотод зохион байгуулж, сургалтад нийт 55 хүн хамрагдлаа.	100%
100.	БСМС-д НТБ-ын мэдээлэл, бүртгэлийн маягтад өөрчлөлт оруулах санал хүргүүлнэ.	Маягт шинэчлэгдсэн байна.	Боловсролын салбарын мэдээллийн систем дэх Насан туршийн боловсролын салбарын мэдээллүүдийг шинэчлэн, Насан туршийн боловсролын төв, хүний нөөц, сургалтуудын мэдээллүүдийг нэмж оруулан статистикийн БДБ маягтуудыг салбарын бодлого, хүний нөөц, суралцагчийн онцлогт тохируулан шинэчлэн боловсруулах хүрээнд 7 маягтыг сайжрууллаа. Насан туршийн боловсролын талаарх олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх сурталчилгааны 118 видео материал боловсруулж, Боловсролын статистик мэдээллийн санд Насан туршийн боловсролын төвүүдийг холбож, Үндэсний төвийн цахим хуудсыг шинэчиллээ.	100%
101.	ЕБС-ийн орчин дахь хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалт зохион байгуулна.	3000 хүртэлх багш, удирдлагыг хамруулна.	БСШУС-ын сайдын 2018 оны А/476 дугаар тушаалаар “Ерөнхий боловсролын сургуулийн орчин дахь Хүүхэд хамгааллын бодлого”-ыг хэрэгжүүлэх зөвлөмжийг боловсруулж, үндэсний сургалтыг 2019 оны 08 сарын 15-23-ны хооронд 21 аймагт, 9 сарын 27-30 хооронд Улаанбаатар хотод зохион байгууллаа. Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх үндэсний сургалтад нийт 1700 гаруй ерөнхий боловсролын сургуулийн захирал, нийгмийн ажилтан хамрагдаж, сургууль, дотуур байрын орчинд суралцагчдыг аливаа болзошгүй эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, мэдээлэл, таамаглалыг хүлээн авах, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх чадавхыг сайжрууллаа. “Ерөнхий боловсролын сургуулийн хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх зөвлөмж”-ийг боловсруулж, 2000 ширхэг хэвлүүлэн ерөнхий боловсролын сургуулиудад хүргүүллээ.	100%

102.	ЕБС-ийн суралцагчдын дунд “Цахим орчны зөв зохистой хэрэглээ”-нд хэвшүүлэх ажлыг зохион байгуулна.	Арга хэмжээ зохион байгуулагдсан байна.	"Хүүхэд хэрэглэгч" аяны хүрээнд БСШУС-ын яамнаас ХЗДХЯ, ХНХЯ, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар, Харилцаа холбооны зохицуулах хороо, Монголын телевизийн холбоо, Монголын хэвлэл мэдээллийн зөвлөл хооронд “Хүүхдийг мэдээллийн сөрөг нөлөөллөөс хамгаалах талаар хамтран ажиллах Санамж бичиг” байгуулан хамтран ажиллаж байна. Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын дунд “Цахим орчны зөв зохистой хэрэглээ” сэдэвт уралдааныг Харилцаа Холбооны зохицуулах хороотой хамтран зохион байгуулж 21 аймаг, 6 дүүргийн 513 хүүхэд залуус оролцлоо.	100%
103.	“Хүүхдийн хөгжил хамгааллын үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангаж ажиллана.	Хэрэгжилтийг ханган ажилласан байна.	Үндэсний хөтөлбөрийг хэрэгжилтийг хангах ажлыг эрчимжүүлэх Ажлын хэсгийг БСШУС-ын сайдын 2019 оны А/308 дугаар тушаалаар байгуулан ажиллаж байна. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны хүүхдийн хөгжил, хамгааллын байнгын ажиллагаатай ажлын хэсэг, дэд ажлын хэсгийн хуралдаанд тогтмол оролцож мэдээлэл хийн, ажлаа тайлагнан хамтран ажиллаж байна.	100%
104.	БСШУС-ын сайд, Эрүүл мэндийн 2018 оны А/448, А/268 дугаар хамтарсан тушаалыг хэрэгжүүлэх зөвлөмжийг боловсруулж, сургуулиудад хүргүүлнэ	Зөвлөмж гарсан байна.	2018 оны 2 сарын 25-ны өдрийн 1а/1323, 1а/1324 дугаар албан бичгээр Сангийн яам, Эрүүл мэндийн яаманд санал авахаар “Цэцэрлэг, сургуулийн хүүхдийн хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээ”-г шинэчлэн боловсруулж, төслийг хүргүүлсэн. Сангийн яаманд нэмэлтээр жишиг хэмжээнд үндэслэн цэцэрлэг, дотуур байрын хүүхдийн хоол, үдийн цайны зардлын норматив нэмэгдэх мөнгөн дүн, төсвийн үр нөлөөний судалгааг хийж дахин 2019 оны 4 сарын 19-ны өдрийн 1а/3084 дугаар албан бичгээр санал авахаар хүргүүлээд байна. БСШУС-ын сайд, Эрүүл мэндийн 2018 оны А/448/268 дугаар хамтарсан тушаалыг хэрэгжүүлэхийг түр түтгэлзүүлэн Эрүүл мэндийн сайдын 2014 оны 113 дугаар тушаалыг мөрдөж байна.	100%
<b>Тав. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх оролцоог дэмжих” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах хүрээнд</b>				
105.	Тусгай хэрэгцээт боловсролын багш, хэл засалч, хөдөлгөөн засалч, хөдөлмөр засалч, дохионы хэлмэрч-орчуулагч,	30 хүртэлх багшийг хамруулна.	Онлайн сургалт, хэлэлцүүлэгт 2137 багш, тэгш хамруулан сургах боловсролын 112 цагийн хичээлд 2680 багш, “Аутизмын хүрээний эмгэгтэй хүүхдийг боловсролд хамруулах нь” сургалтад 500 хүнийг хамруулж, сургалтын материалыг бүх аймгуудад хүргүүлсэн. “Сэтгэцийн эрүүл мэнд”, “ICF”, “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулах арга зүйд сургах нь”, “Хөгжлийн бэрхшээлтэй	100%

	сэтгэл зүйчийг бакалавр, магистр, докторын түвшинд, гадаад, дотоодод шинээр бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх, мэргэшүүлэх сургалтад хамруулна.		хүүхдийг хөгжүүлэх, нөхөн сэргээх, засан сайжруулах, ахуйн баримжаа олгох” зэрэг цуврал сургалтад давхардсан тоогоор 200 орчим багш, эцэг эх хамрагдлаа. 2019-2020 оны хичээлийн жилд ОХУ-ын Москва, Санкт-Петербург, Томск хотуудад хэл засалч, согог зүйч мэргэжлээр 8 оюутан сургаж байна. Ерөнхий боловсролын 55, 29 дүгээр тусгай сургуулийн 6 багшийг Унгар, Оросын холбооны Улсуудад, мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрууллаа.	
106.	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг өөрт нь байгаа авьяас, ур чадвар, нөөц боломжид тулгуурлан мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтад хамруулна.	30 хүртэлх хүүхдийг хамруулсан байна.	Энэ ажлын хүрээнд 2019 онд тогооч нарийн боовчны мэргэжлийн чиглэлээр 19 сурагч, “Зочид буудлын өрөөний үйлчлэгч” бэлтгэх чиглэлээр 7 сурагч суралцаж байна. Монголын Аутизмын холбоотой хамтран Австралийн Засгийн газрын шууд тусламжийн хөтөлбөрийн санхүүжилтээр “Зочид буудлын үйлчлэгч”- ийн загвар өрөөг шинээр тохижуулан нээж сургалтын үйл ажиллагаа явуулж байна. Энэ чиглэлээр хөгжлийн бэрхшээлтэй 13 хүүхэд суралцаж байна.	100%
107.	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хөгжүүлэх, нөхөн сэргээх, ахуйн баримжаа олгох чиглэлээр сургалтын модуль боловсруулж, сургуулийн өмнөх болон бага боловсрол, насан туршийн боловсролын багш нарт сургалт зохион байгуулна.	50 багшийг хамруулна.	БСШУС-ын сайдын 2019 оны А/173 тоот тушаалаар Багш нарт зориулсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хөгжүүлэх, нөхөн сэргээх, ахуйн баримжаа олгох сургалтын модуль” боловсруулсан. Уг модулиар 200-аад багш эцэг эхийг сургалтад хамруулсан. “Тэгш хамруулан сургах боловсрол” холимог бүлгийн багш нарыг чадавхжуулах сургалтыг 8 бүс /Өвөрхангай, Дундговь, Төв, Ховд, Хөвсгөл, Завхан, Хэнтий, Сэлэнгэ/-д 2019 оны 09 дүгээр сард зохион байгуулж нийт 453 багшийг хамрууллаа.	100%
108.	Бага боловсролд хамрагдах хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсролын оношилгоо хийх арга зүйг боловсруулж туршина. /3.2.17/	Арга зүйг боловсруулсан байна.	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хэл ярианы хөгжлийн оношилгооны арга зүйг боловсруулж, нэвтрүүлэх зорилготой туршиж байна. Танин мэдэхүйн хөгжлийг оношлоход шаардлагатай тестийн сан бүрдүүлсэн. Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хөгжлийн түвшинг тодорхойлох, багшлах арга зүйн хэрэглэгдэхүүн, “Суралцахуйн хоцрогдолтой, зан үйлийн эмгэгтэй хүүхдэд дэмжлэг үзүүлэх арга зүй, хэрэглэгдэхүүн” боловсруулсан.	100%



			Эдгээр оношилгооны аргуудыг Жайка төслийн хүрээнд туршилтын 10 сургууль дээр туршлаа. 29.700 ширхэг гарын авлага, сургалтын хэрэглэгдэхүүнийг 144.886.000 төгрөгөөр 803 сургууль, насан туршийн боловсролын төвүүдэд хүргүүлэн судлуулсан байна.	
<b>ДЭЭД БОЛОВСРОЛЫН БОДЛОГЫН ГАЗАР</b>				
<b>Нэг. “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд:</b>				
109.	Боловсролын тухай, Дээд боловсролын тухай, Дээд боловсролын санхүүжилт суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулиудын төслийн үзэл баримтлалын төсөл, хуулиудын төслийг өргөн барина. /ЗГҮАХ 3.2.18./	Өргөн барьсан хуулиуд.	БСШУС-ын сайдын 2019 оны А/71 дүгээр тушаалаар “Боловсролын хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсэг”-ийг шинэчлэн байгуулсан. Ажлын хэсэг боловсролын тухай хуулийн түүхийн эх сурвалжууд, хуулийн өөрчлөлтүүд, хуульд нэмэлт өөрчлөлт оруулахтай холбоотойгоор хийгдсэн томоохон судалгаануудын жагсаалт, тэдгээрийн агуулга зэрэг мэдээллийг судлан, хуульд шинээр оруулах хуулийн гол харилцааны агуулгыг боловсруулан, танилцуулга хийсэн. Улмаар боловсролын хуулийн “Шинэчлэлийн зураглал”-ын төслийг ажлын хэсгийн гишүүдэд танилцуулж, цахим хаягаар хүргүүлэх ажлыг зохион байгуулсан. Мөн 7 орны боловсролын хууль тогтоомжийн харьцуулсан судалгаа хийх олон улсын нээлттэй зөвлөхийн сонгон шалгаруулалт зохион байгуулж, тэдний ажлын даалгавар, төлөвлөгөөний дагуу тайлан зөвлөмжийг хүлээн авч, 300 гаруй хүнийг оролцуулан хэлэлцүүлэг зохион байгуулсан. Хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийн хэрэгцээ шаардлагыг тандан судалсан судалгааны төслийг боловсруулж, Хууль зүй, дотоод хэргийн яаманд 2019 оны 10 сарын 14-нд хүргүүлсэн. Хуулийн төслийн эхний хувилбарыг боловсруулсан. Мөн боловсролын тухай хуулийн боловсруулалтыг сайжруулах зорилгоор дээд боловсролын салбарт одоо хэрэгжиж буй хуулиудын үр дагаврын үнэлгээ хийж байна.	70%
110.	Дээд боловсролын салбарын хөгжлийн бодлогын хэрэгжилтэд үнэлгээ хийж, 2020-2030 оны Боловсролын мастер төлөвлөгөөний	Боловсруулсан баримт, бичиг.	“Дээд боловсролын салбарын хөгжлийн бодлогын хэрэгжилтэд судалгаа, үнэлгээ” хийсэн. Дээд боловсролын салбарын 1993, 2000, 2006 оны мастер төлөвлөгөөний бодлого, тэдгээрийн хэрэгжилтийн нөхцөл байдал, үр дүнд шинжилгээ хийж, ололт амжилт, бэрхшээлтэй асуудлууд, тэдгээрийн учир шалтгааныг илрүүлж, мөн хөгжлийн бодлогыг олон улсын боловсролын тэргүүлэх байгууллагууд болон	70%

	<p>Дээд боловсролын дэд хэсгийг боловсруулна. /ЗГҮАХ 3.2.18./</p>		<p>бусад орны туршлагатай харьцуулан судалсан. Судалгааны үр дүнд үндэслэн цаашид авч хэрэгжүүлэх бодлогын чиглэл, боломжит шийдлүүдийг гаргаж, дээд боловсролын салбарын хөгжлийн замын зураглалын төслийг боловсруулж, ИДС-ийн төлөөллийг оролцуулан хэлэлцүүлэг зохион байгуулсан.</p> <p>БСМТ-ний дэд салбарын зорилт, стратегийн төслийг олон нийтээр хэлэлцүүлэх семинарыг 2019 оны 11 сарын 29-нд зохион байгуулав. Энд дээд боловсролын зорилт, стратегийг сайжруулах чиглэлээр оролцогчид санал, зөвлөмж өгсөн. Семинарын санал зөвлөмжид үндэслэн дээд боловсролын дэд салбарын зорилт, стратегийг хэрэгжилтийн төлөвлөгөөний дагуу сайжруулж байна.</p>	
111.	<p>Судалгаанд суурилсан их сургуульд тавигдах шаардлага, шалгуурыг тогтоож, судалгааны үр дүнг үнэлэх тогтолцоог бүрдүүлэн, “Судалгааны их сургууль, “Судалгааны баг”, “Судлаач оюутан”-д тэтгэлэг олгох журмыг боловсруулж батлуулна.</p> <p>/ЗГҮАХ 3.2.18, МУТХҮБ 2.2.3 ТБТББ 3.15, 3.16/</p>	Батлагдсан журам	<p>БСШУС-ын сайдын 2018 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/654 дүгээр тушаалаар дээд боловсролын сургалтын байгууллагын ангиллын журмыг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг байгуулж, судалгааны их сургууль, түүнд тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон. Хуулийн өөрчлөлт батлагдаж, судалгааны их сургуулийн тухай заалт орсны дараа батлагдах боломжтой.</p> <p>“Судалгаанд суурилсан их сургуулийг хөгжүүлэх” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах хүрээнд “Монгол Улсад судалгааны их сургуулийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг АХБ-ны 30,0 сая ам.доллараар санхүүжүүлэх тохиролцоог Засгийн газрын төвшинд хийсэн. Улмаар тус хөтөлбөрийн дизайн, магадлах үнэлгээг хийх зорилгоор Азийн хөгжлийн банкны 800 мянган америк долларын санхүүжилт бүхий “Судалгаанд суурилсан их сургуулиудыг хөгжүүлэх” техникийн туслалцаа ТА-9663 МОН төслийг 2019 оны 6 дугаар сараас эхлүүлээд байна.</p> <p>Тус төслийн эхлэлтийн тайлангийн хэлэлцүүлгийг 2019 оны 9 сарын 30 өдөр зохион байгуулсан. Төслийн ажлын даалгаварт “Судалгааны их сургууль, “Судалгааны баг”, “Судлаач оюутан”-д тэтгэлэг олгох журмыг боловсруулах асуудлыг тус тус тусгасан. Мөн сайдын тушаалаар ажлын хэсэг байгуулагдаж МУИС, ШУТИС, АШУУИС, ХААИС, МУБИС, СУИС, УБИС, ХҮИС гэсэн төрийн өмчийн 8 их сургуулийг нэгтгэн дэлхийн хэмжээний судалгааны их сургууль байгуулах үзэл баримтлалыг боловсруулан Засгийн газрын хурал, НББШУ-ны байнгын хорооны хурлаар хэлэлцүүлээд байна.</p>	100%

112.	Их, дээд сургуулийн дундын нээлттэй эрдэм шинжилгээний лабораторийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлнэ.  /ЗГҮАХ 3.2.18, МУТХҮБ 2.2.3 ТБТББ 3.15, 3.16/	Мэдээллийн сан бий болсон байна.	<p>2019 онд нийт 1,1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 5 багц лабораторийг их, дээд сургуулиудад нийлүүлсэн бөгөөд сургуулиуд болон судлаачид дундын зарчмаар ашиглаж байна. Тухайн төслөөс нийлүүлсэн лабораториудын талаарх мэдээллийг лаборатори тус бүрээр хийгдэж буй судалгааны чиглэл, төсөл, багш, оюутны тоог гарган дээд боловсролын шинэчлэлийн төслийн вэб сайтад <a href="https://www.herp.mn/page list/laboratorui">https://www.herp.mn/page list/laboratorui</a> гэсэн хаягаар байршуулаад байна. Тодруулбал,</p> <ul style="list-style-type: none"> <li>• АШУҮИС-ийн Говь-Алтай аймаг дахь Анагаах Ухааны сургуульд Молекул биологи, иммунологийн лабораторийг 95,0 сая төгрөгийн санхүүжилтээр байгуулсан.</li> <li>• ШУТИС-ийн Дархан-Уул салбар сургуульд Барилгын материал, хүнс, уур уурхай, металлурги гэх мэт олон салбарын судалгаа туршилт хийх сорил, шинжилгээний туршилтын лабораторийг 104,0 сая төгрөгийн санхүүжилтээр байгуулсан.</li> </ul> <p>МУИС-д лазерийн лабораторийг 1,2 сая ам.долларын, мөн компьютер график, мультимедиагийн судалгааны нээлттэй лабораторийг 100,0 сая төгрөгийн, генетекийн инженерчлэлийн лабораторийг 189,0 сая төгрөгийн санхүүжилтээр тус тус байгуулсан.</p>	100%
<b>Хоёр. “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн 11.5 дахь зорилт, Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд:</b>				
113.	2.1 Багшийн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр боловсруулж, Багшийн хөгжлийн төвд тавигдах шаардлага, ажиллах үлгэрчилсэн журмыг боловсруулж, үйл ажиллагааг нь дэмжинэ.*** /БХДТТ 6.2/	Батлагдсан журам	<p>Монгол Улсын Засгийн газрын 145-р тогтоолд заасны дагуу БСШУС-ын сайдын 2019 оны А/235, А/754 дүгээр тушаалуудаар ажлын хэсэг байгуулж, тус багшийн хөгжлийн төвд тавигдах шаардлага, ажиллах үлгэрчилсэн дүрмийг боловсруулах 5 дэд ажлын хэсгийг байгуулан ажилласан.</p> <p>Тус ажлын хэсгийн гишүүдийг чадавхжуулах, туршлага судлуулах зорилгоор Хонконгийн их сургуулийн зуны сургалтад хамруулсан. Багшийн хөгжлийг дэмжих төвийг байнгын тогтмол үйл ажиллагаатай байлгах үүднээс тус төвд ажиллах багийг нээлттэй зарлан сонгон шалгаруулсан. Ийнхүү Монгол Улсын хэмжээнд дээд боловсролын Багшийн хөгжлийг дэмжих төвтэй болсноор нэгдсэн нэг системтэй, удирдлага зохион байгуулалтаар хангах, багшийн стандарт боловсруулах, багшийн үнэлгээний тогтолцоог бүрдүүлэх, багшлахуй, суралцахуйд идэвхтэй сургалтын аргыг нэвтрүүлэх, сургалтад инноваци,</p>	100%

			технологи нэвтрүүлэх, судлаач багшийг хөгжүүлэх нөхцөл бүрдэнэ. Дээд боловсролын сургалтын 94 байгууллагаас бие даасан Багшийн хөгжлийн төвтэй 54 байгууллага байгаа ба 18 байгууллага нь хариуцсан мэргэжилтэнтэй ажиллаж байна.	
<b>Гурав. “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого”-ын зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд:</b>				
114.	3.1 Иргэдийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагын мэргэшлийн түвшин бүрд хүрэх үр дүнг тогтоосон “Үндэсний мэргэшлийн хүрээ”-г боловсруулж батлуулна. *** /МУ-ын ЗГ-ын 2018 оны 399/	Батлагдсан баримт, бичиг.	Үндэсний мэргэшлийн хүрээг боловсруулах ажлын хэсгийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтран байгуулан, 10 түвшинтэй загвар гаргасан. Нарийвчилсан судалгааг хийж, батлуулах баримт бичгийн агуулга, хэллэг, нэр томъёог цэгцэлж дууссан. Үндэсний мэргэшлийн хүрээний хувилбарыг 20 гаруй их, дээд сургуулийн багш, удирдах ажилтан, эрдэмтэн судлаачдад /700 гаруй хүн/ танилцуулан, хэлэлцүүлж саналыг тусгаад байна. БСШУС-ын яамнаас гаргасан (8, 10 түвшин) эцсийн хувилбар дээр ХНХЯ-тай тохирч бусад яамдаас санал авах ажил үлдсэн.	100%
<b>Дөрөв. “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд:</b>				
115.	4.1 Үр дүнд суурилсан боловсролын арга зүйн дагуу дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн боловсруулалтанд хяналт үнэлгээ хийж, арга зүйн дэмжлэг үзүүлнэ. /ЗГҮАХ 3.2.18./	Үйл ажиллагааны хэрэгжилт	Үр дүнд суурилсан боловсролын бодлогын 4.1.6-д заасны дагуу дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн боловсруулалтад үнэлгээ хийж, санал, дүгнэлт боловсруулах ажлын хэсгийг БСШУС-ын сайдын 2019 оны 6 сарын 19-ний өдрийн А/405 дугаар тушаалаар байгуулан 60 гаруй их, дээд сургуулийн 536 бакалаврын хөтөлбөрт үнэлгээ хийж, чиглэл, зөвлөмжийг холбогдох их, дээд сургуулиудад өгсөн. Хөтөлбөрийн хэрэгжилтийн чанарыг сайжруулах ажлыг үргэлжлүүлэн хийж төгсөгчдийн мэдлэг, чадварыг ажил олгогчдын эрэлтэд нийцүүлнэ. Сэтгэ-Зохио-Бүтээ-Хэрэглэ (CDIO: Conceive-Design-Implement-Operate) арга зүйгээр технологийн хөгжлийн эрин зуунд мэргэжлийн өндөр ур чадвартай, нийгмийн хариуцлагатай, бүтээлч сэтгэлгээтэй инженерийг бэлтгэдэг. CDIO арга зүйг нэвтрүүлснээр сургалтын хөтөлбөрийн агуулга, заах арга, үнэлгээ сайжирч олон улсын инженерийн боловсролын түвшинд ойртож, төгсч буй оюутны чадамж ажлын байрны хэрэгцээтэй нийцэх болно. Ажлын хэсгийн 9 багийн тайланд хөтөлбөрийн ерөнхий 10 чиглэлээр дүн шинжилгээ хийн гарсан үр дүнг 2019 оны 12 сарын 05-ны өдөр зохион байгуулсан “CDIO-2019” эрдэм шинжилгээний хурлаар хэлэлцүүлсэн.	100%

116.	4.2 Бакалаврын сургалтын зарим хөтөлбөрт хөндлөнгийн үнэлгээ хийж, сургалтын чанарыг тодорхойлно. /ЗГҮАХ 3.2.18./	Үнэлгээ хийгдсэн хөтөлбөр.	<p>Дээд боловсролын хөтөлбөрийн чанарыг хөндлөнгөөс үнэлэх үйл ажиллагааны хүрээнд Боловсролын үнэлгээний төвөөр дамжуулан 2019 оны 2 сард “Багш-сургуулийн өмнөх боловсрол”, “Багш-бага боловсрол” хөтөлбөр хэрэгжүүлж буй 26 сургуулийн 9583 оюутан, 4 сард “Эрх зүй, Бизнесийн удирдлага”, “Нягтлан бодох”, “Маркетинг”, “Менежмент, Санхүү, Даатгал” хөтөлбөр хэрэгжүүлж буй 53 сургуулийн 21424 оюутан, 5 сард “Анагаах ухаан”, “Нүүр ам судлал”, “Уламжлалт анагаах ухаан”, “Эм зүй”, “Сувилахуй”, “Эх барихуй” хөтөлбөр хэрэгжүүлж буй 13 сургуулийн 3086 оюутан, нийт 34093 оюутныг хөндлөнгийн шалгалт, судалгаанд хамрууллаа. Дээрх шалгалт, судалгаанд 2, 3 дугаар курст суралцаж буй оюутнууд хамрагдсан.</p> <p>Ийнхүү дээд боловсролын чанарын “Хөндлөнгийн үнэлгээ”-г анх удаа зохион байгуулсан бөгөөд сургуулиудын чанарыг сайжруулах эхний алхам болсон.</p>	100%
117.	4.3 Дээд боловсролын сургалтын байгууллагуудын дотоод чанарын баталгаажуулалтын тогтолцоог бүрдүүлнэ. /ЗГҮАХ 3.2.18./	Үйл ажиллагааны хэрэгжилт.	<p>Дээд боловсролын чанарыг хөндлөнгөөс шалгаж баталгаажуулахаас гадна сургуулийн дотоодод чанараа хянах үйл ажиллагааг сайжруулах ажлыг хийж байна. Дотоод чанарын баталгаажуулалтын ажлыг идэвхжүүлэх, хариуцсан нэгж байгуулан ажиллах чиглэлийг өгч ажилласан.</p> <p>Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл (БМИҮЗ)-өөс гарын авлага хэвлүүлэн, сургуулиудад сургалт хийж, заавар зөвлөмж өгсний дагуу томоохон их сургуулиуд чанарын дотоод баталгаажуулалтын бүтцийн нэгжтэй болсон, зарим сургууль хариуцсан мэргэжилтэн томилж ажиллуулан чанараа хянаж хэвшээд байна.</p> <p>БМИҮЗ-өөс сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор их, дээд сургуулиудын чанарын дотоод баталгаажуулалт хариуцсан багш, мэргэжилтнүүдийн дунд 2019 оны 11 сард туршлага солилцох, чанарын дотоод баталгаажуулалтын сайн туршлагыг сонсох, түгээн дэлгэрүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулж нийт 64 сургууль оролцлоо.</p> <p>Сургуулиудын туршлагаас харахад дээд боловсролын сургалтын байгууллагуудад чанарын соёл тогтож, МУИС-ийн захиргаа, номын сан, ШУТИС-ийн Механик тээврийн сургууль, Эрдэнэтийн технологийн дээд сургууль, Отгонтэнгэр их сургууль, Мандах их сургууль ISO9001:2015 стандартыг нэвтрүүлж гэрчилгээ аваад байна.</p>	100%

			Олон улсын дээд боловсролын чанарын баталгаажуулалтын тогтолцоог БМИҮЗ-ийн шинжээч нарт таниулах зорилго бүхий 2 удаагийн сургалтыг зохион байгуулж 300 гаруй хүн хамрагдсан.	
118.	4.4 Орон нутгийн дээд боловсролын сургалтын байгууллага, элсэгчид суралцагчдын хөгжлийг дэмжих санал боловсруулна	Үйл ажиллагааны хэрэгжилт.	<p>МУБИС-ийн зайн сургалтын төвийн удирдлага дор МУБИС-ийн Архангайн багшийн сургууль, МУИС-ийн Завхан сургууль, Ховд, Дорнод их сургуулийн багш, оюутнуудад онлайн курс төлөвлөлтийн ахисан түвшний сургагч багш бэлтгэх, онлайн курс төлөвлөлт, үр дүнд суурилсан боловсролын үзэл баримтлал, орон нутгийн багш нарын цахим сургалт, тогтвортой хөгжлийн зарчимд суурилсан STEAM боловсрол, хичээлийн үнэлгээний арга зүй гэх мэт сургалтуудыг зохион байгуулсан.</p> <p>Орон нутгийн ИДС-ын сургалт, эрдэм шинжилгээний орчинг сайжруулах хүрээнд бодлогын дэмжлэг үзүүлж, хөрөнгө оруулалтуудыг үе шаттай шийдвэрлэсэн, “Оюутны хөгжлийн зээл”-д хамрагдах оюутны тоог орон нутгийн их, дээд сургуулиудад өндөр тогтоож өгсөн, орон нутгийн их, дээд сургуулиудын боловсон хүчнийг чадавхжуулах, мэргэжил дээшлүүлэхэд анхаарч ажилласан, төвийн, тэргүүлэх их, дээд сургуулиудтай хамтын ажиллагааны эхлэлийг тавихад дэмжлэг үзүүлэн “СДИО-ийн арга зүйн сургалт”, “Дээд боловсролын сургалтын технологи” сэдэвт сургалтууд зохион байгуулан туршлага судлуулсан.</p> <p>Орон нутгийн ИДС-д элсэгчдийн сургалтын төлбөрийн 50 хувь, сувилагч мэргэжлээр элсэгчдийг төрөөс бүрэн даах, урамшууллын тэтгэлэг олгох асуудлыг боловсруулж, 2019 оны 8 сард ЗГ-аар хэлэлцүүлсэн боловч шийдээгүй тул цаашдын хөгжлийн бодлогын төсөлд тусган ажиллаж байна. АШУҮИС-ийн 6 хөтөлбөр, ХААИС-ийн селекци, үрийн аж ахуйн агрономи хөтөлбөрийг хөдөө орон нутгийн сургуульд шилжүүлсэн.</p>	100%
119.	4.5 Боловсролын зээлийн сангийн үйл ажиллагаанд үнэлгээ хийж, үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ. /ЗГҮАХ 3.2.20/	Бодлого, шийдвэр	<p>БСШУС-ын сайдын 2019 оны 3 сарын 11-ний өдрийн А/124 дүгээр тушаалаар баталсан ажлын хэсэг Боловсролын зээлийн сангийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, салбарын бодлого шийдвэрийн хэрэгжилттэй танилцаж, зөвлөмж өгсөн.</p> <p>Тус ажлын хэсгийн дүгнэлт, зөвлөмжид үндэслэн "Суралцагчийн сургалтын төлбөр, амьжиргааны зардалд зориулан олгох хөнгөлөлттэй, эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлийн улсын төсвийн оролцоотой эх үүсвэрийг бүрдүүлэх, эргэн төлүүлэх, сургалтын зээлийг хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох" журмыг батлах тухай УИХ-ын тогтоолын</p>	100%

			төсөл боловсруулан яамдын саналыг 2 удаа авсан. УИХ-ын тогтоолын үзэл баримтлалын төсөл, судалгааны тайлан, журмын төслийг ХЗДХЯ, СЯ руу 12 дугаар сард явуулаад байна. Мөн 2019 оны 05 сарын 9-ний Оюутны хөгжлийн зээл олгох хяналтын тоог БСШУС-ын сайд, Сангийн сайдын хамтарсан тушаалаар батлуулан 11000 оюутан суралцагчдад 33 тэрбум төгрөгийн зээл олгохоор батлуулан хэрэгжүүлж байна. БМИҮЗ-ийн 1,6 тэрбум төгрөгийн зээлийн квотыг нэмэгдүүлэх хамтарсан тушаалын төслийг Сангийн яаманд 12 сард хүргүүлээд байна. Боловсролын зээлийн санд сургалтын чиглэлээр үүссэн авлагын нөхцөл байдлын судалж, нягтлан бодох бүртгэлийн талаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, санал гаргах ажлын хэсэг гарган, ажиллаж, сургалтын дүрэм журмыг боловсруулж байна.	
120.	4.6 Элсэлтийн ерөнхий шалгалтын үйл ажиллагааг цахим технологид шилжүүлнэ. /ЗГҮАХ	Шалгалтын дүн, мэдээ.	Элсэлтийн ерөнхий шалгалтын дүнг засах үйл ажиллагааг ил тод, шуурхай болгосон, иргэдийн цаг хугацаа, зардал хэмнэсэн шилэн технологийг нэвтрүүллээ. Мөн энэ жилээс эхлэн элсэлтийн ерөнхий шалгалтад бүртгүүлэгч өөрийн регистрийн дугаараа хийхэд Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгэлтэй мэдээлэл гарч ирэх болсон. Ингэснээр шалгуулагчийн хувийн мэдээлэл алдаагүй байх, хувийн мэдээлэл үнэн зөв бичигдэх, их, дээд сургуульд элсэхэд асуудал гарахгүй байх давуу талтай болсон. 2019-2020 оны хичээлийн жилд элсэлтийн ерөнхий шалгалтыг 6 сарын 17-20-ны өдрүүдэд 14310 элсэгчдээс авлаа. ЭЕШ-д хөгжлийн бэрхшээлтэй суралцагч орох үйл ажиллагааг дэмжин 10 ширхэг компьютер, 10 ширхэг чихэвч, брайль хэвлэгч машин бүхий анги танхимыг зохион байгуулсан. Ингэснээр сонсголын бэрхшээлтэй шалгуулагчдад дохионы хянагч багш, харааны бэрхшээлтэй элсэгчдэд зориулан баррель үсгээр шалгалтын материал бэлтгэх, саажилттай шалгуулагчийг тусгай ангид шалгалт аван, зөөврийн компьютер, бусад шаардлагатай техник төхөөрөмжөөр ханган, сэдэв даалгаврын гүйцэтгэх хугацааг бүх хичээлийн хувьд уртасган шалгалтыг зохион байгуулах зэрэг арга хэмжээг авч ажилласан.	100%
121.	4.7 Дээд боловсролын удирдлагын мэдээллийн системийг хөгжүүлж, нэвтрүүлэх	Программ хангамж нэвтэрсэн байна.	Дээд боловсролын удирдлага мэдээллийн системийг хөгжүүлэх төслийг амжилттай зохион байгуулснаар их дээд сургуульд элсэгчдийн болон дээд боловсролын сургалтын байгууллагын статистик мэдээллийн санг хөгжүүлэх ажил олон улсын жишигт хүрэхүйц болж өөрчлөгдсөн.	100%

	ажлыг дуусгана. /ЗГҮАХ 3.2.18/		Энэ ажлын хүрээнд дээд боловсролын сургалтын байгууллага, багш, ажилтан ажилчид болон оюутнуудын цогц мэдээлэл болон сургалтын хөтөлбөр, төгсөгчдийн мэдээлэл, хөдөлмөр эрхлэлтийг тодорхойлох бүрэн боломж бүрдсэн. Мөн дээд боловсролын удирдлага мэдээллийн системийг нэгдсэн зохион байгуулалтаар хангах ажлын хүрээнд систем боловсруулалтын багийн зүгээс их дээд сургуулийн систем хариуцсан мэргэжилтнүүдэд олон удаагийн үе шаттай сургалтыг зохион байгуулж, ажилласан. Ийнхүү дээд боловсролын сургалтын байгууллагуудын үйл ажиллагаа элсэлт, төгсөлт, шилжилт хөдөлгөөний байдал, диплом олголт, бүртгэл мэдээллийн нэгдсэн нэг системд орж салбарын мэдээлэл иргэд олон нийтэд нээлттэй болох нөхцөл бүрдээд байна.	
122.	4.8 Дээд боловсролын сургалтын байгууллагын ангиллын журмыг шинэчилж, дээд боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаа, тавигдах нийтлэг шаардлага, тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагын хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийх ажлыг зохион байгуулна. /ЗГҮАХ 3.2.18/	БСШУС-ын сайдын тушаал.	БСШУС-ын сайдын 2018 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/654 дүгээр тушаалаар дээд боловсролын сургалтын байгууллагын ангиллын журам шинэчлэх ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсэг тус журмын төсөл, ангиллын шалгуурын хувилбарыг боловсруулж, тэдгээрийг турших судалгааг төрийн ба төрийн бус өмчийн 20 их дээд сургууль, коллежийг хамруулан зохион байгуулсан. Судалгааны үр дүнг дээд боловсролын сургалтын байгууллага болон мэргэжлийн байгууллагын төлөөлөл 2019 оны 2 сарын 28-ны өдөр, салбарын тэргүүлэх эрдэмтдэд 2019 оны 3 сарын 05-ны өдөр тус тус хэлэлцүүлэг зохион байгуулж, танилцуулсан. Улмаар сайжруулсан ангиллын шалгуурыг турших судалгааг 2019 оны 6 сарын 24-27-ны өдрүүдэд Орхон аймаг дахь ШУТИС, МУИС, Дархан-Уул аймаг дахь МУИС, ХААИС-д хийж, дүнг танилцуулсан. Мөн БСШУС-ын сайдын 2019 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/53 дугаар тушаалаар 16 сургуулийн үйл ажиллагаа, ангилалд тавигдах нийтлэг шаардлага, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын хэрэгжилттэй танилцан, хяналт үнэлгээ хийж, гарсан дүгнэлт гаргах ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсгийн дүгнэлтэд үндэслэн 5 их, дээд сургуулийг татан буулгаж, төрийн бус өмчийн 6 сургуулийн 23 хөтөлбөрөөр сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон. Мөн Сутай дээд сургуулийг Эм ай ю дээд сургуультай, Улаанбаатар эрдэм судлал дээд сургуулийг Үндэсний техникийн их сургуультай нэгтгэх ажлыг зохион байгуулсан.	100%



123.	4.9 Их дээд сургуулийг хотхоноор хөгжүүлэх асуудлыг судлан, ажлыг эрчимжүүлнэ.	Хэрэгжилтийн явцаар	<p>БСШУС-ын сайдын 2019 оны А/73 тоот тушаалаар ажлын хэсэг байгуулагдан шинэчилсэн судалгаа хийж, орон нутагт их сургуулиудын хотхоныг төлөвлөсөн байдал, ажлын явцын талаар Засгийн газарт хүргүүлэх санал боловсруулан, танилцуулга бэлтгэн хүргүүлсэн. Түүнчлэн их сургуулиудын хотхоны бүтээн байгуулалтын танилцуулгыг бэлтгэж, Монгол Улсын Ерөнхийлөгчид танилцуулсан.</p> <p>Монгол германы хамтарсан ашигт малтмал технологийн их сургуулийн өргөтгөл барих ХБНГУ-ын 7 сая еврогийн Зээлийн гэрээг 2019 оны 6 дугаар сард УИХ-аар соёрхон батлуулсан. Ингэснээр Монгол германы хамтарсан ашигт малтмал технологийн их сургуулийн 504 оюутны хүчин чадалтай дотуур байрны барилгын ажил хийгдэнэ.</p> <p>Япон Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний их сургуулийн эмнэлгийг байгуулан ашиглалтад орууллаа. Тус эмнэлэг нь 104 ортой, дэвшилтэт технологи, өндөр түвшний эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлнэ.</p> <p>Дорнод аймаг дахь их сургуулийн хотхоны ТЭЗҮ-г 400,0 сая төгрөгөөр хийгдэж байна.</p>	100%
124.	4.10 “Орлоготой оюутан” хөтөлбөрийн хүрээнд оюутны хөдөлмөр эрхлэлт, бүтээлч санаачлагыг дэмжих тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлж, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, ажлын байранд зуучлах талаар оюутны байгууллага, ажил олгогчидтой хамтран ажиллана. /ЗГҮАХ 3.2.26/	Хөтөлбөрт хамрагдсан оюутны тоо	<p>Орлоготой оюутан хөтөлбөрийн хүрээнд оюутны санаачилгын тэтгэлэгт төслийг 2019 онд 2 удаа зохион байгуулж 1-р ээлжид 38 төслийг 254 гаруй сая төгрөг, 2 -р ээлжийн 19 төслийн 97 оюутанд 132 сая төгрөгийн тэтгэлэг олгогдсон.</p> <p>Оюутны санаачилгын тэтгэлэгт төслийг сонгон шалгаруулахад тухайн сургуулийн тохижилт, орчин сайжруулах, материаллаг төслүүдээс илүү нийгэм, олон нийтэд чиглэсэн шинэ санаа инноваци болохуйц бусдад үр өгөөжөө өгөх төслүүд шалгарсан болно. Мөн орлоготой оюутныг дэмжих хүрээнд байгууллага, оюутны хооронд ажил гүйцэтгэх гэрээг байгуулж дадлага ажлыг хууль эрх зүйн чиглэлээр 14 оюутан, барилгын инженер хөтөлбөрөөр суралцаж буй 3 оюутан, менежментийн чиглэлээр суралцаж буй төгсөх ангийн 4 оюутныг цагийн ажил эрхлэх боломжийг ханган, оюутны мэргэшлийн ур чадварыг нь нэмэгдүүлэх, орлогын эх үүсвэртэй болох боломж бүрдүүлэн БСШУС-ын сайдын 2019 оны 08 сарын 01-ний өдрийн А/486 тушаалаар 48,9 сая гаруй төгрөгөөр санхүүжүүлэн дэмжин ажилласан.</p> <p>2019 оны байдлаар 20 мянга гаруй оюутан цагийн болон үндсэн ажлын байртай болон ажиллаж байгаа нь үйлчилгээний байгууллагууд оюутан, суралцагчтай хамтран ажиллах, ажлын байрны эрэлт хэрэгцээ,</p>	100%

			шаардлага жилээс жилд өсөн нэмэгдэж байгаа ба ажил гүйцэтгэх гэрээг тухайн байгууллага оюутан болон сургуультай нь хамтран байгуулж тодорхой хэмжээний орлого бүрдүүлэхүйц ажлын байраар хангасан байна.	
<b>ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН БОДЛОГЫН ГАЗАР. ИННОВАЦИЙН ХЭЛТЭС</b>				
Засгийн газрын 2017 оны 267 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт: 2.2.4. Шинжлэх ухаан, технологи, инновацийн хөгжлийн бодлого, судалгааны боловсруулалтын ажлын нийгэм, эдийн засгийн үр нөлөөг дээшлүүлж, улс орны хөгжил, нийгмийн сайн сайханд чиглүүлэх				
Нэг. Шинжлэх ухаан, технологи, инновацийн хөгжлийн бодлогын шинжилгээ хийх, хууль тогтоомжийн төсөл, бодлого, хөтөлбөр, журмын хувилбар боловсруулах				
125.	1.1 Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.*** /ШУТ-ийн тухай хуулийн 8.1.1, 8,1.2, Монгол Улсын ШУТ-ийн тухай хуулийн 11.14, ЗГҮАХХАХТ-ний 3.2.29/	Эрх зүйн баримт бичиг /батлагдсан ШУТ-ийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт/	Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу боловсруулж, яамдаас санал авч нэгтгэн, Засгийн газрын 2019 оны 2 сарын 20-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. Засгийн газрын энэхүү хуралдаанаас гаргасан 8 дугаар тэмдэглэлийг хэрэгжүүлэх зорилгоор Хууль зүй, дотоод хэргийн яамнаас хууль тогтоомжийн хуульд заасны дагуу УИХ-д өргөн мэдүүлэх зөвшөөрлийг авч, Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн. Энэхүү хуулийн төслийг 2019 оны 4 сарын 24 өдрийн УИХ-ын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны хурал, 4 сарын 25-ны өдрийн УИХ-ын нэгдсэн чуулганаар тус тус хэлэлцэж, Улсын Их Хурлын намрын чуулганаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн. Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр нарын санаачилсан Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамтатган хэлэлцэхээр хүлээгдэж байна.	100%
126.	1.2 Шинжлэх ухааны паркийн тухай хуулийн төсөл боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн, Улсын Их Хурал Инновацийн тухай хуулийн 6.1.1,	Шинжлэх ухааны паркийн тухай хууль	Хууль тогтоомжийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3-т заасны дагуу БСШУС-ын сайд, ХЗДХ-ийн сайдын хамтарсан шийдвэрээр "Шинжлэх ухааны паркийн эрх зүйн байдлын тухай хууль"-ийн үзэл баримтлалыг 2019 оны 10 сарын 18-ний өдөр батлуулсан. Уг үзэл баримтлалд үндэслэн Шинжлэх ухааны паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг боловсруулж, ШУА, эрдэм шинжилгээний хүрээлэн, төрийн өмчийн 6 их сургууль, МҮХАҮТ /аж ахуйн нэгжээс нэгтгэн ирүүлэх/, ГЕГ, ТЕГ, ӨОГ, НШУҮИГ-аас санал авахаар хүргүүлсэн. Мөн яамны вэб-д	100%

	ЗГҮАХХАХТ-ний 3.2.29 өргөн мэдүүлнэ.		байршуулж, иргэд, олон нийт, мэргэжлийн судлаачдаас онлайнаар санал авах ажлыг 2019 оны 10 сарын 24-өөс 11 сарын 24-ний өдрийг дуусталх хугацаанд нээлттэй зохион байгууллаа. Хуулийн төсөлд 12 яамнаас санал авч байна. 2020 онд Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх зөвшөөрлийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 15.3-т заасны дагуу авч хэлэлцүүлэх, УИХ-д өргөн мэдүүлэх ажлыг зохион байгуулна.	
127.	1.3 Төрөөс инновацийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, батлуулна. /Инновацийн тухай хуулийн 6.1.1, 7.1.2/	БСШУС-ын сайдын тушаал	Төрөөс инновацийн талаар баримтлах бодлогын 6 дугаар хавсралтад үндэслэн 4 зорилт, зорилтыг хэрэгжүүлэх 25 үйл ажиллагааны хүрээнд бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төслийг боловсруулж, БСШУС-ын сайдын 2019 оны "Төрөөс инновацийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай" А/145 дугаар тушаалаар батлуулсан.	100%
128.	1.4 Инновацийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулна.*** /Инновацийн тухай хуулийн 6.1.2, 7.1.2, ЗГҮАХХАХТ-ний 3.2.29/	Инновацийн тэргүүлэх чиглэл тодорхой болж, эдийн засгийн төрөлжилт бий болгох, хөрөнгө нөөц төвлөрүүлэх боломжийг бүрдүүлэх эрх зүйн зохицуулалт бүхий баталгаажсан баримт бичиг	Инновацийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох нөхцөл байдлын судалгааг ШУТИС-ийн <b>БАТС-ийн</b> профессорын багаар хийлгэсэн. Инновацийн тухай хуулийн 7.1.2, Засгийн газрын 2018 оны "Инновацийн тэргүүлэх чиглэл тодорхойлох журам батлах тухай" 353 дугаар тогтоолыг тус тус үндэслэн "Инновацийн үйл ажиллагааны (2019-2023 он) тэргүүлэх чиглэл"-ийг ШУА, төрийн өмчийн их дээд сургууль, мэргэжлийн эрдэмтэн судлаачид, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн саналд тулгуурлан боловсруулж, Шинжлэх ухаан, технологийн үндэсний зөвлөл, 12 яамдаас саналыг авч тусган Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр БСШУС-ын сайдын 2019 оны 9 сарын 24 өдрийн 1а/8449 албан тоотой хүргүүлсэн. Засгийн газрын 2019 оны 10 сарын 02-ны өдрийн хуралдаанд хэлэлцүүлж, ЗГ-ын хуралдааны 42 дугаар тэмдэглэлд "Инновацийн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг батлагдсаны дараа хэлэлцэхээр тогтов" гэжээ.	100%

129.	1.5 “Үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөр-II”-ийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ. /Инновацийн тухай хуулийн 6.1.4, 7.1.2, ЗГҮАХХАХТ-ний 3.2.30/	Үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөр-II /Инновацийг хөгжүүлэх суурь тавигдах нөхцөл бүхий эрх зүйн зохицуулалт тодорхой болно./	“Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль, түүнд баримтлах нийтлэг журам”-ын дагуу ШУТИС-ийн профессорын багаар нөхцөл байдлын судалгааг хийлгэж, журмын 52-т заасны дагуу хөтөлбөрийн төслийг боловсруулсан. Үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөр-II-ийн төслийг холбогдох хавсралтуудын хамт боловсруулан мэргэжлийн байгууллага, эрдэмтэн судлаачид, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, холбогдох мэргэжлийн агентлагаас санал авч төсөлд тусгасан. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 20.3-т заасны дагуу 12 яамдаас санал авч, холбогдох зөвшөөрлийг үндэслэн Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлж, батлууллаа.	100%
130.	1.6 “Эрдэм шинжилгээний байгууллагын судалгааны үндсэн чиглэлийг санхүүжүүлэх журам”-ыг боловсруулж батлуулна. /ШУТ-ийн тухай хуулийн 16.4 дугаар зүйл/	Журам	“Зардлын хуваарилалт батлах тухай” БСШУС-ын сайдын 2019 оны 210 дугаар тушаалаар Монгол улсад хийгдэж байгаа судалгаа боловсруулалтын ажлын өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийлгэх, эрдэм шинжилгээний байгууллагын судалгааны үндсэн чиглэлд тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлтийг тодорхойлох, үндсэн чиглэлийг санхүүжүүлэх аргачлалыг боловсруулах ажлын зардлыг баталж, үйл ажиллагааг нь эхлүүлсэн. Эрдэм шинжилгээний байгууллагын судалгааны үндсэн чиглэлийг санхүүжүүлэх журмын төслийн эхний хувилбарыг боловсруулж, БСШУС-ын яамны веб сайтад байршуулан санал авч журмын төсөлд тусгаад байна. Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар энэхүү журмын төслийг Засгийн газраар батлуулан мөрдүүлэх хууль, эрх зүйн орчин бүрдэнэ.	100%
131.	1.7 Шинжлэх ухааны салбарын дундын нээлттэй лабораторийн үйл ажиллагааг зохицуулах журам батлуулна.*** /ШУТ-ийн тухай хуулийн 8.1.1, Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар	Журам	“Шинжлэх ухааны салбарын дундын ашиглалтай нээлттэй лаборатори”-ийн үйл ажиллагааг зохицуулах журмын төсөлд Азийн хөгжлийн банк, БСШУС-ын яам, Финляндын Нирас зөвлөх компани хамтран хэрэгжүүлж буй “Монгол Улсын Шинжлэх ухаан, технологи, инновацийн бодлогын болон эрх зүйн орчныг бэхжүүлэх” төслийн багийн саналыг тус журмын төсөлд тусгаж дахин боловсруулсан. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж байгаа “Дээд боловсролын шинэчлэлийн төсөл”-ийн хүрээнд хийгдэж байгаа “Лабораторийн судалгаа хөгжлийн зөвлөх” 18/09, “Лабораторийн магадлан итгэмжлэлийн зөвлөх” 18/10 зөвлөх үйлчилгээний судалгааны тайланг хүлээн авч, саналыг журмын төсөлд нэмж тусгасан.	70%

	баримтлах бодлогын 4.5.5/		УИХ-аар хэлэлцүүлэгдэж буй Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар журмыг батлах эрх зүйн орчин бүрдэнэ. Хуулийн төсөлд Захиргааны хуульд нийцүүлэн санал тусгагдсан бөгөөд журмыг сайдаар батлуулан, Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж улсын бүртгэлд бүртгүүлж ажиллах юм.	
132.	1.8 Шинжлэх ухааны оны шилдэг бүтээл шалгаруулах журамд нэмэлт өөрчлөлт оруулж батлуулна.  /ШУТ-ийн хуулийн 6.1.5, 8.1.14/	Журмын нэмэлт, өөрчлөлт	БСШУС-ын сайдын 2010 оны 11 сарын 1 өдрийн 479 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Шинжлэх ухааны оны шилдэг бүтээл сонгон шалгаруулах журам”-д нэмэлт өөрчлөлт оруулан, шат шатны хурлаар хэлэлцүүлж эрдэмтэн судлаачид болон мэргэжилтнүүдийн саналыг тусган эцэслэн боловсруулсан. Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл Улсын их хурлаар хэлэлцүүлэгдэж байна. Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн одоо боловсруулж буй “Шинжлэх ухаан, технологийн тухай” хуулинд дээрх журмыг батлах эрхийг сайдад тусгайлан олгосны дараа сайд баталж, Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэн улсын бүртгэлд бүртгүүлнэ.	70%
133.	1.9 Шинжлэх ухаан, технологийн үндэсний зөвлөлийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулж, Засгийн газраар хэлэлцүүлнэ. /Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 7.3, Засгийн газрын 2007 оны 146 дугаар тогтоол/	ШУТҮЗ-ийн дүрэмд тусгагдсан нэмэлт өөрчлөлт бүхий зохицуулалтын баталгаажсан эрх зүйн баримт бичиг	“Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын 2018 оны 289 дүгээр тогтоол батлагдсантай холбогдуулан Шинжлэх ухааны технологийн үндэсний зөвлөлийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай болсон. Иймд “Дүрэмд өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан Засгийн газрын 2019 оны 4 сарын 10-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, 140 дүгээр тогтоолоор баталгаажуулсан.	100%
134.	1.10 Засгийн газрын “Шинжлэх ухааны байгууллагын талаар авах зарим арга хэмжээний тухай” 2015 оны 27, 78 дугаар тогтоолд нэмэлт,	ШУТ-ийн салбарын байгууллагын бүтэц тодорхой болж, ЗГ-ын тогтоол гарсан байна.	Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 3 сарын 21 өдрийн хуралдааны 11 дүгээр тэмдэглэлээр “шинжлэх ухаан, технологийн салбарын бодлого, төлөвлөлт, удирдлага, менежмент, санхүүгийн тогтолцоог боловсронгуй болгох, шинжлэх ухааны байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг сайжруулах талаар судалж, холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах санал боловсруулах” үүргийг БСШУС-ын сайдад өгсөн. Дээрх тэмдэглэлийг хэрэгжүүлэх зорилгоор “Шинжлэх	100%

	өөрчлөлт оруулах талаар санал боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ.		ухаан, технологийн салбарт авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн 2019 оны 8 сарын 14-ний өдрийн 328 дугаар тогтоолоор баталгаажуулсан. Тус тогтоолоор Засгийн газрын “Шинжлэх ухааны байгууллагын талаар авах зарим арга хэмжээний тухай” 2015 оны 27 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтыг шинэчлэн баталсан бөгөөд ШУА-ийн харьяа 3 хүрээлэнг 6 болгон зохион байгуулж, 1 хүрээлэн шинээр байгуулсан.	
135.	1.11 Шинжлэх ухаан, технологи, инновацийн хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө батлуулан, хэрэгжилтийг хангана.*** /ШУТ-ийн тухай хуулийн 8.1.9, ЗГҮАХХАТ-ний 3.2.35, МУ-ын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл 13.1/	БСШУС-ын сайдын тушаал	“Шинжлэх ухаан, технологи, инновацийн хүний нөөцийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг Засгийн газрын 2019 оны 4 сарын 23-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж, Засгийн газрын “Үндэсний хөтөлбөр батлах тухай” 162 дугаар тогтоолоор батлав. Хөтөлбөрийг 5 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг боловсруулсан. Тус төлөвлөгөөний төсөлд санал авахаар эрдэм шинжилгээний байгууллага, их сургуулиудаас санал авахаар хүргүүлээд байна. 2019 онд хөтөлбөрийг хэрэгжүүлэх төсвийн санхүүжилт батлагдаагүй тул 2020 оны МУЭЗНХҮЧ болон 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэлд үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад улсын төсвөөс зарцуулах төсвийн саналыг тусган оруулсан боловч УИХ-аар баталсан 2020 оны Төсвийн тухай хуульд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хөрөнгө батлаагүй болно. -Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн ивээл дор зохион байгуулсан Шинжлэх ухааны ажилтны улсын анхдугаар их хуралд “Шинжлэх ухаан, технологи, инновацийн хүний нөөцийн хөгжил” салбар хуралдаан зохион байгуулж түүнээс гарсан зөвлөмжийг үндэслэн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулсан. “Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай” БСШУС-ын сайдын 2019 оны 12 сарын 18-ны өдрийн тушаалаар баталлаа.	100%
136.	1.12 Эрдэм шинжилгээний байгууллагуудын орчин нөхцөлийг сайжруулж, их засварын ажлыг хийж гүйцэтгэх /2018 оны ЗГҮАХ 3.6.13/	Их засвар хийх хөрөнгө оруулалтын тооцоо, судалгаанд үндэслэн төсөвт тусган	Шинжлэх ухааны академийн ХХТХ-гийн гадаад талбайн тохижилтод 35 сая төгрөг зарцуулсан. БЗД-т байрлах “Шинжлэх ухааны байгууллагуудын судалгааны лаборатори”-ийн барилгыг 2019 онд багтаан ашиглалтад оруулах талаар барилгын ажил гүйцэтгэгч “Нийслэл өргөө” компанитай тохиролцож, барилгын дотоод заслын ажил хийгдэж байна. Шинжлэх ухааны академийн байрны өргөтгөлийн барилга угсралтын ажил төлөвлөгөөний дагуу явагдаж байна.	100%

		хэрэгжилтийг хангасан байна.	Ургамал хамгааллын хүрээлэн, Палеонтологийн хүрээлэнгийн барилгыг 2020 оноос эхлүүлэхээр саналаа Сангийн яаманд хүргүүлсэн.	
137.	1.13 Гадаадад академик ажил эрхэлж байгаа Монгол эрдэмтдийн мэдээллийн сан бүрдүүлж, тэдгээрийг дотоодын судалгааны ажилд оролцох, хамтарсан төсөл хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх  /2018 оны ЗГҮАХ 3.6.13/	Гадаад дахь Монгол эрдэмтдийн мэдээллийн сан	Засгийн газрын 2019 оны 162 тогтоолоор баталсан “Шинжлэх ухаан, технологи, инновацийн хүний нөөцийг үндэсний хөтөлбөр”-ийн 2.2.3-т заасан зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд гадаадад академик ажил эрхэлж байгаа монгол эрдэмтдийг урьж ажиллуулах, хамтран ажиллах санал, санаачилгыг дэмжих, мэдлэг ур чадвараас нь суралцах асуудлыг тусгасан. Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөлд санал авахаар эрдэм шинжилгээний байгууллага, их сургуулиудад 2019 оны 6 сарын 17 өдрийн 6/0000 дугаартай албан бичиг хүргүүлсэн. БСШУС-ын яамнаас захиалан “Хилийн чанадад нарийн мэргэжлээр сурч, академик ажил эрхэлж байгаа монгол иргэдийн эдийн засаг, нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулах боломжийг бүрдүүлэх” төсөл зарлан гүйцэтгэгчийг сонгон шалгарууллаа. Төслийн хүрээнд дараах ажлууд хийгдэнэ: 1. Хилийн чанадад академик ажил эрхэлж байгаа Монгол эрдэмтэд болон нарийн мэргэжлээр олон улсын нэр хүнд бүхий байгууллагад ажиллаж буй монгол иргэдийн мэдээллийн сан, нээлттэй цахим сүлжээг бий болгох 2. Хилийн чанадад дахь монгол эрдэмтэн, судлаачдыг дотоодын судалгааны ажилд оролцох, монгол дахь эрдэмтэн судлаачидтай хамтарсан төсөл хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээлэл, туршлага солилцох дэд бүтцийг бий болгох 3. Гадаадын шилдэг туршлага, технологийг Монголд нутагшуулахад хамтран ажиллах хөрөнгө оруулагчдын сүлжээг бий болгох, зөвлөх үйлчилгээний тогтолцоог бүрдүүлэх 4. Судалгаа, шинжилгээний ажлын талаар туршлага солилцох, мэдээллээр хангах платформ бий болгох	100%
Хоёр. Шинжлэх ухаан, технологи, инновацийн үйл ажиллагааг бодлогын удирдамжаар ханган хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах				
138.	2.1 Шинжлэх ухаан, технологийн үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны 2019 оны	БСШУС-ын сайдын тушаал	Шинжлэх ухаан, технологийн үндэсний зөвлөл 2019 оны 5 сарын 15 өдөр хуралдаж, Шинжлэх ухаан, технологийн салбарын өнөөгийн байдал, цаашдын зорилт, Шинжлэх ухаан, технологийн сангийн болон Шинжлэх ухаан, технологийн үндэсний зөвлөлийн 2018 оны үйл ажиллагааны	100%

	<p>төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.</p>		<p>тайлан, Шинжлэх ухаан, технологийн үндэсний зөвлөлийн 2019 оны төлөвлөгөө, 2020 оноос эхлэн хэрэгжүүлэх шинжлэх ухаан, технологийн захиалгат төслөөр шийдвэрлүүлэх асуудлуудын саналыг тус тус хэлэлцсэн. Хэлэлцсэн асуудлаар хурлаас зөвлөмж гаргаж, Шинжлэх ухаан, технологийн үндэсний зөвлөлийн 2019 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, 2020 оноос эхлэн хэрэгжүүлэх шинжлэх ухаан, технологийн захиалгат төслөөр шийдвэрлүүлэх асуудлуудын саналыг баталж, Шинжлэх ухаан, технологийн сангаас санхүүжүүлсэн төслүүдийн эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх, олон нийтэд түгээн дэлгэрүүлэх чиглэлээр дорвитой арга хэмжээ авч ажиллахыг холбогдох албан тушаалтнуудад үүрэг даалгавар өгсөн.</p> <p>Шинжлэх ухаан, технологийн сангийн дүрмийг шинэчлэн боловсруулж, Засгийн газрын 2019 оны 50 дугаар тогтоолоор батлуулан мөрдүүлсэн. Засгийн газрын 2019 оны 142 дугаар тогтоолоор Чингис хааны өв, соёлын хүрээлэнг байгуулан ажиллуулсан.</p>	
139.	<p>2.2 Салбарын 2019 оны хөрөнгө оруулалтын арга хэмжээг зохион байгуулж, 2020 оны улсын төсөв, хөрөнгө оруулалтын саналыг боловсруулна.</p>	<p>ШУТИ-ийн 2019-2020 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төсөв, хөрөнгө оруулалтын санхүүжилтийн саналын төсөл</p>	<p>2019 онд тус салбарт багаж, тоног төхөөрөмжийн хангалт хийхэд зориулан улсын төсвөөс хөрөнгө оруулалтын зардал хуваарилагдаагүй. 1.5 тэрбум төгрөгийн өртөгтэй ШУА-ийн өргөтгөлийн барилгын угсралтын ажил хийгдэж байна. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлд шинжлэх ухаан, технологийн салбарыг хөгжүүлэх чиглэлээр тусгах саналыг боловсруулсан. Шинжлэх ухаан, технологийн салбарын төсвийн санхүүжилтийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь сүүлийн жилүүдэд өсөхгүй байна. Шинжлэх ухааны салбарын 2019 оны улсын төсвийн урсгал зардал 37,269,037.2 мянган төгрөгөөр батлагдсан нь ДНБ-ний 0.18%-ийг эзэлж байгаа бөгөөд Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлогын зорилтот хэмжээнд хүргэхэд үүнийг 0.32 пунктээр нэмэгдүүлэх шаардлагатай байна. 2020 оны улсын төсвийн санхүүжилтийн саналыг 90 тэрбум төгрөгт хүргэхээр тооцоолон саналаа Сангийн яаманд хүргүүлсэн. Нийт 75 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай байгааг төсвийн саналд тусгасан. Засгийн газрын 2019 оны 379 дүгээр тогтоолоор Шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн цогцолбор барилга барих, түүний зураг төслийг боловсруулах ажлыг 2020 оноос эхлүүлэхээр тооцон төлөвлөх, хөрөнгийн эх үүсвэрийг улсын төсөвт тусгуулах арга хэмжээ авахыг Сангийн сайд, БСШУС-ын сайдад даалгасан. 2020 оны төсөвт 3 тэрбум төгрөг тусгагдсан.</p>	100%



140.	2.3 Яамны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулж, хэрэгжилтийг хангана.	БСШУС-ын сайдын тушаал	<p>Зөвлөлийн хурлыг нэг удаа зохион байгуулж 2016-2018 онд хэрэгжүүлж байгаа болон дуусч тайлангаа хүлээн өгөх гэж буй БСШУС-ын яамны захиалгатай 16 төслийн явцыг сонсч, төсөл захиалсан газруудаас өгсөн санал, зөвлөмжийг тусгах талаар зөвлөгөө өгсөн. 2018 онд дуусч тайлангаа хүлээлгэн өгөх 6 төслийн хэрэгжилтийн талаар протокол үйлдэн ШУТС-д хүргүүлсэн болно.</p> <p>БСШУС-ын яамны СӨББГ, ЕБСБГ, ДББГ, БТСБГ, СУБГ, ХШУДАГ, ШУТБГ-аас 2020 оноос хэрэгжүүлэх улсын захиалгат төслийн хүрээнд шийдвэрлүүлэх асуудлаа тодорхойлсон 15 төслийн саналыг хүлээн авч нэгтгэсэн. Ирүүлсэн төслийн сэдэв, үр дүнгийн даалгаврын саналыг Салбар зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж 15 төслөөс 7 төслийг дэмжүүлсэн. Дэмжигдсэн төслүүдийг яамны вэб хуудас болон өдөр тутмын хэвлэлээр олон нийтэд нээлттэй зарласан.</p> <p>БСШУС-ын яамны захиалгаар 2019 оноос эхлэн хэрэгжүүлж байгаа Эс Ай Си Эй ХХК-ний “Шинжлэх ухаан, технологийн салбарын статистикийн үзүүлэлтүүдийг олон улсын стандартад нийцүүлэн боловсронгуй болгох” төслийн хүрээнд статистикийн албан ёсны шинэчилсэн маягт, заавар боловсруулсан. ШУТ-ийн шинэчилсэн маягт, зааврыг туршихаар эрдэм шинжилгээний байгууллагуудад хандан албан бичиг хүргүүлэхийг хүсч албан бичгээр хүсэлт тавьсны дагуу 2019 оны 10 сарын 28 өдрийн 6/9413 дугаар албан бичиг төлөвлөн хүрээлэнгүүдэд хүргүүлсэн.</p>	100%
141.	2.4 БСШУС-ын сайдын шинжлэх ухаан, технологийн салбар зөвлөлийн хурлаар судалгааны төслүүдийг хэлэлцүүлэн сонгон шалгаруулж, санхүүжүүлэх саналыг боловсруулна.	БСШУС-ын сайдын тушаал	<p>БСШУС-ын сайдын А/131 дугаар тушаалаар Шинжлэх ухаан, технологийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталж, мөн “Шинжлэх ухаан, технологийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ыг шинээр батлуулав. БСШУС-ын сайдын А/180 дугаар тушаалаар салбар зөвлөлийн 2019 онд шинжлэх ухаан, технологийн төслүүдийг сонгон шалгаруулах үйл ажиллагаанд шаардагдах зардлыг батлуулав. 2019 оны эхний хагас жилд салбар зөвлөл 13 удаа хуралдаж 2019 болон 2020 оноос хэрэгжүүлэх суурь судалгааны төслүүд, 2019 оноос хэрэгжүүлэх инновацийн болон туршилт зүгшрүүлэлтийн төслүүд, 2019 болон 2020 оны захиалгат төслүүд, 2020 оны захиалгат төслүүд болон тэргүүлэх чиглэл цөм технологийн төслүүдийн санал, 2019 оноос хэрэгжүүлэх гадаадтай хамтарсан болон хөтөлбөрийн зорилтот төслүүдийг хэлэлцлээ.</p>	100%

142.	2.5 Улсын захиалгаар 2019 оноос эхлэн хэрэгжүүлэх шинжлэх ухаан, технологийн төслийг сонгон шалгаруулж, хэрэгжүүлнэ.	БСШУС-ын сайдын тушаал	2019 оноос эхлэн хэрэгжүүлэх шинжлэх ухаан, технологийн захиалгат төслийн гүйцэтгэчийг сонгон шалгаруулах болзлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд нээлттэй зарлаж, БСШУС-ын яамны <a href="http://project.edu.mn">http://project.edu.mn</a> цахим хаягаар төслийн санал хүлээн авлаа. “Шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх журам”-ын 4.3-4.13-т зааснаар төслийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, БСШУС-ын сайдын 2019 оны 5 сарын 24-ний өдрийн “Шинжлэх ухаан, технологийн захиалгат төсөл, батлах, санхүүжүүлэх тухай” А/324 дүгээр тушаалаар 36 төслийг хэрэгжүүлэхээр баталгаажууллаа. Төслийн гүйцэтгэгч, санхүүжүүлэгчтэй зохих журмын дагуу гэрээ байгуулан судалгааны ажлыг эхлүүлсэн.	100%
143.	2.6 Улсын захиалгаар 2020 оноос эхлэн хэрэгжүүлэх Шинжлэх ухаан, технологийн төслийн саналыг Шинжлэх ухаан, технологийн үндэсний зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, сонгон шалгаруулна.		Улсын захиалгаар 2020 оноос эхлэн хэрэгжүүлэх Шинжлэх ухаан, технологийн захиалгат төслөөр шийдвэрлүүлэх асуудлуудыг Шинжлэх ухаан, технологийн үндэсний зөвлөлийн 2019 оны 5 сарын 15-ны өдрийн хурлаар хэлэлцэж зөвлөмж гаргасан. Зөвлөмжийг үндэслэн 2020 оноос эхлэн хэрэгжүүлэх Шинжлэх ухаан, технологийн захиалгат 59 төсөлд гүйцэтгэгч сонгон шалгаруулах болзлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нээлттэй зарлаж, шинжлэх ухааны 6 салбараар нийт 95 гүйцэтгэгч байгууллага, хамт олон төслийн саналаа программд бүртгүүлсэн. БСШУС-ын сайдын 2018 оны “Шинжээчийн жагсаалт батлах тухай” А/349 дугаар тушаал, БСШУС-ын сайдын 2018 оны “Аргачлал батлах тухай” А/696 дугаар тушаалаар батлагдсан аргачлалыг баримтлан ажиллав. БСШУС-ын сайдын Шинжлэх ухаан, технологийн салбар зөвлөлийн хурал 2019 оны 11 сарын 20-22-ны өдрүүдэд боллоо. Салбар зөвлөлийн хуралд Анагаах ухааны салбарын 9 захиалгат сэдэв дээр 12 гүйцэтгэгч, Байгалийн ухааны салбарын 4 захиалгат сэдэв дээр 5 гүйцэтгэгч, Хөдөө аж ахуйн салбарын 12 захиалгат сэдэв дээр 14 гүйцэтгэгч, Инженер, технологийн салбарын 7 захиалгат сэдэв дээр 12 гүйцэтгэгч, Нийгмийн ухааны салбарын 10 захиалгат сэдэв дээр 11 гүйцэтгэгч, нийт 42 захиалгат сэдэв дээр өрсөлдсөн 55 гүйцэтгэгч төслүүдээ хэлэлцүүллээ. Салбар зөвлөлийн гишүүдийн саналаар 42 захиалгат сэдвээс 29 сэдэв дэмжигдлээ. 2020 оноос эхлэн хэрэгжүүлэх Шинжлэх ухаан, технологийн захиалгат төслийг батлах, хэрэгжүүлэх, санхүүжүүлэх гэрээ байгуулах ажлыг журмын дагуу зохион байгуулахаар ажиллаж байна	100%

144.	2.7 2020 оноос эхлэн хэрэгжүүлэх суурь судалгааны ажлыг сонгон шалгаруулна.***	БСШУС-ын сайдын тушаал	2020 оноос эхлэн хэрэгжүүлэх суурь судалгааны төслийн сонгон шалгаруулалтыг Засгийн газрын 2014 оны 301 дугаар тогтоолоор баталсан “Шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх журам”-ын дагуу зохион байгууллаа. Нийт 196 төслийн саналыг хүлээн авч, шаардлага хангасан 176 төслийн саналд мэргэжлийн шинжээчээр үнэлгээ өгч, дүгнэлт гаргуулах ажлыг ШУА-ийн холбогдох Бага чуулгантай хамтарч хийлээ. Нийт төслийн 85,8 хувь буюу 151 төслийн саналыг БСШУС-ын сайдын шинжлэх ухаан, технологийн салбар зөвлөлийн хурлаар хэлэлцүүлээ. Салбар зөвлөл нь төсөл сонгон шалгаруулсан талаарх дүгнэлтээ шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулсан болно.	100%
145.	2.8 2019 оноос эхлэн хэрэгжүүлэх суурь судалгааны ажлыг батлуулж, хэрэгжүүлж эхэлнэ.		2019 оноос эхлэн хэрэгжүүлэх суурь судалгааны төслийн сонгон шалгаруулалтыг Засгийн газрын 2014 оны 301 дугаар тогтоолоор баталсан “Шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх журам”-ын дагуу зохион байгууллаа. Суурь судалгааны төслүүдэд нийт 226 төслийн санал хүлээн авснаас төсөлд тавигдах шаардлага хангаагүй 43 төсөл сонгон шалгаруулалтаас хасагдсан. БСШУС-ын сайдын “Шинжээчийн дүгнэлт гаргах, зардал батлах тухай” 2018 оны А/341 дугаар тушаал батлагдаж, мэргэжлийн шинжээчид суурь судалгааны төсөлд үнэлгээ өгч, дүгнэлт гаргахад 186 төслөөс 128 төсөл БСШУС-ын сайдын шинжлэх ухаан, технологийн салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр дэмжигдсэн. Хурлаас нийт 72 төслийн санал дэмжигдэж БСШУС-ын сайдын 2019 оны “Суурь судалгааны төсөл батлах тухай” А/86 дугаар тушаалаар 2019 оноос шинээр хэрэгжиж эхлэх суурь судалгааны төслийн жагсаалтыг батлан, журмын дагуу 100 хувь гэрээ хийгдэн хэрэгжиж эхлээд байна.	100%

146.	2.9 Шинжлэх ухаан, технологийн салбарын тэргүүлэх чиглэл, цөм технологийн 2019 оноос эхлэх төслийг сонгон шалгаруулж, хэрэгжүүлнэ.	БСШУС-ын сайдын тушаал	Шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх цөм технологийн төслийн саналуудаа ЗТХЯ, ЭМЯ, ХХААХҮЯ-наас ирүүлснийг судлан, санал боловсрууллаа. Засгийн газрын 2019 оны 343 дугаар тогтоолоор “Шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх журам”-д Цөм технологийн төслийн талаар нэмэлт өөрчлөлт орсон. Цөм технологийн төслийн сэдвийг ШУТ-ийн салбар зөвлөлөөр хэлэлцүүлж, дэмжигдвэл ШУТҮЗ-ийн хурлаар хэлэлцүүлж, дараа нь олон нийтэд нээлттэй зарлахаар журамд өөрчлөлт орсон. Яамд цөм технологийн төслийн саналаа тодорхойлон ирүүлснийг үндэслэн Зам, тээврийн хөгжлийн яамны 4 төслийн 1-ийг нь 6-р сард ШУТСЗ-өөр хэлэлцүүлж дэмжлэг аваагүй болно. 12 дугаар сард зохион байгуулсан ШУТСЗ-ийн хуралд ЗТХЯ- 1, УИХ-ын Аюулгүй байдлын байнгын хороо 1, БСШУСЯ-2 төслийг Салбар зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэв. Олонхийн дэмжлэг авч чадаагүй.	100%
147.	2.10 Био, нанотехнологийн 2019 оноос эхлэх зорилтот төслийг сонгон шалгаруулж, хэрэгжүүлнэ.	БСШУС-ын сайдын тушаал	Био, нанотехнологийг хөгжүүлэх зорилтот шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэхээр төсвийн санал тусган СЯ-нд хүргүүлсэн боловч төсөв батлагдаагүй. Өмнөх онуудаас биотехнологийн чиглэлээр улсын захиалгат төсөл -30, суурь судалгааны төсөл-1, цөм технологийн 3 төсөл, нанотехнологийн чиглэлээр суурь судалгааны 1 төсөл хэрэгжиж байна.	100%
148.	2.11 Шинжлэх ухаан, технологийн салбарын гадаадтай хамтарсан төслийг сонгон шалгаруулж, хэрэгжүүлнэ. ***	БСШУС-ын сайдын тушаал	БНХАУ-ын Шинжлэх ухаан технологийн яамтай хамтран 2019 оноос хэрэгжүүлэх төслийн жагсаалтыг БСШУС-ын сайдын 2019 оны А/621, ОХУ-ын Суурь судалгааны сантай хамтран 2019 оноос хэрэгжүүлэх төслийн жагсаалтыг БСШУС-ын сайдын 2019 оны А/622 дугаар, Беларус Улсын Суурь шинжлэх ухааны сантай хамтран 2019 оноос хэрэгжүүлэх төслийг БСШУС-ын сайдын 2019 оны А/620 дугаар тушаалаар тус тус баталлаа.  БНХАУ-ын Шинжлэх ухаан технологийн яам, ОХУ-ын Суурь судалгааны сан, Беларус Улсын Суурь шинжлэх ухааны сан, Беларус Улсын Шинжлэх ухаан, технологийн улсын хороо, Евразийн шинжлэх ухааныг дэмжих холбоотой хамтран 2020 оноос хэрэгжүүлэх судалгааны төслийн сонгон шалгаруулалтыг зарлан төслийн саналуудыг хүлээн авч эхэллээ.  БНСВУ-тай хамтарсан төслийн сонгон шалгаруулалтыг эцэслэж вьетнамын талд санал хүргүүлээ. ШУТСан болон БНХАУ-ын Байгалийн	100%

			суурь судалгааны сантай хамтран 2020 оноос хэрэгжүүлэх 5 төсөл хэрэгжүүлэхээр хятадын талтай тохиролцлоо. БНСУ-ын Хөдөөгийн хөгжлийг дэмжих газрын харьяа Копиа-Монгол төв дээр 2019 оноос хэрэгжүүлэх 10 хамтарсан төслийг батлан хэрэгжүүлж эхэллээ. Япон Улсын Шинжлэх ухаан, технологийн агентлагаас зарлан хэрэгжүүлдэг “Сатрепс” төслийн 2020 оноос хэрэгжүүлэх төслийн сонгон шалгаруулалтад 2 төсөл дэмжигдэн Төслийн удирдах зөвлөл байгуулагдан ажиллаж байна.	
149.	2.12 Улсын төсвийн хөрөнгөөр шинжлэх ухаан, технологийн салбарт хэрэгжиж буй судалгаа боловсруулалтын ажлын хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт тавьж үнэлэлт, дүгнэлт гаргана.	ТНБД-ын тушаал/Ажлын хэсгийг байгуулах/, Баталгаажуулсан Хяналт, үнэлгээний тайлан, дүгнэлт	<p>Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн гишүүдийн хурлыг 2019 оны 01 сарын 22-ны өдөр өргөтгөсөн байдлаар хурал зохион байгуулж БСШУС-ын яамны захиалгат төслүүдийг хэлэлцэв. Ялангуяа 2016-2018 онд хэрэгжиж байгаа 16 төслийн явцад мониторинг хийх зорилгоор хэлэлцүүлэг, явцын тайланг сонсч төсөл хэрэгжүүлэх үр дүнгийн даалгаврын хүрээнд шийдвэрлэгдээгүй асуудлыг нэмж судлах даалгавар өгч ажиллалаа. 2018 онд хэрэгжиж дууссан 6 төслийн эцсийн тайланд гишүүд үнэлгээ өгч, хүлээн авах талаар протокол үйлдэн ШУТСанд хүргүүлж протоколыг үндэслэн 6 төслийн тайланг хүлээн авч акт үйлдсэн болно. 2019 онд суурь судалгааны нийт 214 төсөл хэрэгжиж байна.</p> <p>Төслийн гүйцэтгэгчээр эрдэм шинжилгээний хүрээлэн 122, их, дээд сургууль 74, ТББ болон хувийн хэвшлийн 18 байгууллага төслийг хэрэгжүүлж байна. Хэрэгжих хугацаа нь дууссан суурь судалгааны 73 төслийн үр дүнг ШУА-ийн холбогдох Бага чуулганаар хэлэлцүүлэн хүлээн авлаа. 2018-2019 онд хүлээлгэн өгсөн төслийн үр дүнд: Ном бүтээл 15, эрдмийн бүтээл 2, шинэ бүтээгдэхүүн 1, зөвлөмж заавар 3, патент 1, зураг 1, ашигтай загвар, зохиогчийн эрх 3, ЭШ-ний өгүүлэл гадаад 79, эрдэм шинжилгээний өгүүлэл дотоод 108, шинэ онол, теором 1, ЭШ-ний илтгэл гадаад 86, ЭШ-ний илтгэл дотоод 86, стандарт 17, эшлэл, аргачлал 5, үр ашиг 3 тус тус гарсан байна.</p>	100%
150.	2.13 Археологи, палеонтологийн хайгуул, малтлагын зөвшөөрөл олгох ажлыг зохион байгуулж,	БСШУС-ын сайдын тушаал, хэрэгжилт, зохицуулалт, хяналт тавьж	БСШУС-ын сайдын 2019 оны 2 сарын 25-ны өдрийн “Мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн шинэчлэх, журамд өөрчлөлт оруулах тухай” тушаалаар Палеонтологи мэргэжлийн зөвлөл, Түүх, археологийн мэргэжлийн зөвлөлийг шинэчлэн батлав. Палеонтологи, Түүх, археологийн мэргэжлийн зөвлөлийн 2019 оны 3 сарын 28, 4 сарын 4-ний өдрийн хуралдааны тэмдэглэлийг үндэслэн БСШУС-ын сайдын 2019	100%

	хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.***	ажилласан тайлан баталгаажсанаар	<p>оны “Зөвшөөрөл олгох тухай” А/233, А/340 дүгээр тушаал тус тус батлагдан гарч археологийн малтлага судалгааны зөвшөөрлийг олголоо.</p> <p>2019 онд палеонтологи, археологийн авран хамгаалах чиглэлээр хайгуул, малтлага, судалгааны ажил хийх 8 байгууллага, палеонтологийн эрдэм шинжилгээний хайгуул, малтлага судалгааны ажилд 2 байгууллагад 13 зөвшөөрөл, археологийн эрдэм шинжилгээний хайгуул, малтлага судалгааны ажилд 7 байгууллагад 56 зөвшөөрөл тус тус олгосон байна.</p> <p>Түүх, археологийн хүрээлэнгийн “Соёлын өвийн судалгаа, шинжилгээ”-ний ангийн ажилтай 2019 оны 6 сарын 25-26-ны өдрүүдэд газар дээр нь очиж танилцлаа.</p> <p>XVII зууны Монголын хотууд тусгай захиалгат ажлын хүрээнд малтлага хийсэн Төв аймгийн Эрдэнэ сумын нутагт оршин Сарьдагийн хийд Өндөр гэгээн Занабазарын уран бүтээлийн ордонд хийсэн Түүх, угсаатан зүйн хүрээлэнгийн малтлага, судалгааны үр дүнтэй газар дээр нь танилцах, цаашид хамгаалах нөхцөл байдал, малтлага судалгааг үргэлжлүүлэх боломжийг судлах, Шинжлэх ухааны баримтад киноны зураг авалт хийх зэрэг ажлын хүрээнд баг гаран очиж танилцлаа.</p>	
151.	2.14 Шинжлэх ухаан, технологийн салбарын оюуны өмчийн үнэлэмжийг нэмэгдүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулна	БСШУС-ын сайдын тушаал, хэрэгжилтийг зохион байгуулсан тайлан баталгаажсанаар	<p>БСШУС-ын сайд болон Оюуны өмчийн газрын даргын 2019 оны 1 сарын 14 өдрийн А/12 тоот хамтарсан тушаалаар “2019-2020 онд шинжлэх ухаан, технологийн салбарын оюуны өмчийн үнэлэмжийг нэмэгдүүлэх төлөвлөгөө”-г батлан хэрэгжүүлж байна. АХБ-ны санхүүжилтээр хэрэгжиж буй “Шинжлэх ухаан, технологи, инновацийг дэмжих тогтолцоог бэхжүүлэх” техникийн туслалцааны зөвлөх үйлчилгээний төслийн хүрээнд салбарын оюуны өмчийн нөхцөл байдлын судалгааг хийлгэж, “Нээлттэй шинжлэх ухааны платформ” байгуулах төслийг эхлүүллээ.</p> <p>БНХАУ-ын Шинжлэх ухаан технологийн яамтай хамтран “Хятад-Монголын Технологи дамжуулах төвийн платформыг байгуулах”, “Монгол Улсад инкубаторын үйл ажиллагааг хэрэгжүүлэх болон мэдээллийн серверийн бүтээн байгуулалт” төслүүдийг хэрэгжүүлж байна.</p> <p>Оюуны өмчийн газар, ШУТСантай болон бусад байгууллагуудтай хамтран “Оюуны өмчийн соёлыг нутагшуулья”, “Шинжлэх ухаан,</p>	100%

			технологийн хөгжлийг сэтгүүл зүйгээр дамжуулан олон нийтэд түгээн дэлгэрүүлэх”, “Оюуны өмчийн эрх зүй, менежментийн үндсэн ойлголт, менежментийг сайжруулах”, “Боловсролын чанар ба плажиризм”, “Олон улсын анхдугаар Агритек-Монгол форум”, “Author training and Science communication training” зэрэг сургалт, форумыг зохион байгууллаа.	
Гурав. Шинжлэх ухаан, технологи, инновацийн хүний нөөцийг хөгжүүлэх, чадавхжуулах				
152.	3.1 Залуу судлаачдын “Хүрэл тогоот”-ын эрдэм шинжилгээний хурал зохион байгуулж, шилдэг судлаачдад сайдын нэрэмжит грант олгох ажлыг зохион байгуулна.	БСШУС-ын сайдын тушаал /грант олгосон залуу судлаачийн тоо, олгосон урамшууллын мөнгөн дүн/	БСШУ-ны сайдын 2010 оны “Сайдын нэрэмжит грант олгох тухай” 324 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Залуу судлаачдын эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулах, грант олгох журам”-ын дагуу 15 жилдээ “Хүрэлтогоот-2019” эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгууллаа. Тус бага хурал 7 салбар хуралдаанаас бүрдсэн бөгөөд 2019 оны 10 сарын 11-26-ны өдрүүдэд зохион байгуулагдаж 100-аад залуу судлаачдын бүтээлийг хэлэлцэв. Тус 7 салбар хуралдаанаас шалгарсан 14 шилдэг залуу эрдэмтэнд сайдын нэрэмжит 4.0 сая төгрөгийн грант гардуулав. Шалгарсан судлаачдад “Шилдэг залуу судлаачийг батлах тухай” БСШУС-ын сайдын 2019 оны 11 сарын 12-ны А/718 дугаар тушаал, шийдвэрийн дагуу Сайдын нэрэмжит грантын батламж гардуулах ёслолын ажиллагааг 12 сарын 06-ны өдөр зохион байгуулсан. Тушаалыг үндэслэн судлаачидтай гэрээ байгуулж нийт 56.0 сая төгрөгийн санхүүжилт олголоо.	100%
153.	3.2 Докторын дараах судалгаанд сайдын нэрэмжит судалгааны тэтгэлэг олгох ажлыг зохион байгуулна.	БСШУС-ын сайдын тушаал /судалгааны тэтгэлэг олгосон судлаачдын тоо, олгосон урамшууллын мөнгөн дүн/	БСШУ-ны сайдын 2011 оны 222 дугаар тушаалаар батлагдсан “Докторын дараах судалгаанд сайдын нэрэмжит инновацийн тэтгэлэг олгох журам”-ын дагуу инновацийн тэтгэлэг олгох 10 бүтээлийг шалгаруулж БСШУС-ын сайдын 2019 оны 5 сарын 17 өдрийн “Докторын дараах судалгаанд сайдын нэрэмжит инновацийн тэтгэлэг олгох тухай” А/317 тушаалаар баталгаажуулав. Шалгарсан 10 доктор судлаачдад докторын дараах судалгааны ажилд тус бүр 10.0 сая төгрөгийн грант олгох бөгөөд 2 жилд хуваан санхүүжүүлэх юм. Судлаачидтай гэрээ байгуулж, санхүүжилтийн 50 хувийг олгосон болно.	100%
154.	3.3 Залуу судлаачдыг судалгааны арга зүйд мэргэшүүлэх сургалт, семинар зохион байгуулна.	БСШУС-ын сайдын тушаал, сургалтын агуулга, чиглэл, хөтөлбөр,	Шинжлэх ухаан, технологи, инновацийн хүний нөөцийг хөгжүүлэх, залуу судлаачдын чадавхыг бэхжүүлэх зорилгоор дараах сургалтуудыг зохион байгуулж, эрдэм шинжилгээний 1220 ажилтан, багш нарыг хамрууллаа. Эдгээр сургалтуудад нийт 183.2 сая төгрөг зарцуулсан. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 2019 оны хувьд хөрөнгө батлагдаагүй тул	100%

		<p>санхүүжилт баталгаажсанаар</p>	<p>эдгээр сургалтад Дээд боловсролын шинэчлэл төслөөс 114.5 сая төгрөг, ЮНЕСКО-оос 30.0 сая төгрөг, ШУТС-аас 38.7 сая төгрөгийг зарцуулсан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Дээд боловсролын шинэчлэл төслийн санхүүжилтээр “Оюуны өмчийн эрх зүй, менежментийн үндсэн ойлголт, менежментийг сайжруулах” сэдэвт сургалтыг Ай Пи Консалтинг компанитай хамтран;</li> <li>- МУИС-ийн урилгаар ирсэн Харвардын Бизнесийн сургуулийн профессор Хиротака Такэүчийн “Мэдлэгийн менежмент” лекцийг тус сургуультай хамтран зохион байгууллаа. Лекцийг зохион байгуулахад БСШУС-ын сайдын 2019 оны 4 сарын 18 өдрийн “Санхүүгийн дэмжлэг үзүүлэх тухай” А/223 дугаар тушаалын дагуу санхүүгийн дэмжлэг үзүүлсэн.</li> <li>-Springer Nature Academies-тэй хамтран “NATURE RESEARCH ACADEMIES – AUTHOR TRAINING AND SCIENCE COMMUNICATION TRAINING” сэдэвт сургалтыг 2019 оны 6 сарын 4-6-ны өдрүүдэд АХБ-ны Дээд боловсролын шинэчлэлийн төслийн санхүүжилтээр зохион байгууллаа.</li> <li>-ЮНЕСКО-ийн шинжлэх ухаан, технологи, инновацийн бодлогын хэрэгслүүдийн даян дэлхийн ажиглалт GO-SPIN нээлттэй платформд нэгдэн орох ажлыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд 2019 оны 6 сарын 19-21 өдөр ЮНЕСКО-той хамтран сургалт зохион байгууллаа. Сургалтад яамд, агентлаг, эрдэм шинжилгээний байгууллага, их сургууль, хувийн хэвшлийн төлөөлөл оролцлоо. Сургалтанд оролцогчид Шинжлэх ухаан, технологийн, инновацийн тогтолцоог бэхжүүлэх, жендэрийн нөхцөл байдлыг сайжруулахад GO-SPIN болон SAGA аргачлалыг ашиглах, мэдээллээр баяжуулах чадвар эзэмшсэн болно.</li> <li>- БСШУС-ын сайдын “Шинжлэх ухааны залуу судлаачдыг чадавхжуулах сургалт зохион байгуулах тухай” 2019 оны А/599 дүгээр тушаалаар залуу судлаачдын судалгааны арга зүйг дээшлүүлэх, энтрепренер болон гарааны бизнес эрхлэхэд шаардлагатай мэдлэг ур чадварыг эзэмшүүлэх сургалтыг зохион байгуулав.</li> </ul>	
<p>Дөрөв. Шинжлэх ухаан, технологи, инновацийн гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх</p>				



155.	<p>4.1 Шинжлэх ухаан, технологийн салбарын гадаад хамтын ажиллагааг 2019 онд хөгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулна.</p> <p>ШУТ-ийн тухай хуулийн 8.1.7, 8.1.10</p>	<p>Шинжлэх ухаан, технологийн салбарын гадаад хамтын ажиллагааг 2019 онд хөгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнгийн тайлан</p>	<p>БСШУС-ын сайд Ё.Баатарбилэг ОХУ-ын Шинжлэх ухаан, дээд боловсролын сайд М.Котюков, БНХАУ-ын Шинжлэх ухаан, технологийн сайд Ван Жи Ганг нартай хийсэн албан уулзалтын бэлтгэл ажлыг хангаж ажиллав. Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн Монгол, Оросын Засгийн газар хоорондын комиссын ээлжит XXII хуралдаанаар 2019-2024 онд Монгол Улсын нутаг дэвсгэрт хамтарсан иж бүрэн экспедиц зохион байгуулах тухай яам хоорондын хэлэлцээр байгууллаа. БНХАУ болон Беларус Улстай шинжлэх ухаан, технологийн хамтарсан комиссын хуралдааныг хийлээ. БНХАУ-ын Шинжлэх ухаан технологийн яам, ОХУ-ын Суурь судалгааны сан, Евразийн шинжлэх ухааныг дэмжих холбоотой хамтран 2020 оноос шинээр хамтарсан төсөл хэрэгжүүлэхээр санамж бичиг байгууллаа. БНСУ-ын Хөдөөгийн хөгжлийг дэмжих агентлагийн Копиа-Монгол төвтэй хамтран ажиллах санамж бичиг байгууллаа.</p> <p>АХБ-ны санхүүжилтээр хэрэгжиж буй “Шинжлэх ухаан, технологи, инновацийг дэмжих тогтолцоог бэхжүүлэх” техникийн туслалцааны зөвлөх үйлчилгээний ажлын явцад хяналт тавин ажиллалаа. Төслийн хүрээнд “Science Diplomacy”-г хэрэгжүүлэх чиглэлээр нэмэлт ажлын даалгавар боловсруулж төслийн тайланг 12 дугаар сард эцэслэн хүлээж авлаа. Нээлттэй шинжлэх ухааны платформ байгуулах төслийг АХБ-ны техникийн туслалцааны төслийн хүрээнд мөн эхлүүлээ.</p> <p>ЮНЕСКО-ийн шинжлэх ухаан, технологи, инновацийн бодлогын хэрэгслүүдийн даян дэлхийн ажиглалт GO-SPIN нээлттэй платформд нэгдэн орох ажлыг эхлүүлэв. “Шинжлэх ухааны паркийн захиргаа” ШУТ-ийн нэгдлийг Олон улсын шинжлэх ухааны паркуудын холбооны гишүүнээр элсүүлээ.</p> <p>2019 оны 9 сарын 6-7-ны өдрүүдэд БНХАУ-ын ӨМӨЗО-д зохион байгуулагдсан “3 дахь удаагийн Монгол-Хятадын ЭКСПО”-ийн үеэр Монгол-Хятадын технологи дамжуулалт, инновацийн хамтын ажиллагааны хоёрдугаар форумыг хамтран амжилттай зохион байгуулав.</p> <p>2019 оны 09 сард БНХАУ-ын Манжуур хотод зохион байгуулагдсан Хойд бүсийн олон улсын шинжлэх ухаан, технологийн 16 дугаар олон улсын үзэсгэлэнг хамтран зохион байгуулж, оролцлоо. БСШУС-ын сайдын А/274 дугаар тушаалаар 2019 онд зохион байгуулагдах олон улсын эрдэм шинжилгээний 17 хуралд санхүүгийн дэмжлэг үзүүлж ажиллалаа.</p>	100%
------	--	---	--	------

Тав. Шинжлэх ухаан, технологи, инновацийн үйл ажиллагааг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх				
156.	5.1 Шинжлэх ухааны ажилтны өдрийг угтсан сарын арга хэмжээ, “Шинжлэх ухаан, технологи-инноваци-2019” үзэсгэлэн зохион байгуулна.	БСШУС-ын сайдын тушаал /зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөө, тоо, зарцуулсан санхүүжилт/	Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн ивээл дор 2019 оны 9 сарын 26-27-ны өдөр “Хандлагаа өөрчилье” уриатайгаар Шинжлэх ухааны ажилтны анхдугаар их хурлыг Төрийн ордонд амжилттай зохион байгууллаа. Тус арга хэмжээний хүрээнд “Шинжлэх ухаанд суурилсан хөгжлийн бодлого”, “Шинжлэх ухаан, технологийн салбарын хүний нөөц, дэд бүтэц”, “Шинжлэх ухаан, технологийн салбарын санхүүжилт, хөрөнгө оруулалт”, “Шинжлэх ухаан, технологи ба Түншлэл” сэдэвт 4 салбар хуралдааныг МУИС, ШУТИС, АШУҮИС, СУИС-ийн хурлын танхимд тус тус зохион байгуулсан. Их хурлын төлөөлөгч 800 гаруй эрдэмтэн, судлаачид салбарынхаа ололт, амжилт, алдаа дутагдлаа дүгнэн төрөөс батлан хэрэгжүүлж байгаа шинжлэх ухаан, технологи, инновацийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар хэлэлцэн, цаашдын хөгжлийн зорилтоо тодорхойллоо. “Шинжлэх ухаан, технологи-инноваци-2019” үзэсгэлэн зохион байгуулагдлаа. Шинжлэх ухааны салбарт анх удаа full HD 1920x1080 формат бүхий синхрон ярилцлага 4к технологиор бүтээгдсэн бүрэн хэмжээний баримтат кино хийх ажлыг зохион байгууллаа.	100%
157.	5.2 Шинжлэх ухааны, технологийн салбарын 2019 оны шагналд нэр дэвшүүлсэн материалыг хүлээн авч сонгон шалгаруулна.	БСШУС-ын сайдын тушаал /шалгаруулсан, шагнал олгосон хүний тоо, урамшууллын мөнгөн дүн/	Засгийн газрын 2007 оны 147 дугаар тогтоолоор баталсан “Шинжлэх ухаан, технологийн салбарын шагнал олгох журам”-д заасны дагуу 2019 онд шинжлэх ухаан, технологийн салбарын шагналд нэр дэвшүүлсэн бүтээлийг сонгон шалгарууллаа. БСШУС-ын сайдын 2019 оны А/680 дугаар тушаалаар томилогдож ажилласан комисс ХААИС-ийн Мал эмнэлгийн хүрээлэнгээс нэр дэвшүүлсэн, академич Б.Бямбаагийн “Паразиттах өвчтэй малыг эмчлэх, сэргийлэх дэвшилтэт технологи” бүтээлийг тус шагналд тавигдах шаардлагыг хангасан гэж үзсэн. Б.Бямбаагийн санаачлан байгуулсан малын эмийн үйлдвэр 2002-2018 онд нийт 273,6 тн буюу 5,8 тэрбум төгрөгийн “Авермонмек”, “Альмонзол” бүтээгдэхүүнүүдийг үйлдвэрлэн борлуулжээ. Шагналыг 2019 оны 12 сарын 11-ний Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэлээ.	100%
158.	5.3 Их эрдэмтэн Ц.Дамдинсүрэн, Б.Ширэндэвийн нэрэмжит шагналд нэр	БСШУС-ын сайдын тушаал /шагнал олгосон хүний тоо,	Засгийн газрын 2012 оны 204 дүгээр тогтоолоор баталсан “Нэрэмжит шагнал олгох журам”-ын дагуу Академич Б.Ренчин, Ц.Дамдинсүрэн, Б.Ширэндэвийн нэрэмжит шагнал олгох хорооны бүрэлдэхүүнийг	100%

	дэвшүүлсэн материалыг хүлээн авч сонгон шалгаруулна	шагналын мөнгөн дүн/	БСШУС-ын сайдын 2019 оны 10 сарын 24 өдрийн А/679 дүгээр тушаалаар батлуулсан. Нэрэмжит шагнал олгох хороо Академич Ц.Дамдинсүрэнгийн нэрэмжит шагналыг Олон улсын Монгол судлалын холбооноос ОХУ-ын ШУА-ийн Дорно дахины гар бичмэлийн хүрээлэнгийн Төв Ази, Монгол судлалын төвийн дарга, доктор И.В.Кульганек, Академич Б.Ширэндэвийн нэрэмжит шагналыг ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгээс тус хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор Н.Хишигтэд тус тус олгохоор шийдвэрлэснийг БСШУС-ын сайдын 2019 оны “Нэрэмжит шагнал олгох тухай” А/730 дугаар тушаалаар баталгаажуулсан.	
159.	5.4 Шинжлэх ухааны 2019 оны шилдэг бүтээл сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулна.	БСШУС-ын сайдын тушаал /бүтээл шалгаруулах комисс, шалгарсан бүтээлийн тоо, салбар чиглэл, олгосон шагналын мөнгөн дүн/	Шинжлэх ухааны 2019 оны шилдэг бүтээл сонгон шалгаруулах ажлыг зохион байгууллаа. Шинжлэх ухааны 2019 оны шилдэг 9 бүтээлд: Тэргүүн байранд – МУИС-ийн Монгол судлалын хүрээлэнгийн доктор У.Эрдэнэбатын “Монголын эртний нийслэл Хархорум” бүтээл, Дэд байранд – ШУА-ийн харьяа Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн шинжлэх ухааны доктор, академич С.Чулуун ахлагчтай судлаачдын багийн “Сарьдагийн хийд: Өндөр гэгээн Занабазарын уран бүтээлийн хүрээ” бүтээл, МУИС-ийн доктор П.Дэлгэржаргал ахлагчтай судлаачдын багийн “Монголын эзэнт гүрний түүх” 5 боть бүтээл тус тус, Гутгаар байранд – ХААИС-ийн харьяа Мал эмнэлгийн хүрээлэнгийн доктор Б.Баттөр, доктор Н.Дамбий, доктор Б.Батцэцэг нарын “Монгол орны мал, амьтдын паразитын ангилал зүйн нэгдсэн атлас” бүтээл, ХААИС-ийн Агро экологийн сургуулийн доктор А.Буянбаатар ахлагчтай судлаачдын багийн “Агро ойжуулалт” бүтээл тус тус, Тусгай байранд – ШУА-ийн харьяа Хими, химийн технологийн хүрээлэнгийн доктор Л.Жаргалсайхан, доктор М.Баяржаргал нарын “Хог хаягдлын менежмент ба нөөцийг боловсруулах технологи” бүтээл, АШУУИС-ийн багш, шинжлэх ухааны доктор Г.Отгон, судлаач Г.Ачсайхан нарын “Монголын хүүхдийн орчин судлалын физиологи” бүтээл, ХААИС-ийн харьяа Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн доктор М.Бямбасүрэн ахлагчтай багийн “Хөнөөлт шавжтай тэмцэх “ГРИЙН” биобэлдмэл” бүтээл, ШУА-ийн харьяа Ботаникийн хүрээлэнгийн судлаач Ж.Санжид, доктор Б.Мандах нарын “Өмнөд говийн ганц, хоёр наст ургамлын биоморфологи” бүтээл тус тус шалгарч шалгарсан 9 бүтээлийн өргөмжлөл, мөнгөн шагналыг Шинжлэх ухааны ажилтны өдрийн баярын хурал дээр гардууллаа.	100%

Зургаа. Монгол судлалыг хөгжүүлэх, судлаачдыг чадавхжуулах				
160.	6.1 Монгол судлалын үндэсний зөвлөлийн 2019 оны төлөвлөгөөг батлуулан, хэрэгжилтийг зохион байгуулна.	БСШУС-ын сайдын тушаал /Монгол судлалын үндэсний зөвлөлийн 2019 оны төлөвлөгөө/	<p>Монгол судлалын үндэсний зөвлөлийн 2019 оны 5 сарын 1 өдрийн 01 тогтоолоор 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, түүнд шаардагдах 852.443.0 төгрөгийг баталлаа. Төлөвлөгөөнд гадаад дахь монгол судлалын 11 төвийн үйл ажиллагаанд санхүүгийн дэмжлэг үзүүлэх, олон улсын эрдэм шинжилгээний 3 хурал зохион байгуулах, монгол судлалын бааз суурийг бэхжүүлэх, монгол судлалын залуу үеийг бэлтгэх, монгол судлалыг сурталчлах үйл ажиллагааг зохион байгуулахаар тусгагдсан. БСШУС-ын сайдын 2019 оны "Зардал батлах тухай" А/321 дүгээр тушаалаар санхүүгийн дэмжлэг олгох гадаад дахь монгол судлалын төвүүдийн жагсаалт батлав.</p> <p>Төвүүдэд санхүүжилт олгох болсон тухай цахим шуудан илгээлээ. 2019 оны 7 сарын 21-ээс 8 сарын 03-ны өдрүүдэд Олон улсын залуу монгол судлаачдын зуны сургалтыг зохион байгуулах тухай БСШУС-ын сайдын 2019 оны "Ажлын хэсэг байгуулж, сургалт зохион байгуулах тухай" А/377 дугаар тушаал батлагдав. БСШУС-ын сайдын 2019 оны 6 сарын 6 өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/364 дүгээр тушаал баталлаа. Тушаалаар "Дэлхийн номын сангууд дахь монгол судлалын баримт сурвалжууд" сэдэвт олон улсын хурал зохион байгуулахыг МУИС, "Монголын түүх, хэл, соёл, боловсрол, танин мэдэхүйн гурван цуврал бүтээл хэвлүүлэх ажлыг гүйцэтгүүлэхээр МУБИС-д, 2019 оны 7 сарын 18 өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/455 дугаар тушаалаар Монгол судлалын хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардлыг баталж МУИС, ШУА, Монголын Үндэсний номын сан, СУИС-д тус тус эрхийг шилжүүлэн ажилласан. Эрх шилжүүлсэн байгууллагын захирал нарт төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах хуулийн дагуу ажлаа гүйцэтгэхийг үүрэг болгов.</p> <p>БСШУС-ын сайдын 2019 оны 7 сарын 18 өдрийн "Зардал батлах тухай" А/456 дугаар тушаалаар Олон улсын Монгол судлалын холбооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, монгол судлалыг сурталчлах зардлыг батлав. Энэхүү тушаалыг хэрэгжүүлэх хүрээнд Олон улсын Монгол судлалын холбооноос Монколика сэтгүүлийг хэвлүүлэх, Монгол судлалын сонгодог бүтээл хэвлүүлэх, Дэлхийд тархсан Монгол өв цувралаас 1 ботийг хэвлэхэд шаардагдах материал бэлтгэх, каталоги хэвлэн нийтлүүлэх, Монгол судлалын мэдээллийн тогтмол үйл ажиллагаа, номын сангийн баяжилт хийх зэрэг ажлыг гүйцэтгэлээ.</p>	100%

			<p>“Чингис хааны өв, соёлын хүрээлэн” байгуулах тухай Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 142 дугаар тогтоолыг хэрэгжүүлэхээр БСШУС-ын сайдын 2019 оны 10 сарын 10 өдрийн “Зардал батлах тухай” А/635 дугаар тушаалаар тус хүрээлэнгийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зардал батлав.</p> <p>Инновацийн хэлтсийн даргын үүрэг гүйцэтгэгч Д.Одгэрэл, Шинжлэх ухаан, технологийн бодлогын газрын мэргэжилтэн Д.Баттогтох, Г.Оюунцэцэг нар Олон Улсын Монгол судлалын Холбооноос санаачлан БНСУ-ын Үндэсний музейд зохион байгуулсан Олон Улсын Монгол судлалын холбооны Азийн III хуралд оролцов.</p>	
161.	6.2 Гадаад дахь монгол судлалын төвүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулна	БСШУС-ын сайдын тушаал /Гадаад дахь монгол судлалын төвүүдэд олгосон санхүүжилтийн дүн, дэмжлэгийн хувь хэмжээ/	<p>БСШУС-ын сайдын 2019 оны 5 сарын 23 өдрийн “Зардал батлах тухай” А/321 дүгээр тушаалаар санхүүгийн дэмжлэг олгох гадаад дахь Монгол судлалын төвүүдийн жагсаалт, зардлыг батлав. 2019 онд Гадаадын 11 монгол судлалын төвийн үйл ажиллагаанд 223,720.0 /сая/ төгрөгийн санхүүгийн дэмжлэг олголоо. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1.Австрийн Вена их сургууль-20,600.0/сая/</li> <li>2.Австрийн шинжлэх ухааны академи-20,600.0/сая/</li> <li>3.ХБНГУ-ын Хумбольдын их сургууль-20,000.0/сая/</li> <li>4.Унгарын Элтэ их сургууль-35,000.0/сая/</li> <li>5.Канадын Бритиш Колумбын их сургууль-35,000.0/сая/</li> <li>6.Ираны Занжаны их сургууль-31,200.0/сая/</li> <li>7.БНСУ-ын Монгол судлалын төв-15,000.0/сая/</li> <li>8.Кэмбрижийн их сургууль-10,000.0/сая/</li> <li>9.ОХУ-ын Москвагийн Хүмүүнлэгийн Улсын их сургууль-15,600.0/сая/</li> <li>10.ОХУ-ын Санктпетербургийн их сургууль-20,000.0/сая/</li> <li>11.Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улсын Пхеньяны Гадаад хэлний дээд сургууль-10,000.0/сая/ төгрөг.</li> </ol> <p>Гадаад дахь Монгол судлалын төвүүдтэй Шинжлэх ухаан, технологийн бодлогын газрын дарга хамтран ажиллах гэрээ байгуулан холбогдох санхүүжилтийг олголоо.</p>	100%
162.	6.3 Олон улсын залуу монгол судлаачдын зуны сургалтыг зохион байгуулна.	БСШУС-ын сайдын тушаал /Сургалтын агуулга, салбар чиглэл, хамрагдсан судлаачдын тоо, зарцуулсан	<p>БСШУС-ын сайдын 2019 оны 6 сарын 11 өдрийн “Ажлын хэсэг байгуулж, сургалт зохион байгуулах тухай” А/377 дугаар тушаалаар сургалтыг зохион байгуулах зардал 54,982.500 төгрөгийг батлав. Монгол судлалын голлох төвүүдтэй хамтран 2019 оны 7 сарын 21-ээс 8 сарын 3 өдрүүдэд зохион байгууллаа. 2019 оны залуу монгол судлаачдын зуны сургуульд Чех, Швейцар, Орос, Америк, Хятад, Япон, Герман, Унгар, Турк, Польш,</p>	100%

		санхүүжилтийн хэмжээ/	Лаос, Өмнөд Солонгос, Энэтхэг зэрэг 13 орны 22 их сургууль, судалгааны төвөөс ирсэн 30 залуу монгол судлаач оролцлоо. Энэ удаагийн зуны сургуулийг монгол ахуй, монгол судлалын сургалт-эрдэм шинжилгээний төв гэсэн хоёр өөр орчинд зохион байгуулав. Залуу судлаачид Булган аймгийн Сайхан сумын Тал булаг гэдэг газарт хөдөө малчны ахуй амьдралын дунд монгол бичгийн хэл, монгол ярианы хэл, монгол орон судлал, монгол ахуйтай танилцах хичээлийг үзсэнээс гадна Улаанбаатар хотод Монгол Улсын Шинжлэх ухааны академи, МУИС, МУБИС зэрэг монгол судлалын сургалт-эрдэм шинжилгээний гол төвүүдийн нэртэй эрдэмтэн, багш нарын лекцийг сонсоцгоов.	
<b>ИННОВАЦИЙН ХЭЛТЭС</b>				
163.	1.1 Инновацийн төсөл бүртгэх журмын төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ.***	Журам	Инновацийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэг, 6 дугаар зүйлийн 6.1.5 дахь хэсэг, 7 дугаар зүйлийн 7.1.9 дахь хэсгийг тус тус үндэслэн “Инновацийн төсөл бүртгэх журам батлах тухай” Засгийн газрын тогтоолын болон журмын төслийг боловсруулан Засгийн газрын 2019 оны 11 сарын 6 өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн 392 дугаар тогтоолоор батлууллаа. Энэхүү журмаар инновацийн төслийг хүлээн авах, үнэлгээ өгч, дүгнэлт гаргах, мэдээллийн санд бүртгэхтэй холбогдсон харилцааг зохицуулахаар тусгасан. Инновацийн төслийг бүртгэлжүүлэн, үйл ажиллагааг дэмжсэнээр оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулж, нэмүү өртөг шингээсэн, оюуны багтаамж, технологийн агууламж бүхий инновацийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэхэд тодорхой ахиц дэвшил гарна гэж үзэж байна.	100%
164.	1.2 Инновацийн төсөл хэрэгжүүлэх, грант олгох гэрээний загварыг боловсруулж, БСШУС-ын сайдаар батлуулна.	БСШУС-ын сайдын тушаал /Инновацийн төсөл хэрэгжүүлэх, грант олгох гэрээний загвар/	Инновацийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 99 дүгээр тогтоолоор батлагдсан “Инновацийн үйл ажиллагаанд оролцогчид грант олгох журам”-ыг тус тус үндэслэн “Инновацийн төсөлд грант олгох, хэрэгжүүлэх гэрээ”-ний загварыг боловсруулан БСШУС-ын сайдын 2019 оны А/123 дугаар тушаалаар батлууллаа. Энэхүү гэрээнд инновацийн төсөлд грант олгох, хэрэгжүүлэхтэй холбоотой харилцаа болон түүнд оролцогч талуудын эрх, үүргийг зохицуулахаар тусгасан.	100%
165.	1.3 Инновацийн төслөөр дотоод, гадаадын зах зээлд шинэ бараа, бүтээгдэхүүний	Инновацийн төслөөр дотоод, гадаадын зах зээлд шинэ бараа, бүтээгдэхүүний	Инновацийн төслөөр дотоод, гадаадын зах зээлд шинэ бараа, бүтээгдэхүүний үйлдвэрлэл явуулахад шаардлагатай дотоодод үйлдвэрлэдэггүй түүхий эд, материал, урвалж бодисын жагсаалт болон Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж Засгийн газраар хэлэлцүүлэхээр хүргүүллээ. Тогтоолын төсөлд тусгагдсан түүхий эд,	100%

	<p>үйлдвэрлэл явуулахад шаардлагатай, дотоодод үйлдвэрлэгдээгүй түүхий эд, материал, урвалж бодисын жагсаалтыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ.</p>	<p>үйлдвэрлэл явуулахад шаардлагатай, дотоодод үйлдвэрлэгдээгүй түүхий эд, материал, урвалж бодисын жагсаалт баталгаажсанаар</p>	<p>материал, урвалж бодисын жагсаалтад гоо сайхны бүтээгдэхүүний үйлдвэрлэл, лабораторийн оношлуур үйлдвэрлэл, биотехнологи, микробиологийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, байгалийн эрдэст бэлдмэлийн үйлдвэрлэл, эм, эм бэлдмэлийн үйлдвэрлэл, малын эм, эм бэлдмэл, шимт тэжээл, туршилтын үйлдвэрлэл зэрэг 7 салбарын 12 инновацийн төсөл хэрэгжүүлэгч байгууллагын 68 инновацийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд шаардлагатай 3 тэрбум 633 сая төгрөгийн өртөг бүхий 188 нэр төрлийн түүхий эд, материал, урвалж бодис хамрагдсан. Эдгээр түүхий эд, материал, урвалж бодисыг гаалийн татвараас 5 хувь буюу 183.9 сая төгрөг, нэмэгдсэн өртгийн албан татвараас 10 хувь буюу 381.7 сая төгрөгийг чөлөөлснөөр инновацийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид нийт 565.6 сая төгрөгийн татварын хөнгөлөлт эдлэх боломж бүрдэх юм.</p>	
166.	<p>1.4 "Эрдэм шинжилгээний байгууллагын дэргэд гарааны компани байгуулах журам"-д нэмэлт, өөрчлөлт оруулна.***</p>	<p>Журмын нэмэлт, өөрчлөлт баталгаажсанаар</p>	<p>Эрдэм шинжилгээний байгууллагын дэргэд гарааны компани байгуулах журам"-д нэмэлт өөрчлөлт оруулахаар Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, хэлэлцүүлэхээр Засгийн газарт хүргүүлэв.</p> <p>Энэхүү журам нь эрдэм шинжилгээний байгууллагын эрдэмтэн, судлаачид болон өөрсдийн нөөц, санхүүгийн боломжоор технологийн компани байгуулан тодорхой үр дүн гаргаж буй эдийн засагт үр нөлөө үзүүлж байгаа хувийн хэвшлийнхнийг дэмжих, тэдний судалгааны ажлын үр дүн, оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулах зорилготой.</p> <p>Журам батлагдсанаар эрдэм шинжилгээний байгууллагын дэргэд байгуулагдсан гарааны компаниудаас гадна хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгжүүд, хамтын оффисуудад бойжиж байгаа сайн бизнесийн санаатай боловч санхүүгийн боломж чадавхгүй эхлэлийн бизнес эрхлэгчдэд адил тэгш боломжийг бий болгоно.</p>	100%
<p>Хоёр. Инновацийн үйл ажиллагааны хэрэгжилтийг зохион байгуулах, мэргэжил арга зүйн удирдамжаар хангах, зохицуулах</p>				
167.	<p>2.1 Технологи дамжуулах төв, технологийн инкубатор зэрэг инновацийн дэд бүтцийг хөгжүүлэх, инновацийн тогтолцоог</p>	<p>Технологи дамжуулах төв, технологийн инкубатор байгуулагдсан байна</p>	<p>БНХАУ-тай хамтран "Монгол Улсад инкубаторын үйл ажиллагааг хэрэгжүүлэх болон мэдээллийн серверийн бүтээн байгуулалт", "Хятад-Монголын Технологи дамжуулах төвийн платформыг байгуулах" төслүүдийг хэрэгжүүлж байна.</p> <p>Инкубатор байгуулах тохижилтын зураг, интериор зургийг боловсруулан, сүлжээ, серверийн тоног төхөөрөмжүүдийг тээвэрлэх, зөөх, гаалийн</p>	100%

	бэхжүүлэх ажлыг зохион байгуулна.		<p>татвараас чөлөөлүүлэх зэрэг холбогдох арга хэмжээг авч ажилласан. Төслийн хүрээнд firewall, server, storage, switch, router зэрэг 20-иод нэр төрлийн сүлжээний тоног төхөөрөмжүүдтэй 100 терабайт мэдээлэл хадгалах боломжтой сервер байгуулагдсан.</p> <p>“Хятад-Монголын Технологи дамжуулах төвийн платформыг байгуулах” төслийн 2019 оны ажлын нарийвчилсан төлөвлөгөө боловсруулан баталж, хэрэгжилт гүйцэтгэлийг ханган ажилласан. Технологи дамжуулах төвийн дотоод тохижилтын зураг, интерьер зургийг боловсруулсан. Мэдээллийн сан нь монгол, хятад, англи 3 хэл дээр ажиллах боломжтой байхаар Технологи дамжуулах платформын хөгжүүлэлтийг хийж байна.</p> <p>Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй инновацийн дэд бүтэц болох инкубатор төв, дундын оффис, технологи дамжуулах төвүүдийн нэгдсэн судалгааг гаргасан.</p>	
168.	2.2 Инновацийн үйл ажиллагаанд оролцогчид грант олгох ажлыг зохион байгуулна.	БСШУС-ын сайдын тушаал /грант олгосон салбар чиглэл, грантын хэмжээ/	<p>“Инновацийн үйл ажиллагаанд оролцогчид грант олгох журам”-ын дагуу инновацийн төслийг сонгон шалгаруулж, БСШУС-ын сайдын 2019 оны А/326 тоот тушаалаар 5 инновацийн төсөлд нийт 300 сая төгрөгийн грант олгохоор шийдвэрлэсэн. Төсөл хэрэгжүүлэгч байгууллагуудтай “Инновацийн төсөлд грант олгох, хэрэгжүүлэх гэрээ” байгуулан, хэрэгжилт гүйцэтгэлийг ханган ажиллаж байна.</p> <p>Инновацийн үйл ажиллагаанд оролцогчид грант олгох нь инновацийн бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд гаргах, эдийн засгийн үр ашиг, өрсөлдөх чадвар, бүтээмжийг дээшлүүлэх, дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, нутагшуулах зэрэг ач холбогдолтой гэж үзэж байна.</p>	100%
169.	2.3 Шинжлэх ухааны паркийн захиргааны үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан, хэрэгжилтийг зохион байгуулна.	Шинжлэх ухааны паркийн захиргааны үйл ажиллагааны төлөвлөгөө батлагдсан байна.	<p>“Шинжлэх ухааны паркийн захиргаа” шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн нэгдлийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, үр дүнгийн гэрээг боловсруулан, БСШУС-ын сайдаар батлуулан, хэрэгжилт гүйцэтгэлийг ханган ажилласан. “Шинжлэх ухааны паркийн захиргаа” шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн нэгдлийн захирал Б.Бат-Өлзийгийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, үр дүнгийн гэрээний биелэл, тайланг БСШУС-ын сайдын 2019 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/796 тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлэв.</p>	100%



170.	2.4 Шинжлэх ухааны парк байгуулах техник эдийн засгийн урьдчилсан судалгаа боловсруулахад шаардлагатай арга хэмжээг авч ажиллана.	Шинжлэх ухааны парк байгуулах техник эдийн засгийн урьдчилсан судалгааны тайлан	<p>Шинжлэх ухааны паркийн техник эдийн засгийн урьдчилсан судалгааг Монгол Улсын шинжлэх ухаан, технологи, инновацийн хөгжлийн өнөөгийн байдал, бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан парк байгуулснаар бий болох үр нөлөө, эдийн засгийн хэрэгцээ шаардлага, гадаад орнуудын туршлага, холбогдох судалгаанд үндэслэн боловсруулсан. Судалгааны ажлууд дээр үндэслэн "Монгол Улсад Шинжлэх ухааны парк байгуулах техник, эдийн засгийн үндэслэл" боловсруулах ажлын /техникийн/ даалгаврыг боловсруулсан.</p> <p>Монгол Улсын БСШУС-ын сайд 2019 оны 12 сарын 3-4-ний өдрүүдэд БНХАУ-д айлчлал хийсэн. Айлчлалын хүрээнд зохион байгуулагдсан Монгол Улсын БСШУС-ын сайд, БНХАУ-ын Шинжлэх ухаан, технологийн сайд Ван Жи Ган нарын уулзалтаар Монгол Улсад Шинжлэх ухааны паркийн байгуулах нарийвчилсан төлөвлөгөө, ТЭЗҮ боловсруулахад БНХАУ дэмжиж ажиллахаа илэрхийлсэн.</p>	100%
171.	2.5 Технологийн туршилт зүгшрүүлэлтийн төслийг сонгон шалгаруулж, хэрэгжилтийг зохион байгуулна.	БСШУС-ын сайдын тушаал /шалгарсан төслийн тоо, олгох санхүүжилтийн хэмжээ/	<p>"Шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх журам"-ын дагуу технологийн туршилт, зүгшрүүлэлтийн төслийг сонгон шалгаруулж БСШУС-ын сайдын 2019 оны "Технологийн туршилт, зүгшрүүлэлтийн төсөл батлах, санхүүжүүлэх тухай" А/450 дугаар тушаалаар 18 төсөлд 2019 онд 300 сая төгрөгийн санхүүжүүлэлт олгохоор шийдвэрлэсэн. Төсөл хэрэгжүүлэгч байгууллагуудтай технологийн туршилт, зүгшрүүлэлтийн төсөл хэрэгжүүлэх, санхүүжүүлэх гэрээ байгуулан, хэрэгжилт гүйцэтгэлийг ханган ажиллаж байна.</p>	100%
172.	2.6 Их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагын дэргэд гарааны компани байгуулах ажлыг зохион байгуулна.	Байгуулагдсан гарааны компанийн тоо баталгаажсанаар	<p>Их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагын дэргэд гарааны компани байгуулахаар Хими, химийн технологийн хүрээлэнгийн дэргэд гарааны био бүтээгдэхүүн ХХК, МУИС-ийн дэргэд гарааны дижитал солюшнс ХХК, Ерөнхий болон сорилын биологийн хүрээлэнгийн дэргэд Гарааны био увидас ХХК –аас ирүүлсэн хүсэлт, холбогдох материалыг хүлээн авсан. Ирүүлсэн хүсэлтийг судлан, шинжээчийн дүгнэлт гаргууллаа.</p> <p>Мөн эрдэм шинжилгээний байгууллагын дэргэд гарааны компани байгуулах журмын 1.6 дахь заалтыг үндэслэн гарааны компанийн үйл ажиллагааг 2 жилээр сунгах дүгнэлтийг Гарааны цахирам ХХК, Гарааны технологийн инкубатор ХХК, Гарааны рецептор ХХК, Гарааны эврита ХХК, Гарааны дархан элит ХХК, Гарааны монгол экологийн бордоо ХХК,</p>	100%

			<p>Гарааны дерма лаб ХХК, Гарааны монбиотек ХХК, Гарааны гурван хүч ХХК, Гарааны ветбиотек ХХК, Гарааны праймер ХХК-уудад гаргууллаа.</p> <p>2016-2019 оны хооронд нийт 45 гарааны компани байгуулагдсанаас 11 гарааны компани бойжигдож зах зээлрүү шилжсэн. 2019 онд шинээр 3 гарааны компани байгуулагдаж 1 гарааны компани байгуулах хүсэлт ХААИС-иас ирүүлснийг шинжээчийн дүгнэлт гаргуулан Улсын бүртгэлийн газарт хүргүүлээд байна. Мөн 2015-2016 онд байгуулагдсан 11 гарааны компани журмын дагуу 2 жилээр хугацаа сунгуулахаар хүсэлт гарган ирүүлснийг үйл ажиллагааны тайланд шинжээчдээр дүгнэлт гаргуулан ажиллаж Улсын бүртгэлийн ерөнхий газарт хүргүүлэн сунгасан. 2019 оны 10 сарын байдлаар нийт 34 гарааны компани үйл ажиллагаа явуулж байна.</p>	
173.	2.7.Гарааны компани, гарааны бизнесийг дэмжиж, өрсөлдөх чадварыг нь дээшлүүлэх, инновацийн бүтээгдэхүүнийг дотоод, гадаад зах зээлд гарахад дэмжлэг үзүүлж хамтран ажиллана.	Зохион байгуулагдсан сургалтын тоо, агуулга чиглэл, зарцуулсан санхүүжилтийн хэмжээ/	<p>“Гарааны бизнесийг дэмжих, инновацийн соёлыг төлөвшүүлэх, гарааны бизнес эрхлэгчдийн мэдлэг, чадавхыг сайжруулахад чиглэсэн гарааны компани, инновацийн мэргэжилтнүүдэд зориулсан “Гарааны компани, инновацийн хүний нөөцийг чадавхжуулах сургалтыг 2019 оны 9 сарын 19-21 хооронд амжилттай зохион байгууллаа. Энэ удаагийн сургалтын сургагч, чиглүүлэгч багшаар Start компанийн багш нар болон БНХАУ-ын гарааны компани, инкубаторын удирдагч зочин багш Чэн хун цай, Чэн жүн нар урилгаар оролцож, 34 их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагын дэргэдэх гарааны компаниуд, 30 орчим хамтын оффисуудад бойжиж буй багуудын төлөөлөл болон инновацийн мэргэжилтэн, судлаачдыг хамрууллаа. 3 өдрийн сургалтаар энтрепренершип, хөрөнгө оруулалт, бизнес модель, стартапын эко систем, компанийн бүтэц, соёлыг хэрхэн төлөвшүүлэх, гарааны бизнесийг дэмжих, инкубацыг хөгжүүлэх зэрэг сэдвүүдээр хэлэлцүүлэг, сургалт зохион байгуулагдлаа.</p>	100%
<p>Гурав. Инновацийн эрх зүйн орчин, бодлого, зохицуулалт, үйл ажиллагааг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх</p>				

174.	3.1 Шинжлэх ухаан, технологи, инновацийн үр дүнг түгээн дэлгэрүүлэх, нийгмийг соён гэгээрүүлэх, мэдлэгийг сурталчлан таниулах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ.	ШУТБГ-ын даргын баталснаар /батлагдсан арга хэмжээ, санхүүжилтийн хэмжээ, хэрэгжилтийн тайлан/	<p>Шинжлэх ухаан, технологи инновацийг түгээн дэлгэрүүлэх чиглэлээр төлөвлөгөө боловсруулж дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:</p> <p>1."Шинжлэх ухаан, технологийн хөгжлийг сэтгүүл зүйгээр дамжуулан олон нийтэд түгээн дэлгэрүүлэх" сэдэвт шинжлэх ухаан, хэвлэл мэдээллийн салбар дундын сургалт хэлэлцүүлэг, хамтын ажиллагааны шинжлэх ухаан технологийн сантай хамтран зохион байгуулав. Энэхүү арга хэмжээнд Монголын хэвлэл мэдээллийн байгууллага тв, сайт, өдөр тутмын сонины сэтгүүлчид, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эрдэмтэн, судлаачдын 60 гаруй төлөөлөл оролцлоо</p> <p>2.Шинжлэх ухааны ололтыг хөдөө орон нутагт түгээн дэлгэрүүлэх, сурталчлах төлөвлөн ажиллаж байна. Шинжлэх ухааны мэдлэг, технологийн ололт амжилтыг хөдөө орон нутагт түгээн дэлгэрүүлэх арга хэмжээ зохион байгуулах зорилгоор БСШУС-ын сайдын 2019 оны 5 сарын 3 өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/268 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг төлөвлөгөө боловсруулах, хэрэгжилтийг хангах чиглэлээр ажиллаж байна. Энэхүү үйл ажиллагааг “Мэдлэг түгээж соёл дэлгэрүүлэх” аяны уриан дор зохион байгуулна.</p> <p>3.Шинжлэх ухаан, технологи инновацийн талаар төрөөс баримталж байгаа бодлого, дэлхийн болон Монголын шинжлэх ухаан, техник технологийн хамгийн сүүлчийн ололт, амжилтыг олон нийтэд өргөн сурталчлах, шинжлэх ухааны салбарт хийгдэж байгаа судалгаа шинжилгээний ажлын үр дүнг үйлдвэрлэлд түргэн шуурхай нэвтрүүлэх, дэлхийн шинжлэх ухааны төвүүдтэй хамтран ажиллахад тус дөхөм үзүүлэх зорилготой ашгийн бус шинжлэх ухааны сэтгүүлчдийн клуб төрийн бус байгууллагатай хамтран ажиллах төлөвлөгөөний төслийг боловсруулж байна.</p>	100%
175.	3.2 “Инновацийн 7 хоног” арга хэмжээг төлөвлөн, зохион байгуулна.	БСШУС-ын сайдын тушаал /Инновацийн форумын хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээ, зарцуулсан	Монголын улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн хүрээнд инновацийн соёлыг төлөвшүүлж, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, инновацийн түншлэл, хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор “Инновацийн 7 хоног-2019” арга хэмжээг 2019 оны 5 сарын 6-13-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгууллаа. Арга хэмжээг БСШУС-ын яам, ҮХГ, Нийслэлийн шинжлэх ухаан, үйлдвэрлэл, инновацийн газар, Оюуны өмчийн газар, ШУТС, ШУА, ШУТИС, СУИС, ХААИС, БХИС, МУИС, АШУУИС, МУБИС, МҮХАҮТ, Монголын залуу эрдэмтдийн холбоо ТББ, Монголын хамтын	100%

		санхүүжилтийн хэмжээ/	оффисын холбоо ТББ зэрэг байгууллагууд “Хамтын инноваци” уриан дор хамтран зохион байгуулсан. Арга хэмжээний хүрээнд инновацийн үйл ажиллагаанд оролцогч талуудын уулзалт хэлэлцүүлгүүд, олон улсын эрдэм шинжилгээний хурал, инновацийн бүтээгдэхүүний үзэсгэлэн, олон төрлийн хакатон уралдаант тэмцээнүүд явагдаж, инновацийн хамтын ажиллагаа, түншлэлийн боломжууд нээх, олон нийтэд инновацийн бүтээгдэхүүнийг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх ажлууд хийгдсэн. Инновацийн 7 хоног арга хэмжээний үеэр оролцогчдоос тус салбарын үйл ажиллагаа, цаашид хэрэгжүүлэх бодлогын талаар санал, зөвлөмжүүдийг авч, боловсруулж байгаа бодлогын болон бусад бичиг баримтад тусган, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	
<b>СОЁЛ УРЛАГИЙН БОДЛОГЫН ГАЗАР</b>				
Нэг. "Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл-2019"-ийн зорилтыг хангахад чиглэсэн арга хэмжээ:				
Соёл, урлаг, шинжлэх ухааны салбарын ажиллагсдын хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлэх				
176.	1.1. Соёл, урлагийн ажилтны мэргэшлийн болон ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлтийг боловсруулна. /12.3/	Шалгуур үзүүлэлтийн төслийг боловсруулж холбогдох яамдад хүргүүлсэн байна.  III-VII сар	1."Соёл, урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл"-ийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар 7 сарын 3 өдрийн 276 дугаар тогтоолоор батлуулсан. 2. Соёл, урлагийн ажилтны мэргэшлийн нэмэгдэл олгох заалтыг Соёлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгасан. 3. Засгийн газрын 2018 оны “Журам батлах тухай” 382 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл олгох журмыг хэрэгжүүлэх зорилгоор соёлын ажилтанд ур чадвар болон мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлтийг боловсруулж, БСШУС-ын сайдын 2019 оны 10 сарын 31 өдрийн 16/9563 тоот албан бичгээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзоригт хүргүүлсэн. 4.Соёл, урлагийн ажилтны мэргэшлийн болон ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлтийг боловсруулж санал авахаар 3 сарын 14 өдрийн 7/1849 тоотоор Соёл, урлагийн газарт хүргүүлж, саналыг журмын төсөлд тусган боловсруулж байна.	100%

177.	1.2. “Үндэсний /соёлын ажилтан/ ажил, мэргэжлийн ангилал ба тодорхойлолтыг боловсруулна./12.3/	Төслийг боловсруулж Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн байна.  I-IV сар	БСШУС-ын сайдын 16/10675 тоот албан бичгээр Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2010 оны “Үндэсний ажил, мэргэжил, албан тушаалын жагсаалт, ангилал, тодорхойлолт батлах тухай” 16 дугаар тушаалаар батлагдсан “Монгол Улсын Үндэсний ажил мэргэжлийн ангилал ба тодорхойлолт-08” (YAMAT-08)-д заасан соёл, урлагийн салбарын үндэсний ажил, мэргэжлийн ангилал ба тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж төслийг хүргүүлсэн. ICCO-88, YAMAT-08-ын үзэл баримтлал, суурь зарчимд дүйцүүлэн соёл, урлагийн 200 гаруй ажил, мэргэжлийн ангилал, тодорхойлолтыг шинэчлэн боловсрууллаа.	100%
178.	2.1. “Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэх, гавьяат үйлстнийг алдаршуулах, дурсгалыг нь мөнхжүүлэх журам”-д нэмэлт өөрчлөлт оруулна. /Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5.2/	Журмын төслийг боловсруулж Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн байна.	БСШУС-ын сайдын 1а/3187 албан тоотор “Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэх, гавьяат үйлстнийг алдаршуулах, дурсгалыг нь мөнхжүүлэх журам”-ын шинэчилсэн журмын төсөлд Засгийн газрын гишүүдээс санал аван нэгтгэн 5 сарын 10 өдөр 16/4140 тоотор Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүргүүлсэн. Засгийн газрын 2019 оны 5 сарын 22 өдрийн “Журам батлах тухай” 204 дүгээр тогтоолоор батлуулсан.	100%
179.	2.2. Хувийн номын санд дэмжлэг үзүүлэх журмыг батална. /Номын сангийн тухай хуулийн 24.3/	Журмыг батлуулж, улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн байна.	“Чухал ач холбогдол бүхий ганц хувь бүтээл хадгалагдаж байгаа хувийн номын санд дэмжлэг үзүүлэх журам”-ын төслийг боловсруулж, үр нөлөөний болон тандалт судалгаа хийсэн. Журмын төслийг 5 сарын Үндэсний номын сангийн Мэргэжлийн зөвлөлийн хурлаар, 6 сарын 18 өдөр төв, орон нутгийн номын сангийн удирдлагуудын дунд тус тус хэлэлцүүлсэн. Мөн <a href="http://nationallibrary.mn/mn/uploads/files/2019">http://nationallibrary.mn/mn/uploads/files/2019</a> сайтад байршуулан онлайн санал авсан. Журмын төслийг яамны удирдлагуудад танилцуулж байна.	70%
180.	2.3. Аймаг, нийслэлийн Боловсролын газрын дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулна.	Дүрэмд соёлын талаарх чиг үүрэг тусгагдаж, дүрэм батлагдсан байна.	Аймгийн боловсролын газарт өөрчлөлт орж Боловсрол, соёл, урлагийн газар болсонтой холбогдуулан Аймаг нийслэлийн Боловсролын газрын дүрмийг Аймаг нийслэлийн Боловсрол, соёл, урлагийн газрын дүрэм болгож өөрчлөх төслийг боловсрууллаа. Улсын Их Хуралд өргөн барьсан Соёлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 16	70%

			дугаар зүйлийн 16.5. дахь заалтад “Аймаг, нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд соёлын газар ажиллана” гэж заасны дагуу хуулийн төсөл батлагдсаны дараа дүрмийг батлуулна.	
181.	2.4. Соёл, урлагийн салбарын ажилтнуудыг гадаад, дотоодод сургах, мэргэжил дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. /Төрөөс баримтлах соёлын бодлого 4.2.8/	Соёлын ажилтнууд сургалтад хамрагдсан байна.	<p>а) БСШУС-ын сайдын 5 дугаар сарын 17 өдрийн А/313 дугаар тушаалаар “Соёл, урлагийн байгууллагын тогтвортой хөгжил-удирдахуйн шинэлэг хандлага III” сургалтыг 2019 оны 5 сарын 29-30 өдрүүдэд зохион байгуулж, аймгийн Засаг даргын тамгын газар, Боловсрол, соёл, урлагийн газрын соёлын мэргэжилтэн, орон нутгийн соёл, урлагийн байгууллагын удирдлагууд 115 хүн хамруулсан.</p> <p>б) 2019-2020 оны хичээлийн жилд ОХУ-д соёл, урлагийн чиглэлээр суралцах оюутны урьдчилсан сонгон шалгаруулалтыг Россотрудничества агентлагтай хамтран зохион байгууллаа. Шалгалтад сонгон шалгаруулалтаар уран барималч, балетмейстр, хөгжмийн зохиолч, төгөлдөр хуурч, театрын зураач, урлаг судлаач зэрэг нарийн мэргэжлээр 12 тэнцэж ОХУ-д илгээлээ.</p> <p>в) БСШУС-ын сайдын БНХАУ-д хийсэн айлчлалын үеэр тус улсад циркийн урлагийн чиглэлээр 20 хүүхэд бэлтгэхээр шийдвэрлүүлээ.</p>	100%
182.	2.5. Дурсгалт зүйлийг “Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалтад нэр дэвшүүлэх, хянан шийдвэрлэх журам”-ыг батлуулна.	Журмын төслийг боловсруулж Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн байна.	<p>Дурсгалт зүйлийг хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалтад нэр дэвшүүлэх, хянан шийдвэрлэх журмын төслийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж, яамдаас санал авч нэгтгээд Засгийн газрын шийдвэрийн төсөл танилцуулгын хамт дэд сайдын 2019 оны 5 сарын 10 өдрийн 16/4139 тоот албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2019 оны 5 сарын 17 өдрийн ХЭГ/1395 тоот албан бичгээр Засгийн газрын шийдвэрийн төсөл нь Захиргааны ерөнхий хуулийн 64.1-д заасан "Захиргааны хэм хэмжээний актыг хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллага батална" гэсэн заалттай нийцэхгүй гэж үзээд буцааж ирүүлсэн. Үүнтэй холбогдуулан Соёлын өвийг хамгаалах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд дээрх журмыг батлах эрхийг Засгийн газрын бүрэн эрхэд тусган Соёлын тухай хуулийг дагуулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.</p>	100%

183.	2.6. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалд хамгаалалтын бүс тогтоох журмыг батлуулна.	Журмын төслийг боловсруулж Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн байна.	Соёлын өвийг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд хамгаалалтын бүсийг тогтоох, аюулгүй байдлыг хангахтай холбоотой заалтыг, Газрын тухай хуульд хамгаалалтын бүсийн газрыг улсын тусгай хэрэгцээний газрын бүрэлдэхүүн хэсэг болгох талаар зохих заалтыг нэмж тусгахаар хуулийн төслийг боловсруулан Соёлын тухай хуулийг дагуулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.	100%
184.	2.7. Соёлын өвийн дурсгалт газрын хамгаалалтын захиргааны дүрмийг батлуулна.	Журмын төслийг боловсруулж Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн байна.	Дэлхийн өв-Бурхан Халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутаг, Дэлхийн өв-Монгол Алтайн нурууны хадны зургийн цогцолборын хамгаалалтын захиргааны дүрмийг олон улсын гэрээ хэлэлцээр, үндэсний хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж, яамдаас санал авч тусган Засгийн газарт хүргүүллээ.	100%
185.	2.8. Шилдэг уран бүтээлч шалгаруулах журамд нэмэлт өөрчлөлт оруулна.	Журмын төслийг боловсруулж Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн байна.	Засгийн газрын 2008 оны 195 дугаар тогтоолоор “Шилдэг уран бүтээлч шалгаруулах журам”-д нэмэлт өөрчлөлт оруулахаар судалгаа хийж зохиолч, хөгжмийн зохиолч, удирдаач, продюсер, бүжиг дэглээч гэсэн төрлийг оруулж 2018 оны 354 дүгээр тогтоолоор “Соёлын биет бус өвийг үндэсний болон дэлхийн хэмжээнд сурталчлан алдаршуулах, түгээн дэлгэрүүлэхэд онцгой хувь нэмэр оруулсан өвлөн уламжлагчид мөнгөн шагнал олгох журам” батлагдсантай холбогдуулан соёлын өвийг өвлөн уламжлагч төрлийг хаслаа. Мөн шилдэг уран бүтээлч шалгаруулах орон тооны бус мэргэжлийн зөвлөл нь шилдэг уран бүтээлчид нэр дэвшүүлэх болох шилдгээр шалгарсан уран бүтээлчид “Мөнгөн мод” цом олгохоор тогтоолын төсөлд тусгалаа. Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж БСШУС-ын сайдын 2019 оны А/9877 тоот албан бичгээр яамдаас санал авч нэгтгэн сайдын А/10750 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүллээ.	100%
186.	2.9. Соёлын биет бус өвийг сурвалжлан олох, судалгаа шинжилгээ хийх журмыг шинэчлэн батлуулна.	Журмыг батлуулж, улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн байна.	Журмын төслийг шинэчлэн боловсруулж, салбарын эрдэмтэн судлаачдын дунд болоод яамны дэргэдэх Соёлын биет бус өвийн мэргэжлийн зөвлөлийн 2019 оны 11 сарын 2 өдрийн хурлаар тус тус хэлэлцүүлж, гишүүдийн саналыг авлаа. Мөн журмын төслийг яамны вэб хуудсанд байршуулж, олон нийтийн саналыг авч нэгтгэн журмыг батлуулсан	100%
187.	2.10. Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийг тогтоох, бүртгэх журам, соёлын биет бус өвийн	Журмыг батлуулж, улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн байна.	Журмын төслүүдийг шинэчлэн боловсруулж салбарын эрдэмтэн судлаачдын дунд 1 удаа хэлэлцүүлсэн. Журмын төслийг яамны дэргэдэх Соёлын биет бус өвийн мэргэжлийн зөвлөлийн 2019 оны 11 сарын 2 өдрийн хурлаар хэлэлцүүлж, гишүүдийн саналыг авлаа. Мөн журмын	100%

	мэргэжлийн зөвлөлийн ажиллах журмыг шинэчлэн боловсруулж, батлуулна.		төслийг яамны вэб хуудсанд байршуулж, олон нийтийн саналыг авч нэгтгэн, эцэслэн боловсруулж батлуулна.	
188.	2.11. Соёлын биет өвийг сэргээн засварлах болон мэргэжлийн зөвлөлийн ажиллах журмыг боловсруулж батлуулна.	Журмыг батлуулж, улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн байна.	Зөвлөлийн чиг үүрэг Төрийн хяналт шалгалтын тухай хуультай зөрчилдөж байгаа тул Соёлын өвийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд зөрчлийг арилгах заалтыг тусгасан.	100%
189.	2.12. Соёлын өвийг бүртгэл, мэдээллийн санд бүртгэх, мэдээллийг ашиглах журмыг шинэчлэн батлуулна.	Журмыг батлуулж, улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн байна.	Журмын төслийг боловсруулж бэлтгэсэн. Соёлын өвийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд соёлын өвийг бүртгэхтэй холбоотойгоор санал боловсруулан тусгаж, Соёлын тухай хуулийг дагалдуулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Холбогдох хуульд нэмэлт өөрчлөлтийг оруулсны дараа журмыг батлуулна.	70%
<b>Гурав. “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн зорилтыг хангахад чиглэсэн арга хэмжээ</b>				
190.	2.13. Түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалыг сэргээн засварлах журмыг шинэчлэн батлуулна.	Журмыг батлуулж, улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн байна.	Журмын төслүүдийг боловсруулж бэлтгэсэн. Соёлын биет өвийг сэргээн засварлах мэргэжлийн зөвлөлийн чиг үүрэг Төрийн хяналт шалгалтын тухай хуультай зөрчилдөж байгаа тул Соёлын өвийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд зөрчлийг арилгах заалтыг тусгасан. Дээрх зөвлөлийн үйл ажиллагааны гол чиглэл барилга, архитектурын дурсгалтай холбоотой тул журмуудыг уялдуулах зорилгоор хуульд нэмэлт өөрчлөлтийг оруулж хууль хоорондын зөрчил, давхардлыг арилгасны дараа батлуулна.	70%
191.	1.1. Соёлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж УИХ-д өргөн мэдүүлнэ. *** /3.2.42/	Хуулийн төсөл Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэгдэн УИХ-д өргөн баригдсан байна.	Хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг батлуулж, хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандалт судалгааны тайланг гаргаж, хуулийн үзэл баримтлалын төслийг боловсруулан ХЗДХ-ын сайдтай хамтран батлуулна. Хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж БСШУС-ын сайдын 2019 оны 6 сарын 7-ны 1а/5215 албан бичгээр яамдаас санал авч нэгтгэлээ. Соёлын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг төслийг Засгийн газрын 2019 оны 7	100%



			сарын 9-ний хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжиж 2019 оны 8 сарын 16 өдөр УИХ-д өргөн барилаа.	
192.	1.2. Музейн тухай хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийг боловсруулж УИХ-д өргөн мэдүүлнэ. ***/3.2.42/	Хуулийн үзэл баримтлал батлагдан, хуулийн төсөл Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэгдэн УИХ-д өргөн баригдсан байна.	Музейн үзэл баримтлалыг 2019 оны 7 сарын 10-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн сайд, БСШУС-ын сайдаар батлуулсан. Батлагдсан үзэл баримтлалд нийцүүлэн хуулийн төслийг боловсруулан яамны Хуулийн хэлтсээр хянуулж, зардлын тооцоо болон үр нөлөөний судалгааны ажлын тайланг бэлтгэж байна.	70%
193.	3.3. Киноны тухай хуулийн төслийг боловсруулж УИХ-д өргөн мэдүүлнэ. *** /3.2.42/	Хуулийн төсөл Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэгдэн УИХ-д өргөн баригдсан байна.	“Кино урлагийг дэмжих тухай” хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулж Хууль зүй дотоод хэргийн сайд, Сангийн сайдтай хамтран батлууллаа. Хуулийн төслийг боловсруулж яамдаас санал авч нэгтгэн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн 2019 оны 4 сарын 6 өдөр УИХ- өргөн барилаа.	100%
194.	3.4. Номын сангийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулна. /3.2.42/	Хуулийн төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн байна.	Соёлын тухай шинэчилсэн найруулгын дагалдах хуульд оруулахаар хуулийн төсөлд “Номын сангийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт” оруулах төслийг боловсруулж, Засгийн газрын 2019 оны 7 сарын 09-ний хуралдаанаар хэлэлцүүлэн 8 сарын 16 өдөр УИХ-д өргөн барьсан.	100%
195.	3.5. Соёлын өвийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна. /3.2.42/	Хуулийн төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн байна.	Соёлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг дагаж өргөн мэдүүлэх Соёлын өвийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Соёлын тухай хуулийг дагуулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.	100%
196.	3.6. “Архив, номын сангийн өв санг хадгалж хамгаалахад тавигдах шаардлага”	Стандартын төслийг шинэчлэн боловсруулж, Стандарт хэмжил	Улсын стандарт хэмжил зүйн газрын 6 сарын 13 өдрийн хуралдаанаар “Архив, номын сангийн өв санг хадгалж хамгаалахад тавигдах шаардлага” MNS:ISO 11799:2019, “Номын сангийн орчны нөхцөл, үйл	100%

	стандартын төслийг боловсруулна.	зүйн үндэсний төвд хүргүүлсэн байна.	ажиллагаанд тавигдах шаардлага” MNS 5472:2019 стандартууд батлагдсан.	
197.	3.7. Хүүхэд залуучуудад монгол ахуй, монгол өв соёлыг өвлүүлэх, дархлааг бий болгох “Монгол бахархал” аян зохион байгуулна. / ЗГҮАХХАХТ.3.2.39/	“Музейн боловсрол”, “Хүүхэд залуучуудын уншлагыг дэмжих аян”, “Монгол наадгай”, “Урлаг + хүүхэд + боловсрол” аян зохион байгуулагдсан байна.	1.БСШУС-ын сайдын 2018 оны “Музейн нээлттэй өдрүүд зохион байгуулах тухай” А/071 дүгээр тушаалын дагуу төрийн болон орон нутгийн музейгээс Монголын түүх, соёл, зан заншил, үндэсний бахархалт үнэт зүйлсийг сурталчлан таниулах чиглэлээр 10 музей 11 тусгай үзэсгэлэн, 12 музей 14 боловсролын ажил 1 эрдэм шинжилгээний хурал зохион байгуулсан байна. Энэ өдрүүдэд музейгээр 48119 хүүхэд, 47410 том хүн, 1080 гадаадын иргэн, нийт 96609 хүн үйлчлүүллээ. 2.“Дэлхийд данслагдсан монгол өв-Монгол наадгай” аянг зохион байгуулж аяны хүрээнд зохион байгуулсан үзэсгэлэнд нийслэлийн 4 дүүргийн 6 сургуулийн 5-7 -р ангийн 300 гаруй хүүхэд хамрагдаж, үндэсний тоглоом наадгайгаар тоглож суралцлаа.. 3.“Монгол бахархал” аяны хүрээнд хүүхдийн хөгжил хамгааллыг дэмжихэд хүүхдийн уран бүтээл, хүүхдийн театрын үүрэг, ач холбогдлыг таниулах, хүүхдийн уран бүтээл туурвигчид, хүүхдийн хөгжил, хамгааллын чиглэлээр ажиллаж буй төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор “Хүүхэд театр боловсрол” зөвлөгөөнийг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газартай хамтран 2019 оны 11 сарын 28-30 өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгууллаа. Аянаар Улсын Хүүхэлдэйн театр, Хүүхдийн Тэмүжин театр, Хүүхэд залуучуудын театрын уран бүтээлчид уран бүтээлийн дээжээс танилцууллаа.	100%
198.	3.8. Нийслэл хот дахь төрийн болон орон нутгийн өмчийн соёл урлагийн зориулалттай барилгын нөхцөл байдлыг үнэлж, мэргэжлийн соёл, урлагийн байгууллагуудыг уран бүтээл туурвих, тоглолт зохион байгуулах	Уран бүтээл туурвих тайз, дэлгэцийн хуваарилалт батлагдсан байна. V-XI	Нийслэл хот дахь төрийн болон орон нутгийн өмчийн соёл урлагийн зориулалттай барилгын тайзны ашиглалтад үнэлгээ хийж, мэргэжлийн соёл, урлагийн байгууллагуудыг уран бүтээл туурвих, тоглолт зохион байгуулах боломжийг судалж, хэрэгжүүлэхээр ажлыг эхлүүлж Соёлын төв өргөө, Улаанбаатар чуулгын байрны ашиглалтад судалгаа хийлээ. Соёлын төв өргөө тайзаа жилдээ 220 удаагийн тоглолт, 142 удаагийн бэлтгэл сургуулилт нийт 362 удаа буюу ашиглалт 99,1%, Улаанбаатар чуулга жил тайзаа жилдээ 97 удаагийн тоглолт, 112 удаагийн бэлтгэл сургуулилт, захиалгат ажилд 189 удаа нийт 398 удаа буюу ашиглалт 100 % байна. Нийслэлийн Засаг даргатай зөвшилцөж Соёлын төв өргөө,	100%

	боломжийг судалж, хэрэгжүүлнэ.		Улаанбаатар чуулгын тайзыг мэргэжлийн урлагийн байгууллагууд шаардлагатай тохиолдолд ашиглахаар шийдвэрлэлээ.	
199.	3.9. Халхын голын 1939 оны байлдааны ялалтын 80-н жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын соёлын өдрийг ОХУ-д, ОХУ-ын соёлын өдрийг өөрийн оронд зохион байгуулна.	Соёлын өдрүүдийг амжилттай зохион байгуулсан байна.	Халх голын ялалтын 80 жилийн ойг тохиолдуулан “Монголын соёлын өдрүүд”-ийг 2019 оны 6 сарын 7-11-ний өдрүүдэд ОХУ-ын Санкт-Петербург хотод зохион байгууллаа. Урлагийн тоглолтод улсын филармоний морин хуурын чуулга, үндэсний урлагийн их театр, дуурь бүжгийн эрдмийн театрын уран бүтээлчид оролцож ая дуугаа өргөлөө. Энэ удаагийн соёлын өдрүүдийн хүрээнд монголын түүх, бичиг соёлын өв, дурсгал, соёл урлагийг цогцоор нь харуулахыг зорьж нийт найман арга хэмжээг амжилттай зохион байгуулсан юм. Тодруулбал “Өнөөдрийн Улаанбаатар” гэрэл зургийн үзэсгэлэн Кировын нэрэмжит цэцэрлэгт хүрээлэнд, “Цагаан шөнө” задгай театрын тоглолт, “Петербург Монгол судлалын ууган төв болох нь” эрдэм шинжилгээний хурал, гар бичмэлийн үзэсгэлэн, Санкт-Петербургийн Улсын Их Сургуулийн Дорно дахин судлалын дээд сургуулийн Монгол, Төвд судлалын тэнхимийн төгсөгчдийн ёслолын арга хэмжээ, Рерихийн музейд Улаанбаатар хотын түүхээс сэдэвлэсэн гэрэл зургийн үзэсгэлэн, Петр хааны музей “Кунц камер”-т, Халхголын байлдааны ялалтын 80 жилийн ойд зориулсан гэрэл зургийн үзэсгэлэн, “Мөнх хөх тэнгэрийн орон” дүрслэх урлагийн үзэсгэлэнг тус тус зохион байгууллаа.	100%
200.	3.10. БНХАУ-тай дипломат харилцаа тогтоосны 70-н жилийн ойг тохиолдуулан зохион байгуулах соёл, урлагийн арга хэмжээний төлөвлөгөө гарган хэрэгжүүлнэ.	Дипломат харилцаа тогтоосон ойн төлөвлөгөө хэрэгжсэн байна.	Монгол Улс, БНХАУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 70 жилийн ойн хүрээнд “Хятан-Их Ляо улс: БНХАУ-ын Өвөрмонголын Хятаны шилдэг үзмэр” үзэсгэлэнг Монгол Улсын үндэсний түүхийн музейд 2019 оны 6 сарын 27 өдөр нээлээ. БНХАУ-ын ӨМӨЗО-д зохиогдсон “Монгол-Хятадын 3-р экспо”-д дуурь бүжгийн эрдмийн театр, Улсын филармонийн морин хуурын чуулга, цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулга, үндэсний дуу бүжгийн 215 гаруй уран бүтээлчид 2019 оны 9 сарын 05-11-нийг хүртэл амжилттай оролцлоо. “Монгол-Хятадын 3-р Экспо”-гийн хүрээнд БНХАУ-ын ӨМӨЗО-ны Улаанцав хотын спортын төвд Монгол, Хятад, ОХУ-ын уран бүтээлчдийн хамтарсан тоглолт, Хөх хотын Улаан театрт Б.Дамдинсүрэнгийн “Учиртай гурван толгой” дуурь, мөн хотод зохиогдсон олон улсын монгол бүжгийн уралдаанд манай уран бүтээлчид амжилттай оролцлоо. БНХАУ-ын Бээжин хотноо	100%

			Монголын соёлын өдрийг 2019 оны 12 сарын 1-10-ны хооронд зохион байгууллаа. Соёлын өдрүүдийн хүрээнд үндэсний урлагийн их театрын уран бүтээлийн тоглолт, монголын кино өдөрлөг, "Хөх тэнгэрийн орноор" гэрэл зургийн үзэсгэлэнг амжилттай зохион байгууллаа.	
<b>Дөрөв. Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах хүрээнд</b>				
201.	4.1. "Чулуун соёлын өв" хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж батлуулна.	Төлөвлөгөө батлагдсан байна.	БСШУС-ын сайдын 2019 оны А/368 тоот тушаалаар хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлуулж, холбогдох байгууллагуудад хүргүүлэн хэрэгжилтийг хангаж байна.	100%
202.	4.2. "Соёлын биет бус өвийг хамгаалах үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж батлуулна.	Төлөвлөгөө батлагдсан байна.	а) БСШУС-ын сайдын 2019 оны 4 сарын 23 өдрийн "Төлөвлөгөө батлах тухай" А/235 дугаартай тушаалаар "Соёлын биет бус өвийг хамгаалах" /2019-2023/ үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх дунд хугацааны төлөвлөгөөг боловсруулан батлуулаад байна. Төлөвлөгөөнд 5 жилийн хугацаанд 4 зорилтын хүрээнд 14 арга хэмжээг хэрэгжүүлэхээр нийт 59 бүтээгдэхүүн үйлчилгээ үзүүлэхээр тусгагдсан. Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд 2019-2023 онд нийт 11,8 тэрбум төгрөгийн санхүүжилт шаардлагатай тооцоо гарсан болно. б) БСШУС-ын сайдын 2019 оны 3 сарын 25 өдрийн "Чиглэл хүргүүлэх тухай" А/2210 дугаартай албан бичгээр "Соёлын биет бус өвийг хамгаалах" үндэсний хөтөлбөрийг тогтоолын хамт 21 аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлж, уг тогтоолын 2 дугаар заалтад байгаа " орон нутагт дэд хөтөлбөрийг баталж, хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосон"-ыг уламжилж, хэрэгжилтийг хангаж ажиллах талаар үүрэг өглөө.	100%
203.	4.3. "Соёлын баримтат өвийг хамгаалах" хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж батлуулна.	Төлөвлөгөө батлагдсан байна.	Төлөвлөгөөний төсөлд холбогдох байгууллагаас санал авч нэгтгэж, батлуулахад бэлэн болоод байна. Соёлын баримтат өвийг хамгаалах" хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилт 2019 онд төсөвт тусгагдаагүй тул уг хөтөлбөрийн төлөвлөгөөг 2020 онд батлуулж, 2020 оны сайдын багц дахь соёл, урлаг дэмжих зардлын ангиллын төсөвт хөрөнгө тусгуулан, хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.	70%

204.	4.4. “Соёлын бүтээлч үйлдвэрлэл” хөтөлбөрийг 2019-2020 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж батлуулна.	Төлөвлөгөө батлагдсан байна.	Төлөвлөгөөний төслийг боловсруулахаар холбогдох байгууллагаас санал авч нэгтгэж, батлуулахад бэлэн болоод байна. Төлөвлөгөөний төслийг яамны удирдлагуудад танилцуулж байна.	70%
205.	4.5. “Монгол уран бүтээл” хөтөлбөрийг 2019-2020 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж батлуулна.	Төлөвлөгөө батлагдсан байна.	Үндэсний хөтөлбөрийн төлөвлөгөөний төслийг яамны удирдлагуудад танилцуулж байна. Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Соёл, урлагийг дэмжих сангаас 2019 онд дараах төсөл, хөтөлбөр шалгаруулж санхүүжилтийн дэмжлэг үзүүллээ. Үүнд: 1."Хөхөө шувууны домог" бүрэн хэмжээний хүүхэлдэйн жүжгийн төсөлд 10 сая 2."Монгол Хатад" 3 ангит баримтат киноны төсөлд 40 сая 3."Бөөгийн домог" уран сайхны киноны төсөлд 25 сая 4. "Бүнээ Сүнээ хоёр" хүүхдийн олон ангит анимейшн киноны төсөлд 25 сая 5. "Монгол Уламжлалт эрүүл хүнс" баримтат киноны төсөлд 10 сая 6. "Монгол хүү" киног орос, англи хэл рүү дуу оруулах" төсөлд 40 сая 7."Зая гэгээнтэн" төсөлд 10 сая 8. "Их домог аугаа соёл" бүтээлч төсөлд 25 сая төгрөгийн санхүүжилтийн дэмжлэгийг тус тус үзүүлж хэрэгжилтийг ханган ажиллалаа.	70%
206.	4.6. “Сонгодог урлаг-III” хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж батлуулна.	Төлөвлөгөө батлагдсан байна.	а) БСШУС-ын сайдын 2019 оны 4 сарын 23 өдрийн “Төлөвлөгөө батлах тухай” А/236 дугаартай тушаалаар “Сонгодог урлаг-III” /2018-2023/ үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх дунд хугацаанд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулаад байна. Төлөвлөгөөнд 5 жилийн хугацаанд 6 зорилтын хүрээнд 30 арга хэмжээг хэрэгжүүлэхээр нийт 91 бүтээгдэхүүн үйлчилгээ үзүүлэхээр тусгагдсан. Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд 2019-2023 онд нийт 15,8 тэрбум төгрөгийн санхүүжилт шаардлагатай тооцоо гарсан болно. б) БСШУС-ын сайдын 2019 оны 3 сарын 25 өдрийн “Чиглэл хүргүүлэх тухай” а/2210 дугаартай албан бичгээр “Сонгодог урлаг-III” үндэсний хөтөлбөрийг тогтоолын хамт 21 аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлж, уг тогтоолын 2 дугаар заалтад байгаа “ орон нутагт дэд хөтөлбөрийг баталж, хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг аймаг,	100%

			нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосон"-ыг уламжилж, хэрэгжилтийг хангаж ажиллах талаар үүрэг өглөө.	
<b>Тав. Хууль, дүрэм журам, бодлогын хэрэгжилт"-ийг хангахад чиглэсэн арга хэмжээ:</b>				
207.	5.1. Соёлын биет бус өвийн Төлөөллийн болон Яаралтай хамгаалах шаардлагатай СББӨ-ийн үндэсний бүртгэлийн жагсаалтыг шинэчлэн батална.	СББӨ-ийн үндэсний бүртгэлийн жагсаалт шинэчлэн батлагдсан байна.	ССАЖ-ын сайдын 2013 оны 2 сарын 8 өдрийн А/41 дүгээр тушаалаар яаралтай хамгаалах шаардлагатай Монгол Улсын соёлын биет бус өвийн төлөөллийн болон үндэсний бүртгэлийн жагсаалтыг нийт 96 өвийг багтаан баталсан байдаг. Энэхүү жагсаалтыг шинэчлэн боловсруулж, яамны дэргэдэх Соёлын биет бус өвийн мэргэжлийн зөвлөлийн 2 удаагийн хурлаар хэлэлцүүлж, 96 өвийг ЮНЕСКО-гийн Соёлын биет бус өвийг хамгаалах тухай конвенцыг үндэслэн шинэчлэн боловсрууллаа. Шинэчилсэн жагсаалтын "Төлөөллийн жагсаалтад – 239 ширхэг өв, яаралтай хамгаалах жагсаалтад – 96, нийт 335 өвийн жагсаалтыг эцэслэн боловсруулаад байна. Шинэчилсэн жагсаалтыг яамны дэргэдэх Соёлын биет бус өвийн мэргэжлийн зөвлөлийн 2019 оны 11 сарын 2 өдрийн хурлаар хэлэлцүүлж, гишүүдийн саналыг авч тусган БСШУС-ын сайдын 2019 оны "Бүртгэл шинэчлэн батлах тухай" А/759 дүгээр тушаалаар батлуулаад байна. Шинэчилсэн жагсаалтыг албаны хэрэгцээнд ашиглуулахаар КГХА соёл, урлагийн газар болон соёлын өвийн үндэсний төвд тус тус хүргүүлээ.	100%
208.	5.2. Соёлын биет бус өвийг ур чадварын өндөр түвшинд өвлөн эзэмшсэн өвлөн уламжлагчийн үндэсний жагсаалт"-ыг шинэчлэн батална.	Өвлөн уламжлагчдын үндэсний жагсаалт шинэчлэн батлагдсан байна.	"Соёлын биет бус өвийг ур чадварын өндөр түвшинд өвлөн эзэмшсэн өвлөн уламжлагчийн үндэсний жагсаалт"-ыг шинэчлэн боловсруулж, журмын дагуу аймаг, нийслэлээс санал авч Соёлын өвийн үндэсний төвийн дэргэдэх мэргэжлийн зөвлөлийн саналаар шинээр нэр дэвшигчдийг тодруулан БСШУС-ын яамны дэргэдэх "Соёлын биет бус өвийн мэргэжлийн зөвлөл"-д танилцуулан жагсаалтыг эцэслээд байна. Жагсаалтыг Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 13.1.8-д заасны дагуу Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулгыг боловсруулан яамдаас санал авсан. Энэ хүрээнд нийт яамдаас дээрх Засгийн газрын тогтоолын төслийг дэмжсэн байна. Сангийн яамнаас уг жагсаалтыг баталснаар төсөвт үүсэх нөлөөлөл, өвлөн уламжлагчдыг тодруулан алдаршуулах, шавь сургалтыг дэмжих болон шагнаж урамшуулахад шаардагдах санхүүгийн	100%

			тооцооллыг боловсруулж ирүүлэх талаар тодруулга хүссэн тул тооцоолол судалгааг боловсруулан 2019 оны 12 сарын 9 өдрийн 1а/10551 дугаартай албан бичгээр Сангийн сайдаас дахин санал авахаар хүргүүлж, Засгийн газрын 2019 оны 475 дугаар тогтоолоор жагсаалтыг батлууллаа.	
209.	5.3. Соёл, урлагийг дэмжих сангаас санхүүжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээний саналыг судлан шийдвэрлүүлнэ.	Төсөл, хөтөлбөр, арга хэмжээнд зохих журмын дагуу санхүүгийн дэмжлэг үзүүлсэн байна.	Соёл, урлагийг дэмжих санд 2019 онд 2 тэрбум төгрөг батлагдсан бөгөөд тус сангаас санхүүгийн дэмжлэг үзүүлэх төслийн шалгаруулалтыг 2019 оны 3 сарын 4 өдөр хүртэл зарлаж төслийг хүлээн авч шалгаруулалтыг явуулсан. 2019 онд 212 нэрийн 27,0 тэрбум төгрөгийн төсөл сонгон шалгаруулалтад ирсэн. Соёл, урлагийг дэмжих сангийн орон тооны бус зөвлөлөөс 64 нэрийн 2,0 тэрбум төгрөгийн өртөг бүхий төслийг сонгон шалгаруулан хэрэгжүүлж, төслийн тайланг хүлээн авч дүгнэж байна.	100%
210.	5.4. Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтыг шинэчлэн батлуулна.	Жагсаалт шинэчлэн батлагдсан байна.	БСШУС-ын сайдын 2016 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/365 дугаар тушаалаар аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын урьдчилсан жагсаалт бэлтгэх үүрэг бүхий Ажлын хэсгийн байгуулсан. Ажлын хэсгээс аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын урьдчилсан жагсаалтыг бэлтгэж ирүүлсэн. Жагсаалтыг хянаж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж батлууллаа.	100%
211.	5.5 Хүүхдийн төв номын санг орчин үеийн стандартын шаардлага хангасан жишигт хүргэх ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган ажиллана.	Төслийг БНСУ-ын талд хүргүүлж, бэлтгэл ажлыг хангасан байна.	БСШУС-ын сайдын 1а/1631 албан тоотой БНСУ-ын Соёл, спорт, аялал жуулчлалын сайдад Хүүхдийн төв номын санг номын санг өөрчлөн шинэчлэхэд туслалцаа үзүүлэх тухай хүсэлт, номын санг шинэчлэх концепци, төсөл, холбогдох мэдээллийг хүргүүллээ. Тус ажлын хүрээнд 2019 оны 4 сарын 23 өдөр БНСУ-ын Соёл, спорт аялал жуулчлалын яамны болон “Соёлын солилцооны сан”-гийн төлөөлөл хүрэлцэн ирж хүүхдийн төв номын сангийн үйл ажиллагаатай танилцан 2020 онд “Баярлалаа бяцхан номын сан” төслийг монголд хэрэгжүүлэхээр тогтлоо.	100%
212.	5.6.Олон улсын болон үндэсний хэмжээнд зохиогддог соёл, урлагийн уралдаан наадамд бодлогын дэмжлэг үзүүлнэ.	Дэмжлэг үзүүлж уралдаан наадам амжилттай зохион байгуулагдсан байна.	а)Италийн Венец хотноо зохион байгуулагддаг Дүрслэх урлагийн 58 дахь удаагийн Олон улсын биеннальд Монголын павильон оролцож, нээлтийн үйл ажиллагааг 2019 оны 05 сарын 8 өдөр амжилттай зохион байгуулахад санхүүгийн болон удирдлагын дэмжлэг үзүүллээ. б)Азийн ардын урлагийн анхдугаар наадмын зохион байгуулалтад шаардагдах 208 сая төгрөгийн зардлыг шийдвэрлүүлж, наадмын нээлтийн үйл ажиллагаанд оролцлоо.	100%

			<p>в) ЮНЕСКО, Европын Холбооны дэмжлэгтэйгээр Чехийн Прага хотноо 2019 оны 6 сарын 6-16 өдрүүдэд зохион байгуулахад санхүүгийн болон удирдлагын дэмжлэг үзүүллээ.</p> <p>г) Хятадын Бээжин хотноо зохион байгуулагдсан Монголын соёлын өдрүүдэд Үндэсний урлагийн их театрын 50 гаруй уран бүтээлч, Монголын кино урлагийн төлөөлөл, Монголын гэрэл зурагчдын нэгдсэн холбооны төлөөлөл, уран бүтээлчдийг оролцуулахад дэмжин ажиллалаа.</p>	
213.	5.7.Соёл, урлагийн үндэсний зөвлөлийн үйл ажиллагаанд бодлогын дэмжлэг үзүүлнэ.	Зөвлөлийн хурлыг зохион байгуулж, дэмжлэг үзүүлсэн байна.	<p>Монгол Улсын ерөнхий сайдын дэргэд байгуулагдсан Соёл, урлагийн үндэсний зөвлөлийн ээлжит хурлыг 2019 оны 1, 2 дугаар улиралд тус тус 2 удаа хуралдууллаа. Эхний хурлаар үндэсний зөвлөлийн гишүүдээс салбарын хөгжлийг дэмжих замаар нийгэмд үзүүлэх эерэг нөлөөллийг дээшлүүлэх чиглэлээр авах арга хэмжээний талаар санал солилцож, үндсэн 4 чиглэлээр үйл ажиллагааг зохион байгуулахаар шийдвэрлэсэн. Шийдвэрийн дагуу бүх нийтийг соён гэгээрүүлэх чиглэлээр “Монгол хүний үнэт зүйл”-ийг тодорхойлж, бүх нийтийг соён гэгээрүүлэх аян зохион байгуулахаар тогтож, 2 дахь удаагийн хурлаар 2019-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг эцэслэн хэлэлцлээ.</p> <p>Төлөвлөгөөнд “Бүх нийтийг соён гэгээрүүлэх”, “Соёлын өвийг хадгалж, хамгаалан, түгээн дэлгэрүүлэх”, “Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх”, “Сонгодог болон орчин үеийн урлагийг дэмжих” гэсэн үндсэн 4 чиглэлд 10 зорилт дэвшүүлж, зорилтыг хангах чиглэлээр 52 арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөсөн байна. Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд хөрөнгө оруулалт, барилга байшин шинээр барих болон төсөл арга хэмжээ хэрэгжүүлэх, улсын хэмжээний аян, уралдаан наадам зохион байгуулах, шинээр үндэсний агуулга бүхий түүхэн кино, ном, концерт, жүжиг бүтээж тайзнаа тавих зэрэг ажилд улсын төсөв болон гадаад дотоодын хандив тусламжийн хөрөнгөөр нийт 108,1 тэрбум төгрөг зарцуулан хэрэгжүүлэхээр тусгагдсан байна.</p>	100%
<b>БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН БОДЛОГЫН ГАЗАР</b>				
Нэг. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл-2019"-ийн зорилтыг хангахад чиглэсэн арга хэмжээ:				
“Спортын салбарын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, соёлын салбарт техник, технологийн ололтыг нэвтрүүлж, бүх нийтийн биеийн тамирын хөгжилд төрөөс дэмжлэг үзүүлэх зорилтын хүрээнд				



214.	1.1 Магадлан итгэмжлэгдсэн спортын клубт идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэсэн иргэний үйлчилгээний төлбөрт эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлт үзүүлэх /ЭЗНХҮЧ-ийн 12.2, ЗГҮАХ-ийн 3.2.56.1, 3.2.56.3/	Магадлан итгэмжлэгдсэн клубын тоо	БСШУС-ын сайд, Эрүүл мэндийн сайдын 2019 оны 3 сарын 29 өдрийн А/178, А/144 дүгээр хамтарсан тушаалаар “Спортын клубыг магадлан итгэмжлэх журам, шалгуур үзүүлэлт, үйлчилгээний төлбөрийн хэмжээ тогтоох тухай” журам батлагдсан. “Спортын клубыг магадлан итгэмжлэх” журмын дагуу Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир, спортын газрын даргын 2019 оны 5 сарын 27 өдрийн А/187 тоот тушаалаар “Спортын клубыг магадлан итгэмжлэх хараат бус шинжээчийн үйл ажиллагааны журам”-ыг баталсан бөгөөд магадлан итгэмжлэх үйл ажиллагааг чиг үүргийн дагуу Биеийн тамир, спортын газар гүйцэтгэж байна.	100%
Хоёр. Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн зорилтыг хангахад чиглэсэн арга хэмжээ:				
215.	2.1 Спортын эрдэм шинжилгээ, спортын анагаах ухааныг хөгжүүлэх, тамирчдын бэлтгэл сургуулилт хийх таатай орчин нөхцөлийг бүрдүүлнэ.*** /3.2.54/	Биеийн тамир, спортын шинжлэх ухааны бие даасан бүтэц бий болгох	Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 11 сарын 14 өдрийн хуралдааны 47 дугаар тэмдэглэлийн дагуу биеийн тамир, спортын шинжлэх ухааны бие даасан бүтэц бий болгох “Спортын шинжлэх ухааны төв”-ийг байгуулах тухай ЗГ-ын тогтоолын төсөл, танилцуулгыг бэлтгэн яамдаас санал авч нэгтгэж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн.	100%
216.	2.2 Спортыг дэмжих сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг сонгон шалгаруулах /3.2.55/	10-20 төсөл	БСШУС-ын сайдын “Бүрэлдэхүүн батлах тухай” 2019 оны 3 сарын 19 өдрийн А/105 дугаар тушаалаар “Спортыг дэмжих сан”-ийн удирдах зөвлөлийг байгуулсан. Удирдах зөвлөлийн хуралдаанаар иргэд, спортын холбоод, төрийн болон төрийн бус байгууллагаас ирүүлсэн нийт 86 төслийг хэлэлцэн дүгнэлт гаргасан. Ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн БСШУС-ын сайдын 2019 оны 5 сарын 3 өдрийн А/286 дугаар тушаалаар 21 төсөл, арга хэмжээнд 1.3 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлэн үйл ажиллагааг эхлүүлсэн. Гэрээ байгуулсан төслүүд дээр хяналт шинжилгээ дотоод аудитын газраас хяналт хийж байна. БСШУС-ын сайдын 2019 оны А/578 дугаар тушаалаар өвлийн спорт, нийтийн биеийн тамирын чиглэлээр 11 төсөлд 621.586.900 төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлэхээр шийдвэрлэсэн.	100%

217.	2.3 Биеийн тамир, спортын эрх зүйн орчинг боловсронгуй болгож нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх, үндэсний спортын өв соёлыг хөгжүүлэх, өвлөн уламжлах бодлого, тогтолцооны шинэчлэлийг хэрэгжүүлнэ. /3.2.52/		Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2017 онд УИХ-аар баталсан. “Төрөөс биеийн тамир, спортын талаар баримтлах бодлого”-ын төслийг боловсруулж, Засгийн газрын 2019 оны 4 сарын 17 өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн 153 дугаар тогтоолоор батлуулсан. Төрийн бодлогыг хэрэгжүүлэх “Биеийн тамир, спортыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг Засгийн газрын 2019 оны 8 сарын 21 өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан.	100%
Гурав. Хууль, дүрэм журам, бодлогын хэрэгжилт”-ийг хангахад чиглэсэн арга хэмжээ:				
218.	3.1 Төрөөс биеийн тамир, спортын талаар баримтлах бодлогын төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр ЗГХЭГ-т хүргүүлнэ. /ЗГҮАХ-ийн 3.2.52/**	Засгийн газрын тогтоол гарсан байна.	Засгийн газрын 2019 оны 4 сарын 17 өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн 153 дугаар тогтоолоор “Төрөөс биеийн тамир, спортын талаар баримтлах бодлого”-ийг батлуулсан.	100%
219.	3.2 Засгийн газраас биеийн тамир, спортын хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр ЗГХЭГ-т хүргүүлнэ. /БТС тухай хуулийн 6.1.3/**	Засгийн газрын тогтоол гарсан байна.	Засгийн газрын 2019 оны 335 дугаар тогтоолоор “Биеийн тамир, спортыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг батлуулсан.	100%
220.	3.3 “Гаалийн албан татвараас чөлөөлөх спортын зориулалт бүхий тоног төхөөрөмж,	Жагсаалтад байгаа тоног төхөөрөмжийг татвараас	Засгийн газрын 2019 оны 247 дугаар тогтоолын хавсралтаар “Гаалийн албан татвараас чөлөөлөгдөх спортын зориулалтын тоног төхөөрөмж, хэрэглэлийн жагсаалт”-ыг батлуулсан.	100%

	хэрэглэлийн жагсаалт батлах тухай" ЗГ-ын тогтоолын төсөл боловсруулна.***	чөлөөлөх эрх зүйн орчин бүрдсэн байна.		
221.	3.4 Биеийн тамирын арга зүйчид мэргэжлийн зэрэг олгох журам батлуулна. /ЗГҮАХ-ийн 3.2.52/	БСШУС-ын сайд, ХНХ-ын сайдын хамтарсан тушаалаар журам батлагдсан байна.	БСШУС-ын сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан 2019 оны А/319, А/176 дугаар тушаалаар "Биеийн тамирын арга зүйчид мэргэжлийн зэрэг олгох журам"-ыг батлуулсан. Журмыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж Захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн санд 4398 дугаартайгаар бүртгүүлсэн.	100%
222.	3.5 Улсын хэмжээний спортын тэмцээн, наадмыг зохион байгуулахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам батлуулна.	Улсын хэмжээний тэмцээн, наадмын зохион байгуулалтад санхүүжилт хийгдэх эрх зүйн орчин бүрдэнэ.  БСШУС-ын сайд, Сангийн сайдын хамтарсан тушаалаар журам батлагдсан байна.	Улсын хэмжээнд зохион байгуулах спортын тэмцээн, наадмыг зохион байгуулахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх журмын төслийг боловсруулж, БТСГ, аймаг, нийслэл, дүүргийн БТСГ-аас санал авахаар хүргүүлсэн.	70%
223.	3.6 Спорт дахь допингийн эсрэг үндэсний дүрэм батлах тухай ЗГ-ын тогтоолын төсөл боловсруулж, батлуулна.	Засгийн газрын тогтоол гарсан байна.	Спорт дахь допингийн эсрэг үндэсний дүрмийн төслийг боловсруулан Олон улсын жишиг дүрмийг орчуулж дууссан.	70%
224.	3.7 Монголын хүүхдийн спортын VI, Бүх ард түмний спортын XV наадмын өвлийн төрлийг зохион байгуулах.	Спортын 25-30 төрөл	Бүх ард түмний спортын XV наадмын өвлийн төрлийг гүйлтийн тэшүүр, гүйлтийн цана, шрот трейк, шайбтай хоккей, уулын цана, биатлон зэрэг спортын 6 төрлийн 27 жин зайд өрсөлдлөө. Наадамд 19 аймаг, нийслэлийн 9 дүүрэг, хүчний байгууллагын нийт 500 гаруй тамирчид оролцлоо. Монголын хүүхдийн спортын VI наадмыг өвлийн төрлийн 4 насны ангилалаар цана, тэшүүрийн 38 зай, төрөлд 17 аймаг, 9 дүүргийн 234	100%

			<p>тамирчин оролцлоо. Хүүхдийн спортын наадмын зуны төрлийг 2019 оны 9 сард зохион байгуулагдлаа.</p> <p>БСШУС-ын сайдын 2018 оны А/777 дугаар тушаалын дагуу Монголын хүүхдийн спортын VI наадмыг орон даяар 3 үе шаттайгаар зохион байгууллаа. Анхан шатны тэмцээнээс спортын 34 төрөлд шалгарсан 5600 гаруй өсвөрийн тамирчид хамрагдаж спортын төрөл тус бүрд алт, мөнгө, хүрэл медалийн эзэд тодорлоо. Наадмын нээлтийн арга хэмжээг 9 сарын 9 өдөр Буянт Ухаа спортын ордонд зохион байгуулж, хаалтын арга хэмжээг Спортын төв ордны “А” зааланд зохион байгуулж шилдэг тамирчид, дасгалжуулагчид, байгууллагын нэгдсэн дүнгээр эхний байрт шалгарсан аймаг, дүүргийн Биеийн тамир, спортын газар, хороодын шагналыг гардууллаа.</p>	
225.	3.8 Олимпийн наадамд бэлтгэх үндэсний хорооны 2019 оны ээлжит хуралдаанаар батлагдсан төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллах.	100%	<p>Олимпийн наадамд бэлтгэх үндэсний хорооны 2019 оны 4 сарын 3 өдрийн хурлаар Олимпийн бэлтгэл ажлыг хангах чиглэлээр 2 тогтоол, 2019-2020 онд хэрэгжүүлэх календарьчилсан төлөвлөгөөг тус тус баталсан.</p> <p>Төлөвлөгөөний дагуу Олимпийн эрхийн тэмцээн, дотоодын бэлтгэл цугларалтын хуваарь гаргаж бэлтгэл сургуулилт хийгдэж байна.</p> <p>Олимпийн наадамд бэлтгэх Үндэсний хорооны хурлыг 9 сарын 25 өдөр хуралдуулж “Токио-2020” Олимпийн болон Паралимпийн наадамд оролцох ҮШБ-ийн бэлтгэл ажлын явц, төлөвлөгөөний биелэлт, цаашид авах арга хэмжээний талаар мэдээлэл хийлээ. Мөн сонгон шалгаруулалтад шалгарсан “Токио-2020” Олимпийн болон Паралимпийн наадамд оролцох Монгол Улсын багийн бүрэлдэхүүний өмсөх спортын болон ёслолын хувцасны танилцуулга хийгдэж уг загварыг баталгаажуулж БСШУС яам, “Олимп сан”-тай гуравласан гэрээ байгуулж, Мишээл &amp; Амазонка загварын агентлагт батламж гардууллаа. Гэрээ байгуулан захиалга хийгдсэн. Олимпийн наадамд бэлтгэх үндэсний хорооны 2019 оны төлөвлөгөө 100% хэрэгжсэн.</p>	100%
226.	3.9 Монгол Улсад 2019 онд зохион байгуулагдах Олон улсын тэмцээнд дэмжлэг үзүүлэх.***	10-13 спортын төрлийн олон улсын тэмцээн	<p>БСШУС-ын сайдын 2019 оны А/137 дугаар тушаалаар Монгол Улсад 13 олон улсын тэмцээн зохион байгуулж 1.062.000 төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн. Тэмцээн зохион байгуулсан гэрээний акт үйлдэн үлдэгдэл санхүүжилтийг олгоод байна.</p>	100%

227.	3.10 Спортын төрлүүдийн стандартыг хэрэгжүүлэх “Спортын сургалтын жишиг хөтөлбөр” боловсруулах	3 спортын төрлийн стандартад тулгуурласан сургалтын жишиг хөтөлбөр	Бадминтон, дартс, хөнгөн атлетик, жүдо бөхийн стандарт, буудлагын спортын стандартад тулгуурласан сургалтын жишиг хөтөлбөрийн төслийг боловсруулсан.	100%
228.	3.11 Бие бялдрын түвшин тогтоох стандартыг турших судалгаа хийх, бие бялдрын түвшин тогтоох сорилын стандартыг боловсруулж батлуулах	100%	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир, спортын газрын даргын 2019 оны А/177 тоот тушаалаар “Бие бялдрын түвшин тогтоох сорил”-ын стандартыг боловсруулах ажлын хэсгийг байгуулж, Хүн амын бие бялдрын хөгжлийн түвшин тогтоох сорилын шалгуур үзүүлэлт болон арга аргачлалыг боловсруулж туршиц судалгааг орон нутагт Архангай, Хэнтий, Завхан, Сүхбаатар, Орхон, Дундговь аймагт, нийслэлийн Хан-Уул, Сонгино-хайрхан, Бага хангай, Чингэлтэй, Баян-Зүрх дүүргүүдэд тус тус зохион байгуулж нийт 5000 гаруй иргэдээс судалгаа авч, судалгааны дүнг нэгтгэж бие бялдрын түвшин тогтоох сорилын стандартыг боловсруулсан.	100%
Дөрөв. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээ:				
229.	4.1 Үндэсний, спортыг хөгжүүлэх хөтөлбөрийг боловсруулж батлуулна. /БТС тухай хуулийн 6.1.4/	Уламжлалт үндэсний спортын төрлүүдийг дунд хугацаанд хөгжүүлэх хөтөлбөрийг Үндэсний спортын холбоодтой хамтран боловсруулна	Үндэсний спортыг хөгжүүлэх хөтөлбөрийн төслийг боловсруулж, 2019 оны 5 сарын 8-10-ны өдрүүдэд хөтөлбөрийн төсөлд санал авах зорилгоор үндэсний спортын төрлийн холбоодтой уулзалт зохион байгуулсан. Тус уулзалтын үеэр спортын холбоодоос гаргасан тулгамдсан асуудлаар саналыг авч, хөтөлбөрийн төслийг боловсруулсан, холбогдох тооцоо судалгааг гарган боловсруулсан.	100%
230.	4.2 Багийн спортыг хөгжүүлэх хөтөлбөрийг боловсруулж батлуулна. /БТС тухай хуулийн 6.1.4/	Нийтлэг хөгжсөн багийн спортын төрлүүдийг дунд хугацаанд хөгжүүлэх хөтөлбөрийг Багийн спортын	Багийн спортыг хөгжүүлэх хөтөлбөрийн төслийг боловсруулж хөтөлбөрийн төсөлд санал авах зорилгоор БТСГ, багийн спортын төрлийн холбоодоос саналыг авч, холбогдох тооцоо судалгааг боловсруулж байна. Хөтөлбөрийн төслийг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын жагсаалтад оруулахаар санал хүргэгдсэн боловч 2016-2020 оны ЗГҮАХ-т тусгагдаагүй учир 2020 онд хэлэлцүүлэхээр хойшлогдсон.	70%

		төрлийн холбоодтой хамтран боловсруулна		
<b>ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗАР</b>				
231.	<p>1.1 Төрийн албаны тухай хууль тогтоомж, Хөдөлмөрийн тухай хуулийн хүрээнд:</p> <p>БСШУС-ын төсвийн ерөнхийлөн захирагч, боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын харьяа байгууллагын удирдлагуудтай үр дүнгийн гэрээ болон хөдөлмөрийн гэрээ байгуулах, сунгах, дүгнэх ажлыг зохион байгуулна.</p>	<p>Шинээр томилогдсон удирдах албан тушаалтан бүрээр гэрээг байгуулсан байна. 99 байгууллагын удирдах ажилтны гүйцэтгэлийн гэрээ</p>	<p>1.Харьяа 100 байгууллагын /боловсролын салбарын -73, соёлын салбарын-19, шинжлэх ухааны салбарын-7, спортын салбарын-1/ удирдлагуудтай Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын төсвийн ерөнхийлөн захирагч үр дүнгийн гэрээ болон хөдөлмөрийн гэрээг байгуулан ажилласан.</p> <p>2.Харьяа соёл, шинжлэх ухаан, спортын байгууллагын төсвийн шууд захирагчийн Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан үр дүнгийн гэрээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2019 оны эхний хагас жилийн болон бүтэн жилийн биелэлтийг тайланг хүлээн авч, хэрэгжилтийг хангуулах ажлыг төрийн захиргааны удирдлагаар ханган ажиллалаа. БСШУС-ын сайдын 2019 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/796 дугаар тушаалын дагуу харьяа 100 байгууллагын төсвийн шууд захирагчийн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан 2019 оны үр дүнгийн гэрээг дүгнэх ажлыг амжилттай зохион байгуулж нийт 65 байгууллагын төсвийн шууд захирагчид бүрэн хангалттай, 35 байгууллагын төсвийн шууд захирагчид хангалттай гэсэн үнэлгээг өгч БСШУС-ын сайдын Б/01, Б/17 дугаар тушаалаар үр дүнгийн урамшуулал олгож ажиллалаа.</p>	100%
232.	<p>1.2 Төрийн албаны тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хүрээнд: Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын харьяа байгууллагын удирдах ажилтны ажлын байрны</p>	<p>Албан тушаалын тодорхойлолт боловсруулж батлуулсан байна.</p>	<p>1. БСШУС-ын сайдын 2019 оны А/281, А/282, А/283, Б/29, А/558 тоот тушаалаар яамны харьяа соёл, шинжлэх ухааны харьяа 13 байгууллага болон ерөнхий боловсролын сургууль, тусгай цэцэрлэг, ерөнхий боловсролын тусгай сургуулийн удирдах албан тушаалтны албан тушаалын тодорхойлолтыг батлав.</p> <p>2. Дээрх албан тушаалын тодорхойлолт батлагдсанаар 6 музей, 1 номын сан, 2 театр, 4 шинжлэх ухааны байгууллага болон ерөнхий боловсролын сургууль, тусгай цэцэрлэг, ерөнхий боловсролын тусгай сургуулийн төсвийн шууд захирагч нарын сонгон шалгаруулалтыг зохион байгуулах нөхцөл бүрдсэн болно.</p>	100%

	тодорхойлолт, холбогдох дүрэм журам зааврыг шинэчлэн боловсруулж батлуулна.			
233.	<p>1.3 Төрийн албаны хууль тогтоомжийн хүрээнд:</p> <p>Яамны харьяа боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байгууллагын удирдах ажилтны хүний нөөц бүрдүүлэх, ажлын байрны сонгон шалгаруулалтыг зарлах, зохион байгуулах, тайлагнах арга хэмжээг зохион байгуулна.</p>	Хүний нөөцийн бүрэлдэхүүний мэдээллийг холбогдох төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн байна	<p>1. Төрийн албаны тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1.11-т заасны дагуу төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн албан тушаалд Боловсрол, соёл шинжлэх ухаан салбарын 25 байгууллагын удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалтыг Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 5 сарын 28 өдрийн 25 дугаар тогтоолоор баталсан “Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулах журам”-д заасны дагуу зарлан, зохион байгуулав.</p> <p>2. Төрийн албаны зөвлөлийн БСШУС-ын яамны дэргэдэх салбар зөвлөлийн 2019 оны 03, 04, 05, 09 тоот тогтоолоор сонгон шалгаруулалтын комисс байгуулагдан нийт 11 иргэн тэнцэж БСШУС-ын сайдын Б/20-Б/26, Б/33, Б/50-52 тоот тушаалаар тухайн албан тушаалд томилогдон ажиллаж байна.</p>	100%
234.	<p>1.4 Төрийн албаны тухай хууль:</p> <p>Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлан гаргах, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллана.</p>	Тайлан мэдээг тогтоосон хугацаанд боловсруулсан байна	<p>1. Яамны төрийн албан хаагчдын бүрэлдэхүүн хөдөлгөөний мэдээллийг төрийн албаны зөвлөлийн программд тухай бүр мэдээлэл оруулан, баяжилт, хасалт хийн ш. 2019 онд яамны нийт албан хаагчдын цалин, нэмэгдэлд ЗГ-ын тогтоолыг үндэслэн өөрчлөлт оруулж баталсан. Энэ мэдээллийг бүрэн оруулсан. Шинээр томилогдон хувийн хэргээ бүрдүүлж өгсөн албан хаагчдын мэдээллийг оруулаад байна.</p> <p>2. Харьяа байгууллагын хүний нөөцийн мэдээллийг төрийн албаны хүний нөөцийн нэгдсэн системд бүртгэх, мэдээллийн санг шинэчлэх ажлыг удирдлага зохицуулалтаар хангаж ажиллав. 100 хувь гүйцэтгэлтэй</p>	100%
235.	<p>1.5 Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хүрээнд:</p> <p>Яамны нийт албан хаагчид, Харьяа байгууллагын удирдах</p>	Хөтлөх материалд хяналт тавина.	<p>1. Төрийн албаны зөвлөлийн баталсан журмын дагуу яамны албан хаагчдын хувийн хэрэг шинэчлэх ажлыг зохион байгуулж, зөвлөгөө өгч, хяналт тавьж ажиллаж байна. Хувийн хэргийн шинэчлэл 90 гаруй хувьтай байна. Хувийн хэргээ одоогоор зарим удирдлага өгөөгүй байна. Хувийн хэргийн баяжилтыг журмын дагуу шийдвэр гарах бүрт баяжилт</p>	100%

	албан тушаалтны хувийн хэргийн хөтлөх, баяжуулах, шинэчлэх ажлыг зохион байгуулна.		хийн ажиллаж байна. Хувийн хэргийн баяжилтыг ТАЗ-ийн шинжээч шалгаж бүртэл хангалттай гэж үнэлсэн. 2.Харьяа байгууллагын удирдах албан тушаалтны хувийн хэргийн шинэчлэл 100 хувь хийгдсэн.	
236.	1.6 Төрийн албаны хууль тогтоомжийн хүрээнд:  Захиргааны удирдлага, хууль эрх зүй, төрийн албаны стандарт, хүний нөөцийн чиглэлээр харьяа байгууллагын удирдах ажилтанд мэргэжил аргагүйн дэмжлэг үзүүлэх, зөвлөн туслах, сургалт зохион байгуулах ажлыг зохион байгуулна. ***	Зөвлөн туслах ажиллагааг зохион байгуулах нарийвчилсан төлөвлөгөөг батлуулсан байна.	Төрийн албаны стандарт, хүний нөөцийн чиглэлээр: Салбар зөвлөлөөс Засгийн газрын агентлаг Биеийн тамир, спортын газар, Соёл урлагийн газарт дараах чиглэлээр зөвлөмж, чиглэл, даалгавар өгч ажилласан. Үүнд: 1. Төрийн албаны шинэчилсэн хууль, түүнийг дагаж гарсан журам, дүрмийг нийт албан хаагчдадаа судлуулах, сургалт зохион байгуулах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллах, 2. Албан хаагчдын хувийн хэргийг журмын дагуу шинэчлэх, 3. Сул орон тооны судалгааг ирүүлэх 4.Ёс зүйн зөвлөлд төлөөлөл оруулах талаар санал ирүүлэх, 5.Албан тушаалын тодорхойлолт боловсруулах талаар зөвлөмж өгч, Төрийн албаны зөвлөлд хүргэж хянуулах чиглэлийг өгч ажиллалаа. Төрийн албаны зөвлөлийн БСШУС-ын яамны дэргэдэх салбар зөвлөлийн даргын баталсан удирдамжийн дагуу 2019 оны 2 сард Дорнод аймгийн Дорнод их сургууль, ерөнхий боловсролын лаборатори “Хан-Уул” сургуулийн, 2019 оны 4 сард Төв аймгийн ерөнхий боловсролын лаборатори “Хүмүүн” сургуулийн, мөн Улаанбаатарын их сургуулийн хүний нөөцийн үйл ажиллагаанд төрийн албаны хууль тогтоомжийн хэрэгжилттэй танилцан, зөвлөн тусалж ажиллалаа.  Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир спортын газрын болон Соёл урлагийн газрын хүний нөөцийн асуудал хариуцсан албан хаагчдад хувийн хэрэг бүрдүүлэх, албан тушаалын тодорхойлолт боловсруулах чиглэлээр зөвлөн туслах ажлыг хийсэн. Мөн харьяа 5 байгууллагад хүний нөөцийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлан гаргах талаар арга зүйн тусалцаа үзүүлж ажилласан.	100%
237.	1.7 Төрийн албаны тухай хууль, яамны эрх зүйн байдлын тухай хуулийн хүрээнд	Тухайн онд хэрэгжүүлэх арга хэмжээг нарийвчлан батлуулна.	Хуулийн заалтыг хэрэгжүүлэх зорилгоор албан хаагчдаас авсан нийгмийн баталгаа, сургалтын хэрэгцээ шаардлагын судалгааны үндэслэн Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны 5 сарын 28-ны өдрийн А/136 дугаар тушаалаар "БСШУС-ын яамны төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр", БСШУС-ын яамны албан хаагчдын сургалтын хөтөлбөр"-ийг тус тус шинэчлэн баталж,	100%



	<p>Яамны албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээг үе шаттай зохион байгуулна.**</p>		<p>хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлан ажиллаж байна. Хөтөлбөр төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг улсын болон төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр хэрэгжүүлдэг. Гэвч 2019 оны улсын төсөвт шаардагдаж төсвийг тусгуулахаар санал өгсөн боловч батлагдаагүй. Яам санхүүгийн нөөц бололцооны хүрээнд зохицуулалт хийн зохион байгуулж ажиллаа. Яамны нийт албан хаагчдын ажиллах нөхцөлийг нэмэгдүүлэх зорилгоор тоног төхөөрөмж, ширээ, сандлыг бүрэн шинэчлэх ажлыг зохион байгуулж байна.</p> <p>2019 онд Төрийн албаны тухай хуулийн дагуу 3 албан хаагчид 84,065,021 мянган төгрөгийн тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийн шийдвэрийг гаргаад байна. 2019 оны 10 сарын 25 өдрийн байдлаар яамны 12 албан хаагчид 11, 000,000 төгрөгийн буцалтгүй тусламж олгосон. 16 албан хаагчдад яамны хөдөлмөрийн дотоод журмын дагуу 10-14 хоногийн цалинтай чөлөө олгосон.</p> <p>Яамны албан хаагчдад зуслангийн газартай болгох асуудлаар Төв аймгийн засаг даргад хүсэлт бичиг явуулаад байна.</p> <p>Төрийн тусгай албан хаагчдын эмнэлэг, Сонгдо эмнэлэг, Монгол-Японы эмнэлэг, АШУҮИС-ийн эмнэлгээс яамны албан хаагчдыг урьдчилан сэргийлэх үзлэгт оруулах шинжилгээний багцын санал авч, АШУҮИС-ийн эмнэлгээс яамны албан хаагчдыг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулахаар болов. Үзлэгт 15 000 000 төгрөг зарцуулах шийдвэрийг батлуулсан.</p> <p>Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир спортын газрын Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний албаны оношлох аппаратаар 2019 оны 10 сарын 2, 4, 9-ний өдөр яамны албан хаагчдын нурууны хазайлт, бөгтөр болон тэгш байдал, мушгиралтыг оношлон, эмчийн зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулсан. Оношилгоонд яамны 76 албан хаагч хамрагдаж, эмчийн зөвлөгөө аваад байна.</p> <p>АШУҮИС-ийн харьяа эмнэлэгт яамны албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах хүсэлтийг хүргүүлээд байна.</p>	
238.	<p>1.8 Төрийн албаны тухай хууль, яамны эрх зүйн байдлын тухай хуулийн хүрээнд.</p> <p>Яамны албан хаагчдын сургалтын хөтөлбөр,</p>	<p>Тухайн онд хэрэгжүүлэх арга хэмжээг нарийвчлан батлуулна</p>	<p>Төрийн албаны тухай хууль, 2018 онд батлагдсан яамны албан хаагчдын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө /2018-2022/-г үе шаттайгаар хэрэгжүүлэн ажиллаж байна. Сургалтын хөтөлбөр төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг 2019 онд улсын төсөвт шаардагдаж төсвийг тусгуулахаар санал өгсөн боловч батлагдаагүй. Боловсрол соёл, шинжлэх ухаан, спортын яам нөөц бололцооны хүрээнд зохицуулалт</p>	<p>100%</p>

	<p>төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээг үе шаттай зохион байгуулна.***</p>		<p>хийн зохион байгуулсан. Гадаад, дотоодын олон улсын болон сургалтын байгууллагуудын зохион байгуулж буй сургалтуудад ажлын байрны чиг үүргийн дагуу яамны албан хаагчдыг хамруулан мэдлэг мэргэжлийг тасралтгүй дээшлүүлэх ажлыг зохион байгуулж байна. 2019 оны эхний хагас жилийн байдлаар яамны 12 албан хаагчийг гадаад, 63 албан хаагчийн дотоодын урт болон богино хугацааны сургалтад хамруулаад байна.</p> <p>Яамны нийт албан хаагчдад “Төрийн албаны стандарт, ёс зүй ба манлайлал”, “Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх, хяналт тавих нь”, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага, хууль эрх зүйн зохицуулалт”, “Худалдан авах ажиллагааны хууль тогтоомжийн өөрчлөлт, шинэчлэлт, хэрэгжилтэд анхаарах асуудал”, “Төсөв, санхүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилт, анхаарах асуудал”, “Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлт” сэдэвт сургалтыг 10,340,0 мянган төгрөгөөр зохион байгуулаад байна. Удирдлагын академийн “Гараг”-ын сургалтад 1, англи хэл-орчуулагчийн бакалаврын ангид 1, Австрали Улсад магистрын сургалтад сурч байна. 1 албан хаагч ЖАЙКА-гийн хөтөлбөрт сургалтад хамрагдаж байна.</p> <p>Төрийн албаны тухай шинэчилсэн хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Төрийн албан зөвлөл, Удирдлагын академийн зохион байгуулж байгаа тэргүүн түшмэлийн болон эрхэлсэн түшмэлийн сургалтад түр томилгоогүй удирдах албан тушаалтныг хамруулах ажлыг үе шаттай зохион байгуулж, тэргүүн 1, эрхэлсэн 9, ахлах түшмэлийн багц сургалтад 11 албан хаагчийн хамруулаад байна.</p> <p>Ёс зүй зөвлөл яамны нийт албан хаагчдад:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Ёс зүйн зөвлөлөөс яамны нийт албан хаагчдад “Олон улсын мэргэжлийн ёс зүйн туршлага”</li> <li>2. “Төрийн албан хаагчийн ёс зүйн байдал ба бид”</li> </ol> <p>Сэдэвт сургалтын зохион байгуулсан.</p>	
239.	<p>1.9 Төрийн албаны тухай хууль, яамны эрх зүйн байдлын тухай хууль.</p>	<p>Бүтэц өөрчлөгдсөн байна</p>	<p>Яамны бүтцэд нэмэлт өөрчлөлт оруулах судалгаа хийж, санал боловсруулан яамдаас санал авч нэгтгэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Засгийн газрын 2019 оны 161 дүгээр тогтоолоор яамны бүтцэд нэмэлт өөрчлөлт оруулан баталсан. Тогтоолыг үндэслэн яамны ажлын байрны нэрийг шинэчлэн боловсруулж батлуулсан.</p>	<p>100%</p>


	<p>Яамны бүтэц зохион байгуулалтыг тодорхой болгох, ажлын давхардал, хийдлийг арилгах санал боловсруулж батлуулна.</p>		<p>Засгийн газрын 2019 оны “Төрийн захиргааны албан албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт батлах тухай” 275 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор яамны төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэлийг Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны “Тушаалын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” А/202 дугаар тушаалаар батлуулсан.</p>	
240.	<p>1.10 Төрийн албаны тухай хууль, Яамны эрх зүйн байдлын тухай хууль, болон холбогдох бусад хууль тогтоомж.</p> <p>Яамны албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж батлуулна.</p>	<p>Ажлын байрны тодорхойлолт боловсруулж батлуулсан байна.</p>	<p>Төрийн албаны тухай хууль, Засгийн газрын тогтоол, Төрийн албаны зөвлөлийн баталсан журам, албан тушаалын ажлын байранд тавигдах шаардлагыг мөрдөн хэрэгжүүлэх зорилгоор яамны ажлын байрны албан тушаалын тодорхойлолтын төслийг боловсруулсан. Нэгжийн дарга нарын ажлын байрны албан тушаалын тодорхойлолтын төслийн Төрийн албаны зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, 2019 оны 46 дугаар тогтоолоор батлах зөвшөөрлийг олгосон. Дээрх тогтоолыг үндэслэн Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны “Албан тушаалын тодорхойлолт батлах тухай” Б/127 дугаар тушаалаар нэгжийн дарга нарын ажлын байрны албан тушаалын тодорхойлолтыг баталсан.</p> <p>Төрийн албаны зөвлөлөөс өгсөн чиглэлийн дагуу албан хаагчдын ажлын байрны албан тушаалын тодорхойлолтын төслийг дахин боловсруулж, яамны дэргэдэх Салбар зөвлөлийн 2019 оны 10 сарын 18-ны өдрийн хурлаар хэлэлцэн Төрийн албаны зөвлөлөөр хянуулж зөвшөөрөл авахаар 2019 оны 10 сарын 24-ний өдөр хүргүүлсэн. ТАЗ 2 дахин загварт өөрчлөлт орсон гэж засвар хийлгэсэн. Яамны бүтцэд нэмэлт, өөрчлөлт оруулах болсон тул албан тушаалын тодорхойлолтыг ТАЗ-ийн хурлаар хэлэлцүүлэх асуудлыг түр хойшлуулах хүсэлтийг явуулсан.</p>	100%
241.	<p>1.11 Засгийн газрын 2019 оны 38 дугаар тогтоол</p> <p>Гүйцэтгэлийн төлөвлөгөөг байгуулах, үйл ажиллагааг бодитой, чанартай дүгнэж урамшуулах, хариуцлага тооцох</p>	<p>Гүйцэтгэлийн гэрээ</p>	<p>Нэгжийн болон албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөө, биелэлт гаргах маягтыг боловсруулсан. Маягтын дагуу нэгжийн дарга, албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлах ажлыг зохион байгуулж ажиллалаа. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг хагас жилийн байдлаар гаргуулсан. Хагас жилийн байдлаар урамшуулал олгоогүй.</p> <p>Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 3 дугаар улиралд нийт албан хаагч, нэгжээс гаргуулан авсан.</p> <p>2019 оны жилийн эцсийн байдлаар гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг үнэлэх үнэлгээний багийн бүрэлдэхүүнийг батлуулаад байна.</p>	100%

	ажлыг зохион байгуулна.		2019 оны жилийн эцсийн байдлаар гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг үнэлэх үнэлгээний багийн бүрэлдэхүүнийг БСШУС-ын яамны ТНБД-ын 2019 оны А/278 дугаар тушаалаар батлуулсны үндсэн дээр биелэлтийг дүгнэн ТНБД-ын 2019 оны 12 сарын 16 өдрийн Б/177 тоот тушаалаар хангалттай болон бүрэн хангалттай үнэлгээ авсан нэгж, албан хаагчдад мөнгөн урамшуулал тооцож олгох шийдвэр гаргуулаад байна.	
242.	<p>1.12 Төрийн албаны тухай хууль, яамны эрх зүйн байдлын тухай хууль тогтоомж.</p> <p>Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулж, тайланг холбогдох байгууллагад хүргүүлнэ.</p>	Салбар зөвлөлийн үйл ажиллагаа журмын дагуу явагдсан байна.	<p>Салбар зөвлөлийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 15 зүйл, 38 арга хэмжээг тусган баталж, хагас жилийн байдлаар 91 хувийн биелэлттэй хэрэгжүүлж ажиллалаа. Салбар зөвлөл 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэсэн.</p> <p>Үүнд:</p> <p>Төрийн албаны тухай хууль тогтоомж болон Төрийн албаны шийдвэрийн хэрэгжилтийг хангах чиглэлээр</p> <ul style="list-style-type: none"> <li>✓ БСШУС-ын яамны дэргэдэх Ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүнийг журмын дагуу яам, агентлагийн албан хаагчдаас санал авч, хамгийн олон санал авсан 7 албан хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан. Ёс зүйн зөвлөл 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөө батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</li> <li>✓ Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны “Хөтөлбөр, төлөвлөгөө батлах тухай” А/136 дугаар тушаалаар “Яамны албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр төлөвлөгөө”-г батлан хэрэгжилтийг үе шаттай ханган ажиллаж байна. Харамсалтай нь жил бүр уг хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийн төслийг боловсруулан Сангийн яаманд хүргэдэг боловч батлагддаггүй. Тус яам хөтөлбөр төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор удирдлагуудад танилцуулан төсвийн зохицуулалт хийн ажиллаж байна.</li> <li>✓ Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны “Хөтөлбөр, төлөвлөгөө батлах тухай” А/136 дугаар тушаалаар “Яамны албан хаагчдын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө”-г батлан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Яамны болон харьяа байгууллагын албан хаагчдад 2019 онд давхардсан тоогоор 9 сургалтыг зохион байгуулаад байна.</li> <li>✓ Салбар зөвлөлийн даргын баталсан удирдамжийн дагуу Дорнод аймгийн Дорнод их сургууль, ерөнхий боловсролын лаборатори</li> </ul>	100%

			<p>“Хан-Уул” цогцолбор сургуулиудын үйл ажиллагаатай танилцаж, зөвлөн туслах ажлыг зохион байгуулж ажилласан.</p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Яам, агентлагийн албан хаагчдын хувийн хэргийн баяжилт, бүрдүүлэлт хийх ажлыг журмын дагуу зохион байгууллаа.</li> <li>✓ БСШУС-ын яамны дэргэдэх Ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүнийг журмын дагуу яам, агентлагийн албан хаагчдаас санал авч, хамгийн олон санал авсан 7 албан хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан. Ёс зүйн зөвлөл 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөө батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</li> <li>✓ 2018 онд яамны сул ажлын байранд шалгалт өгч Төрийн албаны зөвлөл нөөцөд бүртгэн нэр дэвшүүлсэн 3 албан хаагчийн туршилтын хугацаагаар ажилласан хугацаа дуусч, 2019 оны 6 сарын 24 өдөр тангараг өргүүлсэн.</li> <li>✓ Яамны харьяа 25 байгууллагын төсвийн шууд захирагчийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан. Үүнээс 12 байгууллагын төсвийн шууд захирагчийн сонгон шалгаруулалтыг дахин зохин байгуулсан. Сонгон шалгаруулалтад орсон иргэдийн дүнг хэлэлцэн, нэр дэвшүүлэх тухай шийдвэрийг гаргаж, томилох эрх бүхий этгээдэд хүргүүлсэн.</li> <li>✓ Яамны төрийн захиргааны дэс түшмэлийн болон ахлах түшмэлийн албан тушаалын тодорхойлолтыг хэлэлцэж, Төрийн албаны зөвлөлөөс зөвшөөрөл авахаар тогтсон.</li> <li>✓ Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир спортын газрын, Соёл урлагийн газрын зарим албан хаагчдад зэрэг дэв олгох, ахиулах асуудлыг хэлэлцэж тогтоол гаргасан. Тогтоолыг үндэслэн сайдын тушаалаар зэрэг дэв олгох ахиулан батлуулах, агентлагт хүргэх ажлыг зохион байгуулсан.</li> <li>✓ Яамны харьяа 8 байгууллагын төсвийн шууд захирагчийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулахаа сонгон шалгаруулалтын зарын ТАЗ болон яамны цахим хуудсанд байрлуулаад байна.</li> </ul>	
243.	<p>1.13 Төрийн албаны тухай хууль, яамны эрх зүйн байдлын тухай хууль, тогтоомж.</p> <p>Төрийн жинхэнэ албаны сул орон тоонд</p>	<p>Үйл ажиллагаа хууль, журмын дагуу хэрэгжсэн байна.</p> <p>Үйл ажиллагаа хууль, журмын</p>	<p>Үйлдвэрлэлийн хэлтсийн даргын, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Харьяа байгууллага, тусгай сангийн төсвийн бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтний ажлын байранд Төрийн албаны тухай хуулийн 44.1 дэх хэсгийг үндэслэн шилжүүлэн томилох шийдвэрийн төслийг боловсруулан батлуулсан. БСШУС-ын яамны 7 нэгжийн удирдах албан</p>	100%

	ажлын байрны сонгон шалгаруулалт зарлах, албан хаагчдад зэрэг дэв олгох, зарим албан хаагчдыг төрийн албан хаагчийн тангараг өргөх арга хэмжээг зохион байгуулна.	дагуу хэрэгжсэн байна.	тушаалын ажлын байранд тусгай шалгалт зохион байгуулуулах захиалгыг Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн. Төрийн албаны зөвлөл Төрийн захиргааны удирдлагын газрын, Санхүү хөрөнгө оруулалтын газрын даргын ажлын байрны тусгай шалгалтыг зохион байгуулсан. Яамны сул орон тооны судалгааг ТАЗ-д ирүүлсэн маягтын дагуу хүргүүлсэн.	
244.	1.14 Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Яамны эрхзүйн байдлын тухай хуулийн 7.1.3, 9.6.2, 9.6.3, 12.1, 12.2, 12.3, 23.1 ТАЗ-ийн тогтоол БСШУС-ын яамны төсвийн шууд захирагчийн 2019 оны үр дүнгийн гэрээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөг дүгнэх, үйл ажиллагааны тайланг нэгтгэн, ажлын хэрэгцээнд түгээх, 2020 оны үр дүнгийн гэрээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөг нэгтгэн боловсруулж батлуулах ажлын зохицуулалтыг хангана.	Үйл ажиллагаа хууль, журмын дагуу хэрэгжсэн байна.	БСШУС-ын яамны төсвийн шууд захирагчийн 2019 оны үр дүнгийн гэрээ болон яамны 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан, батлуулж, ажлын хэрэгцээнд түгээв. БСШУС-ын яамны 2019 оны II, III, IV улирлын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг газар, хэлтсүүдээс төвлөрүүлэн авч нэгтгэн боловсруулж тухай бүрд удирдлага, яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газарт тус тус хүргүүлсэн.	100%
245.	1.15 Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 9.4. 19.1	Холбогдох төлөвлөгөө, тэдгээрийн хэрэгжилтийн тайлан, үнэлгээ	Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарт дэвшүүлсэн 238 арга хэмжээний 2019 оны эхний хагас жилийн, жилийн эцсийн тайланг тус тус нэгтгэн, боловсруулж тус яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар, Засгийн	100%

	Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын зорилтуудын биелэлтийг нэгтгэн тайлагнана		газрын хэрэг эрхлэх газарт цаг хугацаанд нь хүргүүлсэн. Тайланг нэгтгэн боловсруулах үед, шаардлага хангаагүй тайланг буцаан, холбогдох мэргэжилтэнтэй уулзаж тодруулга аван засварыг хийн газар нэгжийн даргаар нь баталгаажуулан авсан.  Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан 238 арга хэмжээний 2019 оны эхний хагас жилийн биелэлт 57.88 хувьтай, 2019 оны III улирлын биелэлт 68.02 хувьтай гарсан. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн салбарын зорилт арга хэмжээг 2019 оны яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	
246.	1.16 Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 12.10, 19.1  Эдийн засаг, нийгмийг 2018, 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг хагас бүтэн жилээр нэгтгэж, тайлагнана.	Хэрэгжилтийг бүрэн хангуулах ажлыг зохион байгуулна.	Эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийн эхний хагас жилийн тайланг газар нэгжүүдээс төвлөрүүлэн авч, нэгтгэн боловсруулж, хангалтгүй тайлагнасан мэргэжилтэнтэй эргэн холбогдож тайланг өмнөх онтой харьцуулсан байдлаар хүснэгт, графикаар илэрхийлэн, товч тодорхой, үр дүнг тайлагнан засвар хийн газар нэгжийн дарга нараар баталгаажуулан Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар, Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Сангийн яам, Үндэсний аудитын газарт тайлант хугацаанд нь хүргүүлсэн болно. 2019 оны эхний хагас жилийн байдлаар 61.36 хувийн биелэлттэй гарсан байна. 2019 оны жилийн эцсийн тайланг нэгтгэн, боловсруулж тус яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар, Засгийн газрын хэрэг эрхлэх газарт цаг хугацаанд нь хүргүүлсэн.	100%
247.	1.17 Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль  Яамнаас хэрэгжилтийг нь зохион байгуулах хууль, тогтоол,	Хууль, тогтоол, шийдвэрийн мэдээллийн санд баяжилт хийгдэнэ.	Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим санд БСШУС-ын яамны чиг үүрэгт хамаарах 200 хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт урьдчилсан үнэлгээгээр 90.2 хувьтай байна.  БСШУС-ын яамны Төрийн нарийн бичгийн даргын “Хууль тогтоомж, тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” 2019 оны А/205 дугаар тушаалаар хэрэгжилтийг эрчимжүүлэх, шуурхайлах чиглэл өгч ажиллаа.  УИХ, Засгийн газраас гаргасан хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийг Able программд бүртгэн карталж, нийт албан хаагчдын албан хэрэгцээнд зориулан байршуулж, цахим санг бүрдүүлэн ажиллаж байна. 2019 онд	100%

	<p>шийдвэрийн мэдээллийн сан бүрдүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж, тайлан мэдээ гаргана.</p>		<p>нийт 118 тогтоол шийдвэрийг байршуулсан байна.</p> <p>Able системд байршуулсан тогтоол, шийдвэр /2019 он/</p>  <table border="1"> <thead> <tr> <th>Төрөл</th> <th>Тоо</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Ерөнхийлөгчийн зарлиг</td> <td>4</td> </tr> <tr> <td>УИХ-ын БХ-ны тогтоол</td> <td>1</td> </tr> <tr> <td>УИХ-ын даргын захирамж</td> <td>1</td> </tr> <tr> <td>Засгийн газрын тогтоол</td> <td>144</td> </tr> <tr> <td>Засгийн газрын хуралдааны тэмдэглэл</td> <td>120</td> </tr> <tr> <td>Ерөнхий сайдын захирамж</td> <td>39</td> </tr> </tbody> </table>	Төрөл	Тоо	Ерөнхийлөгчийн зарлиг	4	УИХ-ын БХ-ны тогтоол	1	УИХ-ын даргын захирамж	1	Засгийн газрын тогтоол	144	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	120	Ерөнхий сайдын захирамж	39	
Төрөл	Тоо																	
Ерөнхийлөгчийн зарлиг	4																	
УИХ-ын БХ-ны тогтоол	1																	
УИХ-ын даргын захирамж	1																	
Засгийн газрын тогтоол	144																	
Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	120																	
Ерөнхий сайдын захирамж	39																	
248.	<p>1.18 Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль</p> <p>БСШУС-ын салбарын холбогдох батлагдсан Үндэсний хөтөлбөрийн зорилт, арга хэмжээг яамны урт болон богино хугацааны төлөвлөгөөнд тусган төлөвлөх, батлуулах, хэрэгжилтийг хангуулах, тайлагнах шаардлагатай зохицуулалтаар хангах.</p>	<p>Хэрэгжилтийг бүрэн хангуулах ажлыг зохион байгуулна.</p>	<p>Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын хэмжээнд хэрэгжүүлж буй 20 үндэсний хөтөлбөрийн мэдээллийн сан үүсгэж, хэрэгжилтийг тайлагнан ажиллаа. Үндэсний хөтөлбөрийн зорилт, арга хэмжээг яамны болон хэлтэс, газрын, мэргэжилтний гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг хангаж ажиллаж байгаа</p> <p>“БСШУС-ын яамны газар, хэлтсээс бодлогын баримт бичиг, хууль, тогтоомж шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааг тайлагнах календарьчилсан төлөвлөгөө” /2019, 2020 он/-г нэгтгэн боловсруулан мөрдөж ажиллаж байна. ABLE программын Файлын сан-д дэд хавтас (sub folder) үүсгэн байгууллага дотроо нийт албан хаагчдад харагдахаар байршуулсан. Энэхүү төлөвлөгөөний дагуу хууль тогтоомж, тогтоол шийдвэр, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнах ажлыг зохион байгуулж байна.</p> <p>Салбарын яамдаас тайлан шаардсан үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулж, биелэлтийг тайлагнаж ажиллаа. Тухайлбал,</p> <ul style="list-style-type: none"> <li>- Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр</li> <li>- Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үндэсний хөтөлбөр</li> <li>- Үйлдвэржилт 21:100 үндэсний хөтөлбөр</li> <li>- Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөр</li> </ul>	100%														



			Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуульд нийцүүлэн зорилго, зорилт давхацсан үндэсний хөтөлбөрүүдийг нэгтгэх, шинэчлэн боловсруулах, хэрэгжилт хангалтгүй, хэрэгжих боломжгүй, санхүүжилт тодорхойгүй үндэсний хөтөлбөрүүдийн талаар дүгнэлт гаргаж, цаашид авах арга хэмжээг тодорхойлохтой холбогдуулан тухайн салбарт хэрэгжиж буй үндэсний хөтөлбөрүүдийн талаарх саналыг ЗГХЭГ-т хүргүүлсэн.	
249.	<p>1.19 Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль</p> <p>Яамны дотоод журмыг хэрэгжилтийг хангаж, зохицуулалтыг шуурхай, чанартай хангаж, “Мэдээллийн цаг”-ийг тогтмолжуулна.</p>	<p>Журмын хэрэгжилтэд хяналт тавьсан байна.</p>	<p>Яамны дотоод журмын зохицуулалтын хангах үүднээс яамны өдөр тутмын зохион байгуулалтын ажлыг шуурхай зохион байгуулах, удирдлагаар хангах зорилгоор БСШУС-ын 2019 оны А/275 дугаар тушаалаар “ БСШУС-ын сайдын удирдлагын шуурхай хурлыг зохион байгуулах журам”-ын баталж хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд уг журмын дагуу сар бүрийн эхний 7 хоногт Сайдын шуурхай хуралдааныг яамны бүх нэгжийн дарга нар, сайдын багцад харьяалагддаг төсвийн шууд захирагч нарыг оролцуулан зохион байгуулдаг байх, бусад үед ТНБД-аас 14 хоног тутамд яамны аппаратын шуурхай хуралдааныг зохион байгуулдаг байх, эдгээр шуурхай хурлаар цаг үеийн болон төлөвлөгөөт ажлын гүйцэтгэлийг дүгнэх, мэдээлэл удирдлагын түвшинд шуурхай зохион байгуулах, өмнөх хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг тайлагнах үйл ажиллагааг тогтмол хийдэг болсон нь яам, салбарын өдөр тутмын шуурхай удирдлагыг хэрэгжүүлэхэд ихээхэн ач холбогдолтой болсон.</p> <p>Мөн 2019 онд Яамны нийт албан хаагчдын дунд мэдээллийн цагийг тогтмолжуулж, нийт 8 удаагийн сургалт зохион байгуулсан. Мэдээллийн цагийн үеэр Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, Төрийн албаны ёс зүй, харилцаа, хувцаслалтын соёлын талаар, Албан хэрэг хөтлөлт болон бусад төлөвлөгөөт сургалтуудыг зохион байгуулж ирлээ.</p>	100%

250.	<p>1.20 Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль</p> <p>Яамны дотоод журмыг хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, эрхзүйн баримт бичгийг үндэслэн шинэчлэн батлуулна.</p>	<p>Дотоод журмыг шинэчлэн батлуулсан байна.</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгатай холбогдуулан эрх бүхий байгууллагаас 2019 онд баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам”, “Төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах, түүнд гомдол гаргах журам”, “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-д зааснаар БСШУС-ын яамны бүтэц, зохион байгуулалт, Байгууллагын албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтод нийцүүлэн Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн боловсруулаад байна.</p> <p>Яамны “хөдөлмөрийн дотоод журам”-д ТНБД-ын 2019 оны 10 сарын 4 өдрийн А/232 тоот тушаалаар тус тус өөрчлөлт орж батлагдсан байна.</p>	100%
251.	<p>1.21 Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль</p> <p>Яамны санхүүгийн үйл ажиллагааг хууль, тогтоомжийн хүрээнд чанартай зохион байгуулна.</p>	<p>Санхүүгийн болон дотоод мөнгөн касс, аж ахуйн үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь. Чанартай зохион байгуулсан байна</p>	<p>БСШУС-ын яамны харьяа 227 байгууллагын 2019 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг нэгтгэн хуулийн хугацаанд Үндэсний аудитын газарт хүргүүлж, явцын аудитад хамрагдсан. Харьяа 227 байгууллагын 2019 оны эхний хагас жилийн нэгдсэн тайлан гаргахтай холбоотой кассын нэгтгэл, хоорондын тооцоог байгууллага бүрээр тулган баталгаажуулж, төсвийн гүйцэтгэлийн тайлангийн танилцуулгыг бэлтгэн Сангийн яаманд цахимаар болон цаасаар хүргүүлэн Засгийн газрын нэгдсэн тайланд нэгтгүүлсэн. Яамны урсгал үйл ажиллагаа болон хөтөлбөр арга хэмжээний төсвийг батлагдсан хуваарийн дагуу санхүүжилт хийгдсэн тухай бүрт санхүүжилтийн эрхийг нээлгэж, зориулалтын дагуу эрх бүхий албан тушаалтнуудын шийдвэрээр, анхан шатны баримт материалыг үндэслэн гүйлгээ гарган, нягтлан бодох бүртгэлийг хөтөлж, санхүүгийн үйл ажиллагааг зохион байгууллаа.</p> <p>Нэмэлт санхүүжилтийн дансаар Сангийн яам, НҮБ-ын Хүүхдийн сан болон, Хүн амын сангаас нийт 566,625.9 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосныг тухай бүр эрх нээлгэн гэрээ, анхан шатны баримтыг үндэслэн гүйлгээ гарган санхүүгийн тайланд тусгасан.</p> <p>Яамны албан хаагчдын цалинг сар 2 удаа тооцон олгож, цалингийн мэдээлэл, картыг албан хаагч бүрт цахим шуудангаар явуулсан.</p> <p>Нийгмийн даатгалын тайлан, татварын тайлан болон төсвийн гүйцэтгэлийн мэдээг хуулийн хугацаанд боловсруулан хүргүүлсэн..</p>	100%

			Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган холбогдох мэдээллийг <a href="http://www.shilendans.gov.mn">www.shilendans.gov.mn</a> сайтад байршуулан ажилласан. Яамны 2020 оны төсвийн төслийг боловсруулж батлуулсан.	
252.	1.22 Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль Албан хаагчдыг үйл ажиллагаагаа тасралтгүй, хэвийн явуулах, хангамж, үйлчилгээ, санхүү, эрх зүйн дэмжлэг үзүүлнэ.	Батлагдсан төсвийн хүрээнд авсан арга хэмжээ, үр дүн. Чанартай зохион байгуулсан байна	Байгууллагын дотоод мөнгөн кассын өдөр тутмын үйл ажиллагааг зохих журмын дагуу хөтлөн, тухай бүрт анхан шатны баримтыг бүрдүүлэн ажилласан. Яамны албан хаагчдад шаардлагатай бичиг хэргийн болон хангамжийн материалыг тухай бүр олгож хэвийн үйл ажиллагааг хангасан. Бараа материалын орлого, зарлагыг өдөр бүр анхан шатны баримтын дагуу хийж, шаардах хуудсаар тухай бүр зарлагадаж бараа материалын тайланг улирал бүр гарган ажилласан. Үндэсний аудитын газраас өгсөн зөвлөмжийн дагуу үндсэн хөрөнгө тооллогыг эхний хагас жилээр хийж ашиглах боломжгүй, элэгдэх хугацаа дууссан хөрөнгийн жагсаалтыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар хүргүүлсэн. Мөн олон жил болсон ашиглалтын шаардлага хангахгүй байгаа хангамжийн материалыг ТНБД-ын тушаалын дагуу актлахаар жагсаалтыг гарган тооллогын комисс, өмч хамгаалах комисст танилцуулсан. Яамны албан хаагчдад шаардлагатай тавилга, эд хогшил, тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолтыг бэлтгэн, батлуулж үнэлгээний хорооны нарийн бичигт өгсөн. Сайд, дэд сайд, Төрийн нарийн бичгийн даргын гадаад, дотоодод томилолтоор ажиллах бэлтгэл ажлыг ханган ажилласан. Үндэсний аудитын газраас өгсөн зөвлөмжийн дагуу Техникийн комисс байгуулан комиссын шийдвэр, хурлын тэмдэглэлийг үндэслэн авто машины засвар үйлчилгээг хийлгэн тухай бүр техникийн карт хөтлөн ажиллаж байна. Ажиллагсдын нийгмийн даатгал, эрүүл мэндийг дэвтрийг тухай бүр бөглөн баталгаажуулсан. Яамны ахмадын хорооноос зохион байгуулсан үйл ажиллагаанд хамтран ажилласан.	100%
253.	1.23 Засгийн газрын тухай хууль, МУ-ын яамны эрхзүйн байдлын тухай хууль	Хуралдсан, хэлэлцсэн асуудлын тоо, гарсан шийдвэр,	Сайд, дэд сайд, төрийн нарийн бичгийн даргын шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврыг яамны нэгжийн дарга, мэргэжилтнүүдэд дотоод сүлжээгээр хүргэх, хэрэгжилтийг хангах, өдөр тутмын үйл ажиллагаанд	100%

	<p>Сайд, дэд сайд, төрийн нарийн бичгийн даргын өдөр тутмын үйл ажиллагаанд мэргэжлийн дэмжлэг зөвлөгөө үзүүлэх, мөн Сайд, Дэд сайд, Төрийн нарийн бичгийн даргын ахалдаг болон бүрэлдэхүүнд нь ажилладаг комисс, зөвлөл, хорооны ажлын зохицуулалтыг хангаж, тайлагнана.</p>	<p>өгсөн үүрэг даалгавар чиглэл санал, түүний мөрөөр авсан арга хэмжээ үр дүнгээр.</p>	<p>мэргэжлийн дэмжлэг зөвлөгөө үзүүлэх ажлыг тогтмол зохион байгуулдаг.</p> <p>Сайд, Дэд сайд, Төрийн нарийн бичгийн даргын ахалдаг болон бүрэлдэхүүнд нь ажилладаг комисс, зөвлөл, хорооны ажлын зохицуулалтыг хангаж, тайлагнана.</p> <p>БСШУС-ын сайд, дэд сайд болон төрийн нарийн бичгийн дарга нар Ерөнхийлөгчийн захирамж, УИХ-ын Байнгын хорооны тогтоол, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын тушаалаар нийт 43 ажлын хэсэг, хороо, комисс зэргийн бүрэлдэхүүнд ажиллаж байна.</p>	
254.	<p>1.24 Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль</p> <p>Яамны албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг сайжруулах, баримт бичгийн цахим санг тасралтгүй нэмэгдүүлнэ.</p>	<p>Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа, зохион байгуулалт сайжирч, байгууллага, иргэдэд шуурхай, үйлчилгээ үзүүлнэ.</p>	<p>2019 онд яаманд хандаж ирүүлсэн нийт 14574 албан бичиг, 3685 өргөдөл гомдлыг хүлээн авч бүртгэн, иргэд, албан байгууллагаас ирүүлсэн хариутай албан бичиг, өргөдөл гомдлын тайланг гаргаж шийдвэрлэгдээгүй, хугацаа хэтэрсэн өргөдөл гомдол, албан бичгийн дэлгэрэнгүй болон шийдвэрлэлтийн талаарх мэдээллийг 14 хоног тутам нийт удирдлага, албан хаагчдад цахим хэлбэрээр мэдээлж, удирдлагын шуурхай хуралдаанд танилцуулж, шийдвэрлэлтийн байдалд хяналт тавин ажиллалаа.</p> <p><b><u>2019 онд нийт ирсэн, явсан бичгийн эргэлтийн тоо:</u></b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Бичгээр ирсэн албан бичиг, өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн тоо-18259</li> <li>• Хариутай бичгийн тоо-10880</li> <li>• Хариугүй шууд бичгийн тоо-3694</li> <li>• Захидал, өргөдөл, гомдол-3685</li> <li>• Явуулсан бичиг-10855</li> </ul> <p>2019 онд иргэд, албан байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн тоог өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад албан бичиг 5.5%-аар нэмэгдсэн бол өргөдөл 2 дахин буурсан үзүүлэлттэй байна. БСШУСЯ-нд ирсэн баримт бичгийг ангилж, өмнөх онуудын мөн үеийнхтэй харьцуулан, тоо болон графикаар үзүүлбэл:</p>	100%

			<table border="1"> <thead> <tr> <th rowspan="2">№</th> <th rowspan="2">Он</th> <th colspan="2">2017</th> <th colspan="2">2018</th> <th colspan="2">2019</th> </tr> <tr> <th>Ангилал</th> <th>Тоо</th> <th>Хувь</th> <th>Тоо</th> <th>Хувь</th> <th>Тоо</th> <th>Хувь</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td>Хариутай бичиг</td> <td></td> <td>4992</td> <td>31.9%</td> <td>10744</td> <td>52.5%</td> <td>10880</td> <td>59.6%</td> </tr> <tr> <td>2</td> <td>Өргөдөл, гомдол, захидал</td> <td></td> <td>5117</td> <td>32.8%</td> <td>6350</td> <td>31.1%</td> <td>3685</td> <td>20.2%</td> </tr> <tr> <td>3</td> <td>Шууд бичиг</td> <td></td> <td>5508</td> <td>35.3%</td> <td>3353</td> <td>16.4%</td> <td>3694</td> <td>20.2%</td> </tr> <tr> <td colspan="2"><b>Дүн</b></td> <td></td> <td><b>15617</b></td> <td><b>100%</b></td> <td><b>20447</b></td> <td><b>100%</b></td> <td><b>18259</b></td> <td><b>100%</b></td> </tr> </tbody> </table> <p>Нийт ирсэн 18259 албан бичиг, өргөдөл, гомдол, явсан 10855 албан бичиг буюу 150000 орчим хуудас, 600 гаруй хавтас баримт бичгийг албан хэрэг хөтлөлтийн программд цахим хэлбэрээр бүртгэсэн байна.</p>	№	Он	2017		2018		2019		Ангилал	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	1	Хариутай бичиг		4992	31.9%	10744	52.5%	10880	59.6%	2	Өргөдөл, гомдол, захидал		5117	32.8%	6350	31.1%	3685	20.2%	3	Шууд бичиг		5508	35.3%	3353	16.4%	3694	20.2%	<b>Дүн</b>			<b>15617</b>	<b>100%</b>	<b>20447</b>	<b>100%</b>	<b>18259</b>	<b>100%</b>	
№	Он	2017				2018		2019																																															
		Ангилал	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь																																															
1	Хариутай бичиг		4992	31.9%	10744	52.5%	10880	59.6%																																															
2	Өргөдөл, гомдол, захидал		5117	32.8%	6350	31.1%	3685	20.2%																																															
3	Шууд бичиг		5508	35.3%	3353	16.4%	3694	20.2%																																															
<b>Дүн</b>			<b>15617</b>	<b>100%</b>	<b>20447</b>	<b>100%</b>	<b>18259</b>	<b>100%</b>																																															
255.	<p>1.25 Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль</p> <p>Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт бэлтгэх ажлын төлөвлөгөө</p>	<p>Төлөвлөгөө батлагдан хэрэгжиж, үзлэгт амжилттай дүн үзүүлнэ.</p>	<p>Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Улсын үзлэг зохион байгуулах тухай” 150 дугаар тогтоолоор Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг явуулахаар шийдвэрлэж, Ерөнхий сайдын 2019 оны 4 сарын 17-ны өдрийн 46 дугаар захирамжаар улсын үзлэг явуулах ажлыг удирдан зохион байгуулах Төв комиссын бүрэлдэхүүн болон үзлэг явуулах хуваарь, үзлэгийн удирдамжийг баталсан. Энэхүү үзлэг нь улсын хэмжээнд 4-5 жилийн давтамжтай явагддаг томоохон үзлэг бөгөөд архив, албан хэрэг хөтлөлтийн талаарх хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг шалгах, төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, төлөвлөлт, архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологийн</p>	100%																																																			

	<p>батлуулан хэрэгжүүлж, ажиллана.</p>		<p>үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг шалгаж, үнэлгээ, дүгнэлт өгдөг билээ. Иймд үзлэгийн бэлтгэл хангах зорилгоор дараах ажлуудыг хийж гүйцэтгэн, амжилттай дүгнүүлээ. Үүнд:</p> <p>Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийн бэлтгэл хангах зорилгоор 2019 оны “Салбар комисс байгуулах тухай” Сайдын А/346 дугаар тушаал, Сайдын 2019 оны 6 сарын 14 өдрийн "Зардал батлах тухай" А/393 дугаар тушаал, 2019 оны ТНБД-ын "Салбар комиссын ажлын төлөвлөгөө, удирдамж, үзлэгт хамрагдах байгууллагын жагсаалт, үзлэг явуулах хуваарийг батлах тухай" А/124 дүгээр тушаал, ТНБД-ын 2019 оны 6 сарын 14 өдрийн "Комисс томилох тухай" А/135 дугаар тушаалыг тус тус боловсруулан батлуулсан.</p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Салбар комиссоос 2019 оны 6 сарын 5 өдөр харьяа байгууллагуудад үзлэг зохион байгуулах талаар нэгдсэн хуралдааныг зохион байгуулсан.</li> <li>✓ Улсын үзлэг угтаж, Салбар комиссын төлөвлөгөөт ажлын хүрээнд АЕГ, ТАЗ-өөс багш нар урьж, яамны нийт албан хаагчид, харьяа байгууллагын удирдлага, архив, бичиг хэрэг хариуцсан ажилтан, салбар комиссын болон дэд ажлын хэсгийн гишүүдэд зориулсан сургалтыг 2019 оны 6 сарын 11-14-нд амжилттай зохион байгуулсан.</li> <li>✓ Дэд ажлын хэсгүүд үзлэг явуулах хуваарийн дагуу 2019 оны 6 сарын 24-өөс 2019 оны 7 сарын 5 өдрүүдэд бүх харьяа байгууллагад үзлэг явуулж, алдаа дутагдлыг илрүүлэн, үйл ажиллагааг сайжруулах, зөвлөн туслах, цаашид авах арга хэмжээний санал дүгнэлт боловсруулан ажилласан.</li> <li>✓ Үзлэгийн дүнд цаашид авах арга хэмжээний талаарх санал, дүгнэлт бүхий зөвлөмж боловсруулан гаргаж, БСШУС-ын яамны 2019 оны 8 сарын 21-ний өдрийн 9/7472 тоот албан бичгээр харьяа байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажилласан талаар биелэлтийн мэдээг ирүүлсэн байна.</li> <li>✓ Мөн яамны удирдлагын үйл ажиллагааг баримтжуулах явцад үүсч хөтлөгдөж буй архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгох, яамны нэгж, албан хаагч, архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтнууд тус үзлэгт бэлтгэл зохион байгуулалттай оролцох, 4 үндсэн чиглэлтэй нийт</li> </ul>	
--	--	--	--	--

			<p>128 заалт бүхий ажлын төлөвлөгөөг батлуулан, биелэлтийг гаргаж ажилласан. Байгууллагын комиссын үйл ажиллагааны хүрээнд яамны нийт албан хаагчдын баримт бичигтэй ажиллах явцтай ажлын байранд нь танилцаж, заавар зөвлөгөө өгч ажиллалаа.</p> <p>✓ БСШУС-ын яамны төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд 11 сарын 15-20-ны өдрүүдэд улсын үзлэг явууллаа. Үзлэгийг мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Н.Цагаанхүүгээр ахлуулсан 5 хүний бүрэлдэхүүнтэй улсын үзлэг зохион байгуулах төв комиссын ажлын хэсэг дараах 4 чиглэлийн хүрээнд үзлэг явуулж, дүгнэсэн. Үүнд:</p> <p>Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалтын чиглэлээр 500 оноо авахаас 453 оноо авч, 90.6 буюу А үнэлгээтэй, архивын чиглэлээр 1000 онооноос 950 оноо авч, 95 буюу А үнэлгээгээр, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр 1000 онооноос 953 оноо авч, 95,3 буюу А үнэлгээгээр, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологийг нэвтрүүлэх чиглэлээр 1000 онооноос 970 оноо авч, 97 буюу А үнэлгээгээр тус тус амжилттай дүгнүүлж, нэгдсэн дүнгээр 94,47% буюу “А” маш сайн гэсэн үнэлгээ авлаа.</p>	
256.	<p>1.26 Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль</p> <p>Албан бичиг, өргөдөл, гомдол, захидлын шийдвэрлэлтэд тогтмол хяналт тавьж, тайлан, мэдээг тогтоосон хугацаанд гаргаж, мэдээлнэ.</p>	<p>Тайлан, мэдээг хугацаанд нь, гаргаж хүргүүлсэн байна.</p>	<p>Яаманд хандаж ирүүлсэн албан бичиг, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайланг 14 хоног бүрийн баасан гаригт гаргаж, удирдлагуудын шуурхай хуралдаанд танилцуулан, яамны нийт албан хаагчдад дотоод сүлжээгээр хүргүүлж, шийдвэрлэлтэд хяналт тавин ажиллалаа.</p> <p><b><u>Шийдвэрлэлтийн байдал:</u></b></p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Шийдвэрлэж, хариу өгсөн албан бичгийн тоо/хувь - 10650/97,9%</li> <li>✓ Шийдвэрлэж, хариу өгсөн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн тоо/хувь - 3624/98,3%</li> <li>✓ Шийдвэрлэгдээгүй судлагдаж байгаа албан бичиг, өргөдлийн тоо/хувь - 180/1,2%</li> <li>✓ Шийдвэрлээгүй, хугацаа хэтэрсэн албан бичиг, өргөдлийн тоо/хувь - 110/0,7%</li> </ul> <p>Яамнаас явуулж буй албан бичгийг тухайн өдөрт нь бүртгэлийн дэвтэрт бүртгэн, биеэр хүргэх буюу шуудангаар илгээж, хүсэлт, өргөдөл,</p>	100%

			<p>гомдлын хариуг гарсан даруйд нь холбогдох байгууллага, иргэдэд утсаар мэдэгдэх болон биеэр хүргэж гадны байгууллага, иргэдэд соёлтой, түргэн шуурхай үйлчилгээ үзүүлж байна.</p> <p>Биеэр хүргэх бичгийн бүртгэл, хөдөө орон нутагт явуулсан бичгийн бүртгэл, хот дотор явуулсан бичгийн бүртгэлийн дэвтрийг тус тус хөтлөн ажиллаж байна.</p> <p>Сүүлийн 5 жилд БСШУС-ын яаманд ирсэн албан бичиг, өргөдлийг харьцуулан харуулбал:</p> <table border="1" data-bbox="898 499 1655 716"> <thead> <tr> <th>№</th> <th>Он</th> <th>2015</th> <th>2016</th> <th>2017</th> <th>2018</th> <th>2019</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td>Хариутай бичиг</td> <td>5088</td> <td>5546</td> <td>4992</td> <td>10744</td> <td>10880</td> </tr> <tr> <td>2</td> <td>Шууд бичиг</td> <td>4090</td> <td>3193</td> <td>5508</td> <td>3353</td> <td>3694</td> </tr> <tr> <td>3</td> <td>Өргөдөл, гомдол</td> <td>5156</td> <td>4278</td> <td>5117</td> <td>6350</td> <td>3685</td> </tr> </tbody> </table> <p>Энэ ачаалал хэрхэн үүсч байгааг судалж тогтоон, ачааллыг багасгах арга хэмжээ авч ажиллалаа.</p> <p>Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Аймаг, нийслэлийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, соёл, урлаг, биеийн тамир, спортын анхан шатны байгууллагаас их засвар хийлгэх, тавилга, тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт хүссэн албан бичиг асар олноор ирж байгаа нь яаманд механик ачаалал ихээр үүсгэж байгаа тул цаг хугацаа хэмнэх, ажлын ачааллыг бууруулах, бичиг хэргийн үр ашиггүй зардлыг багасгах зорилгоор орон нутгийн хэмжээний хөрөнгө оруулалт, төсөвтэй холбоотой асуудлын нэгдсэн судалгааг гарган эрэмбэлж, саналаа жил бүрийн 3 болон 6 сарын 15-ны дотор аймаг, нийслэлийн Засаг даргын гарын үсэг бүхий албан тоотгоор ирүүлэх талаар аймаг, нийслэлийн засаг дарга нар болон Боловсрол, соёл, урлагийн газар, Биеийн тамир, спортын газарт "Чиглэл өгөх тухай" сайдын 2019 оны 4 сарын 24 өдрийн 1а/3320 тоот албан бичгийг боловсруулан хүргүүлсэн.</li> <li>2. БСШУС-ын яаманд хандаж байгаа иргэдийн хүсэлт, яамнаас явуулж байгаа албан бичгийн 30 орчим хувийг эзэлдэг боловсролын баримт бичгийн лавлагааг олгох талаар:             <ol style="list-style-type: none"> <li>а/ ЕБС төгссөн баримт бичгийн лавлагаа авах бол:                     <p>Нийслэлд ЕБС төгссөн иргэд харьяа дүүргийн боловсролын хэлтсээс, хөдөө орон нутагт төгссөн иргэд аймгийн БСУГ-аас, Япон, Итали улс руу</p> </li> </ol> </li> </ol>	№	Он	2015	2016	2017	2018	2019	1	Хариутай бичиг	5088	5546	4992	10744	10880	2	Шууд бичиг	4090	3193	5508	3353	3694	3	Өргөдөл, гомдол	5156	4278	5117	6350	3685	
№	Он	2015	2016	2017	2018	2019																										
1	Хариутай бичиг	5088	5546	4992	10744	10880																										
2	Шууд бичиг	4090	3193	5508	3353	3694																										
3	Өргөдөл, гомдол	5156	4278	5117	6350	3685																										



			<p>суралцах иргэд БСШУС-ын яамнаас авахаар зохицуулалт хийсэн. Мөн бүрэн дунд болон суурь боловсролын гэрчилгээгээ хаяж үрэгдүүлсэн иргэд төгссөн аймаг, дүүргийн БСУГ, боловсролын хэлтэст хандаж дахин шинээр гаргуулахаар тусгасан.</p> <p>б/Их дээд сургууль төгссөн баримт бичгийн лавлагаа авах бол: Тухайн сургууль үйл ажиллагаа явуулж байгаа тохиолдолд сургуулиасаа, татан буугдсан бол яамнаас тодорхойлолт авахаар тусган, хэрэгжүүлж байна.</p> <p>Үүний үр дүнд сүүлийн хоёр оны бичгийн тоог харьцуулахад өргөдлийн тоо эрс буурч, явсан бичгийн тоо мөн дагаад буурсан дүнтэй байна.</p> <p>Иргэдээс төрийн захиргааны төв байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээ, тайланг чанартай гарган тогтоосон цаг хугацаанд нь улирал бүрийн 10-ны дотор Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэх ажил тогтмолжсон.</p> <p>Иргэдээс БСШУС-ын яам болон харьяа байгууллагад ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн 2018 оны жилийн эцсийн тайланг нэгтгэж 2019 оны 1 сард 2/230 тоот албан бичгээр, 2019 оны 1 дүгээр улирлын тайланг 4 сард 2/2745 тоот албан бичгээр, 2 дугаар улирлын тайланг 7 сард 2/6446 тоот албан бичгээр, 3 дугаар улирлын тайланг 10 сард 2/8877 тоот албан бичгээр тус тус Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлэн ажиллалаа.</p>	
257.	<p>1.27 Архивын тухай хуулийн 25-р зүйлийн 25,2, УАГ-ын даргын Байгууллагын архивын ажлын үндсэн заавар батлах тухай 59-р тушаал</p> <p>Архивын үйл ажиллагааг чанаржуулж, архивын сан хөмрөгийг бүрдүүлэх, цахим хэлбэрт шилжүүлэх, цахим санг тасралтгүй нэмэгдүүлэх, архивын</p>	<p>Цахим хэлбэрт шилжүүлсэн баримтын тоо, үйлчилсэн лавлагааны тоо.</p>	<p>Яамны архивын үйл ажиллагааг сайжруулах, иргэд, байгууллагад хөнгөн шуурхай үйлчилгээ үзүүлэх, төрийн албан хэрэг хөтлөлт, архивын баримтыг эмх цэгцтэй, стандартын дагуу зохион байгуулах түүний бүрдэл, хадгалалт, хамгаалалт, ашиглалтыг шаардлагад нийцүүлэх зорилгоор Багшийн хөгжлийн ордон, архивын өрөөний хадгалалт хамгаалалт, гал, усны аюулгүй байдалд хяналт тавьж ариутгал, цэвэрлэгээг хийж БХО-нд хадгалагдаж буй 2011-2018 оны баримт бичгийг байнга, түр, 70 жилээр нь ангилан төрөлжүүлж хадгаламжийн нэгжийг дугаарлах, дотоод товъёог, баталгааны хуудас үйлдэх зэрэг ажлуудыг хийж үдэж хавтасласан.</p> <p>Цахим санг тасралтгүй нэмэгдүүлэн захирамжлалын баримт бичиг болох 2018 оны сайдын тушаал, боловсон хүчний холбогдолтой сайдын тушаалыг хуудас бүрээр сканердаж боть тус бүрээр нь файл үүсгэн хадгалсан.</p>	100%

	лавлагаагаар үйлчлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.		Архивын үндсэн болон туслах баримт бичгүүд, дотоодод хөтлөгддөг баримт бичгүүдийг зааврын дагуу хөтөлж 1586 хүнд лавлагаа, мэдээллээр чирэгдэлгүй шуурхай үйлчилсэн. Үүнээс: ✓ аппаратын албан хаагч 425 хүнд байгууллага, иргэд 1161 хүнд	
258.	1.28 Монгол Улсын Засгийн газрын болон Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын шагналын мэдээллийн бүртгэлийг цахимжуулан боловсронгуй болгож, мэдээллийн бааз үүсгэх “Шагналын систем” програм хангамжийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэхтэй холбогдуулан шагналын журамд нэмэлт заалт оруулан, шинэчлэн батлуулна.	Журам шинэчлэгдэн, сайдын тушаалаар батлагдсан байна.	“ БСШУС-ын салбарын албан хаагчид шагнал олгох журам”-ыг сайдын 2019 оны 12 сарын 20 өдрийн А/828 тушаалын нэгдүгээр хавсралтаар, “Засгийн газрын хүндэт тэмдэг”-ийн болон “ БСШУС-ын яамны жуух бичиг”-ийн загварыг 2, 3 дугаар хавсралтаар тус тус баталсан.	100%
259.	1.29 Монгол Улсын Засгийн газрын болон БСШУС-ын салбарын шагналын мэдээллийн бүртгэлийг цахимжуулан боловсронгуй болгож, мэдээллийн бааз үүсгэх “Шагналын систем” програмыг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх зорилгоор 21 аймаг,	“Шагналын систем” програмын сургалтад 21 аймаг, нийслэлийн Боловсрол, соёлын газрын шагналын асуудал хариуцсан болон ИТ мэргэжилтнүүд хамрагдсан байна.	Сургалт зохион байгуулах төсөв батлагдаагүйтэй холбоотой сургалтыг Боловсролын мэдээллийн системийн шинжээч Б.Туяатай хамтран Зайны сургалт зохион байгуулсан. Шагналын системийн хэрэглэгчийн гарын авлагыг 1. БСШУС-ын яамны шагнал хариуцсан мэргэжилтэн 2. БСУГ-ын шагнал хариуцсан мэргэжилтэн 3.СӨБ болон ЕБС-ийн шагнал хариуцсан мэргэжилтний гэсэн 3 түвшинд боловсруулж, нийслэл болон 21 аймгийн боловсрол, соёл, урлагийн газарт мэйлээр илгээн, тус хичээлийг Боловсролын мэдээллийн сангийн сайтад байршуулан, мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангасан. Энэ нь төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг агуулгаар нь бүрэн хүргэсэн төдийгүй төсвийн 20 сая төгрөгийг хэмнэсэн үр дүнтэй ажил болсон	100%

	нийслэлийн Боловсрол, соёлын газрын шагналын асуудал хариуцсан болон IT мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулна.			
260.	1.30 Салбарын тэргүүний ажилтны тэмдэг, үнэмлэх, жуух, хавтас худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд зохион байгуулсан байна.	Журмын шаардлагын дагуу нэр дэвшигчийн материалыг хянаж, баталгаажуулсан байна.	Журмын дагуу салбар бүрийн тэргүүний ажилтан, албан хаагчид шалгарч, БСШУС-ын сайдын “Шагнах тухай” 2019 оны 2 сарын 4 өдрийн А/58, 4 сарын 3 өдрийн А/193, 7 сарын 25 өдрийн А/571, 10 сарын 22 өдрийн А/671 тушаал тус тус батлагдан, хэрэгжилт хангагдсан. БСШУС-ын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны 2 сарын 28 өдрийн А/28 дугаар тушаалаар байгуулагдсан Үнэлгээний хороо “Салбарын тэргүүний ажилтан тэмдэг үйлдвэрлэн нийлүүлэх БСШУСЯ/201903446”, “Салбарын тэргүүний ажилтны үнэмлэх, яамны жуух бичиг, хавтас хэвлэн, нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах БСШУСЯ/201903447” дугаар бүхий цахим тендерийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу тус тус цахим тендерийг зохион байгуулж, шалгарсан гүйцэтгэгч “Цэц тэнгэр” ХХК-тай 39,420,150, “Сод пресс” ХХК-тай 18,282,000 төгрөгөөр тус тус 2019 оны 4 сарын 8 өдөр гэрээ байгуулж, ажил гүйцэтгүүлэн, хүлээн авсан. 10,947,250 төгрөгийн төсвийн хэмнэлттэй ажилласан. Хэмнэсэн төсвөөрөө хуулийн дагуу 20 хувьд 2019.11.25-ны өдөр БСШУСЯ/201903446+1, БСШУСЯ/201903447+1 дугаартай нэмэлт гэрээг байгуулан, 2019 оны 12 сарын 11 өдөр 100% гүйцэтгүүлж, тус тус акт үйлдэн хүлээн авсан	100%
Хоёр. Салбарын мэдээллийн технологийн үйл ажиллагааг зохицуулах, статистикийн мэдээлэл нэгтгэх, боловсруулах, дүн шинжилгээ хийх, мэдээллийн сан бүрдүүлэх, хэрэглэгчийг мэдээллээр хангах хүрээнд				
261.	2.1 Боловсролын салбарын мэдээллийн системийг үргэлжлүүлэн боловсруулах ба СӨБ,	СӨБ, ЕБС-ийн 16 модуль шинэчилж, 6 модуль шинээр боловсруулж, 2 програм	Дээд боловсролын салбарт Дээд боловсролын удирдлага мэдээллийн систем /ДБУМС/ нэвтрүүлж, СӨБ, ЕБС-ийн зарим модулийг шинэчлэн, ЕБС-ийн түвшинд Боловсролын бичиг баримт хэвлэх систем, цахим журналын системийг шинээр нэвтрүүлсэн бөгөөд боловсролын баримт бичгийн лавлагааг ТҮЦ машинаас олгож эхлээд байна.	100%

	<p>ЕБС, дээд боловсролын салбарын үлдсэн модулиудыг бүрэн боловсруулж дуусгана.</p>	<p>хангамжийг боловсруулж ашиглалтад оруулна.</p> <p>Дээд боловсролын 25 модулийг шинээр боловсруулна.</p>	<p>a. Дээд боловсролын салбарт ДБУМС-ийн суурь флатформыг хөгжүүлж, фрэймвөрүүд, энтерпрайз компонентыг боловсруулсан. Сургалтын үйл ажиллагаатай холбоотой байгууллага, тусгай зөвшөөрөл, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, сургалтын агуулга, суралцагчийн элсэлт, хөдөлгөөн, багш, дата импорт, ажилтан, комисс хороо, дүн үнэлгээ, дүнгийн схем, төгсөлт, дугаар захиалга, гадаад боловсрол, сургалтын орчин, лавлагаа зэрэг 17 модулийг нэвтрүүлсэн. Мөн санхүү, эрдэм шинжилгээ, төсөл хөтөлбөр, магадлан итгэмжлэл, төгсөгч гэсэн модулийг хөгжүүлж, тестлэн нэвтрүүлэхэд бэлэн болоод байна. Статистикийн модулийг бүрэн ажиллагаанд оруулж 2019-2020 оны хичээлийн жилийн намрын статистик тайланг системээс гаргалаа.</p> <p>b. 2018-2019 хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуулийн боловсролын баримт бичгийг системээс хэвлэж олгосон бөгөөд, лавлагааг системээс вебээр болон гар утсаны аппликешнаар дамжуулан олгодог болоод байна.</p> <p>c. Тодорхойлолтын мэдээллийг ХУР системтэй цахим сервисээр солилцож 2019 онд олгогдсон суурь, бүрэн дунд боловсролын гэрчилгээ болон 2016-2018 онд дээд боловсролын сургалтын байгууллагаас төгсөгчдөдөө олгосон дипломын тодорхойлолтыг ТҮЦ машинаас олгож эхлээд байна.</p> <p>d. Боловсролын салбарын мэдээллийн системд багшийн систем, багшийн болон анги удирдсан багшийн цахим журнал, дэвтэр хөтлөх, хэвлэх модулийн хөгжүүлэлтийг хийж ерөнхий боловсролын сургуулийн багш, анги удирдсан багш, сургалтын менежер, удирдлага цахим журналыг вебээр болон гар утсаны аппликешнаар хөтлөх, эцэг, эх, асран хамгаалагч нь сургуулийн талаар болон өөрийн хүүхдийн ирц, дүн, хичээлийн явцын талаар дэлгэрэнгүй мэдээллийг авах боломжийг бүрдүүлж нэвтрүүлээд байна.</p> <p>e. 2018-2019 оны хичээлийн жилд Системийн хэрэглэгчийн удирдлага, Тусгай зөвшөөрлийн удирдлага, Хичээлийн хуваарийн удирдлага, Шилжилт хөдөлгөөний бүртгэл, Баримт бичгийн лавлагааны систем, Багшийн бүртгэлийн систем програм хангамж, Нэгтгэл системүүд, СӨБ суралцагчийн үнэлгээний систем, Статистикийн тайлант үеийн удирдлагын модулийн нэмэлт хөгжүүлэлтийг хийлээ.</p>	
--	---	--	---	--

			<p>f. Насан туршийн боловсролын бичиг үсгийн тайлгадалт, амьдрах ухаан зэрэг сургалтын хөтөлбөрийн модулийг боловсруулж нэвтрүүлэхэд бэлэн болгов.</p> <p>Мөн шинээр хөгжүүлсэн болон сайжруулсан модуль, цахим журнал хөтлөх гарын авлагуудыг бэлтгэн видео хичээл хэлбэрээр боловсруулж систем дээр байршууллаа.</p>	
262.	2.2 Боловсролын салбарын өндөр хурдны өргөн зурвасын нэгдсэн сүлжээний орон нутгийн сүлжээний хурдыг нэмэгдүүлнэ.	Улаанбаатар хотын 122, аймгийн төвийн 69, 313 сумын төвийн 334 ЕБС-ийн хурдыг нэмэгдүүлэх, Улаанбаатар хотын 13, аймгийн төвийн 10 ЕБС-ий шинээр боловсролын салбарын нэгдсэн сүлжээнд нэмж холбох.	<p>Боловсролын салбарын нэгдсэн сүлжээний орон нутгийн тоон урсгал, сувагчлал, байр талбайн түрээс, интернет үйлчилгээний зардлыг БСШУС-ын сайдын 2019 оны 1 сарын 18 өдрийн “Зардал гаргах тухай” А/28 дугаар тушаалаар баталсантай холбогдох төрийн байгууллагуудтай дараах гэрээг байгууллаа. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Улаанбаатар, 21 аймгийн төвийн сувагчлал, 21 аймгийн төв, 266 сумын төв тоон урсгал, 233 байрлалд байр талбай, цахилгааны түрээсийн нийт 1,142,104,480 төгрөг үнийн дүнтэй гэрээг Мэдээлэл холбооны сүлжээ ТӨК-тэй,</li> <li>✓ 50 сумын тоон урсгал, 86 байрлалд байр талбай, цахилгааны түрээсийн, салбарын интернет үйлчилгээний нийт 2,146,760,000 төгрөгийн үнийн дүнтэй гэрээг Монголын цахилгаан холбоо ХК-тай тус тус байгууллаа.</li> <li>✓ Боловсролын салбарын нэгдсэн сүлжээнд Нийслэлийн 2, 16, 48, 33, 97, 25-р сургуулийг холбох ажлыг Мэдээлэл холбооны сүлжээ ТӨК-аар, 63, 46, ӨЗБЛА сургуулийг холбох ажил, нийслэлийн 42, Орхон аймгийн төвийн 6 сургуулийн шилэн кабель засварлах ажлыг сонгон шалгаруулалт явуулсны үндсэн дээр Монкабель системс ХХК -аар тус тус гүйцэтгүүллээ. Мөн Сонгино-хайрхан дүүргийн 74, 121 дугаар сургууль руу татсан газрын шилэн кабелийн Улаанбаатар, Дархан чиглэлийн авто замын шинэчлэл өргөтгөх ажлын трасстай давхардсан хэсгийг шилжүүлэх Шинэ зууны боловсрол төслийн туслан гүйцэтгэгч Нью оптик ХХК-аар гүйцэтгүүллээ.</li> <li>✓ Төв аймгийн 4-р сургууль, Өмнөговь аймгийн Ханбогд сумын 2-р сургуульд шинэ төхөөрөмж нийлүүлж хуваарилж, суурилуулан боловсролын салбарын нэгдсэн сүлжээнд холболлоо.</li> </ul>	100%

			Боловсролын салбарын нэгдсэн сүлжээнд холбогдсон сургуулийн шилэн кабел, интернет үйлчилгээнд хяналт тавьж, нийт 30 орчим тоног төхөөрөмжийн эвдрэл гэмтлийг засварлаж, 1,500 орчим дуудлагад хариу өгч ажиллалаа.	
263.	<p>2.3 Статистикийн тухай хууль, Боловсролын тухай хууль</p> <p>Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын статистикийн мэдээллийг батлагдсан үзүүлэлт, маягтын дагуу хүлээн авч, нэгтгэн боловсруулж шинжилгээ хийнэ.</p>	174 маягтаар мэдээллийг цуглуулан нэгтгэн боловсруулсан байна.	<p>Боловсролын салбарын 2019-2020 оны хичээлийн жилийн статистикийн мэдээллийг гарган хэрэглэгчдэд хүргэлээ.</p> <p>А. Сургуулийн өмнөх боловсролын салбар 2019-2020 оны хичээлийн жилд 1439 цэцэрлэгийн 8112 бүлэгт 263170 хүүхэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшиж байна. Сургуулийн өмнөх сургалтын байгууллагад 27985 ажиллагчид ажиллаж байгаагаас 8036 нь үндсэн багш байна.</p> <p>Б.Ерөнхий боловсролын салбар Ерөнхий боловсролын 820 сургуулийн 21,794 бүлэгт нийт 646,839 суралцагч өдөр, орой, эчнээ, дүйцсэн хөтөлбөрөөр боловсрол эзэмшин суралцаж байна.</p> <p>Энэ хичээлийн жилд 3 ээлжээр хичээллэж буй сургуулийн тоо 14 дахин буурч 2 сургуулийн 9 бүлэгт 308 суралцагч 3-р ээлжээр хичээллэж байна. 1-р ангид шинээр элсэгчдийн тоо өмнөх оноос 4,6 мянгаар өсч 76,892 суралцагч шинээр элссэн байна. Тус салбарт нийтдээ 51,550 ажиллагчид ажиллаж байгаагийн 62.2 буюу 32,085 нь үндсэн багш байна.</p> <p>В.Дээд боловсролын салбар Дээд боловсролын салбарын 2019-2020 оны хичээлийн жилийн статистикийн мэдээллийг Дээд боловсролын удирдлагын мэдээллийн системд нэвтрүүлэн регистрт суурилсан мэдээллийн сан бүрдүүлснээр мэдээлэл үнэн зөв, бодитой байх боломжтой боллоо. Энэ хичээлийн жилд 95 их, дээд сургуульд 148,945 суралцагч суралцаж байна.</p>	100%
264.	<p>2.4 Статистикийн тухай хууль, Боловсролын тухай хууль</p> <p>Ази, Номхон далайн бүс нутгийн улс орнуудын боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарын үндсэн үзүүлэлт болон судалгаа ба хөгжлийн</p>	10 маягтаар	<p>Ази, Номхон далайн бүс нутгийн улс орнуудын соёл, шинжлэх ухааны салбарын үндсэн үзүүлэлт болон судалгаа ба хөгжлийн талаарх мэдээллийг 2019 survey of formal education Students and teachers (ISCED 0-4), 2019 survey of formal education Students and teachers (ISCED 5-8), 2019 survey of formal education National education systems, Questionnaire on Educational attainment statistics, Questionnaire on Literacy statistics гэсэн маягтаар нэгтгэн гаргаж, ЮНЕСКО-ийн Статистикийн хүрээлэнд албан ёсны 10 маягтаар хүргүүлээ.</p> <p>Мөн ЮНЕСКО-гийн Статистикийн хүрээлэнгээс шинэчлэн гаргасан 2019 Questionnaire on Research and Experimental Development (R&amp;D) Statistics</p>	100%

	талаарх мэдээллийг нэгтгэн гаргаж, ЮНЕСКО-д хүргүүлнэ.		статистикийн мэдээллийг ЮНЕСКО-с ирүүлсэн 12 маягт, 100 гаруй үзүүлэлтийн дагуу Монгол Улсын Шинжлэх ухаан, технологи, инновацийн 2018 оны статистикийн мэдээллийг нэгтгэн боловсруулж, ЮНЕСКО-гийн Статистикийн хүрээлэнд хүргүүлээ. Энэхүү мэдээ нь ЮНЕСКО-гийн албан ёсны сайт болох <u>Global Observatory of Science, Technology and Innovation Policy Instruments (GO-SPIN)</u> <a href="https://en.unesco.org/go-spin">https://en.unesco.org/go-spin</a> дээр албан ёсоор тавигдан дэлхий дахинд монгол улсын мэдээллийг тархааж байна.	
265.	2.5 Статистикийн тухай хууль, БСШУС-ын салбарын 2018 он, 2018-2019 оны хичээлийн жилийн статистикийн мэдээллээр эмхтгэл бэлтгэн хэвлүүлж, хэрэглэгчдэд түгээнэ.	Эмхтгэл – I, II Брошур – 2 Календарь - 1	2018-2019 оны хичээлийн жилийн статистикийн мэдээллийн санг баяжуулан <a href="http://www.esis.edu.mn">www.esis.edu.mn</a> -д байршуулан мэдээллийг иргэд, олон нийтэд нээлттэй болгох үүднээс инфографик болон статистик хэсэгт байршуулан холбогдох мэдээллээр ханган ажиллаж байна.	100%
266.	2.6 Статистикийн тухай хууль БСШУС-ын салбарын статистикийн мэдээллийн санг баяжуулж, засгийн газар, төрийн байгууллагууд, яамны удирдлага, мэргэжилтэн, иргэд, байгууллагад мэдээллээр үйлчилнэ.	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын статистикийн мэдээллийн сан бүрдсэн байна.	Боловсролын салбарын 2018-2019 оны хичээлийн жилийн боловсролын салбарын статистикийн мэдээлэл болон суралцагч, багш, хүний нөөц болон сургалтын орчны талаарх мэдээллийн санг бүрдүүлэн холбогдох байгууллага, албан хаагчдыг мэдээллээр ханган ажиллаж байна.  Соёл, шинжлэх ухаан, спортын салбарын 2018 оны статистикийн мэдээллийн санг бүрдүүлэн, цахимаар болон хэвлэмэлээр хэрэглэгчдэд тархаан үйлчилж байна.  Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын салбарын 2018-2019 оны хичээлийн жилийн боловсролын салбарын статистикийн мэдээлэл болон суралцагч, багш, хүний нөөц болон сургалтын орчны талаарх мэдээллийн санг бүрдүүлэн холбогдох байгууллага, албан хаагчдыг мэдээллээр ханган ажиллаж байна.	100%
<b>ХУУЛИЙН ХЭЛТЭС</b>				
"Салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгох" зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:				
"1.Салбарын хуулийн тогтоомжийн үзэл баримтлал боловсруулах, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах хуулийн төсөл боловсруулах чиглэлээр зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх хүрээнд:				

267.	1.1. Боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах.***	Үзэл баримтлал батлагдаж, хуулийн төслийг УИХ-д өргөн барьсан байх	Бүрэн хангалттай. 100%  Хуулийн хэлтсийн хувьд Боловсролын хуулийн үзэл баримтлалын төсөл, хуулийн төсөл боловсруулах, судалгаа хийлгэх ажлыг өмнөх онуудын хэмжээнээс илүү сайн ахиулах, шуурхайлах арга хэмжээ авч ажиллаж, үр дүнд хүрсэн.	100%
268.	1.2. Бага, дунд боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах	Үзэл баримтлал батлагдаж, хуулийн төслийг УИХ-д өргөн барьсан байх	Хэлтсийн албан хаагчдаас үл хамааран хугацаа сунжрах, хойшлох асуудал гарсан ч төсөл боловсруулах ажил маш эрчимжсэн тул хэлтсийн үнэлгээг бүрэн хангалттай гэж дүгнэж байна.  1-р улиралд: Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын сайдын 2016, 2017 онуудад хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байсан бөгөөд 2019 оны 2 сарын 14 өдрийн А/71 дүгээр тушаалаар “Боловсролын хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсэг”-ийг дахин шинэчлэн байгуулсан. Ажлын хэсгийн зүгээс дараах үйл ажиллагааг зохион байгуулсан.	100%
269.	1.3. Сургуулийн өмнөх боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах	Үзэл баримтлал батлагдаж, хуулийн төслийг УИХ-д өргөн барьсан байх	1.Нийт ажлын хэсгийн гишүүд болон БСШУС-ын сайдад Боловсролын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн боловсруулалтын өнөөгийн байдлын талаарх мэдээлэл өгөх зорилгоор “Боловсролын тухай хууль, шинэчлэлийн агуулга” сэдэвт presentation бэлтгэн холбогдох мэдээллийг өгсөн. Мэдээлэлд Боловсролын тухай хуулийн түүхийн эх сурвалжууд, өнгөрсөн хугацаанд хуульд орж байсан гол гол өөрчлөлтүүд, одоо нэмэлт өөрчлөлтөөр оруулах хуулийн гол харилцааны агуулга, хуульд нэмэлт өөрчлөлт оруулахтай холбоотойгоор хийсэн томоохон судалгаануудын жагсаалт, тэдгээрийн агуулга зэрэг мэдээллийг тусган нийт ажлын хэсгийн гишүүд болон хуулийг шинэчлэхэд оролцох гол оролцогч нарт нийт 3 удаагийн танилцуулга хийж, тус бүр ажлын хэсгийн хуралдааныг зохион байгуулсан. Сайдаас хуулийн төсөлд тусгах болон хуулиар зохицуулах гол гол асуудлын санал, чиглэлийг авч ажилласан.	100%
270.	1.4.Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах	Үзэл баримтлал батлагдаж, хуулийн төслийг УИХ-д өргөн барьсан байх	2.Ажлын хэсгийн гишүүн Ц.Мөнх-Оргилоос /УИХ-ийн гишүүн/ хуулийн шинэчлэл хийхэд гол тулгарч буй асуудлыг тодорхойлсон Боловсролын хуулийн “Шинэчлэлийн зураглал” Road map-ийг боловсруулах санал гаргасны дагуу Ажлын хэсгийн ахлагч Б.Баярсайхан /ТНБдарга/ албан даалгавар гаргаж, уг албан даалгаврын дагуу яамны бодлогын газруудтай хамтран шинэчлэлийн зураглалын төслийг бэлтгэж нийт	100%
271.	1.5.Дээд боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах	Үзэл баримтлал батлагдаж, хуулийн төслийг УИХ-д өргөн барьсан байх		100%
272.	1.6.Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, тухай хуулийн төсөл боловсруулах	Үзэл баримтлал батлагдаж, хуулийн төслийг УИХ-д өргөн барьсан байх		100%



			<p>ажлын хэсгийн гишүүдэд танилцуулах, цахим хаягаар хүргүүлэх ажлыг зохион байгуулсан.</p> <p>2-р улиралд: Боловсролын хуулийн “Шинэчлэлийн зураглал” Road map–ийн хүрээнд судлагдан гарч ирсэн асуудлын хүрээнд Олон улсын /6-аас доошгүй улс орнуудын/ хууль тогтоомжийг судлах, уг судалгааг хийлгэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгээс өгсөн даалгаврын хүрээнд дараах ажлыг зохион байгуулсан. Үүнд:</p> <p>1.Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны 3 сарын 1 өдрийн А/33 дугаар тушаалаар “Үнэлгээний хороо” байгуулан, “Дэлхийн зарим улс орны боловсролын багц хуулийг харьцуулан судлах, зөвлөмж боловсруулах” зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврыг боловсруулж, санхүүжүүлэх байгууллага болох Азийн хөгжлийн банкнаас холбогдох зөвшөөрлийг авч, тус зөвлөх үйлчилгээ сонгон шалгаруулах тухай тендерийн урилгыг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээж Олон улсын нээлттэй сонгон шалгаруулалтыг Дэлхийн банкны “Боловсролын чанарыг дээшлүүлэх” төслийн нэгжтэй хамтран зохион байгуулсан. Нээлттэй сонгон шалгаруулалтын үр дүнд гадаадын 1 зөвлөх /Япон улсын иргэн/, дотоодын 2 зөвлөхийг шалгаруулж холбогдох ажлын даалгавар, төлөвлөгөөний дагуу тайлан зөвлөмжийг гаргуулах, хүлээн авах ажлыг “Боловсролын чанарыг дээшлүүлэх” төслийн нэгжтэй хамтран зохион байгуулсан.</p> <p>3-р улиралд: Улс орнуудын Боловсролын хуулийг харьцуулан судалсан судалгааны тайланг зөвлөмжийг төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн болон судалгааны байгууллагын нийт 300 гаруй оролцогчид /давхардсан тоогоор/ -ын дунд 3 удаагийн санал солилцох уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулав. Мөн оролцогчдоос ирүүлсэн саналыг нэгтгэн боловсруулж, хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийн хэрэгцээ шаардлагын тандан судалгааны төслийг боловсруулж Хууль зүй, дотоод хэргийн сайдтай хамтран батлуулахаар БСШУС-ын сайдын 1а/9004 тоот албан бичгээр ХЗДХЯ-нд хүргүүлсэн. Хууль зүй дотоод хэргийн яамны шийдвэрийг хүлээж байна.</p> <p>4-р улиралд: Хуулийн төслийн эхний хувилбарыг боловсруулсан. Хуулийн үзэл баримтлалын төсөлд санал авахаар холбогдох төрийн бус</p>	
--	--	--	--	--

			байгууллага болон мэргэжлийн холбоодод хүргүүлээд байна. Ирүүлсэн саналыг нэгтгэн хуулийн төсөлд тусгахаар ажиллаж байна. Хууль зүй, дотоод хэргийн яамнаас хуулийн үзэл баримтлал батлагдан ирвэл холбогдох яамдын саналыг авч хуулийн төслийг УИХ хуралд өргөн барих бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	
273.	1.7.Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Үзэл баримтлал батлагдаж, хуулийн төслийг УИХ-д өргөн барьсан байх	Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу боловсруулж Засгийн газрын 2019 оны 2 сарын 20 өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. Хуулийн төслийг Засгийн газраас 2019 оны 4 сарын 9-нд Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Энэхүү хуулийн төслийг 2019 оны 4 сарын 24 өдрийн УИХ-ын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны хурлаар, 4 сарын 25 өдрийн УИХ-ын нэгдсэн чуулганаар тус тус хэлэлцэж, Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр нарын санаачилсан Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамтатган хэлэлцэхээр хүлээгдэж байна.	100%
274.	1.8.Шинжлэх ухаан, технологийн паркийн тухай хуулийн төсөл	Үзэл баримтлал батлагдаж, хуулийн төслийг УИХ-д өргөн барьсан байх	Шинжлэх ухааны паркийн тухай хуулийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судалсны үндсэн дээр Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалтын дагуу Шинжлэх ухааны паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн үзэл баримтлалыг Шинжлэх ухаан, технологийн бодлогын газартай хамтран боловсруулж ХЗДХЯаманд хүргүүлсэн. Хуулийн үзэл баримтлалыг Хууль зүй, дотоод хэргийн сайдаас 2019 оны 10 сарын 16 өдрийн 1/4587 тоот албан бичгээр батлан ирсэн. Батлагдсан үзэл баримтлалын хүрээнд хуулийн төсөл боловсруулж, хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу яамдаас санал авах ажлыг зохион байгуулж байна.	70%
275.	1.9. Соёлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах.***	Үзэл баримтлал батлагдаж, хуулийн төслийг УИХ-д өргөн барьсан байх	Энэхүү хуулийн төслийг эцэслэн боловсруулахад Соёл, урлагийн бодлогын газартай удаа дараа ярилцлага хийн бодлого, үзэл баримтлалд тулгуурлан нарийвчлан боловсруулсан. Хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэг БСШУС-ын сайдын 2018 оны 5 сарын 4 өдрийн А/265 дугаар тушаалаар байгуулагдан ажилласан. Соёлын тухай хуулийн /шинэчилсэн найруулга/ төслийн тандан судалгааны тайлан үзэл баримтлалыг эцэслэн боловсруулж БСШУС-ын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдаар батлуулсан.	100%

			Хуулийн төслийг, танилцуулга, , "Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлсэн тайлан", "Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийсэн тайлан"-г боловсруулан, яамдаас санал авч, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн. Соёлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжигдэж, УИХ-д өргөн барьсан.	
276.	1.10. Киноны тухай хуулийн төсөл боловсруулах.***	Үзэл баримтлал батлагдаж, хуулийн төслийг УИХ-д өргөн барьсан байх	<p>Кино урлагийг дэмжих тухай хуулийн төслийн тандан судалгааны тайлан үзэл баримтлалыг эцэслэн боловсруулж БСШУС-ын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдаар батлуулсан.</p> <p>Хуулийн төслийг, танилцуулга, , "Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлсэн тайлан", "Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийсэн тайлан"-г боловсруулан, яамдаас санал авч, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн. Кино урлагийг дэмжих тухай хуулийн төслийг 2019 оны 3 сарын 21-ны өдөр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, 11 дүгээр тэмдэглэлээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтсон. Кино урлагийг дэмжих тухай хуулийн төслийг Засгийн газраас 2019 оны 4 сарын 6 өдөр Улсын Их Хуралд өргөн барьсан.</p>	100%
277.	1.11. Музейн тухай хуулийн төсөл боловсруулах.***	Үзэл баримтлал батлагдаж, хуулийн төслийг УИХ-д өргөн барьсан байх	<p>Музейн тухай хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт ажиллан, эрх зүйн зөвлөгөө чиглэлээр санал, зөвлөгөөг өгч ажилласан. Музейн тухай хуулийн төслийн Үзэл баримтлалын төсөл, хуулийн төсөл боловсруулах тандан судалгааны тайланг боловсруулж, Үзэл баримтлалыг БСШУС-ын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдаар батлуулсан.</p> <p>Соёл, урлагийн бодлогын газраас өгсөн хуулийн төсөл дээр концепци, хууль тогтоомжтой уялдсан байдал, уялдаа, хэллэг, агуулгын чиглэлээрх саналаа өгсөн. Бодлогын газраас хуулийн төслийн хувилбар эцэслэн ирээгүй байна. Хуулийн хэлтсийн албан хаагчдаас үл хамаарч хугацаа хойшилсон, удаашралтай байгаа тул хэлтсийн хувьд бүрэн хангалттай гэж дүгнэлээ.</p>	100%
278.	1.12.Соёлын өвийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах	Үзэл баримтлал батлагдаж, хуулийн төслийг УИХ-д өргөн барьсан байх	<p>Соёлын хуулийн /шинэчилсэн найруулга/ төслийг дагалдуулан Соёлын өвийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан.</p> <p>Соёлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн дэмжээд УИХ-д өргөн барьсан.</p>	100%

279.	1.13.Номын сангийн тухай хуулийн төсөлд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах	Үзэл баримтлал батлагдаж, хуулийн төслийг УИХ-д өргөн барьсан байх	Соёлын хуулийн /шинэчилсэн найруулга/ төслийг дагалдуулан Номын сангийн тухай хуульд хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан. Соёлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн дэмжээд УИХ-д өргөн барьсан.	100%
<b>"Хоёр. "Салбарын хуулийн хэрэгжилтийг хангах зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:</b>				
<b>"2. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын хэмжээнд мөрдөгдөх захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр, дүрэм, журмыг боловсруулахад эрх зүйн зөвлөгөө, дэмжлэгээр хангах" хөтөлбөрийн хүрээнд:</b>				
280.	2.1. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын хуулиудад батлан мөрдүүлэхээр заасан дүрэм, журмын жагсаалтыг шинэчлэн гаргах	Жагсаалт гарсан байх	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын хуулиудад батлан мөрдүүлэхээр заасан дүрэм, журмын жагсаалтыг 3 удаа шинэчлэн гаргаж Бодлогын газрын газрын дарга, мэргэжилтэн нарт цаасаар болон цахим хаягаар хүргэж хэвшсэн. Журам, дүрэм, хөтөлбөр, эрх зүйн баримт бичгийг боловсруулах талаар удирдлага, мэргэжилтэн нартай байнга уулзан сануулах, зөвлөх арга хэмжээ авч ажилласан. Холбогдох дүрэм, журмуудыг боловсруулахад байнгын эрх зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлсэн.	100%
281.	2.2 Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын хуулиудад батлан мөрдүүлэхээр заасан дүрэм, журмыг боловсруулахад зөвлөгөө дэмжлэг үзүүлэх	Батлагдсан дүрэм, журам	Сайд, ТНБД-ын тушаал шийдвэр болон эрх зүйн үр дагавар бүхий албан бичгийн эрх зүйн үндэслэлийг эцэслэн хянах замаар холбогдох хууль тогтоомжийн талаар удирдлага, албан хаагчдад зөвлөгөө дэмжлэг үзүүлж ажиллаа. Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөг боловсруулан батлуулж, төлөвлөгөөний гүйцэтгэлийг тухай бүр шаардаж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн 88 асуудлыг боловсруулах, яамдаас санал авах, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхэд зөвлөгөө дэмжлэг үзүүлсэн.	100%
<b>Гурав. Шийдвэр, гэрээ, хэлэлцээрийн төсөл боловсруулалтыг бусад хууль тогтоомжид нийцүүлэх хүрээнд:</b>				
282.	3.1. БСШУС-ын сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаалыг хууль тогтоомжид нийцүүлэх, хянах	Батлагдсан тушаал, шийдвэр	2019 оны 1 сарын 1 өдрөөс 2019 оны 12 сарын 16-ны өдрийн байдлаар БСШУС-ын сайдын 861 тушаал, Төрийн нарийн бичгийн даргын 425 тушаалыг нийтлэг болон салбарын хууль тогтоомжид нийцүүлэн хянаж ажиллалаа.	100%

283.	3.2.Олон улсын болон дотоодын гэрээ, хэлэлцээрийг хууль тогтоомжид нийцүүлэх, хянах	хянасан гэрээ, хэлэлцээр	2019 оны 12 сарын 12 өдрийн байдлаар БСШУС-ын яамнаас байгуулсан дотоодын 467 гэрээ, олон улсын 19 гэрээг хууль тогтоомжид нийцүүлэн хянаж, бүртгэсэн.	100%
284.	3.3. Худалдан авах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг хангахад дэмжлэг үзүүлж, гэрээний төслийг хянах, хууль тогтоомжид нийцүүлэх	байгуулсан гэрээ, хэлэлцээр	<p>2019 оны 1 сараас байгуулагдсан үнэлгээний хороодод хэлтсийн албан хаагчид хариуцсан салбар тус бүрээр гишүүнээр ажилласан. Үнэлгээний хорооны худалдан авах үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлэхэд эрх зүйн зөвлөгөө өгч Үнэлгээний хороо байгуулах 51 тушаалыг хянаж ажилласан.</p> <p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт 2019 оны 6 сарын 1 өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан яамны албан хаагчдад хуульд орсон өөрчлөлтийг судлан Үнэлгээний хорооны гишүүн, нарийн бичгийн даргаар ажиллахдаа анхаарах асуудлыг тусгайлан гарган танилцуулсан.</p> <p>2019 оны 5 сарын 25-нд харьяа байгууллагын удирдлага, нягтлан бодогч, яамны нийт албан хаагчдад “Санхүүгийн аудит, түүний гүйцэтгэл, төрийн сан, шилэн дансны үйл ажиллагаа, анхаарах асуудал, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт, анхаарах асуудал” сэдэвт сургалтыг Хуулийн хэлтэс, Төрийн захиргааны удирдлагын газар, Санхүү, хөрөнгө оруулалтын газар хамтран зохион байгуулсан.</p> <p>Засгийн газрын 2013 оны “Босго үнэ батлах тухай” 68 дугаар тогтоолд заасан үнийн дүнгээс хамаарч худалдан авах ажиллагааны аргаа сонгох талаар мэдээлэл хийсэн.</p> <p>Салбарын худалдан авах ажиллагааны болон төсөл хөтөлбөр гэрээнүүдийг холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд хянан зөвлөгөө, эрх зүйн туслалцааг тухай бүр нь өгч ажиллалаа. Худалдан авах үйл ажиллагаатай холбоотой байгуулах 105 гэрээг хянаж холбогдох хууль тогтоомжид нийцүүлэх ажлыг хэрэгжүүлсэн. Гэрээг хянах явцад Үнэлгээний хороо гүйцэтгэгч сонгох аргаа буруу сонгосон, үнэлгээг буруу тооцож үнэлсэн, Үнэлгээний хорооны гишүүд хууль бус шийдвэр гаргасан зэрэг алдааг илрүүлж залруулах зөвлөмжийг өгсний үндсэн дээр гэрээг хянаж ажиллав</p>	100%

285.	3.4. Эрх зүйн маргаантай асуудлаар Сайд, Төрийн нарийн бичгийн даргын итгэмжлэлээр хууль хяналтын байгууллагад яамыг төлөөлөн ажиллах	Төлөөлөн хэрэгжүүлсэн итгэмжлэл	<p>Захиргааны болон иргэний 28 хэрэгт Засгийн газар болон яамны итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож, хариу тайлбар, холбогдох нотлох баримтыг гарган хэрэг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд оролцлоо. Үүнд:</p> <p>1. Синчи-Ойл” ХХК-ийн нэхэмжлэлтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцсон. 2019 оны 6 сарын 17-ны өдөр Улсын дээд шүүх хэргийг хянан хэлэлцээд нэхэмжлэгчийн гаргасан нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож, Давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэсэн.</p> <p>2. Хөх хайрхан трейд ХХК-ийн нэхэмжлэлтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож байна. Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүх хэргийг хянан хэлэлцээд нэхэмжлэгчийн гаргасан нэхэмжлэлийг бүхэлд нь хангахгүй орхин шийдвэрлэсэн. Тус шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрч нэхэмжлэгч тал давж заалдах шатны шүүхэд гомдол гаргасан бөгөөд Давж заалдах шатны шүүх хэргийг 2019 оны 10 сарын 16-ны өдөр хянан хэлэлцээд анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулж, нэхэмжлэгчийн гаргасан давж заалдах гомдлыг хангахгүй орхин шийдвэрлэсэн.</p> <p>3. Баянхонгор аймгийн Үйлдвэрчний эвлэлийн нэхэмжлэлтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцсон. Тус хэргийг Захиргааны хэргийн Давж заалдах шатны шүүх 2019 оны 5 сарын 28-ны өдөр анхан шатны журмаар хянан хэлэлцээд нэхэмжлэгчийн гаргасан нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн. Нэхэмжлэгч тал тус шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрч Улсын дээд шүүхэд гомдол гаргасан бөгөөд Улсын дээд шүүх 2019 оны 9 сарын 09-ны өдөр хэргийг хянан хэлэлцээд Давж заалдах шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулж нэхэмжлэгчийн гаргасан давж заалдах гомдлыг хангахгүй орхин шийдвэрлэсэн.</p> <p>4. Сонгино-хайрхан дүүргийн Иргэний хэргийн Анхан шатны шүүхэд “Боорчи” ХХК-ий нэхэмжлэлтэй Нийслэлийн Сонгино-хайрхан дүүргийн Засаг дарга, Сонгино-хайрхан дүүргийн Биеийн тамир, спортын хороо, БСШУС-ын сайдад холбогдох иргэний хэрэгт сайдаас олгосон итгэмжлэлийн дагуу оролцсон. Анхан шатны шүүхээс хэргийг хянан хэлэлцээд нэхэмжлэгчийн нэхэмжлэлийг хангаж яамнаас 174 сая төгрөгийг гаргуулахаар шийдвэрлэсэн. Тус шийдвэрийг эс зөвшөөрч</p>	100%
------	---	---------------------------------	---	------

			<p>хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хувьд давж заалдах гомдлыг гаргасан. Захиргааны хэргийн Давж заалдах шатны шүүх давж заалдах гомдлыг хүлээн авч хянан хэлэлцээд анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулж давж заалдах гомдлыг бүхэлд нь ханган шийдвэрлэсэн.</p> <p>5. Д.Энхжаргалын нэхэмжлэлтэй иргэний хэрэгт итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажиллаж, хариу тайлбар, нотлох баримт хүргүүлсэн. 2019 оны 7 сарын 29-ний өдрийн 1а/6763 тоот албан бичгээр итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр Ц.Мөнхбатыг томилсноор тухайн иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох ажиллагаа дуусгавар болсон.</p> <p>6. Г.Батбаатарын нэхэмжлэлтэй иргэний хэрэгт 2019 оны 6 сарын 05-ны өдрийн 1а/5102 тоот албан бичгийн дагуу итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажиллаж байна. Г.Батбаатарыг ажилд эгүүлэн томилох, ажилгүй байсан хугацааны цалин хөлс олгох, нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлөх тухай анхан шатны шүүгчийн захирамж, давж заалдах шатны шүүхийн тогтоол болон Дээд шүүхийн тогтоолууд тус тус гарсан. Уг хэрэгт итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажиллаж байсан Цэндсүрэнгээс Дээд шүүхэд шинээр илэрсэн нөхцөл байдлыг хянуулах хүсэлт гаргасан байдалтайгаар хэргийг хүлээн авсан ч Дээд шүүхээс хүсэлтийг шийдвэрлэхтэй холбоотой тодорхой ажиллагаа хийгдээгүйн улмаас БСШУС-ын сайдаас гарах шийдвэр тодорхойгүй хугацаагаар хойшлоод байна</p> <p>7. БСШУС-ын яамны Шинжлэх ухаан, технологийн бодлогын газрын даргын үүрэг гүйцэтгэгчээр ажиллаж байсан Д.Одгэрэлийн нэхэмжлэлтэй “ажлаас үндэслэлгүй чөлөөлөгдсөн, ажлаас чөлөөлсөн тушаалыг хүчингүй болгуулах, ажилгүй байсан хугацааны цалин гаргуулах” захиргааны хэрэгт итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажилласан. Шүүхийн шатанд эвлэрч ажилд томилох болсон тул шүүх эвлэрлийг баталсан.</p> <p>8. БСШУС-ын яамны үйлдвэрлэлийн хэлтсийн даргын үүрэг гүйцэтгэгчээр ажиллаж байсан С.Нансалмаагийн нэхэмжлэлтэй “ажлаас үндэслэлгүй чөлөөлөгдсөн, ажлаас чөлөөлсөн тушаалыг хүчингүй болгуулах, ажилгүй байсан хугацааны цалин гаргуулах” захиргааны хэрэгт итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож, шүүхээс нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэсэн.</p>	
--	--	--	--	--

			<p>9. Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн шүүхэд Архангай аймгийн лаборатори сургуулийн захирлаар ажиллаж байсан Ч.Мөнх-Өлзийн нэхэмжлэлтэй “ажлаас үндэслэлгүй чөлөөлөгдсөн, ажлаас чөлөөлсөн тушаалыг хүчингүй болгуулах, ажилгүй байсан хугацааны цалин гаргуулах” иргэний хэрэгт анхан шатны шүүхийн шийдвэр гарч нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг ханган шийдвэрлэсэн.</p> <p>10. Завхан аймгийн Тосонцэнгэл сумын сургуулийн лаборатори захирлаар ажиллаж байсан Б.Цэрэннадмидын нэхэмжлэлтэй “ажлаас үндэслэлгүй чөлөөлөгдсөн, ажлаас чөлөөлсөн тушаалыг хүчингүй болгуулах, ажилгүй байсан хугацааны цалин гаргуулах” иргэний хэрэгт итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцсон. Нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэсэн.</p> <p>11. Нийслэлийн Багануур дүүргийн лаборатори сургуулийн захирлаар ажиллаж байсан М.Туулсайханы нэхэмжлэлтэй “ажлаас үндэслэлгүй чөлөөлөгдсөн, ажлаас чөлөөлсөн тушаалыг хүчингүй болгуулах, ажилгүй байсан хугацааны цалин гаргуулах” иргэний хэрэгт итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож, шүүхийн шатанд эвлэрэн ажлын байраар хангасан болно.</p> <p>12. Баян-Өлгий аймгийн лаборатори сургуулийн захирлаар ажиллаж байсан К.Еркегүлийн нэхэмжлэлтэй иргэний хэрэгт итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож, иргэний хэргийн анхан шатны шүүхээс шүүхээс нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн.</p> <p>13. Иргэн С.Батмагнайн нэхэмжлэлтэй “ажилгүй байсан хугацааны цалин гаргуулах” иргэний хэрэгт итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож, иргэний хэргийн анхан шатны шүүхээс нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэсэн.</p> <p>14. БСШУС-ын яамны газрын даргаар ажиллаж байсан С.Чинбатын нэхэмжлэлтэй “ажлаас үндэслэлгүй чөлөөлөгдсөн, ажлаас чөлөөлсөн тушаалыг хүчингүй болгуулах, ажилгүй байсан хугацааны цалин гаргуулах” захиргааны хэрэгт итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож, шүүхээс нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэсэн.</p> <p>15. Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн захирал Ж.Болормаагийн нэхэмжлэлтэй захиргааны актад нэмэлт зохицуулалт оруулах, ажилгүй байсан хугацааны цалин гаргуулах нэхэмжлэлтэй захиргааны хэрэгт итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцсон. Захиргааны</p>	
--	--	--	--	--



			<p>хэргийн анхан шатны шүүхээс хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.</p> <p>16. Иргэн Б.Батдэлгэрийн Сайдад холбогдуулан ирүүлсэн захиргааны хэрэгт хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож байна. энэ ажлын хүрээнд нэхэмжлэлийн хариу тайлбар холбогдох нотлох баримтыг хүргүүлсэн. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дуусаагүй байна.</p> <p>17. Иргэн Ц.Бахархалын нэхэмжлэлтэй БСШУС-ын сайд, нийслэлийн боловсролын газарт холбогдуулан гаргасан захиргааны хэрэгт хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажиллаж байна. Тус нэхэмжлэлийн хариу тайлбарыг холбогдох нотлох баримтын хамт хүргүүлсэн. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дуусаагүй байна.</p> <p>18. Иргэн Н.Отгонтуяагийн нэхэмжлэлтэй Сайд, Төрийн албаны Салбар зөвлөлд холбогдуулан гаргасан захиргааны хэрэгт хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож байна. тус хэрэгт нэхэмжлэлийн хариу тайлбарыг хүргүүлсэн. Хэргийг эцэслэн хянан шийдвэрлэх хүртэлх хугацаагаар захиргааны актыг түдгэлзүүлсэн шийдвэрийг анхан шатны шүүхээс гаргасан. Холбогдох үйл ажиллагааг хэрэгжүүлээгүй байна.</p> <p>19. Иргэн Ч.Даваасүрэнгийн нэхэмжлэлтэй Улсын филармонийн захирлын албан тушаалд эгүүлэн тогтоолгох, ажилгүй байсан хугацааны цалин гаргуулах иргэний хэрэгт итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож байна. Шүүхэд хариу тайлбар, нотлох баримтыг хүргүүлсэн. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дуусаагүй байна.</p> <p>20. Нийслэлийн Засаг даргад холбогдох Суруга пропертиз ХХК-ийн нэхэмжлэлтэй захиргааны хэрэгт гуравдагч этгээд оролцож, хариу тайлбар, нотлох баримтыг гарган хүргүүлсэн. Үндэсний урлагийн их театрын шинэ барилга барих газар олгосон Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/794 захирамжийн биелэлтийг түр хугацаагаар түдгэлзүүлсэн. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дуусаагүй байна.</p> <p>21. Нийслэлийн Засаг даргад холбогдох Суруга партнерс ХХК-ийн нэхэмжлэлтэй захиргааны хэрэгт гуравдагч этгээдээр оролцож, хариу тайлбар, нотлох баримтыг гарган хүргүүлсэн. Үндэсний урлагийн их театрын шинэ барилга барих газар олгосон Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/794 захирамжийн биелэлтийг түр хугацаагаар түдгэлзүүлсэн. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дуусаагүй байна.</p>	
--	--	--	---	--

			<p>22. “Шинэхэн групп” ХХК-ийн нэхэмжлэлтэй Монгол Улсын Засгийн газар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдад холбогдох захиргааны хэрэгт Засгийн газрын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажиллаж, тайлбар, нотлох баримтыг гаргасан. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дуусаагүй байна.</p> <p>23. “Эрх зүйн соёл” НҮТББайгууллагын гаргасан Засгийн газрын 2019 оны 280 дугаар тогтоолын 2.3 дахь хэсгийг хүчингүй болгуулах тухай нэхэмжлэлтэй захиргааны хэрэгт Засгийн газрын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажиллаж, тайлбар, нотлох баримтыг гаргасан. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дуусаагүй байна.</p> <p>24. Үлэг гүрвэлийн төв музейн захирлаар ажиллаж байсан иргэн Н.Жавзмаагийн нэхэмжлэлийн Засгийн газар, БСШУС-ын сайдад холбогдох хэрэгт итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож, хариу тайлбар, холбогдох нотлох баримтыг гаргасан. Захиргааны хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхээс тодорхой шийдвэр гарсан. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дуусаагүй байна.</p> <p>25. Монгол дээд сургуулийн захирал Н.Дашзэвэгийн нэхэмжлэлтэй БСШУС-ын сайдын 2019 оны 259 дүгээр тушаал дахь тус сургуулийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосонтой холбогдох захиргааны хэрэгт итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож, хариу тайлбар, холбогдох нотлох баримтыг тухай бүр нь гарган өгсөн. Засгийн газрын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажиллаж, тайлбар, нотлох баримтыг гаргасан. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дуусаагүй байна.</p> <p>26. Иргэн Н.Дорждэрэмийн нэхэмжлэлтэй, БСШУС-ын сайдад холбогдох БСШУС-ын сайдын 2019 оны Б/38 дугаар тушаалыг хүчингүй болгуулах, ажилд эгүүлэн тогтоолгох иргэний болон захиргааны хэрэгт итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажиллаж байна. Иргэн Н.Дорждэрэмээс хэрэг маргааныг хянан шийдвэрлэх явцад БСШУС-ын сайдын 2019 оны Б/38 дугаар тушаалын биелэлтийг түдгэлзүүлэх тухай хүсэлт гаргасныг үндэслэлгүй гэж үзэн холбогдох тайлбарыг гаргаж хүсэлтийг хэрэгсэхгүй болгох тухай Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2019 оны 128/Ш32019/7687 тоот захирамж гарсан. Засгийн газрын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажиллаж, тайлбар, нотлох баримтыг гаргасан. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дуусаагүй байна.</p>	
--	--	--	--	--

			<p>27. Иргэн Н.Нарантуяагийн нэхэмжлэлтэй иргэний хэрэгт хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож байна. Шүүхээс хэрэг шийдвэрлэхэд хангалтай нотлох баримт бүрдээгүй учир шинээр илэрсэн нөхцөл байдлыг арилгуулахаар захирамж гаргаж шүүхийн хурлыг тодорхойгүй хугацаагаар хойшлуулсан. Засгийн газрын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажиллаж, тайлбар, нотлох баримтыг гаргасан. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дуусаагүй байна.</p> <p>28. “Протек ХХК”-ийн нэхэмжлэлтэй захиргааны хэрэгт хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож, хариу тайлбар, нотлох баримт гаргаж өгсөн. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дуусаагүй байна.</p>	
<p>Дөрөв. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн зорилтыг хангахад чиглэсэн арга хэмжээ:</p>				
286.	4.1.“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх, төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж, тайланг нэгтгэн гаргах.	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр салбар болон яаманд хэрэгжсэн байх	<p>Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх, төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. Улсын Их хурлын 2016 оны “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай” 51 дүгээр тогтоол, Засгийн газрын 2017 оны Төлөвлөгөө батлах тухай 114 дүгээр тогтоол, Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор БСШУС-ын сайдын 2019 оны 6 сарын 10-ны өдрийн “Хөтөлбөр, төлөвлөгөө, зөвлөмжийг хэрэгжүүлэх зарим арга, хэмжээний тухай” А/373 дугаар тушаал, Аймгийн боловсрол, соёлын газрын дарга нарт, Нийслэлийн боловсролын газрын дарга, Нийслэлийн соёл, урлагийн газарт тус тус 2019 оны 6 сарын 11-ний өдрийн 1а/5297, 1а/5298, 1а/5299 дугаар “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгийг хүргүүлэн чиглэл, үүргийн дагуу авсан арга хэмжээний мэдээллийг 2019 оны 10 сарын 1-ний дотор ирүүлэхийг даалгасан байгаа болно.</p> <p>Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх, төлөвлөгөөний тайланг 2020 оны 1 сарын 15-ны дотор нэгтгэн хүргүүлэхээр ажиллаж байна.</p> <p>БСШУС-ын яамнаас 2019 оныг “Иргэний ёс зүйн боловсролын жил” болгон зарлаж Авлигатай тэмцэх газартай хамтран “УРИАЛГА” гарган хамтран ажиллаж байна. Мөн Авлигатай тэмцэх газрын 2019 оны 03/3631, 01/4296 дугаар албан бичгээр ирүүлсэн Зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор тус яамны газрын дарга нар, Аймаг, Нийслэлийн боловсролын газар, Нийслэлийн дүүргийн боловсролын хэлтсийн дарга, бүх шатны боловсролын сургалтын байгууллагын захирал, эрхлэгч нарт</p>	100%

			<p>“Чиглэл хүргүүлэх тухай” албан бичиг, БСШУС-ын сайдын тушаал батлан хугацаатай үүрэг даалгаврыг тус тус хүргүүлээд байна.</p> <p>БСШУС-ын сайд Ё.Баатарбилэг, Авлигатай тэмцэх газрын дарга, тэргүүн комиссар З.Дашдаваа нар хамтран ажиллах тухай “Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарт соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө”-г /хугацаатай 21 хэрэгжүүлэх ажил бүхий/ хамтран батлан, хэрэгжүүлж байна.</p> <p>Авлигатай тэмцэх газраас зохион байгуулж буй сургалтад БСШУС-ын яамны албан хаагчид болон харьяа байгууллагын нийт 72 албан хаагчийг сургалт, хэлэлцүүлэгт хамруулсан байна.</p>	
287.	4.2.Нийтийн албанд томилогдох этгээдийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг эрх бүхий байгууллагад хянуулах, эрхэлсэн салбарын хэмжээнд нийтийн албанд томилогдсон албан хаагчдын ХАСХОМ-ийг хуульд заасны дагуу гаргуулан авах	Хүргүүлсэн тоо, нэгтгэсэн тайлан	<p>Нийтийн албанд томилогдох этгээдийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг эрх бүхий байгууллагад хянуулах, салбарын хэмжээнд нийтийн албанд томилогдсон албан хаагчдын ХАСХОМ-ийг хуульд заасны дагуу гаргуулан авч холбогдох албан хууль тогтоомжийн дагуу 2019 оны хагас жилийн байдлаар салбарын 45 албан хаагчдын ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг АТГ –аар хянуулан, холбогдох хууль тогтоомжид заасны дагуу ажилласан байна.</p>	100%
<b>Тав.Төрийн нууцын үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлэх</b>				
288.	5.1. Төрийн болон албаны нууцад хамаарах мэдээллийг боловсруулах, ашиглах, хадгалах үйл ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулах	Хуулийн хэрэгжилт хангагдсан байх	<p>Төрийн болон албаны нууцад хамаарах мэдээллийг боловсруулах, ашиглах, хадгалах үйл ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулах ажлыг үе шаттай хийж байна. БСШУС-ын сайдын 2018 оны а/284 дүгээр тушаалаар батлагдсан төрийн нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтнуудыг аюулгүй байдлын шалгалтад бүрэн хамруулж, холбогдох дүгнэлтийг авсан. Мөн зарим холбогдох албан хаагчдаас нууцын баталгаа гаргуулж авсан. Тус яамны Төрийн болон албаны нууцад хамаарах мэдээллийг боловсруулах, ашиглах, хадгалах үйл ажиллагааг хуулийн дагуу хэвийн явагдаж байна.</p>	100%

289.	5.2.Харьяа байгууллагын дайчилгааны төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэхэд удирдлага, арга зүйн дэмжлэг үзүүлэх	Батлагдсан төлөвлөгөө	Батлан хамгаалахын сайдын 2019 оны 11 сарын 19 өдрийн 1а/4265 дугаар “Журмын төсөлд санал авах тухай” албан бичигт Дайчилгааны тухай хуулийн 7.3, 13.1.4, 13.1.8, 30.1, 32.5, 35.3 дахь хэсгийг хэрэгжүүлэх, эрх зүйн орчин боловсронгуй болгохоор “Дайчилгааны зарлан мэдээлэл явуулах журам”, “Дайчилгааны нөөц бүрдүүлэх журам”, “Хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн өмчийг дайчилсан тохиолдолд, нөхөх олговор төлөх журам”, “Дайчилгааны сургууль явуулах журам”, “Техник хэрэгслийг дайчилгааны сургуульд татан оролцуулсны хөлсийг төлөх журам”, “Хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгжээс дайчилсан санхүүгийн нөөцийг төлөх журам”-ын төслүүд, танилцуулга, Засгийн газрын тогтоолын болон Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төсөлтэй боловсруулан яамд болон холбогдох газруудаас саналыг авсан. Батлан хамгаалах яамны төрийн байгууллагын дайчилгааны төлөвлөгөөний загварыг шинэчлэн баталсны дараа төлөвлөгөөг батлах чиглэл өгсөн.	70%
290.	5.3. Төрийн болон албаны нууцын хадгалалт, хамгаалалтад хяналт тавих, үзлэг тооллого хийх	Үзлэг тооллогын тайлан, мэдээ	Тагнуулын ерөнхий газрын 2019 оны 01/537 дугаар албан бичгийн дагуу төрийн болон албаны нууцад хамаарах баримт, бичиг, бусад нууцын тээгчийн төрөл, тоо хэмжээний талаарх мэдээллийг ирүүлсэн хүснэгтийн дагуу үзлэг, тооллогыг зохион байгуулж, мэдээллийг хүргэсэн.	100%
<b>Зургаа. Эрх зүйн сургалт, сурталчилгааны чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээ.</b>				
291.	6.1.Яам, агентлаг, харьяа байгууллагын эрх зүйн асуудал хариуцсан албан хаагчдад зориулан дотоод, гадаад сургалт зохион байгуулах.***	Сургалтын тоо	Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орж, хүчин төгөлдөр үйлчилж эхлэх гэж байгаатай холбогдуулан яамны нийт албан хаагч, харьяа байгууллагын удирдлага нарт тус хуулийн хэрэглээ бусад анхаарах асуудлаар сургалт-мэдээллийг 2019 оны 05 сарын 25-ны өдөр зохион байгуулсан. Тус сургалтад яамны нийт албан хаагчдаас 85 албан хаагч, харьяа байгууллагын 102 удирдлага, нягтлан бодогч нар бүрэн хамрагдсан. Сургалтад Сангийн яам, Азийн хөгжлийн банкны төлөөлөгч нар холбогдох хууль тогтоомжид орсон өөрчлөлт, худалдан авах үйл ажиллагаанд анхаарах асуудлын талаар мэдээллийг өгч ач холбогдол бүхий сургалт болсон гэж үзэж байна. Монгол Улсын Боловсролын салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, Төрийн өмчийн их сургууль, боловсролын байгууллагын эрх зүйн	100%

			<p>асуудал хариуцсан албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад 2019 оны 12 сарын 14-21-ний өдрүүдэд “Захиргааны байгууллага, захиргааны байгууллагын шийдвэр гаргах үйл ажиллагаа, Олон улсын туршлага” сэдэвт 7 хоногийн сургалтыг зохион байгуулав. Сургалтад харьяа байгууллагын нийт 11 албан хаагч хамрагдсан бөгөөд сургалтын үр дүнд нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэн засагласан шийдвэр гаргадаг захиргааны байгууллагууд тэдгээрийн шийдвэр гаргах үйл ажиллагаа, захиргааны акт, захиргааны гэрээ, захиргааны хэм хэмжээний актын талаарх практик мэдлэг ур чадвараа дээшлүүлж, энэ чиглэлийн үйл ажиллагаа явуулж буй Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Мюнхен хотын Ханнс Зайделийн сан, Бавар мужийн Боловсролын яам, Хотын захиргаа-Хуулийн хэлтэс, “Ludwig Maximilian”-ний Их сургуулийн дотоод үйл ажиллагаа тэдгээрийн шийдвэр гаргах процесс ажиллагаатай танилцан, практик туршлага солилцов.</p>	
292.	6.2. Яамны албан хаагчдад Төрийн албаны тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн талаар сургалт зохион байгуулах.	Сургалтын тоо	<p>Төрийн албаны тухай хууль, хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд дагаж гарсан дүрэм, журмыг яамны албан хаагчдад хууль, Улсын Их Хурлын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Төрийн албаны зөвлөлийн тогтоол гэсэн бүлгүүдээр албан хаагчдад танилцуулсан.</p> <p>- Яамны нийт албан хаагчид Захиргааны ерөнхий хуулийн дагуу мэдлэг олгох талаар “Захиргааны байгууллагын ойлголт”, “Захиргааны байгууллагын шийдвэр гаргах ажиллагаа” сэдэвт хичээлүүдийг цахим хэлбэрээр хүргүүлсэн.</p> <p>Төрийн албаны ёс зүйн сэдэвт сургалтыг “Акселфишер академи” ХХК-тай хамтран яамны албан хаагчдад зохион байгуулсан.</p> <p>Яамны албан хаагчдад төрийн албаны хууль тогтоомж, салбарын хууль тогтоомжийн талаар тасралтгүй зөвлөгөө өгч баримт бичгийг хянаж, боловсруулалтыг сайжруулж байгаа нь ажлын байранд дахь тасралтгүй сургалтын хэлбэр юм.</p> <p>Албан хаагчдад Төрийн албаны тухай хуулийг таниулсан хэлбэрээр “Төрийн албаны шинэтгэл” дэвтэр хэвлүүлэн түгээсэн нь ихээхэн ач холбогдолтой болсон гэж үзэж байна.</p>	100%

293.	<p>6.3.ХАС, ХОМ, ХАСУМ хэрхэн үнэн зөв мэдүүлэх талаар сургалт, сурталчилгаа хийх, албан хаагчдын эрхзүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор харьяа байгууллагын болон яамны албан хаагчдыг хамарсан эрх зүйн сургалт зохион байгуулах.</p>	Сургалтын тоо	<p>ХАС, ХОМ, ХАСУМ хэрхэн үнэн зөв мэдүүлэх талаар сургалт, сурталчилгаа хийх, албан хаагчдын эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх талаар сургалтыг 2019 оны 11 сард зохион байгуулахаар төлөвлөж байна. Мөн БСШУС-ын сайд Ё.Баатарбилэг, Авлигатай тэмцэх газрын дарга, тэргүүн комиссар З.Дашдаваа нар хамтран ажиллах тухай “Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарт соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө”-нд сургалтын асуудлууд туссан байгаа бөгөөд 2020 онд хийгдэх ажлууд мөн тусгагдсан байгаа болно.</p> <p>Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн 3 төрлийн /ХАУСМ, ХАСХОМ, “Ашиг сонирхлын зөрчлөөс хэрхэн сэргийлэх” болон анхаарах асуудлаар гэсэн сэдэвтэй видео шторкийг яамны цахим санд болон харьяа байгууллагын ЭБАТ нараар дамжуулан мэдээллийн цахим санд нь байршуулсан.</p> <p>Авлигатай тэмцэх газрын олон нийтийн төвд зохион байгуулагдаж буй авлигын эсрэг бүртгэлд цахим системийг ашигладаг болсонтой холбогдуулан сургалтад хамрагдан зохион байгуулж буй сургалтад БСШУС-ын яамны албан хаагчид болон харьяа байгууллагын 72 албан хаагчийг хамруулсан байгаа болно.</p> <p>Яамны нийт албан хаагчдад сургалтын мэдээлэл, гарын авлагыг албаны цахим хаягаар тогтмол хүргэн танилцуулж байна.</p>	100%
294.	<p>6.4.Сайд, Төрийн бичгийн даргын тушаалын боловсруулалт, албан бичгийн боловсруулалтын стандартын хэрэгжилтийн талаар дотоодод албан хэрэгцээнд ашиглах загвар гаргах, хэрэгжилтийг хангуулах</p>	Батлагдсан загвар	<p>Албан хэрэг хөтлөлт, сайд, төрийн нарийн бичгийн даргын тушаалын төсөл боловсруулах талаар яамны албан хаагчдад сургалт зохион байгуулж, зөвлөгөө, мэдээлэл өгсөн.</p> <p>Сайд, Төрийн бичгийн даргын тушаалын боловсруулалт, албан бичгийн боловсруулалтын стандартын хэрэгжилтийн талаар дотоодод албан хэрэгцээнд ашиглах загвар, төслийг танилцуулсан.</p>	100%

295.	6.5.Яамны цахим хуудсанд Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарт мөрдөх нийтээр дагаж мөрдөх “Захиргааны хэм хэмжээний акт”-уудыг мэдээллийн санд байршуулах, legalinfo.mn эрх зүйн мэдээллийн нэгдсэн системтэй холбох ажлыг үргэлжлүүлэх	Эрх зүйн мэдээллийн сангийн баяжилт	Захиргааны ерөнхий хуулийн 71 дүгээр зүйлийн 71.2 дахь хэсэгт “Захиргааны хэм хэмжээний актын салбарын сан улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн тухайн байгууллагын нийт актаас бүрдэнэ” гэж заасны дагуу БСШУС-ын яамны цахим хуудсанд “Эрх зүйн акт” холбоосыг байршуулан ажиллаж байна. Уг эрх зүйн мэдээллийн системд Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын нийт 31 хууль, УИХ-ын тогтоол 4, Ерөнхийлөгчийн зарлиг 8, ЗГ-ын тогтоол 143, Сайдын тушаал 263 /үүнээс хэм хэмжээ тогтоосон 67/, Төрийн нарийн бичгийн даргын тушаал 1, орчуулсан эрх зүйн акт 3-ыг тус тус байршуулсан ба үүнээс 2019 онд ЗГ-ын тогтоол 17, сайдын тушаал 10 /үүнээс хэм хэмжээ тогтоосон 8/-ыг нэмж байршуулаад байна. Эрх зүйн мэдээллийн санд холбогдох хууль тогтоомжийг байршуулснаар салбарын эрх зүйн мэдээллээр хэрэглэгчдийг шуурхай хангах нөхцөл бүрдсэн.	100%
<b>ОЛОН УЛС ТӨСӨЛ, ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГАЗАР, ГАДААД ХАРИЛЦААНЫ ХЭЛТЭС</b>				
Нэг. Боловсролын тухай хууль, Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого," гэсэн бодлогын баримт бичгийн зорилтыг хангахад чиглэсэн арга хэмжээ:				
296.	"1. Боловсролын тухай хууль 28.1.2; 28.1.10 Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого 6.2"-ийн ЗГҮАХХАХТ-3.2.2, 3.2.3 хүрээнд: 1.1. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарт хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүдийн нэгдсэн мэдээллийн сан бүхий цахим хуудастай болно.	Мэдээллийн сан бүрдэн, бүх төсөл, хөтөлбөрийн мэдээлэл цахим хэлбэрт шилжсэн байна.	Мэдээллийн сан бүрдүүлсэн. Дотоод сүлжээнд албан хэрэгцээнд ашиглах зорилгоор байршуулах гэж байна.	85%



297.	1.2. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарт шинээр хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн судалгаа хийн, төсөл боловсруулж эрх бүхий байгууллагаар батлуулах арга хэмжээ авна.	Судалгаа бэлэн болж, судалгаанд суурилсан төслүүд боловсрогдон батлагдсан байна.	“Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсрол төсөл”-ийг судалж боловсруулан АХБ-нд хүргүүлэн хэрэгжүүлэхээр тохирсон. Мөн 2019 оны 10 сард АХБ-ны боловсролын асуудал хариуцсан мэргэжилтэн Асако Маруяматай уулзалтын тэмдэглэлд гарын үсэг зурж, шинэ төслийн концепцыг тохиролцсон болно. Монгол-Германы ашигт малтмал, технологийн их сургуулийн хотхоны өргөтгөл санхүүгийн хамтын ажиллагааны гэрээг УИХ-аар соёрхон батлуулсан.	100%
298.	1.3. Азийн хөгжлийн банкны буцалтгүй тусламжийн санхүүжилтээр хэрэгжүүлэх “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсрол төсөл”-ийн концепцыг боловсруулах судалгаа хийх, АХБ-ны хяналтын уулзалтуудыг зохион байгуулах, буцалтгүй тусламжийн гэрээ хэлэлцээрийг эхлүүлэх, менежментийг АХБ-иар батлуулах ажлыг зохион байгуулахад бодлогын дэмжлэг үзүүлж ажиллах.***	<ul style="list-style-type: none"> <li>▪ Төслийн концепцыг боловсруулах судалгааны ажил хийгдэх</li> <li>▪ Төслийн концепцыг боловсруулах</li> <li>▪ АХБ-ны хяналтын уулзалтуудыг хийх</li> <li>▪ Буцалтгүй тусламжийн гэрээ хэлэлцээр эхлүүлэх</li> </ul> Менежментийг АХБ-иар батлуулах	Төсөл хэрэгжүүлэх бодит байдал шаардлага, хэрэгцээний талаар АХБ-нд хүргүүлэн хэрэгжүүлэхээр тохирсон. Мөн 2019 оны 10 сард АХБ-ны боловсролын асуудал хариуцсан мэргэжилтэн Асако Маруяматай уулзалтын тэмдэглэлд гарын үсэг зурж, шинэ төслийн концепцийг тохиролцсон болно. Үүнтэй холбогдуулан 2020 оны 4 сард санхүүжилтийн гэрээнд гарын үсэг зурахаар ажиллаж байна.	100%
299.	1.4. Азийн хөгжлийн банкнаас хэрэгжүүлж буй “Эдийн засгийн хүндрэлтэй үед боловсролын чанар, хүртээмжийг дэмжих” төслийн хэрэгжилтийн	7 цэцэрлэг, 2 сургуулийн барилга угсралтын ажлыг хийх гүйцэтгэгч компанитай гэрээ байгуулсан байна.	2018 оны 11 сарын 27-ны /А/302 дугаар тушаал/, 2019 оны 1 сарын 4-ний өдрийн /А/02 дугаар тушаал/, 2019 оны 4 сарын 3-ны өдрийн /А/70 дугаар тушаал/, 2018 оны 11 сарын 28-ны өдрийн /А/308 дугаар тушаал/, 2019 оны 5 сарын 8-ны өдрийн /А/109 дүгээр тушаал/, 2019 оны 5 сарын 8-ны өдрийн /А/110 дугаар тушаал/-аар байгуулагдсан Үнэлгээний хороод 7 цэцэрлэг, 2 сургуулийн тендерийн баримт бичгийг боловсруулан АХБ-д хүргүүлэн санал авж тендерийг зохион байгуулсан.	100%

	үйл ажиллагааг дэмжиж ажиллах.		Түүнээс 2 сургууль, 4 цэцэрлэгийн барилгын ажил гүйцэтгэгч нь шалгаран гэрээ байгуулах шатандаа явж байна. 1 цэцэрлэгийн барилгын ажил эхэлсэн. 1 цэцэрлэгийн тендерийн үйл ажиллагааг дахин зарлахаар болсон. Учир нь өмнөх тендерт аливаа нэгэн аж ахуйн нэгж оролцоогүй болно.	
300.	1.5. БНХАУ-ын Экспорт, импортын банкны санхүүжилтээр хэрэгжиж буй “Өрсөлдөх чадвартай дээд боловсрол” төслийн хэрэгжилтийн үйл ажиллагааг дэмжиж ажиллах.	Төслийн гүйцэтгэгч компани сонгогдсон байна.	БНХАУ-ын Экспорт, импортын банкны санхүүжилтээр хэрэгжиж буй “Өрсөлдөх чадвартай дээд боловсрол” төслийн хэрэгжилтийн үйл ажиллагааг Монгол Улсын их сургууль хариуцаж ажиллаж байна. Ажлын хүрээнд тус яамнаас шаардагдах дэмжлэгийг үзүүлж байна. Одоогийн байдлаар Төслийг гүйцэтгэх компанийг сонгон шалгаруулах явцад БНХАУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамнаас ирүүлсэн хүсэлтийн дагуу сонгон шалгаруулалт түр зогссон болно. Энэхүү төслийн асуудлаар МУИС-аас шаардагдах мэдээллийг Монгол Улсын Сангийн яаманд хүргүүлсэн болно. Сангийн яам БНХАУ-ын Худалдааны яамтай шууд харилцаж төслийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.	100%
301.	1.6. Боловсролын салбарт хэрэгжиж буй төслийн уялдааг хангах, төслүүдийн 2018 оны ажлыг дүгнэх, 2019 оны ажлын төлөвлөгөөг батлуулах арга хэмжээ авна.	Төслийн давхардал арилах, уялдаа сайжирч, зөв төлөвлөлттэй болсон байна.	Боловсролын салбарт хэрэгжиж буй төслүүдийн 2018 оны ажлыг дүгнэн хангалттай гэж үзэн 2019 оны ажлын төлөвлөгөөг тухайн төслийн удирдах хорооны хурлаар баталсан.	100%
302.	1.7. Төслүүдийн удирдах хорооны бүрэлдэхүүнд нэмэлт өөрчлөлт оруулах, удирдах хорооны ажлын нэгдсэн төлөвлөгөө батлуулан хэрэгжилтийг хангана.	Төслийн удирдах хорооны ажил чанаржин, үйл ажиллагаа нь тогтмолжсон байна.	Сайдын А/351 тушаалаар 5 төслийн удирдах хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан.	100%
303.	"2. Гурван тулгуурт хөгжлийн бодлого"-ын баримт бичгийн 5.3.21-ын хүрээнд:	Бэлтгэлийг хангахад дэмжлэг үзүүлсэн байх.	Үнэлгээний бэлтгэл ажил эхэлсэн. 2019 оны 1-2 дугаар сар Түүвэрлэлт 1-г тохирсон. Орчуулгын бэлтгэл ажлуудыг хангасан. Үүнд: Omega-T орчуулгын програмд хэрхэн ажиллуулах онлайн хурлуудад хамрагдах орчуулагч нарыг сонгох, орчуулга хэрхэн хийх заавар, семинарт суулгах ажлуудыг хийсэн.	100%

	2.1. Боловсролын олон улсын чанарын үнэлгээнд (PISA) хамрагдах бэлтгэлийг хангахад дэмжлэг үзүүлэх.		2019 оны 5 сарын 8 өдөр захирлын болон сурагчийн асуулгыг үндэсний онцлогт тохируулан засвар оруулж илгээсэн. 2019 оны 5 сарын 22 өдөр асуулгын тохируулгыг гэрээлэгч талаас баталгаажуулсан. 2019 оны 6 сарын 12 өдөр асуулгыг зөвшилцсөний дагуу асуулгыг шинэчилсэн. 2019 оны 7 сарын 3-ны өдөр асуулгыг нийцүүлэх ажил хийгдсэн. 2019 оны 8 сарын 19 өдөр орчуулгыг 2 хувилбараар илгээсэн. 2019 оны 8 сарын 13 өдөр математик, унших, байгалийн ухаан хичээлүүдийн орчуулгыг 2 орчуулагч зэрэг орчуулж явуулсан байна. 2019 оны 9 сарын 2 өдөр үндэсний хувилбараа бэлтгэж гэрээлэгчид илгээсэн. 2019 оны 9 сарын 19 өдөр бүтээлч сэтгэлгээний даалгаврын орчуулга хийгдсэн.	
304.	"2. Гурван тулгуурт хөгжлийн бодлого"-ын баримт бичгийн 3.7.3.12-ын хүрээнд: 2.2. Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрийн дагуу гадаадаас ирэх оюутны баримт бичгийг хүлээн авч, суралцуулах шийдвэрийг батлуулж, холбогдох сургуулиуд болон Боловсролын зээлийн санд хүргүүлнэ.	Үйл ажиллагаа холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжсэн байна.	Тухай бүр нь холбогдох байгууллагатай болон сургуулиудтай хамтран хэрэгжүүлэн ажиллаж байна.	100%
305.	"ЗГҮАХ-3.2.8, 3.2.25"-ын хүрээнд 3.1. Засгийн газрын гэрээ, хэлэлцээрийн дагуу гадаад улсад суралцах тэтгэлгийн сонгон шалгаруулалтыг	Гадаад улсын ЭСЯ болон холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулсан байна. 1200-аас дээш оюутныг гадаад ад	Монгол Улсын Засгийн газар болон бусад орны засгийн хоорондын хэлэлцээрийн дагуу зохион байгуулагддаг 2019-2020 хичээлийн жилийн тэтгэлэгт хөтөлбөрийг тухайн орноос Монгол Улсад суугаа Элчин сайдын яам, консулын газар болон бусад төлөөлөгчийн газруудтай хамтран зохих журмын дагуу ил тод, нээлттэй бүртгэл, зохион байгуулалтаар ханган ажиллаа. /Нийт хэдэн улсын , боловсролын салбарын мэдээллийн системийн цахим бүртгэлийг ашиглаж 2100 гаруй	100%

	зохих журмын дагуу нээлттэй, ил тод зохион байгуулах арга хэмжээ авна.	суралцуулах ажлыг зохион байгуулсан байна:	иргэн бүртгэлд хамрагдан сонгон шалгаруулалтад оролцож үүнээс 1359 иргэн/.	
306.	3.2. Монгол Улсаас гадаадад сургах мэргэжлийн чиглэл, тоонд хяналт шинжилгээ хийн, санал боловсруулж эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлнэ.	Гадаадад суралцуулах тэргүүлэх мэргэжлийн жагсаалт шинэчлэгдэн, гадаадад суралцагчдын тооны чанарт ахиц гарсан байна.	БСШУС-ын сайдын комисс байгуулах тухай тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн гишүүдийн саналаар. Боловсролын зээлийн сангаар санхүүжүүлэн суралцан сурагчдын талаар судалгаа, шинжилгээг хийж дүгнэлт гаргасан. Тус дүгнэлтийн дагуу Гадаадын их, дээд сургуульд суралцах оюутны мэргэжлийн чиглэлийг Засгийн газрын 2014 оны 71-р тогтоолын дагуу зохион байгуулж шийдвэрлэсэн болно. /Өндөр хөгжилтэй орны их, дээд сургуулийн хөтөлбөрт нийт 187 иргэн бүртгүүлж 1-р шатны сонгон шалгаруулалтын дүнд 149 иргэн ярилцлагын шатанд тэнцэж үүнээс 91 иргэн БЗС-гийн зээлийн эрх үүсэж зээлийн гэрээ байгуулах эрх авсан/.	100%
307.	3.3. Улсын төсвийн хөрөнгөөр өндөр хөгжилтэй оронд магистрантур, докторантурт сургах сонгон шалгаруулалтыг холбогдох журмын хүрээнд зохион байгуулж, шийдвэр гаргуулна.	Сонгон шалгаруулалт зохиох журмын хүрээнд шударга зохион байгуулагдсан байна.	Монгол Улсын Боловсролын зээлийн сангаар санхүүжүүлэн суралцан сурагчдын талаар судалгаа, шинжилгээг ажлын хэсэг байгуулан дүгнэлт гаргасан. Тус дүгнэлтийн дагуу Дэлхийн шилдэг их, дээд сургуульд суралцах оюутны сонгон шалгаруулалтыг зохиох хууль журмын хүрээнд Комисс байгуулан ажиллаж сонгон шалгаруулалтыг ямар нэгэн маргаангүй зохион байгуулсан болно. /Магистр, Докторын сургалтад эрх авсан 93 иргэд БЗС-гийн зээлийн хөтөлбөрийн сонгон шалгаруулалтад оролцож 51 иргэн зээл авах эрх үүссэн болно/	100%
308.	3.4. Боловсрол, соёл шинжлэх ухаан, спортын салбарын олон улсын хамтын ажиллагаа, интернационалчлал, бүс нутгийн интеграцийг хөгжүүлэх талаар бодлогын баримт бичиг боловсруулах ажлын хэсгийг дэмжиж ажиллах.	Боловсруулсан баримт бичгийг холбогдох газарт хүргүүлсэн байна.	Боловсрол, соёл шинжлэх ухаан, спортын салбарын олон улсын хамтын ажиллагаа, интернационалчлал, бүс нутгийн интеграцыг хөгжүүлэх талаар бодлогын баримт бичгийг гаргах судалгааны ажил хийж байна. Үүний хүрээнд Гадаадад төгсөгчдийн холбоо ТББ-аар МУ-аас гадаадад суралцаж буй оюутнуудын судалгааг авч нэгтгэж, бүс нутгийн боловсон хүч бэлтгэх дээр ажиллаж байна.	70%

Гадаад харилцааны хэлтэс				
309.	1.1 Монгол Улсын БСШУС-ын яам, Бүгд Найрамдах Словак Улсын Боловсрол, шинжлэх ухаан, судалгаа, спортын яам хоорондын оюутан солилцох тухай хэлэлцээрийн төслийг эцэслэх чиглэлээр ажиллана. /БТХ-28.1.10, ТБТББ-6.5, ЗГҮАХ-3.2.25/	Хэлэлцээрийн төслийг эцэслэн тохирсон байна.	Хэлэлцээрийн төслийг боловсруулан Словакийн талд хүргүүлж, эцэслэх чиглэлээр идэвхтэй ажилласан. Хэлэлцээрийн Монголын талын төслийг удаа дараа хүргүүлж (хамгийн сүүлд 2019 оны 7 сарын 18-ны өдрийн 10/6518 тоотой), Словакийн талтай хийх дээд хэмжээний яриа, хэлэлцээний сэдэвт оруулж байсан (хамгийн сүүлд Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар Братислав хотод 2019 оны 12 сарын 5-6-ны өдрүүдэд болох Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын Сайд нарын зөвлөлийн 26 дугаар уулзалтын үеэр Словакийн талтай хийх ярианы сэдэвт тусгуулсан)	100%
310.	1.2 Монгол Улсын БСШУС-ын яам, Германы Эрдмийн солилцооны алба хоорондын Монгол-Германы хамтарсан тэтгэлэгт хөтөлбөрийг хэрэгжүүлэх тухай хэлэлцээрийг байгуулах чиглэлээр ажиллана.***/БТХ-28.1.10, ТБТББ-6.5, ЗГҮАХ-3.2.25/	Хэлэлцээрийн төслийг боловсруулж, Германы талтай эцэслэн тохирсон байна.	Германы Эрдмийн солилцооны албатай Хамтарсан тэтгэлгийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх тухай хэлэлцээрийн Монголын талын төслийг боловсруулан холбогдох газрын санал авч, нэгтгэсэн. Хэлэлцээрийн төслийг монгол, герман хэлээр бэлтгэн Германы талд зохих журмын дагуу 2019 оны 6 сарын 11-ний өдөр хүргүүлсэн. Германы талаас хэлэлцээрийн төслийг хүлээн авч, хэлэлцээрийн төслийн агуулгыг хүлээн зөвшөөрч, хэлэлцээрийн хүрээнд хэрэгжих үйл ажиллагааны эдийн засгийн тооцоог гарган ирүүлэхээр болсон.	100%
311.	1.3 ӨМӨЗО-нд монгол оюутан суралцуулах тухай Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын ӨМӨЗО-ны Ардын Засгийн газар	Хэлэлцээрийн төслийг боловсруулж, төслийг харилцагч талтай эцэслэн тохирсон байна.	Хэлэлцээрийг 2019 оны 6 сарын 27-ны өдөр Улаанбаатар хотноо байгуулсан. Хэлэлцээрт Монголын талыг төлөөлж БСШУС-ын дэд сайд Г.Ганбаяр гарын үсэг зурсан. Хэлэлцээрийн хүрээнд жил бүр 150 монгол оюутныг ӨМӨЗО-ны Засгийн газрын зардлаар Өвөр Монголд суралцуулна.	100%

	хоорондын хэлэлцээрийг байгуулах чиглэлээр ажиллана. /БТХ-28.1.10, ТБТББ-6.5, ЗГҮАХ-3.2.25/			
"Хоёр": Боловсролын тухай хууль, "Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн зорилтыг хангахад чиглэсэн арга хэмжээ:				
312.	2.1 Филиппин, Австри Улсуудтай боловсролын салбарт хамтран ажиллах боломж, нөхцөлийг судална. /БТХ-28.1.10, ЗГҮАХ 3.2.25/	Филиппин, Австрийн холбогдох байгууллагад хамтын ажиллагааны саналыг хүргүүлсэн байна.	Австри Улстай боловсролын салбарт хамтран ажиллах боломж, нөхцөлийг судлан үзэж, Эдийн засгийн хамтын ажиллагааны Монгол, Австрийн Засгийн газар хоорондын комиссын VII хуралдаанаар Австрийн Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр боловсрол, мэргэжлийн боловсролын сургалт чиглэлийн хүрээнд "Хиймэл оюун ухаан", "Нээлттэй боловсрол", "Биоинженерчлэл" салбарын бааз суурийг ШУТИС-ийг түшиглэн хөгжүүлэх төслийн саналыг дэвшүүлсэн.  Филиппин Улстай боловсролын салбарт хамтран ажиллах боломж, нөхцөлийг судлан үзсэн. Монгол, Филиппиний ГХЯ-нд хоорондын бодлогын зөвлөлдөх уулзалтын сэдэвт боловсролын солилцоог идэвхжүүлэх, энэ салбарт дахь хамтын ажиллагааны баримт бичгийн төслийг солилцох саналыг боловсруулан хүргүүлсэн.	100%
313.	2.2 Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол-Оросын Засгийн газар хоорондын комиссын Боловсрол, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны дэд комиссын XIII хуралдааныг Улаанбаатар хотноо зохион байгуулна.*** /БТХ-28.1.10/	Хуралдааныг зохион байгуулсан байна.	Дэд комиссын хуралдааныг 2019 оны 5 сарын 28-ны өдөр Улаанбаатар хотноо амжилттай зохион байгуулсан. Хуралдаанаар Оросын талтай хамтран хэрэгжүүлэх арга хэмжээний талаар тохиролцсон. Монголын талаас Соёл, урлаг болон спортын салбарын албан хаагч нарыг цаашид ОХУ-ын их, дээд сургуулиудын магистр, докторын хөтөлбөрүүдэд элсэн суралцуулах зорилгоор тэдэнд орос хэл заах багш нарыг Монгол Улсад илгээх зэрэг саналыг Оросын талд тавьсан.	100%

314.	2.3 Боловсрол, шинжлэх ухаан салбарт болон залуучуудын асуудлаар ажиллах тухай Монгол Улсын БСШУС-ын яам, Бүгд Найрамдах Чех Улсын Боловсрол, залуучууд, спортын яам хоорондын хэлэлцээрийг байгуулна. /БТХ-28.1.10, ЗГҮАХ-3.2.25/	Хэлэлцээрт гарын үсэг зурах товыг Чехийн талтай тохиролцож, хэлэлцээрт гарын үсэг зурах арга хэмжээг зохион байгуулсан байна.	Хэлэлцээрийг 2019 оны 5 сарын 20-ны өдөр Прага хотноо байгуулсан. Хэлэлцээрт Монголын талыг төлөөлж Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар гарын үсэг зурсан. Хэлэлцээр нь 2021.12.31-ний өдрийг хүртэл хүчин төгөлдөр байна.	100%
"Гурав": Соёлын тухай хуулийн зорилтыг хангахад чиглэсэн арга хэмжээ:				
315.	3.1 Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Засгийн газар хоорондын 2019-2023 онуудад хэрэгжүүлэх Соёлын солилцооны хөтөлбөрийн төслийг эцэслэх чиглэлээр ажиллана. /СТХ-13.1.7/	Хөтөлбөрийн төслийг эцэслэн тохирсон байна.	"Соёлын Солилцооны Тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Засгийн газар хоорондын 2019-2023 оны хөтөлбөр"-ийг яамдаас санал авч, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 9 сарын 18-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, Ерөнхий сайдын захирамж гарсан/Ерөнхий сайдын захирамжийн дугаар хараахан ирээгүй болно/ Монгол Улсын Ерөнхийлөгчийн Бүгд Найрамдах Энэтхэг Улсад хийсэн төрийн айлчлалын хүрээнд Соёлын солилцооны тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Энэтхэг улсын Засгийн газар хоорондын 2019-2023 оны хөтөлбөрт Монголын талаас Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар, Энэтхэгийн талаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд М.П.Сингх нар гарын үсэг зурав.	100%
316.	3.2 2018-2020 онд Соёлын салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын БСШУС-ын яам болон Бүгд Найрамдах Чех Улсын Соёлын яам хоорондын хэлэлцээрийг байгуулна. /СТХ-13.1.7/	Хэлэлцээрийг төслийг Чехийн талтай эцэслэн тохирсон.	Хэлэлцээрийг 2019 оны 5 сарын 20-ны өдөр Прага хотноо байгуулсан. Хэлэлцээрт Монголын талыг төлөөлж Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар гарын үсэг зурсан. Хэлэлцээр нь 2021 оны 12 сарын 31-ний өдрийг хүртэл хүчин төгөлдөр байна. Хэлэлцээрийг холбогдох газруудад хүргүүлсэн болно.	100%

317.	3.3 Монгол Улсын БСШУС-ын яам, БНХАУ-ын Соёлын яам хооронд 2018-2021 онд хэрэгжүүлэх соёлын солилцооны төлөвлөгөөг байгуулна. *** /СТХ-13.1.7/	Соёлын солилцооны төлөвлөгөөний төслийг эцэслэн тохирсон.	Монгол Улсын БСШУС-ын яам, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Соёл, аялал жуулчлалын яам хооронд 2019-2022 онд хэрэгжүүлэх соёлын солилцооны хөтөлбөрийг айлын талтай харилцан тохиролцож, Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгын Бүгд Найрамдах Хятад Ард Улсад хийсэн төрийн айлчлалын үеэр байгуулсан болно. Төлөвлөгөөнд Монголын талыг төлөөлж Монгол Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайд Д.Ганхуяг гарын үсэг зурсан.	100%
"Дөрөв": Биеийн тамир, спортын тухай хуулийн зорилтыг хангахад чиглэсэн арга хэмжээ:				
318.	4.1 Бүгд Найрамдах Солонгос Улстай спортын салбарт хамтран ажиллах боломжийг судална.	Боломжийг судалсан байна.	Монгол Улсын Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатарын Бүгд Найрамдах Солонгос Улсад албан айлчлал хийхтэй холбогдуулан яриа, хэлэлцээрийн сэдэвт спортын салбарт хамтран ажиллах тухай санамж бичгийг төслийг хүргүүлсэн.	100%
319.	4.2 Бүгд Найрамдах Сингапур Улстай спортын салбарт хамтран ажиллах боломжийг судална.	Боломжийг судалсан байна.	Бүгд Найрамдах Сингапур Улстай спортын салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлийн хүрээнд БСШУС-ын яамны албан хаагчид, Биеийн тамир спортын газрын мэргэжилтнүүд болон МУБИС-ийн Биеийн тамирын сургуулийн албаны хүмүүсийн бүрэлдэхүүн 2019 оны 10 сарын 28 өдрөөс 11 сарын 02-ны өдрүүдэд Сингапурын Наньянг их сургуулийн бакалавр, магистрын сургалтын хөтөлбөртэй танилцах, тэдний хөтөлбөрийг Монгол Улсад нутагшуулах, хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх боломжийг судалсан. Монгол Улсын Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатарын Бүгд Найрамдах Сингапур Улсад албан айлчлал хийхтэй холбогдуулан яриа, хэлэлцээрийн сэдэвт спортын салбарт хамтран ажиллах тухай санамж бичгийн төслийг хүргүүлсэн.	100%
"Тав": Шинжлэх ухаан, технологийн тухай хууль, Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлогын зорилтыг хангахад чиглэсэн арга хэмжээ:				
320.	5.1 Монгол Улсын БСШУС-ын яам, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хөдөөгийн Хөгжлийг Дэмжих Газар хоорондын харилцан	Холбогдох зохицуулалтыг хийсэн байна.	Монгол Улсын БСШУС-ын яам, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хөдөөгийн Хөгжлийг Дэмжих Газар хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг байгуулахаар холбогдох газруудтай тохиролцон Төрийн нарийн бичгийн даргын түвшинд дипломат шугамаар гарын үсэг зурж, баталгаажуулахаар болсон.	100%



	ойлголцлын санамж бичиг байгуулах боломжийг судална. /ШУТТХ 8.1.10, ТШУТТББ 4.6.1/			
321.	5.2 Америкийн Нэгдсэн Улстай шинжлэх ухаан, технологийн салбарт хамтран ажиллах боломжийг судална. /ШУТТХ 8.1.10, ТШУТТББ 4.6.1/	Боломжийг судалсан байна.	Америкийн Нэгдсэн Улстай шинжлэх ухаан, технологийн салбарт хамтран ажиллах боломжийг судалж, Америкийн Нэгдсэн Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны төлөөлөгч болон АНУ-ын Төрийн департаментийн мэргэжилтэн нартай Улаанбаатар хотноо уулзаж, Монгол Улсад суугаа Америкийн Нэгдсэн Улсын Элчин сайдын яамтай хамтарч залуу судлаач нарт зориулсан арга хэмжээ зохион байгуулах, сансар судлалын чиглэлээр хамтарч ажиллах талаар хэлэлцсэн. АНУ-ын Төрийн департаментээс санхүүжигддэг “Speaker series” хөтөлбөрөөр залуу эрдэмтэн судлаач 2020 оны эхээр урихаар болсон. Түүнчлэн Америкийн Нэгдсэн Улсын Элчин сайдын яамтай хамтран 2019 оны 4 сарын 25-нд хоёр улсын их дээд сургуулиуд хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх, хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх зорилготой сургалт амжилттай зохион байгуулсан. Энэхүү сургалтад Монгол Улсын Төрийн өмчит их дээд сургуулиас оролцсон (МУИС, ХААИС, Монгол Улсын Консерватори, ШУТИС, АШУҮИС, МУБИС, СУИС, БХИС).	100%
322.	5.3 Австрали Улстай шинжлэх ухаан, технологийн салбарт хамтран ажиллах боломжийг судална. /ШУТТХ 8.1.10, ТШУТТББ 4.6.1/	Боломжийг судалсан байна.	Австрали Улстай шинжлэх ухаан, технологийн салбарт хамтран ажиллах боломжийг судлах ажлын хүрээнд БСШУС-ын сайд Ё.Баатарбилэг Австрали Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын сайд Дэйв Воусэнтэй 2019 оны 03 сарын 15-нд уулзаж Австралийн хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлсэн туршлагаас суралцаж Монголын хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх хамтарсан иж бүрэн судалгааг хийх, шинэ бүтээгдэхүүний судалгаа болон хөгжлийн ажлыг хамтран хэрэгжүүлэх талаар санал солилцсон. Гадаад хамтын ажиллагааны газар Австрали Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамтай уулзаж, шинжлэх ухаан, технологийн салбарын хамтын ажиллагааг идэвхжүүлэх, баримт бичгийн төслийг солилцох саналыг хүргүүлсэн.	100%
"Зургаа": Боловсролын тухай хууль, Соёлын тухай хууль, Биеийн тамир, спортын тухай хууль, Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн зорилтыг хангахад чиглэсэн арга хэмжээ:				

323.	6.1 Харьяа байгууллагуудын гадаад харилцааны ажилтнуудад зориулсан байгууллага хоорондын гэрээ, хэлэлцээрийг боловсруулах, байгуулах талаар сургалт зохион байгуулна. *** /БТХ-28.1.10, ТБТББ-6.5, ШУТТХ 8.1.10, СТХ 13.1.7/	Сургалтыг зохион байгуулсан байна.	2019 оны 10 сарын 06-12-ны өдрүүдэд боловсролын салбарын харьяа байгууллагуудын удирдлагын түвшний бүрэлдэхүүн ХБНГУ-ын их сургуулиудтай уулзаж, хамтын ажиллагааны гэрээ хэлэлцээр байгуулж, шинээр байгуулах боломжийг эрэлхийлсэн сургалт, уулзалтыг зохион байгуулсан. Гадаад хамтын ажиллагааны газраас харьяа байгууллагуудын гадаад харилцааны нэгжүүдтэй холбогдож гадаад улсуудтай байгуулсан гэрээ, хэлэлцээрийн талаарх мэдээллийг нэгтгэж байгаа болно. Мөн бусад харьяа байгууллагуудын нэгжүүдэд зориулж Гадаад харилцааны яамны Олон улсын гэрээ эрх зүйн газартай хамтарч 2019 оны 12 сарын 20-нд зохион байгуулахаар болсон.	100%
324.	6.2 Яамны удирдлагын гадаад уулзалт, хурлыг чанартай зохион байгуулна. /БТХ-2.8.10, ШУТТХ 8.1.10, СТХ 13.1.7/	Уулзалтыг зохион байгуулсан байна.	БСШУС-ын сайд, дэд сайд, төрийн нарийн бичгийн дарга нарын гадаад уулзалтуудыг чанартай зохион байгуулсан. Тухайлбал: Сайд, Дэд сайд, Төрийн нарийн бичгийн даргын Монгол Улсад суугаа гадаад улсын Элчин сайдуудтай хийсэн уулзалт, НҮБ-ын төрөлжсөн байгууллагын суурин төөлөгчидтэй хийсэн уулзалт, Монгол Улсын хамтрагч улс, түншүүдтэй хийсэн уулзалтуудыг тухай бүр бэлтгэл ажлыг хангах, орчуулах, ярианы сэдэв бэлдэх зохицуулалтыг хийж гүйцэтгэсэн.	100%
325.	6.3 БСШУС-ын сайд дэд сайд, төрийн нарийн бичгийн даргын гадаад улсад хийх айлчлалын зохицуулалтыг хангана. /БТХ-28.1.10, ШУТТХ 8.1.10, СТХ 13.1.7/	Холбогдох зохицуулалтыг гүйцэтгэсэн байна.	БСШУС-ын сайд, дэд сайд, төрийн нарийн бичгийн даргын гадаад улсад хийх айлчлалын зохицуулалтыг ханган ажилласан. Одоогийн байдлаар сайдын Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улс, Австрали Улс, Япон Улс, Бүгд Найрамдах Франц Улс, Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Колумби Улс, Америкийн Нэгдсэн Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Дэд сайдын Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Оросын Холбооны Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Бүгд Найрамдах Казахстан Улс, Төрийн нарийн бичгийн даргын Норвегийн Вант Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Унгар Улс, Канад Улсад хийсэн айлчлалуудын зохицуулалтуудыг бүрэн ханган ажилласан.	100%
<b>Санхүү, хөрөнгө оруулалтын газар, үйлдвэрлэлийн хэлтэс</b>				
Нэг. Монгол улсын ЭЗН-ийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээ				

326.	<p>1.Төсвийн хуулийг хэрэгжүүлэх хүрээнд:</p> <p>1.1 Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын урсгал болон хөрөнгө оруулалтын 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн хязгаар боловсруулна. /Төсвийн тухай хуулийн 8.3.1, 8.4.3-р зүйл/</p>	<p>Төсөв, санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн саналд салбарын төсвийн төсөөлөл бүрэн тусгасан байна.</p>	<p>Салбарын 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэлд хүргүүлэх саналыг Сангийн сайдад 2019 оны 4 сарын 17-ны 1а/3086 тоот албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>БСШУС-ын яамны төсвийн ерөнхийлөн захирагчийн нийт зардлыг 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэлд салбарын 2019 оны батлагдсан төсвийг 1,317.3 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, 2020 оны нийт төсвийг 3,180.9 тэрбум төгрөг байхаар төлөвлөлөө. Үүнээс: урсгал зардалд 725.5 тэрбум, хөрөнгө оруулалтын зардалд 591.8 тэрбум төгрөг нэмэгдэж байна.</p> <p>Улсын их хурлын чуулганы 2019 оны 5 сарын 30-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2021-2022 оны төсвийн төсөөллийн тухай хуулийг баталсан.</p> <p>Салбарын 2020 оны төсвийн хязгаарын саналыг Сангийн сайдад 2019 оны 6 сарын 10-ны 1а/5282 тоот албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>БСШУС-ын яамны Төсвийн ерөнхийлөн захирагчийн нийт зардлыг 2019 оны батлагдсан төсвийг 1,616.2 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, 2020 оны нийт төсвийн хязгаарыг 3,479.8 тэрбум төгрөг байхаар төлөвлөлөө. Үүнд: урсгал зардалд 693.5 тэрбум, хөрөнгө оруулалтын зардалд 922.7 тэрбум төгрөг нэмэгдэж байна.</p>	100%
327.	<p>1.2 Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын урсгал арга хэмжээний болон хөрөнгө оруулалтын 2020 оны төсвийн төсөл, 2021-2022 оны төсвийн төсөөлөл боловсруулна. /Төсвийн тухай хуулийн 8.4.3, 8.6.2, 14-р зүйл/</p>	<p>Төсөв, санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн саналд салбарын төсвийн төсөөлөл бүрэн тусгасан байна.</p>	<p>Салбарын 2020 оны төсвийн төслийг бэлтгэж, 2019 оны 8 сарын 14-ны өдрийн 1а/7268 тоот албан бичгээр, Гадаадын зээл, тусламжийн санхүүжилтээр хэрэгжих төсөл арга хэмжээний 2020 оны төсвийн төслийн саналыг 1а/7268 тоот албан бичгээр Сангийн сайдад хүргүүлээ.</p> <p>“Монгол Улсын 2020 оны төсвийн тухай”, “Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2021-2022 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулиуд Улсын Их Хурлын 2019 оны 11 сарын 13-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн батлагдлаа.</p> <p>Монгол Улсын төсвөөс 2020 оны төсвийн жилд БСШУС-ын сайдын төсөв зарцуулах нийт эрх 2,222,961.9 сая төгрөг санхүүжүүлэхээр төсөвт туссан байна.</p> <p>Үүнээс: урсгал зардал 1,560,540.4 сая /салбарын нийт төсвийн 70.2%/, дотоод эх үүсвэрээс олгох зээл 54,800.0 сая, боловсролын зээлийн эргэн төлөлт -5,000.0 сая, улсын төсвийн хөрөнгө оруулалтын</p>	100%

			<p>зардалд 662,421.5 сая төгрөг /салбарын нийт төсвийн 29.8%/ тус тус байна.</p> <p>Нийт төсвийн 1,877.6 тэрбум буюу 84.5% нь боловсролын, 220.6 тэрбум буюу 9.9% нь соёл урлагийн, 53.4 тэрбум буюу 2.4% нь шинжлэх ухааны, 71.3 тэрбум буюу 3.2% нь биеийн тамир, спортын салбарт ногдож байна.</p>	
328.	<p>1.3 Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын 2018 оны санхүүгийн нэгдсэн тайланг гаргаж холбогдох байгууллагад хүргүүлнэ. /Төсвийн тухай хуулийн 8.9.5/</p>	<p>Тайланд салбарын санхүүгийн үзүүлэлт бүрэн тусгагдсан байна.</p>	<p>БСШУС-ын сайдын эрхлэх асуудлын хүрээний 2018 оны санхүүгийн нэгдсэн тайланд харьяа 223 байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн тоон мэдээллийг тусган харууллаа. Эдгээр байгууллагыг төсвийн захирагч тус бүрээр авч үзвэл: төвлөрүүлэн захирагч 24, шууд захирагч 69, тусгай сан 4, төсөл хөтөлбөр 5, төрийн өмчид үйлдвэрийн газар 17 бусад 104 байгууллага тайланд нэгтгэгдсэн. Нийт хөрөнгийн 29 хувь нь Төрийн өмчит үйлдвэрийн газар, 71 хувийг Төсөвт байгууллагын хөрөнгө эзэлж байна. Үндэсний аудитын газрын дүгнэлтээр хязгаарлалттай дүгнэлт авсан.</p>	70%
329.	<p>1.4 БСШУС-ын урсгал арга хэмжээ, тусгай зориулалтын шилжүүлэг, хөрөнгө оруулалтын санхүүжилтийг зохион байгуулж, төрийн сангийн үйл ажиллагааг явуулна /Төсвийн тухай хуулийн 37-р зүйл/</p>	<p>Нягтлан бодох бүртгэлийг бүрэн хөтөлсөн байна.</p>	<p>Төсвийн тухай хуулийн дагуу орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх тусгай зориулалтын 2 арга хэмжээг шилжүүлсэн. Орон нутагт эрх шилжүүлснээс бусад хөрөнгө оруулалтын ажил гүйлгээг салбар бүрийн дансаар нягтлан бодох бүртгэлийг хөтлөн гүйцэтгэлээ.</p> <p>2019 оны 12 сарын 14-ний байдлаар Боловсролын салбарын хөрөнгө оруулалт 129,0 тэрбум төгрөг, соёлын салбарын хөрөнгө оруулалт 16,5 тэрбум төгрөг, спортын салбарын хөрөнгө оруулалт 16,9 тэрбум төгрөг, шинжлэх ухааны салбарын хөрөнгө оруулалт 70,0 сая төгрөг нийт 162,5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгчид шилжүүлэн ажилласан. 2019 оны 11 сарын орон нутгийн мэдээгээр 129,8 тэрбум төгрөгийн санхүүжилт олгогдоод байна.</p> <p>Нийт хөрөнгө оруулалтын гүйцэтгэл 292,3 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна.</p>	100%
330.	<p>1.5 Аймаг, нийслэлийн Засаг даргатай 2019 онд Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээ байгуулна. 2020 онд байгуулах гэрээний төслийг боловсруулна.</p>	<p>Гэрээнд 2019 оны төсвийн үзүүлэлтийг бүрэн оруулсан байна.</p>	<p>БСШУС-ын сайд “Төсвийн тухай” хуулийн 14.1.6, 14.1.8 эрхлэх асуудлын хүрээнд мөн хуулийн 39 дүгээр зүйлийг баримтлан аймаг, нийслэлийн Засаг даргатай 2019 онд Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээг холбогдох газар, хэлтсээс санал авсны дагуу төслийг боловсруулсан бөгөөд гэрээг 2019 оны 1 сарын 17-ны өдөр байгуулсан болно. Өмнөх онтой харьцуулахад салбарын төсөвт соёл урлагийн болон биеийн тамирын салбарын төсөв орон нутагт</p>	100%

	*** /Төсвийн тухай хуулийн 39-р зүйл/		шилжсэнтэй холбогдуулан гэрээнд тус салбарын үйл ажиллагаа болон төсөв, санхүүтэй холбоотой холбогдох заалт тусгагдаагүй болно.	
Хоёр. Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ				
331.	2. МУ-ын хөрөнгө оруулалтын хөтөлбөр хэрэгжүүлэх хүрээнд: 2.1 Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын 2020 оны ТХМ, төсвийн хязгаар, 2020 оны төсвийн төсөл, 2021-2022 оны төсвийн төсөөлөл боловсруулахад хариуцсан салбарын хөрөнгө оруулалтын судалгааг үндэслэн, хөрөнгө оруулалтын санал тусгаж ажиллана. /Төсвийн тухай хуулийн 8.3.1, 8.4.3, 8.6.2, 14-р зүйл/	Төсөв, санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн саналд салбарын хөрөнгө оруулалтын төсвийн төсөөлөл бүрэн тусгасан байна.	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын хөрөнгө оруулалтын <u>2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл</u> 930.4 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэхээр тусган Сангийн яаманд 2019 оны 4 сарын 17-ны өдөр хүргүүлсэн. БСШУС-ын сайдын дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд суурилсан <u>2020 оны төсвийн хязгаарын саналд</u> 2,918,809.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 2020 онд 1,539,170.1 сая төгрөгөөр санхүүжих нийт 601 төсөл, арга хэмжээ тусгасны он дамжин үргэлжлэх 255, шинээр хэрэгжих 346 төсөл, арга хэмжээг тусган Сангийн яаманд 2019 оны 6 сарын 10-ны өдөр хүргүүлсэн болно. Эдгээр төсөл, арга хэмжээний боловсролын салбарт 421, соёлын салбарт 135, спортын салбарт 29, шинжлэх ухааны салбарт 13, улсын хэмжээнд 3 хэрэгжихээр байна. Салбарын <u>2020 оны төсвийн төслийг бэлтгэж</u> , 2019 оны 8 сарын 14-ний өдрийн 1а/7268 тоот албан бичгээр Сангийн сайдад хүргүүлээ. Салбарын 2020 оны төсвийн төсөлд хөрөнгө оруулалтын зардлыг нийт 2,667,330.6 сая төгрөгөөр тусгалаа. Улсын Их Хурлаар батлагдсан 2020 оны төсөвт хөрөнгө оруулалтын зардалд нийт 662.4 тэрбум төгрөг батлагдаж үүнээс барилга 572.7 тэрбум, их засвар 45.2 тэрбум, тоног төхөөрөмж 44.6 тэрбум төгрөг батлагдсан байна.	100%
332.	2.2 Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд батлагдсан салбарын хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажиллана. /Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулийн 4 дүгээр	Ашиглалтад орж буй барилга бүрийг улсын комисс хүлээн авсан байна.	2019 онд БСШУС-ын салбарт хэрэгжүүлэх шинэ 381, шилжих 222 төсөл нийт 603 төсөл арга хэмжээг нийслэлийн хөрөнгө оруулалтын газар болон барилга хөгжлийн төвийн захиалагчийн хяналтын хэлтэстэй хамтран зохион байгуулан ажиллаж байна. БСШУС-ын яамны 5, НЗДТ газарт эрх шилжүүлсэн 49, ТӨБЗ газарт эрх шилжүүлсэн 102, орон нутагт шилжүүлсэн 226 төсөл арга хэмжээг үйлдвэрлэлийн хэлтэс, хяналт шалгалтын гэрээт инженерүүдийн хамт өдөр тутмын хяналтыг хийж шийдвэрлүүлэх асуудлыг зохих журмын дагуу тухай бүр шийдвэрлүүлэн ажилласан. Төлөвлөсөн арга хэмжээнээс 221 төсөл арга хэмжээг бүрэн ашиглалтад оруулсан байна.	100%

	<p>хавсралтын XIII.1.1, XIII.2.1, XIII.3.1/</p>		<p style="text-align: center;">2019 онд ашиглалтанд орсон төсөл арга хэмжээ</p> <table border="1" style="width: 100%; border-collapse: collapse;"> <thead> <tr> <th rowspan="2">Нэр</th> <th colspan="2">Нийслэл</th> <th colspan="2">Орон нутаг</th> <th colspan="2">Улсын хэмжээнд</th> </tr> <tr> <th>2019.12.10</th> <th>Хүчин чадал</th> <th>2019.12.10</th> <th>Хүчин чадал</th> <th>2019.12.10</th> <th>Хүчин чадал</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Сургууль</td> <td>20</td> <td>10560</td> <td>17</td> <td>5190</td> <td>37</td> <td>15750</td> </tr> <tr> <td>Цэцэрлэг</td> <td>25</td> <td>4395</td> <td>31</td> <td>3325</td> <td>56</td> <td>7720</td> </tr> <tr> <td>Спорт заал</td> <td>1</td> <td>0</td> <td>6</td> <td>320</td> <td>7</td> <td>320</td> </tr> <tr> <td>Дотуур байр</td> <td>0</td> <td>0</td> <td>9</td> <td>1020</td> <td>9</td> <td>1020</td> </tr> <tr> <td>Соёл, спортын байгууламж</td> <td>1</td> <td>1080</td> <td>26</td> <td>4460</td> <td>27</td> <td>5540</td> </tr> <tr> <td>Засвар</td> <td>6</td> <td>0</td> <td>69</td> <td>0</td> <td>75</td> <td>0</td> </tr> <tr> <td>Тоног төхөөрөмж</td> <td>4</td> <td>0</td> <td>6</td> <td>0</td> <td>10</td> <td>0</td> </tr> <tr> <td>Нийт</td> <td>57</td> <td>16035</td> <td>164</td> <td>14315</td> <td>221</td> <td>30350</td> </tr> </tbody> </table> <p>2019 оны 12 сарын 31-нд дахин 40 төсөл арга хэмжээг ашиглалтад оруулахаар ажиллаж байна.</p> <p style="text-align: center;">2019 оны 12 сард ашиглалтанд орох төсөл арга хэмжээ</p> <table border="1" style="width: 100%; border-collapse: collapse;"> <thead> <tr> <th rowspan="2">Нэр</th> <th colspan="2">Нийслэл</th> <th colspan="2">Орон нутаг</th> <th colspan="2">Улсын хэмжээнд</th> </tr> <tr> <th>2019.12.31</th> <th>Хүчин чадал</th> <th>2019.12.31</th> <th>Хүчин чадал</th> <th>2019.12.31</th> <th>Хүчин чадал</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Сургууль</td> <td>0</td> <td>0</td> <td>9</td> <td>3368</td> <td>9</td> <td>3368</td> </tr> <tr> <td>Цэцэрлэг</td> <td>4</td> <td>820</td> <td>13</td> <td>1670</td> <td>17</td> <td>2490</td> </tr> <tr> <td>Спорт заал</td> <td>0</td> <td>0</td> <td>0</td> <td>0</td> <td>0</td> <td>0</td> </tr> <tr> <td>Дотуур байр</td> <td>0</td> <td>0</td> <td>1</td> <td>150</td> <td>1</td> <td>150</td> </tr> <tr> <td>Соёл, спортын байгууламж</td> <td>1</td> <td>700</td> <td>8</td> <td>3480</td> <td>9</td> <td>4180</td> </tr> <tr> <td>Засвар</td> <td>0</td> <td>0</td> <td>4</td> <td>0</td> <td>4</td> <td>0</td> </tr> <tr> <td>Тоног төхөөрөмж</td> <td>0</td> <td>0</td> <td>0</td> <td>0</td> <td>0</td> <td>0</td> </tr> <tr> <td>Нийт</td> <td>5</td> <td>1520</td> <td>35</td> <td>8668</td> <td>40</td> <td>10188</td> </tr> </tbody> </table>	Нэр	Нийслэл		Орон нутаг		Улсын хэмжээнд		2019.12.10	Хүчин чадал	2019.12.10	Хүчин чадал	2019.12.10	Хүчин чадал	Сургууль	20	10560	17	5190	37	15750	Цэцэрлэг	25	4395	31	3325	56	7720	Спорт заал	1	0	6	320	7	320	Дотуур байр	0	0	9	1020	9	1020	Соёл, спортын байгууламж	1	1080	26	4460	27	5540	Засвар	6	0	69	0	75	0	Тоног төхөөрөмж	4	0	6	0	10	0	Нийт	57	16035	164	14315	221	30350	Нэр	Нийслэл		Орон нутаг		Улсын хэмжээнд		2019.12.31	Хүчин чадал	2019.12.31	Хүчин чадал	2019.12.31	Хүчин чадал	Сургууль	0	0	9	3368	9	3368	Цэцэрлэг	4	820	13	1670	17	2490	Спорт заал	0	0	0	0	0	0	Дотуур байр	0	0	1	150	1	150	Соёл, спортын байгууламж	1	700	8	3480	9	4180	Засвар	0	0	4	0	4	0	Тоног төхөөрөмж	0	0	0	0	0	0	Нийт	5	1520	35	8668	40	10188	
Нэр	Нийслэл		Орон нутаг		Улсын хэмжээнд																																																																																																																																									
	2019.12.10	Хүчин чадал	2019.12.10	Хүчин чадал	2019.12.10	Хүчин чадал																																																																																																																																								
Сургууль	20	10560	17	5190	37	15750																																																																																																																																								
Цэцэрлэг	25	4395	31	3325	56	7720																																																																																																																																								
Спорт заал	1	0	6	320	7	320																																																																																																																																								
Дотуур байр	0	0	9	1020	9	1020																																																																																																																																								
Соёл, спортын байгууламж	1	1080	26	4460	27	5540																																																																																																																																								
Засвар	6	0	69	0	75	0																																																																																																																																								
Тоног төхөөрөмж	4	0	6	0	10	0																																																																																																																																								
Нийт	57	16035	164	14315	221	30350																																																																																																																																								
Нэр	Нийслэл		Орон нутаг		Улсын хэмжээнд																																																																																																																																									
	2019.12.31	Хүчин чадал	2019.12.31	Хүчин чадал	2019.12.31	Хүчин чадал																																																																																																																																								
Сургууль	0	0	9	3368	9	3368																																																																																																																																								
Цэцэрлэг	4	820	13	1670	17	2490																																																																																																																																								
Спорт заал	0	0	0	0	0	0																																																																																																																																								
Дотуур байр	0	0	1	150	1	150																																																																																																																																								
Соёл, спортын байгууламж	1	700	8	3480	9	4180																																																																																																																																								
Засвар	0	0	4	0	4	0																																																																																																																																								
Тоног төхөөрөмж	0	0	0	0	0	0																																																																																																																																								
Нийт	5	1520	35	8668	40	10188																																																																																																																																								
333.	<p>2.3 Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд батлагдсан салбарын их засвар, тоног төхөөрөмжийн хэрэгжилтийг хангана. /Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулийн 4 дүгээр хавсралтын XIII.1.2, XIII.2.2, XIII.3.2, XIII.4/</p>	<p>2019 оны салбарын батлагдсан их засварын ажлыг техникийн комисс хүлээн авсан байна.</p>	<p>Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд салбарын их засварын 79 төсөл, арга хэмжээнд 25.8 тэрбум төгрөг батлагдсан бөгөөд санхүүжилтийг санхүүжүүлсэн тухай бүр нь гүйцэтгэгч компани руу шилжүүлсэн. Үүнд</p> <ul style="list-style-type: none"> <li>✓ боловсролын салбарт 1,800.0 сая/төг</li> <li>✓ соёлын салбарт 214.4 сая/төг</li> <li>✓ спортын салбарт 88.1 сая/төг</li> <li>✓ шинжлэх ухааны салбарт 70.0 сая, төгрөг нийт 2,172.5 сая төгрөгийн санхүүжилтийг олгоод байна. Орон нутгийн 11 сарын мэдээгээр 13,2 тэрбум төгрөгийн их засварын ажлыг хийж гүйцэтгэн санхүүжүүлсэн.</li> </ul> <p>Барьцаа хөрөнгийн дансанд энэ онд ашиглалтад орсон 52 төсөл арга хэмжээний 3.1 тэрбум төгрөгийн барьцаа хөрөнгийг байршуулж 70</p>	100%																																																																																																																																										

			төсөл арга хэмжээтэй холбоотой 7.6 тэрбум төгрөгийн барьцаа хөрөнгийг чөлөөлсөн байна. Баталгаат хугацаанд ямар нэгэн зөрчил гараагүй болно.	
334.	2.4 Анги дүүргэлт хэт өндөртэй сургууль, цэцэрлэгийн ачааллыг бууруулж, 3 ээлжтэй ерөнхий боловсролын сургуулийг 2 ээлжид шилжүүлэх. *** /ЗГҮАХ 3.2.3/	Нийслэлд 3 ээлжээр хичээллэж байгаа 28 сургуулийн тоог бууруулсан байна.	2019-2020 оны хичээлийн жилд нийслэлд 3 ээлжээр хичээллэх ерөнхий боловсролын 18 сургуулийн 192 бүлгийн 7189 хүүхэд байсан. Эдгээр хүүхдүүдийг 2 ээлжид шилжүүлэх батлагдсан аргачлалын дагуу сургалтын эрүүл ахуй, стандартын шаардлага хангасан барилга байгууламжийг түрээслэн хичээл, сургалтын үйл ажиллагаа зохион байгуулж, 2019-2020 оны хичээлийн жилд нийслэлд 3 ээлжээр хичээллэхгүй байхаар шийдвэрлэлээ. Байр түрээслэх зардлын тооцоог гаргаж, Сангийн яаманд албан бичгээр хүсэлт хүргүүлсний дагуу 2020 оны төсөвт ЕБС-д 1396.2 сая төгрөг, СӨБ-д 643.7 сая төгрөгийн түрээсийн зардал батлагдсан байна.	100%
335.	2.5 Чойжин ламын сүм музейг шинэчлэн засварлаж, Тоньюкукийн цогцолборыг хамгаалах, музей байгуулах /ЗГҮАХ 3.2.51 /	Чойжин ламын сүм музей шинэчлэн засварлагдсан байна. Тоньюкукийн цогцолборыг хамгаалах, музей байгуулахад шаардлагатай Монголын талын хөрөнгийг Сангийн яаманд уламжлан хүргүүлж, шийдвэрлүүлсэн байна	Чойжин ламын сүм музейн Занхан ба гол сүмийн хоорондох залгаа танхимын дээврийг 178.2 сая төгрөгөөр сэргээн засварлаж, 2019 оны 8 сард ашиглалтад оруулсан. Чойжин ламын сүм музейн иж бүрэн сэргээн завсар, тохижилтын ажлын зураг төслийг боловсруулах ажлын эхлүүлэх шийдвэрийг 2019 оны 10 сард гарган ажиллаж байна. Ирэх оны сайдын их засварын задаргаанд тусгахаар төлөвлөж байна. Тоньюкукийн дурсгал хүртэл татах цахилгааны шугам сүлжээний ажилд шаардагдах 20,0 сая төгрөгийг урсгал зардлаас шийдвэрлэсэн.	100%
336.	2.6 Архангай аймгийн Хөгжимт драмын театрын шинэ барилгыг гүйцээж ашиглалтад оруулах /2018 оны ЗГҮАХ 6.1.4/	Барилгыг улсын комисс хүлээн авсан байна.	Хөгжимт драмын театрын шинэ барилгын ажлын гүйцэтгэгчээр "Акми холдинг" ХХК-ийг сонгож, 2013 оны 6 сарын 28-нд барилга угсралтын ажлын гэрээг байгуулсан. 2019 онд 2752.4 сая төгрөгийн санхүүжилттэй ажиллаж барилга угсралтын ажлын гүйцэтгэл 80 хувьтай байна. Монгол Улсын 2020 оны улсын төсөвт тус төсөл, арга хэмжээний төсөвт өртөг 13,492.2 сая төгрөг, санхүүжих дүн 3,543.8 сая төгрөгөөр батлагдсан. Ирэх оны 2 дугаар улиралд ашиглалтад орно.	70%

337.	2.7 Архангай аймгийн Эрдэнэбулган сум дахь Хүүхэд залуучуудын цэцэрлэгт хүрээлэнг Хүүхдийн парктэй болгох зураг төсвийг хийж батлуулах	ТЭЗҮ бүрэн хийгдсэн байна.	2020-2024 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтад тусгаж, Засгийн газарт хүргүүлж, танилцуулагдсан. Жич: Тус ажил нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багцад хамаарах асуудал гэж үзэж байна.	40%
338.	2.8 Хүүхдийн парк байгуулах /2018 оны ЗГҮАХ 6.1.5/	Батлагдсан санхүүжилтийг зарцуулсан байна	2020-2024 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтад тусгаж, Засгийн газарт хүргүүлж, танилцуулагдсан. Жич: тус ажил нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багцад хамаарах асуудал гэж үзэж байна.	40%
339.	2.9 Баянхонгор аймагт кино театрыг барих /2018 оны ЗГҮАХ 6.3.5/	Батлагдсан санхүүжилтийг зарцуулсан байна.	Баянхонгор суманд кино театрын барилга барих төсвийн 1000.0 сая төгрөгийг 2020 оны төсөвт суулгуулахаар Сайдын 2019 оны 08 сарын 14-ний өдрийн 1а/7268 тоот албан бичгээр Сангийн сайдад хүргүүлсэн боловч УИХ-аар хэлэлцүүлэх саналаас хасагдсан байна.	40%
340.	2.10 Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын 3 дугаар сургуулийн 640 хүүхдийн барилгыг шинээр барих /2018 оны ЗГҮАХ 6.3.5”	Улсын комисс ажилласан байна	Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын 3 дугаар сургуулийн 320 хүүхдийн барилгыг шинээр барихаар 3,3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй батлагдсан. 2020 онд 1 тэрбум төгрөгийн санхүүжилт батлагдсан. Худалдан авах ажиллагааг АЗДТГ-т зохион байгуулахаар эрх шилжсэн байна	70%
341.	2.11 Говьсүмбэр аймгийн боржигон чуулгын шинэ барилга барих “2018 оны ЗГҮАХ 6.6.1”	Улсын комисс ажилласан байна	Аймгийн төвд Боржигон чуулгын шинэ барилгыг 5494.0 сая төгрөгөөр барихаар төлөвлөж, 2020 оны төсөвт 1494.0 сая төгрөгийг суулгуулахаар Сайдын 2019 оны 8 сарын 14-ний өдрийн 1а/7268 тоот албан бичгээр Сангийн сайдад хүргүүлсэн 2020 оны улсын төсвийн саналд тусган хүргүүлсэн боловч УИХ-аар хэлэлцүүлэх саналаас хасагдсан байна. Мөн Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд Боржигон чуулгын гаднах талбайн тохижилт /Говьсүмбэр, Сүмбэр сум/ төсөл, арга хэмжээний 106.0 сая төгрөг батлагдаж, ажил хийгдэж байна.	40%
342.	2.12 Дархан-Уул аймгийн багш хотхон” болон “Боловсрол хотхон”-ы бүтээн байгуулалтыг үе шаттайгаар	Техникийн комисс хүлээн авсан байна.	“Багш хотхон” болон “Боловсрол хотхон”-ы төсвийг орон нутгаас санал авч 2019, 2020 оны төсвийн төсөлд санал хүргүүлсэн боловч хасагдсан байна. 2020 оны төсвийн төсөлд Сайдын 2019 оны 8 сарын 14 өдрийн 1а/7268 тоот албан бичгээр Сангийн сайдад хүргүүлсэн.	40%



	хэрэгжүүлэх “2018 оны ЗГҮАХ 6.7.4”			
343.	2.13 Дорнод аймагт спортын ордон шинээр барих “2018 оны ЗГҮАХ 6.9.4”	Улсын төсөвт тусгагдсан байна	Дорнод аймгийн Хэрлэн суманд 5300.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй усан бассейн бүхий спортын ордон шинэ барилга барихаар төлөвлөж, 1300.0 сая төгрөгийг 2020 оны төсөвт суулгуулахаар Сайдын 2019 оны 8 сарын 14 өдрийн 1а/7268 тоот албан бичгээр Сангийн сайдад хүргүүлсэн 2020 оны улсын төсвийн саналд тусган хүргүүлсэн боловч УИХ-аар хэлэлцүүлэх саналаас хасагдсан байна.	40%
344.	2.14 Дундговь аймгийн Дэлгэрхангай суманд спорт заалны барилга шинээр барих “2018 оны ЗГҮАХ 6.10.1”	Улсын төсөвт тусгагдсан байна	2018 оны улсын төсөвт 2.377.0 төгрөг батлагдсан бөгөөд Урагшлах ХХК гэрээ 2228,8 сая төгрөгийн өртөгтэй гэрээ байгуулсан. 2018 онд 500.0 сая төгрөгийн санхүүжилттэйгээр барилгын ажил эхэлсэн. Сургууль, спорт зал 2-ыг холбох хүзүүвчний барилгын санхүүжилтийг нэмэлтээр шийдвэрлэсэн, барилгыг 11 сард ашиглалтад хүлээлгэн өгсөн.	100%
345.	2.15 Дундговь аймгийн Адаацаг суманд спорт заалны барилга шинээр барих “2018 оны ЗГҮАХ 6.10.1”	Улсын төсөвт тусгагдсан байна	Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд Дундговь аймгийн Адаацаг суманд спорт заалны барилга шинээр барих 320,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй батлагдаж, санхүүжилт бүрэн батлагдсан байна. Худалдан авах ажиллагааг ТХААГ-т зохион байгуулахаар эрх шилжсэн байна	100%
346.	2.16 Дундговь аймгийн Говь-Угтаал суманд спорт заалны барилга “2018 оны ЗГҮАХ 6.10.2”	Улсын төсөвт тусгагдсан байна	Барилгын ажил 2019-2020 онд хэрэгжихээр 1000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 2019 онд 500.0 сая төгрөгийн санхүүжилттэй Бум констракшн ХХК-тай гэрээ хийсэн. Барилгын суурийн ажил хийгдэж байна. 2020 оны улсын төсөвт нэмэлт ажлын 500.0 сая төгрөг тусгагдан батлагдсан.	100%
347.	2.17 Дундговь аймгийн Говийн ирээдүйн цогцолбор сургуульд спорт заал шинээр барих “2018 оны ЗГҮАХ 6.10.3”	Улсын төсөвт тусгагдсан байна	Барилгын ажил 2020-2021 онд хэрэгжих, 800.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй. 2020 оны Улсын төсөвт 320.0 сая төгрөг тусгагдан батлагдсан.	100%
348.	2.18 Цагаандэлгэр суманд соёлын төвийн барилга шинээр барих “2018 оны ЗГҮАХ 6.10.6”	Улсын төсөвт тусгагдсан байна	Дундговь аймгийн Цагаандэлгэр суманд 240 суудалтай соёлын төвийн шинэ барилга 1230.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 2019 онд 575.0 сая төгрөгийн санхүүжилттэй ажил эхэлсэн. 2020 оны Улсын төсөвт нэмэлт ажлын 655.0 сая төгрөг тусгагдан батлагдсан.	100%

349.	2.19 Дэлгэрцогт суманд соёлын төвийн барилга шинээр барих “2018 оны ЗГҮАХ 6.10.6”	Улсын төсөвт тусгагдсан байна	Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд Дэлгэрцогт суманд соёлын төвийн барилга шинээр барихаар 1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй батлагдаж, 2020 онд 500 сая төгрөгийн санхүүжилт батлагдсан. Худалдан авах ажиллагааг ТХААГ-т зохион байгуулахаар эрх шилжсэн байна.	100%
350.	2.20 Орхон аймгийн сургууль, цэцэрлэгийг шаардлагатай багуудад шинээр барих /Цагаанчулуут, Рашаант, Булаг, Шанд, Уртын гол, Яргуйт, Даваат, Согоот/ “2018 оны ЗГҮАХ 6.12.1”	Улсын төсөвт тусгагдсан байна.	Цагаанчулуут багт 280 хүүхдийн цэцэрлэг баригдсан 2019 оны 04 сард ашиглалтад орсон. Рашаант багт 250 хүүхдийн сургуулийн барилгын гүйцэтгэгчээр 1900,0 сая төгрөгийн гэрээний үнийн дүнгээр Жам ХХК шалгарсан. Барилгын суурийн ажил хийгдэж байна. 15 хувийн гүйцэтгэлтэй байна. 2020 оны улсын төсөвт саналд нэмэлт ажлын 600.0 сая төгрөг тусгагдан батлагдсан. Булаг багт 150 хүүхдийн цэцэрлэг баригдаж байна. Бодьхангай ХХК гүйцэтгэгчээр шалгарсан, барилга 80 хувийн гүйцэтгэлтэй байна. Уртын гол багт 150 хүүхдийн цэцэрлэг баригдаж байна. 2020 онд ашиглалтад орно. Яргуйт багт 150 хүүхдийн цэцэрлэгийн барилгын гүйцэтгэгчээр Ээлт-Өлгий ХХК шалгарсан. Барилгын явц 75 хувьтай байна. Даваат багт 150 хүүхдийн цэцэрлэг баригдаж байна. 2020 онд ашиглалтад орно. Согоот багт 150 хүүхдийн 2 цэцэрлэг баригдаж байна. 2020 онд ашиглалтад орно.	100%
351.	2.21 Орхон аймгийн алслагдсан багуудад соёл, спортын төвүүдийг шинээр байгуулах /2018 оны ЗГҮАХ 6.12.2/	Улсын төсөвт тусгагдсан байна	Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд "Соёлын төвийн 250 суудалтай барилга, 1500.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, /Орхон, Баян-Өндөр сум, Даваат баг/, 2019 онд 650 сая төгрөг батлагдсан. Барилга угсралтын ажил 20 хувийн гүйцэтгэлтэй байна. 2020 оны улсын төсөвт нэмэлт ажлын 850.0 сая төгрөг тусгагдан батлагдсан. "Соёлын төвийн барилга /Орхон, Баян-Өндөр сум, Наран баг/"-ийн барилга 1000.0 сая төгрөгийн өртөгтэй, гүйцэтгэгчээр Наян констракшн ХХК шалгарч, барилга угсралтын ажил эхэлсэн. "Спорт заалны барилга /Орхон, Баян-Өндөр сум, Баянбулаг баг/" 800.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 2019 онд 300.0 сая төгрөг батлагдаж, гүйцэтгэгч сонгон барилга угсралтын ажил хийгдэж байна. Барилгын үндсэн карказ дууссан. Гадна өнгөлгөөний өрлөг дууссан, дотор засал, цонх суулгах ажил хийгдэж байна. Барилга угсралтын ажил 85 хувийн гүйцэтгэлтэй байна. Үлдэгдэл санхүүжилт болох 279.4 сая төгрөгийг	100%

			Сайдын 2019 оны 12 сарын 06 өдрийн А/775 “Санхүүжилтийн өөрчлөлт оруулах тухай” тушаалаар зохицуулалтаар шийдвэрлэсэн.	
352.	2.22 Орхон аймгийн стандартын шаардлага хангасан музейн барилга барьж, үзмэрийн сан хөмрөгийг нэмэгдүүлж, хадгалалтыг сайжруулах	Улсын төсөвт тусгагдсан байна	Орхон аймгийн Баян-Өндөр суманд 3912.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй музейн барилга шинээр барилга барихаар төлөвлөж, 2020 оны төсөвт 2000.0 сая төгрөг суулгуулахаар Сайдын 2019 оны 8 сарын 14-ний өдрийн 1а/7268 тоот албан бичгээр Сангийн сайдад хүргүүлсэн 2020 оны улсын төсвийн саналд тусган хүргүүлсэн боловч УИХ-аар хэлэлцүүлэх саналаас хасагдсан байна.	40%
<b>Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар</b>				
Нэг. Засгийн газрын 2017 оны 267 дугаар тогтоолын хавсралтын “Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”-ийн 3.3.10 /хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг”-ийн хүрээнд:				
353.	1.1.Боловсролын салбарт мөрдөгдөж байгаа зарим захиргааны эрх зүйн актын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, дүгнэлт, зөвлөмж гаргах	Боловсролын салбарт мөрдөгдөж байгаа зарим захиргааны эрх зүйн актын жагсаалтыг гаргасан.	<p>2016-2018 оны хооронд БСШУС-ын сайд 2019 онд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт ажлын хүрээнд нийт 32 байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ, Боловсролын тухай хууль болон бусад хууль, тогтоомж тэдгээрт нийцүүлэн эрх бүхий байгууллагаас гаргасан тогтоол, шийдвэр, сайдын баталсан захиргааны хэм хэмжээ тогтоосон эрх зүйн акт, дүрэм, журмын хэрэгжилтийг хамруулан, илэрсэн зөрчлийг арилгуулах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар дүгнэлт, санал зөвлөмжийг өгч, биелэлтийг тооцон ажилласан.</p> <p>2016-2018 оны хооронд БСШУС-ын сайдын баталсан тушаалаар ХШҮДАГ-т үүрэгжүүлсэн болон хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх эрх зүйн баримт бичгийн жагсаалтыг гаргаж, нэгтгэсэн. Үүнд тусгай зөвшөөрөл олгох сунгах сайдын тушаал-7, дүрэм, журам, хөтөлбөр төлөвлөгөө баталсан акт-38, зардал томилолттой холбоотой сайдын тушаал-16, ажлын хэсэг удирдамж баталсан-17 байна БСШУС-ын сайдын 2019 оны 11 сарын 7-ны өдрийн “Ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай” А/705 дугаар тушаалын дагуу Цэцэрлэгийн туслах багшийг бэлтгэх түр сургалт, боловсролын сургалтын байгууллагын албан бус нэршлээр үйл ажиллагаа явуулж, мэргэжлийн диплом олгож буй байгууллагыг шалган,</p>	100%

			цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай санал дүгнэлт боловсруулах ажлын хүрээнд нийт 21 сургалтын байгууллагын үйл ажиллагаанд хяналт хийж, санал дүгнэлтийг нэгтгэж дууссан.	
354.	1.2. БСШУС-ын сайдын аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулсан үр дүнгийн гэрээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх.	2017 онд БСШУС-ын сайдын аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулсан үр дүнгийн гэрээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдсэн.	БСШУС-ын сайдын 2019 оны 12 сарын 6-ны өдрийн А/789 дугаар “Ажлын хэсэг” байгуулах тушаалын дагуу гэрээний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэх ажил хийгдэж байна.	100%
355.	1.3.Дотуур байрын хүртээмжийн байдалд хяналт-шинжилгээ хийх	Дотуур байрны хүртээмжийн судалгаа авах асуумж боловсруулсан.	Монгол улсын Засгийн газрын 2019 оны 37 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”, БСШУС-ын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын 2019 оны төлөвлөгөөний дагуу Дотуур байрны орчин, үйлчилгээний өнөөгийн нөхцөл байдлын мэдээлэлд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийлээ. Үнэлгээ хийхдээ Засгийн газрын 89 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Бодлогын хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын зургаадугаар зүйлд заасан хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүйг баримталсан. 2019-2020 оны хичээлийн жилийн статистик мэдээгээр нийт 532 дотуур байрнаас 474 буюу 89,0% нь стандартын барилгатай, 46 буюу 11% нь стандартын бус барилгатай бөгөөд дотуур байранд суухаар 38698 сурагч хүсэлтээ өгч, 35757 сурагч амьдарч байгаагаас 27136 нь малчдын хүүхэд байна. Үүнээс хөгжлийн бэрхшээлтэй 557 сурагч байна.	100%
356.	1.4. Тусгай зөвшөөрөл олголтын байдалд хяналт-шинжилгээ хийх.***	БСШУС-ын яамнаас тусгай зөвшөөрөл авсан байгууллагын судалгааг гаргах	“Аж ахуй үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай” Монгол Улсын Дээд Шүүхийн 2009 оны 3 сарын 31-ний өдрийн 09 дугаар тогтоолын 4. “Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг биелүүлж байгаад хяналт тавих” эрхийг тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагад хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3-т зааснаар олгосон тул уг хяналтыг хэрэгжүүлэхдээ Төрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан хяналт, шалгалт хийх нийтлэг үндэслэл, журам, арга хэлбэрийг удирдлага болгоно. гэж	100%

			<p>тус тус заасны дагуу их дээд сургуулиудад хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Улаанбаатар Эрдэм судлал дээд сургууль нь сургалтын үйл ажиллагаа явуулж буй эсэх нь тодорхойгүй, улсын бүртгэлийн гэрчилгээ дээрх хуулийн этгээдийн үйл ажиллагаа явуулах албан ёсны хаягт байхгүй тул дээд боловсролын байгууллагад сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох.</li> <li>2. Түшээ, Эко-Ази дээд сургуулиудын сургалтын орчин, багшлах боловсон хүчин нь “Дээд боловсролын сургалтын байгууллагын ангилал тогтоох журам”-ын 2-д заасан Дээд боловсролын сургалтын байгууллагад тавигдах нийтлэг шаардлагыг хангаагүй, тусгай зөвшөөрлийн хавсралтад заасан зарим мэргэжлээр элсэлт аваагүй тул тухайн мэргэжлийн хөтөлбөрийг хаах</li> <li>3. Утга зохиол, нийгмийн ажилтны дээд сургуулийн тусгай зөвшөөрлийг сунгах асуудлыг шийдвэрлэж, сургалтын үйл ажиллагаа явуулаагүй байгаа хөтөлбөрүүдийг хаах.</li> <li>4. Боловсролын тухай хуулийн 25.2-д “Боловсролын сургалтын байгууллагыг энэ хуулийн 25.1.1-д заасны дагуу татан буулгах шийдвэр гарахаас 2 сарын өмнө тухайн боловсролын сургалтын байгууллагыг татан буулгах ажлын төлөвлөгөө, авах арга хэмжээний талаарх саналаа холбогдох тооцоо, судалгааны хамт боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх бөгөөд боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага уг саналыг судлан дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргана.” гэсэн заалтын хүрээнд Улаанбаатар Эрдэм судлал дээд сургуулийн сургалтын ажил эрхлэх тусгай зөвшөөрлийг цуцлах,</li> <li>5. “Монгол дээд сургуулийн үүсгэн байгуулагч Н. Дашзэвэг нь БСШУС-ын яаманд 2019 оны 4 сарын 16-нд ирүүлсэн “Хүсэлт гаргах тухай” бичигт тус сургууль нь 2018 онд Улаанбаатар Эрдэм их сургуулийн харьяа сургууль болсон тухай дурдсан байгаа бөгөөд 2018-2019 оны хичээлийн жилд Монгол дээд сургууль нь бие даан үйл ажиллагаа явуулаагүй бөгөөд Улаанбаатар-Эрдэм их сургуулийн бүрэлдэхүүнд /харьяа/ нэгдэж, нэг хөтөлбөрөөр сургалт явуулж байгаа тул тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох талаар санал боловсруулан БСШУС-ын сайдад танилцуулсан.</li> </ol>	
--	--	--	--	--

			БСШУС-ын сайдын баталсан “Шинжээчийн хэсэг байгуулах тухай” А/593 тушаалаар баталсан ажлын хэсэгт орж Боловсролын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2 дахь хэсэг болон БСШУС-ын сайдын 2010 оны “Шаардлага, загвар батлах тухай” 353 дугаар тушаалын хэрэгжилтийг “Эмпати- Ертөнц” ХХК-аас ирүүлсэн хүсэлтийн дагуу Сүхбаатар дүүргийн 2 дугаар хороонд үйл ажиллагаа явуулдаг “Элит багачууд” цэцэрлэгт хяналт-шинжилгээ хийсэн.	
357.	1.5. Гэрээгээр хамтран ажиллаж, ажил гүйцэтгүүлж буй байдлыг дүгнэх	Судалгааг хийсэн.	Уг ажлын хүрээнд Боловсрол, соёл шинжлэх ухаан, спортын салбарын хөрөнгө оруулалтын ажлын явцын мэдээг сар бүр тогтмол гаргаж, гүйцэтгэгч байгууллагууд гэрээний үүргээ /гэрээний хугацаанд ажлаа гүйцэтгэж байгаа эсэх/ хэрхэн биелүүлж байгаа талаар мэдээлэл бэлтгэж ажилласан. Гэрээний үүргээ биелүүлээгүй “Хангайн хятруун” ХХК-д гэрээ цуцлах тухай албан тоот хүргүүлсэн.	100%
358.	1.6. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын үйл ажиллагаанд Засгийн газрын 89 дүгээр тогтоолын дагуу үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	2018 онд боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын нийт 22 байгууллагад хяналт-шинжилгээ хийсэн.	Тайлангийн хугацаанд төлөвлөгөөний дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээг 20 их дээд сургууль /Цахим дээд сургууль, Гүрэн дээд сургууль, Урлах эрдмийн дээд сургууль, Сутай дээд сургууль, Нийгэм сэтгэл судлалын дээд сургууль, Евро-Ази дээд сургууль, Улаанбаатар-Эрдэм их сургуулийн салбар Монгол дээд сургууль, Гэгээ коллеж, Кино урлагийн дээд сургууль, Хэл иргэншлийн дээд сургууль, Шинэ иргэншил дээд сургууль, Евро-Ази дээд сургууль, Улаанбаатар-Эрдэм судлал дээд сургууль, Эко-Ази дээд сургууль, Түшээ дээд сургууль, Утга зохиол нийгмийн ажилтны дээд сургууль, Жонон дээд сургууль, Техник технологийн дээд сургууль, Мандах дээд сургууль, Санхүү эдийн засгийн дээд сургуулиудад ажиллаж дээд боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаа, ангилалд тавигдах шаардлага, тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагын хэрэгжилттэй танилцан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ./, соёлын 3 байгууллага /Үндэсний урлагийн их театр, Занабазарын дүрслэх урлагийн музей, Соёл, урлаг дэмжих сан/, спортын 1 байгууллага /Биеийн тамир, спортын сан/-д хийсэн. БСШУС-ын сайдын 2019 оны 10 сарын 25-ны өдрийн А/686, А/731, А/797 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг МУБИС, БМДИ, Нийслэлийн 1 дүгээр сургууль, Багануур дүүргийн Боловсрол цогцолбор зэрэг байгууллагууд дээр ажиллаж байна.	100%

359.	1.7. Аймгуудын Боловсрол, соёл, урлагийн газруудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх /3-аас доошгүй аймаг/	2017, 2018 онд Сэлэнгэ, Дархан-Уул зэрэг аймгийн Боловсрол, соёл, урлагийн газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн.	УИХ-ын даргын ажлын хэсэгт орж, БСШУС-ын дэд сайд Г.Ганбаяраар ахлуулсан бүрэлдэхүүн Баянхонгор, Өвөрхангай аймагт 2019 оны 2 сарын 24-өөс 28-ны өдрүүдэд БСШУС-ын яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баярсайханаар ахлуулсан бүрэлдэхүүн Увс, Ховд, Завхан аймагт 2019 оны 5 сарын 9-өөс 14-ний өдрүүдэд тус тус ажилласан. Ажлын хэсэг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын бодлого шийдвэрийн хэрэгжилт, хөрөнгө оруулалтыг болон аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар, Биенийн тамир, спортын газрууд болон салбарын байгууллага болох сургууль, цэцэрлэг, дотуур байр, музей, театр, спорт хороо зэрэг орон нутгийн байгууллагуудын ажилтай газар дээр нь танилцах, салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнд үнэлгээ дүгнэлт өгч, холбогдох зөвлөмжүүдийг хүргүүлж ажилласан. Мөн аймгуудын БСУГ-ын тайланг татан авч нэгтгэх ажлыг хийсэн.	100%
360.	1.8. Салбарт хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн байдалд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт хийх	Салбарт хэрэгжиж буй гадаадын зээл, тусламжийн 1 төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд дотоод аудит хийсэн.	Нийслэлийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөлт, Хан-уул дүүрэг, Сонгино-хайрхан дүүрэгт хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний явцын байдалд хяналт шалгалт хийх “Ажлын хэсэг”-т орж ажилласан бөгөөд шалгалтын явцад илэрсэн зөрчлүүдэд Ажлын хэсэг газар дээр нь чиглүүлэх, зөвлөн туслах ажлыг хийж гүйцэтгэн дүнг дэд сайдад танилцуулсан. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газрын 2019 оны 5 сарын 29-ний өдрийн 01/245 тоот албан бичгийн дагуу “Монгол кино” ТӨҮГ-ын “Түүхийн хүрд” баримтат кино бүтээхтэй холбоотой гарсан төсөл, арга хэмжээний зарцуулалтанд хяналт шалгалт хийж дүгнэлт зөвлөмжийг слайдаар бэлтгэж газрын даргад танилцуулсан. БСШУС-ын сайдын 2019 оны А/538 тушаалаар Соёл, урлагийг дэмжих сангийн хөрөнгийг 2019 онд 2.0 тэрбум төгрөгөөр баталсан, Тус оны сонгон шалгаруулалтад 27.0 тэрбумын өртөг бүхий 215 төсөл ирснээс 63 төслийн 2.0 тэрбум төгрөгийн өртөг бүхий төсөлд санхүүгийн дэмжлэг үзүүлэн хяналт тавин ажиллаж байна. БСШУС-ын сайдын А/537 тоот тушаалаар “Соёл урлагийг дэмжих сан”-гийн 2019 оны төслийн үйл ажиллагаанд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт хийж зөвлөгөө өгч, зөвлөмж дүгнэлт гаргаж, гарсан зөрчилд албан шаардлага өгч ажиллалаа.	100%

361.	<p>1.9. Дотоод аудит хийсэн байгууллагуудад илэрсэн зөрчлийг арилгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, зөвлөмж, дүгнэлтийг байгууллага тус бүрээр гаргаж, дотоод аудитын хороо, сайдад танилцуулах.***</p>	<p>Дотоод аудитын үйл ажиллагаатай холбогдох тайлан мэдээг боловсруулан Сангийн яаманд хүргүүлж. Үндэсний Аудитын газар, Авлигатай тэмцэх газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт өгсөн.</p>	<p>1. БСШУС-ын сайдын баталсан 2019 оны 3 сарын 29-ний өдрийн ажлын хэсэг байгуулах тухай А/183 тоот тушаалын хавсралтаар батлагдсан удирдамжийн хүрээнд Үндэсний урлагийн их театрын 2017-2018 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт хийж зөвлөгөө өгч, зөвлөмж, дүгнэлтийг гаргаж, дотоод аудитын хорооны хурлаар хэлэлцүүлэн тогтоол гаргав.</p> <p>2. Үндэсний урлагийн их театрын 2017-2018 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт хийж төсвийг үндэслэлтэй төлөвлөж батлуулаагүй, анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг зохих журмын дагуу хөтөлдөггүй, бараа материалын зарцуулалтанд тавих хяналт хангалтгүй, гэрээгээр гүйцэтгэсэн ажлын хөлс гэж олгосон боловч гүйцэтгэлийн баримт хангалтгүй зэрэг 8 төрлийн 100551,1 мянган төгрөгийн зөрчил төлбөр илэрсэнд зөрчил дутагдлыг арилгуулах зөвлөмж өгсөн.</p> <p>3. БСШУС-ын сайдын баталсан 2019 оны 03 сарын 29-ний өдрийн “Ажлын хэсэг” байгуулах тухай А/182 тоот тушаалын хавсралтаар батлагдсан удирдамжийн дагуу “Дүрслэх урлагийн музей”-н 2017-2018 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт хийж 2018 оны төсвийг үндэслэлтэй төлөвлөж батлуулаагүй, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогыг ангилж бүртгээгүй, үндсэн орлогыг бүрдүүлдэг үзвэрийн билет, үнэт цаасны тооцоо болон шатах тослох материал, сэлбэг, бараа материал, томилолтын зарцуулалтын тооцоог сар бүр бодож үлдэгдлийг баталгаажуулалтгүй шууд зардалд бичиж, үлдэгдлийн журналаар тайлагнаж байсан, анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг зохих журмын дагуу хөтөлдөггүй, бараа материалын зарцуулалтад бүртгэлээр тавих хяналт сул зэрэг нийт 10 зөрчилтэй холбоотой 102774,2 мянган төгрөгийн зөрчил, мөн шалгалтын хугацаанд 146995,3 мянган төгрөгийн бараа материалын нярвын тайланг нөхөн гаргуулж, тооцоог бодох,үлдэгдлийг баталгаажуулах, анхан шатны тайланг залруулах ажлыг хийж гүйцэтгэн илэрсэн зөрчлийг арилгах зөвлөмж өгч,дотоод аудитын хороо, сайдад танилцуулав.</p> <p>4. БСШУС-ын сайдын 2019 оны 10 сарын 28-ны өдрийн баталсан удирдамжийн дагуу Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг БТСГ-тай гэрээ байгуулсан Үндэсний шигшээ багийн спортын 17 төрлүүдийн 2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд хэсэгчилсэн дотоод аудитыг хийж</p>	100%
------	---	--	---	------



			анхан шатны баримтын иж бүрдэл, хүчин төгөлдөр бус баримтаар ажил гүйлгээ хийсэн, бэлэн мөнгөний тайлан хийгдээгүй зэрэг 354455,6 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч, дэд сайдад урьдчилсан байдлаар танилцуулга хийгдсэн бөгөөд нэгдсэн тайланг Ажлын хэсгийн нарийн бичиг О.Гэрэлд хүргүүлээд байна.	
362.	1.10. Салбарын байгууллагуудын шилэн дансанд байршуулсан мэдээллийг үнэн зөв эсэхэд хяналт тавина.	Салбарын байгууллагуудын шилэн дансанд байршуулсан мэдээллийг үнэн зөв эсэхэд хяналт тавьж тайланг Үндэсний Аудитын газарт хүргүүлсэн.	Салбарын байгууллагуудын шилэн дансанд мэдээллийг бүрэн байршуулж хэвшсэн байна.	70%
363.	1.11. Дотоод аудитын үйл ажиллагаатай холбогдох тайлан мэдээг боловсруулан холбогдох байгууллагад хүргүүлэх.	Дотоод аудитын үйл ажиллагаатай холбогдох тайлан мэдээг боловсруулан Сангийн яаманд хүргүүлж. Үндэсний Аудитын газар, Авлигатай тэмцэх газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт өгсөн.	1. Дотоод аудитын дүрмийн дагуу Сангийн яамны Санхүүгийн хяналт эрсдэлийн удирдлагын газарт 2019 оны эхний хагас жилд дотоод аудит болон санхүүгийн хяналт шалгалтаар хийсэн ажлын тайлан, тоон мэдээг хүргүүлсэн, одоо 2019 онд хийсэн ажлын тайлан болон тоон мэдээг хүргүүлэхээр бэлтгэж байна. Мөн дотоод аудит болон санхүүгийн хяналт шалгалтаар 2018 онд хийсэн ажлын тайланг Үндэсний Аудитын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт өгсөн. Авлигатай тэмцэх газарт Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн зарим үйл ажиллагаанд БСШУС-ын сайдын баталсан 2018 оны 10 сарын 17 өдрийн ажлын хэсэг байгуулах тухай А/655 тоот тушаалын хавсралтаар батлагдсан удирдамжийн дагуу санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн аудитын тайланг хүргүүлж гэрчийн мэдүүлэг, тайлбар тодорхойлолт гаргаж өгсөн. Мөн уг шалгалтын дүнтэй холбогдуулан Сангийн яаманд гомдол гарсан тайлбар өгч шалгуулсан. Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтаар улсын ахлах байцаагчийн 08-02/13-08-02/21 тоот 9 акт тогтоосныг актыг хүчингүй болгуулахаар өргөдөл гаргасныг Сангийн яаманд хянуулж 2 актыг хүчингүй болгосон. Сангийн яам хянаад хүчинтэй хэвээр үлдсэн 3 актыг Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхэд гомдол гаргасанд тайлбар гарган шүүх хуралд оролцож байна.	100%

			<p>2. Нийслэлийн ерөнхий боловсролын лаборатори 28 дугаар сургуулийн захирал Ц.Манахүүгийн нэхэмжлэлтэй холбоотой асуудлаар Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдон тайлбар гарган өгч оролцож байна.</p> <p>3. Завхан аймгийн Улиастай сумын Чандмань-Эрдэнэ лаборатори нэг дүгээр сургуулийн 2013-2017 он, 2018 оны эхний 8-н сарын санхүүгийн үйл ажиллагааны баримтад АТГ-ын хүсэлтээр Сангийн яамнаас ирсэн хуулга, санхүүгийн нэмэлт материалыг дахин шалгаж тайланг өгсөн. Тус сургуулийн захирлаар ажиллаж байсан Д.Баянмөнхөд холбогдох эрүүгийн хэргийн хохирогч, иргэний нэхэмжлэгчээр Төсвийн тухай хуулийн 4.1.49 дэх заалтыг үндэслэн томилогдон ажиллаж байна.</p>	
364.	1.12. Төсвийн ерөнхийлөн захирагчийн захиалгаар болон өргөдөл гомдол, холбогдох байгууллагын хүсэлтээр төлөвлөгөөт бус дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт хийх.	Дотоод аудитын нэгжийн чиг үүрэгт хамаарах асуудлаар 2016, 2017 оны санхүүгийн баримтын шалгалт, дотоод аудит хийсэн.	<p>1. Нийслэлийн ерөнхий боловсролын лаборатори 28 дугаар сургуулийн 2017-2018 он, 2019 оны эхний 5 сарын санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд БСШУС-ын сайдын баталсан 2019 оны 05 сарын 24-ний өдрийн ажлын хэсэг байгуулах тухай А/330 тоот тушаалын хавсралтаар батлагдсан удирдамжийн дагуу дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт хийж зөвлөгөө өгч, зөвлөмж, дүгнэлтийг байгууллага тус бүрээр гаргаж, сайдад танилцуулан дотоод аудитын хорооны хурлаар хэлэлцүүлсэн. Тус сургуульд хийсэн дотоод аудит санхүүгийн хяналт шалгалтаар биеийн тамирын заалны орлого, тус сургуулийн төгсөх ангийн сурагчдаас сургуульд үлээх “Үлдээмжийн мөнгө”- г төрийн сангийн дансанд тушааж данс бүртгэлд тусгаагүй, анхан шатны зарим баримтын бүрдэл дутуу, худалдан авалт хийхдээ үнийн судалгаа хийгээгүй, гэрээгээр гүйцэтгүүлсэн ажилд тавих хяналтыг сулруулсан зэрэг 5 төрлийн зөрчилд 153524,6 мянган төгрөгийн зөрчил дутагдал илэрсэнд зөвлөж өгсөн.</p> <p>2. Төрийн өмчийн их, дээд сургуулиудын тогтмол зардлын өр төлбөрийн талаар мэдээлэл бэлтгэж аудитын хорооны хуралд хэлэлцүүлэн тогтоол гаргаж хүргүүлсэн.</p> <p>3. Завхан аймгийн Сантмаргаз сумын иргэн Д.Дунгармаагаас тус сумын сургуулийн багшийн ёс зүйгүй үйлдлийн талаар гаргасан гомдлыг барагдуулсан.</p>	100%

			<p>4. Нийслэлийн ерөнхий боловсролын лаборатори 14 дугаар сургуулийн 5 дугаар ангийн сурагчдын эцэг эхчүүдээс ирүүлсэн гомдлын дагуу тус сургуулийн төгсөх ангийн сурагчдаас бэлэн мөнгө их хэмжээгээр хураан авсан талаар хяналт шалгалт хийж зөвлөгөө өгч, зөвлөмж, дүгнэлтийг гаргаж, дотоод аудитын хорооны хурлаар хэлэлцүүлэхээр бэлтгэн сайдад танилцуулсан.</p> <p>5. Монгол улсын Засгийн газрын 2019 оны 07 сарын 03-ны өдрийн 281 дүгээр тогтоолоор Үлэг гүрвэлийн төв музейг 2018 оны 8 сарын 1 өдрөөс татан буулгаж Байгалийн түүхийн музейтэй нэгтгэн зохион байгуулах шийдвэр гарсантай холбоотой 2 музейн үйл ажиллагааг хэвийн явуулахын тулд музейн бүртгэл мэдээлэл, сан хөмрөг, эд хөрөнгө, санхүү аж ахуй, хүний нөөцийн асуудал хариуцсан ажилтан, албан тушаалтнуудын ажлыг албан ёсоор хүлээлцүүлэх, хоёр талаас сан хөмрөгийн эд хөрөнгө, үзмэр үзүүлэгийн бүрэн бүтэн байдал, хадгалалт хамгаалалтын стандарт зөрчигдөж байгаа байдал, орон тоо бүтэц ,цалин нийгмийн даатгал, музейн сан хөмрөгийг хууль эрх зүйн хүрээнд баяжуулсан эсэх, хамаарал бүхий хүмүүсийг ажиллуулж байгаа, музейн стандарт барихгүй байгаа,шүүхийн шийдвэр бүхий цалин НДШ-ийг шийдвэрлэхгүй байгаа зэрэг 14 асуудал бүхий мэдээллийг шалган, судалж байх хугацаанд 4 хүний гомдолтой холбоотой 30,0 сая төгрөгийг барагдуулах арга хэмжээг авлаа. Мэдээллийн үнэн бодит байдлыг тогтоох зорилгоор нотлох баримтыг цуглуулах, тайлбар авах, шаардлагатай тохиолдолд тэмдэглэл хөтлөн нэгдсэн танилцуулгыг асуудал нэг бүрээр бичиж, дүгнэн дэд сайдад хүргүүлж ажиллав.</p> <p>6. Авлигатай тэмцэх газрын 2019 оны 03 сарын 11-ний өдрийн 05/2065 тоот албан бичгийн дагуу Биеийн тамир спортын газрын даргын 2017 оны 11 сарын 30-ны өдрийн А/340 тоот тушаалын хүрээнд Монгол улсын сагсан бөмбөгийн шигшээ багийн тамирчдын БНХАУ-ын Фужиан хотод Хамтарсан бэлтгэлд төсвөөс хэдэн төгрөг зарцуулсан болохыг тогтоох зорилгоор хяналт шалгалтыг хийж дүнг газрын даргад танилцуулан АТГ-т хариуг албан бичгээр хүргүүлэв.</p> <p>7. Харааны бэрхшээлтэй хүүхдийн 116 дугаар тусгай сургуулийн нягтлан бодогчтой холбоотой гомдол мэдээллийн дагуу газар дээр нь очиж санхүүгийн анхан шатны бүртгэл хөтлөлт, баримт бүрдүүлэлтэд хэсэгчилсэн хяналт шалгалтыг хийж, зөвлөмжийг өгч ажилласан.</p>	
--	--	--	--	--

			8. ЦЕГ эрүүгийн цагдаагийн албаны Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх газрын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэст шалгагдаж байгаа Зээлийн боловсролын сантай холбоотой хэрэг бүртгэлтийн 194100007 дугаартай хэрэгт “Шинжээч томилж, шинжилгээ хийлгэх” мөрдөгчийн тогтоолын дагуу шинжээчээр томилогдон дүгнэлтийг 12 сарын 25-ны дотор хүргүүлэхээр ажиллаж байна.	
365.	1.13. Яам болон харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд Үндэсний аудитын газраас өгсөн зөвлөмжийн биелэлтэд хяналт тавьж, дүгнэлт гаргах	Үндэсний аудитын газраас өгсөн зөвлөмжийн биелэлтэнд тавьж, дүгнэлт гаргасан.	<p>Үндэсний аудитын газраас хийсэн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтэнд хяналт тавьж, дүгнэлт гаргах ажлын хүрээнд: А.</p> <p>1.Төрийн өмчид их дээд сургуулиудад хуульд заасны дагуу улсын төсвөөс олгох санхүүжилтийн төлөвлөлт, гүйцэтгэл, эдийн засгийн хөшүүргийн агуулга, ач холбогдолд тусгайлан үнэлгээ, дүгнэлт өгч, дээд боловсролыг санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгох санал боловсруулж, зохих журмын дагуу шийдвэрлэх,</p> <p>2.Хуульд заасан шаардлага, агуулга, зориулалтад нийцсэн харьцангуй тогтвортой байх зарчмыг баримтлан сургалтын төлбөрийг тооцох, өөрчлөх стандарт, журам, аргачлал, арга зүйг бий болгож мөрдүүлэх,</p> <p>3.Төрийн өмчит их дээд сургуулиудыг Нягтлан бодох бүртгэлийн нэгдсэн бодлогоор хангах санхүү, хөрөнгийн нөөцийг ил тод, үр нөлөөтэй зарцуулах, түүнд тохирсон хяналт-шинжилгээ, үнэлгээний болон дотоод хяналтын үр нөлөөтэй тогтолцоог нэвтрүүлэх,</p> <p>4.ТӨИДС-иудын хамтын болон гүйцэтгэх удирдлагад тавигдах шаардлага /стандарт/, сонгон шалгаруулах, томилох журмыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх,</p> <p>5.ТӨИДС-иудын эзэмшил газрын ашиглалтад шалгалт хийж, зөрчил түүнээс гарсан үр дагаврыг арилгах арга хэмжээг хууль журмын дагуу авч хэрэгжүүлэх,</p> <p>6.Хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн санхүүжилтийн тооцоо нийлэх /21.1 сая.төг/,</p> <p>7.Төсөл арга хэмжээний санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан /1,073.5 сая.төг/,</p> <p>8.Төсөл арга хэмжээний санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан /2,937.5 сая.төг/,</p> <p>9.Үндэсний аудитын газраас ажиллуулсан шинжээчийн дүгнэлтээр барилгын гүйцэтгэлд хийгдээгүй ажилд гүйцэтгэл бичсэн нь илэрсэн байна /245.8 сая.төг/,</p>	100%

			<p>10.УАГ-аас ажиллуулсан шинжээчийн дүгнэлтээр барилгын гүйцэтгэлд хийгдээгүй ажилд гүйцэтгэл бичсэн нь илэрсэн байна /908.0 сая.төг/,          11.УАГ-аас ажиллуулсан шинжээчийн дүгнэлтээр барилгын өртгийг давхардуулж гүйцэтгэл бичсэн нь илэрсэн байна /890,3 сая төг/,          12.УАГ-аас ажиллуулсан шинжээчийн дүгнэлтээр барилгын өртгийг давхардуулж гүйцэтгэл бичсэн нь илэрсэн байна /402.3 сая төг/,          13.УАГ-аас ажиллуулсан шинжээчийн дүгнэлтээр барилгын төсөвт НӨАТ, нормчлолын сан, захиалагчийн хяналт, магадлашгүй ажлын зардлыг илүү төсөвлөсөн нь тогтоогдсон байна /8.7 сая.төг/,          14.Улсын төсвийн барьцаа хөрөнгийн дансанд төсөл, арга хэмжээний барьцаа хөрөнгийг холбогдох хууль, журмын дагуу байршуулаагүй /973.9 сая.төг/,          15.Сургалтын төрийн сангаас шалгуур хангаагүй иргэд болон гадаадын их дээд сургуульд суралцагчид сургалтын зардал олгосон, зарим суралцагч сургалтын зардлыг давхардуулан авсан, сонгон шалгаруулалтад оролцсон иргэдийн бичиг баримт алга болсон тул журамд нийцүүлэн сонгон шалгаруулалт явуулаагүй албан тушаалтанд хариуцлага тооцох, сургалтын зардал санхүүжилтийн талаар мэдээллийн нэгдсэн сан бий болгох /нийт 477.7 мянган ам.доллар буюу 927.1 сая төгрөг/,нийт-1 тэрбум 39 сая төгрөгийн зөрчлийг арилгасан эсэхэд хяналт хийж, биелэлт нэг бүрээр гарган зөвлөмжийн хэрэгжилтийг албан бичгээр Үндэсний аудитын газарт хүргүүлсэн, Б.Үндэсний аудитын газраас өгсөн зөвлөмжийн биелэлтэнд хяналт тавьж, дүгнэлт гаргасан.Үүнд:          БСШУС-ын сайдын 2018 эрхлэх асуудлын хүрээнд хийсэн аудитаар 88 байгууллагад “Зөрчилгүй” санал дүгнэлт,14 байгууллагад “Хязгаарлалттай” санал дүгнэлт 1 байгууллагад “Сөрөг” санал дүгнэлт өгсөн байна. Тус оны санхүүгийн тайлан,төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар</p> <ul style="list-style-type: none"> <li>✓ 125.2 ая төгрөгийн 3 зөрчлийг хуулийн байгууллагад шилжүүлж,</li> <li>✓ 299.4 сая төгрөгийн 29 зөрчилд төлбөрийн акт тогтоож,</li> <li>✓ 192.9 сая төгрөгийн 60 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж 180.6 сая төгрөгийн 251 зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмжийг өгөгдсөний дагуу зөвлөмжийн биелэлт, дүгнэлтийг 14 байгууллага тус бүрээр гаргаж дотоод аудитын хороо болон сайдад слайд бэлтгэн танилцуулсан бөгөөд</li> </ul>	
--	--	--	--	--

			хурлаас эдгээр байгууллагуудын ерөнхий нягтлан бодогчдод хариуцлага тооцож ажиллах дотоод аудитын хорооны тогтоол гарч тус байгууллагуудад хүргэгдсэн болно.	
366.	1.14. Төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын худалдан авах ажиллагааны 2018 оны гүйцэтгэл, үр дүн, 2019 оны явцад тайлангийн үр дүнд дотоод аудит хийх.	Төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын худалдан авах ажиллагааны 2018 оны гүйцэтгэлд салбарын хэмжээнд хяналт тавьж ажилласан.	БСШУС-ын дэд сайдын 2019 оны 05 сарын 06-ны өдрийн баталсан Монгол улсын 2018-2019 оны төсвийн хөрөнгө оруулалтаар нийслэлд хэрэгжиж буй барилга байгууламж, бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэхэд хяналт тавих удирдамжийн дагуу хөрөнгө оруулалтын явцын байдалд хяналт тавьж ажилласан. Удирдамжийн дагуу БЗД-ийн 14 дүгээр хороонд цэцэрлэг худалдан авах талаар судалж танилцуулсан.	70%
367.	1.15. Төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын худалдан авах ажиллагааны 2018-2019 оны төлөвлөлт ба гүйцэтгэлд салбарын хэмжээнд хяналт тавих, салбарын хөрөнгө оруулалтын давхардал, хийдлээс урьдчилан сэргийлж, төлөвлөлтийн зохистой арга хэлбэрийг нэмэгдүүлэх, гүйцэтгэлийн явцад газар дээр нь ажиллаж удаашралтай дахин хөрөнгө шаардлагатай объектын судалгаа гаргах. /Хөрөнгө оруулалтын мэдээллийн сан	Төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын худалдан авах ажиллагааны 2018 оны гүйцэтгэлд салбарын хэмжээнд хяналт тавьж ажилласан.	БСШУС-ын дэд сайдын 2019 оны 05 сарын 06-ны өдрийн баталсан Монгол Улсын 2018-2019 оны төсвийн хөрөнгө оруулалтаар нийслэлд хэрэгжиж буй барилга байгууламж, бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэхэд хяналт тавих удирдамжийн дагуу СХД-ийн 16-р хороо 1, 113 дугаар цэцэрлэгийн өргөтгөл 200 ортой, СХД-ийн 16-р хороо 119 дүгээр цэцэрлэгийн өргөтгөл 200 ортой, СХД-ийн 12 дугаар хороо Ирээдүй цогцолборын 480 хүүхдийн хүчин чадалтай, 3 давхрын өргөтгөлийн хөрөнгө оруулалтын явцын байдалд хяналт тавьж ажилласан.	100%

	бүрдүүлэх, хяналт тавих./			
368.	1.16. Салбарын хэмжээнд эрх шилжүүлсэн хөрөнгө оруулалтын үр ашгийг тооцож, хууль тогтоомжийн хэрэгжилт хэрхэн хангасан байдалд газар дээр нь ажиллаж хяналт тавьж, холбогдох зөрчил дутагдлыг төсвийн ерөнхийлөн захирагчид танилцуулах.***	Салбарын хэмжээнд эрх шилжүүлсэн хөрөнгө оруулалтын үр ашгийг тооцож, хууль тогтоомжийн хэрэгжилт хэрхэн хангасан байдалд хяналт тавьж дүнг төсвийн ерөнхийлөн захирагчид танилцуулсан.	Төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын худалдан авах ажиллагааны 2019 оны төлөвлөлт ба гүйцэтгэлд салбарын хэмжээнд хяналт тавих, салбарын хөрөнгө оруулалтын давхардал, хийдлээс урьдчилан сэргийлж, төлөвлөлтийн зохистой арга хэлбэрийг нэмэгдүүлэх, гүйцэтгэлийн явцад газар дээр нь ажиллаж удаашралтай дахин хөрөнгө шаардлагатай объектын судалгаа гаргаж, холбогдох мэдээллийг дэд сайдад танилцуулсан.	100%
369.	1.17. Салбарын хөрөнгө оруулалтын хяналтыг онлайн болгох	-	Салбарын хөрөнгө оруулалтын мэдээллийг авдаг нэгдсэн сүлжээтэй болсон.	70%
370.	1.18. Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх.***	-	БСШУС-ын сайдын баталсан А/371 тоот тушаалаар болон тушаалын хавсралтаар баталсан удирдамжийн дагуу Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг нэгтгэж байна.	100%
Хоёр. Монгол Улсын Их Хурлын 2015 оны 12 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого”-ын 3.18 /Бүх шатны боловсролын байгууллагын үйл ажиллагаанд өөрийн үнэлгээ, дотоод мониторингийн тогтолцоог хөгжүүлнэ./-ын хүрээнд:				
371.	2.1. Лаборатори сургуулиудад эрсдэлийн үнэлгээ хийх.***	Лаборатори сургуулиудад эрсдэлийн үнэлгээ хийх асуумж боловсруулсан.	Кембриджийн олон улсын хөтөлбөрийн сургалттай төрийн өмчийн ерөнхий боловсролын “Шинэ эрин” сургуулийн олон улсын хөтөлбөрт эрсдэлийн үнэлгээ хийдэг арга зүйд хяналт-шинжилгээ хийж, бусад лаборатори сургуульд хийх талаар зөвлөмж гаргах ажлыг хийж байна.	70%

372.	2.2. Дээд боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаа болон оюутан элсүүлэх үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх. /Их дээд сургууль 8-аас доошгүй хамруулах/	Хяналт-шинжилгээ, судалгааны асуумж боловсруулагдсан.	Тайлангийн хугацаанд төлөвлөгөөний дагуу Цахим дээд сургууль, Гүрэн дээд сургууль, Урлах эрдмийн дээд сургууль, Сутай дээд сургууль, Нийгэм сэтгэл судлалын дээд сургууль, Евро-Ази дээд сургууль, Улаанбаатар-Эрдэм их сургуулийн салбар Монгол дээд сургууль, Гэгээ коллеж, Кино урлагийн дээд сургууль, Хэл иргэншлийн дээд сургууль, Шинэ иргэншил дээд сургууль, Евро-Ази дээд сургууль, Улаанбаатар-Эрдэм судлал дээд сургууль, Эко-Ази дээд сургууль, Түшээ дээд сургууль, Утга зохиол нийгмийн ажилтны дээд сургууль, Жонон дээд сургууль, Техник технологийн дээд сургууль, Мандах дээд сургууль, Санхүү эдийн засгийн дээд сургуулиудын оюутан элсүүлэх үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, тайланг нэгтгэсэн.	100%
373.	2.3. Сургуулийн өмнөх боловсролын хувилбарт болон үндсэн сургалтын өнөөгийн нөхцөл байдлын судалгаа хийж, дүгнэлт гаргах.***	Судалгааны хүснэгт боловсруулж байна.	Засгийн газрын 2019 оны 37 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”, БСШУС-ын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын 2019 оны төлөвлөгөөний дагуу Сургуулийн өмнөх боловсролын хувилбарт сургалтын өнөөгийн нөхцөл байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийлээ. Үнэлгээ хийхдээ Засгийн газрын 89 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Бодлогын хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын зургадугаар зүйлд заасан хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүйг баримталсан. 2019-2020 оны хичээлийн жилд 20710 хүүхэд хувилбарт сургалтад хамрагдаж байгаа үзүүлэлт нь өмнөх хичээлийн жилээс 880 хүүхдээр буурсан үзүүлэлттэй байна.	100%
374.	2.4. Дүйцсэн хөтөлбөрөөр суралцаж буй суралцагчдын боловсролын баримт бичиг олголтод хяналт хийх.***		Засгийн газрын 2019 оны 37 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”, БСШУС-ын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын 2019 оны төлөвлөгөөний дагуу Дүйцсэн хөтөлбөрөөр суралцаж буй суралцагчид болон насан туршийн боловсролын багш нарын судалгаанд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийлээ. Үнэлгээ хийхдээ Засгийн газрын 89 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Бодлогын хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын зургадугаар зүйлд заасан хяналт-шинжилгээ, үнэлгээний арга	100%



			зүйг баримталсан. Дүйцсэн хөтөлбөрөөр суралцаж буй суралцагчид болон насан туршийн боловсролын багш нарын судалгааг аймаг, нийслэлээс ирүүлсэн байдлаар нэгтгэж 2019-2020 оны хичээлийн жилийн статистик дүн мэдээтэй харьцуулан гаргалаа.	
Гурав. Засгийн газрын 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын хүрээнд:				
375.	3.1. Хууль, УИХ-ын шийдвэр, Ерөнхийлөгчийн зарлиг, ҮАБЗ-ийн зөвлөмж, тэмдэглэл болон Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийг тухай бүр хяналтад авах, хэрэгжилтэд хяналт тавих ажил, үйлчилгээ. Тоо хэмжээ: Тухай бүр Хугацаа- 1-12 дугаар сар	2018 оны эхний хагас жилийн байдлаар 74,2 хувьтай үнэлэгдсэн.	УИХ-ын тогтоол, Засгийн газрын шийдвэрийн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарт хэрэгжүүлэхээр заасан хяналтад авсан зүйл, заалтуудын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Монгол Улсын Засгийн газрын 2017 оны “Журам шинэчлэн батлах тухай” 89 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгож ажиллалаа. Хяналт-шинжилгээ, үнэлгээг 2018 оны жилийн эцсийн байдлаар нэгтгэсэн “Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарт хэрэгжүүлэхээр хяналтад авсан заалтуудын хэрэгжилтийн явцын тайлан” бусад холбогдох мэдээ, мэдээллийг үндэслэн хийсэн болно. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарт хэрэгжүүлэхээр гаргасан УИХ-ын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, тэмдэглэл зэрэг нийт 227 шийдвэрээс 226 заалтыг хяналтад авч ажилласан. 2018 оны жилийн эцсийн байдлаар хэрэгжилтийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд нийт 95,62 хувийн хэрэгжилттэйгээр үнэлэгдэж, цаашид хугацаа болоогүй болон 30, 70 хувийн биелэлттэй байгаа ажил үйлчилгээг бүрэн хэрэгжүүлж, тодорхой үр дүнд хүргэхээр төлөвлөн ажиллаж байна. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн 2018 оны тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үйл ажиллагааны гүйцэтгэлийг Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн сан / <a href="http://unelgee.gov.mn/">unelgee.gov.mn/</a> -д байршуулан хугацаанд нь тайлагнасан.	100%
376.	3.2. Засгийн газрын 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл	2017, 2018 оны жилийн эцсийн үнэлгээтэй харьцуулах.	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 8.4-т заасныг үндэслэн ЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор ЗГ-ын 2018 оны 42 дугаар тогтоолоор “Гурван тулгуурт хөгжлийн бодлого”-ыг баталсан бөгөөд уг бодлогын баримт бичгийн 2018 оны хэрэгжилтийн тайланг БСШУС-ын яамнаас хариуцан хэрэгжүүлэхээр заасан, сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах	100%

	ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу тайлан болон үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайлагнах		төсөл, арга хэмжээний зорилтын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ ингэхдээ ЗГ-ын 2017 оны "Журам шинэчлэн батлах тухай" 89 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ыг удирдлага болгож ажиллалаа. Хяналт-шинжилгээг журмын 7 дугаар бүлгийн 7.1, 7.5.5 дахь заалтуудыг баримтлан үнэлгээ хийж ҮХГ-т хүргүүллээ. "Гурван тулгуурт хөгжлийн бодлого"-д тусгагдсан БСШУС-ын сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах нийт 31 зорилт, арга хэмжээний биелэлтийг 2018 оны жилийн эцсийн байдлаар гаргаж ирүүлсэн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 100 хувийн биелэлттэй 20 зорилт, арга хэмжээ, 70 хувийн биелэлттэй 6 зорилт, арга хэмжээ, 40 хувийн биелэлттэй 3 зорилт, арга хэмжээ, Үнэлэх боломжгүй 2 арга хэмжээ байна.	
377.	3.3.Гадаадын зээл тусламжаар хэрэгжиж байгаа хэрэгжилт, хөтөлбөрийн хэрэгжилт.***	2017 оны хэрэгжилтийн тайланд аудит хийгдсэн.	Гадаадын зээл тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг 2018 оны жилийн эцсээр хийж, Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад Засгийн газрын 89 дүгээр тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-д заасан хугацаанд хүргүүлсэн.	100%
Дөрөв. Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолын хавсралт "Дотоод аудитын дүрэм"-ийн 5.1. /Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт/-ын чиглэлээр:				
378.	4.1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн баталсан төлөвлөгөөний дагуу 15-аас доошгүй байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт хийх	Дотоод аудитын нэгжийн чиг үүрэгт хамаарах асуудлаар 2016, 2017 оны санхүүгийн баримтын шалгалт, дотоод аудит хийсэн.	БСШУС-ын сайдын баталсан удирдамжийн дагуу лаборатори 28 дугаар сургууль, Үндэсний урлагийн их театр, Занабазарын дүрслэх урлагийн музей, Соёл, урлаг дэмжих сан, Биеийн тамир спортыг дэмжих сан, БНД-ийн Боловсрол цогцолбор сургууль гэсэн 5 харьяа байгууллагад дотоод аудит, ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг БТСГ-тай гэрээ байгуулсан Үндэсний шигшээ багийн спортын 17 төрлүүдийн 2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд хэсэгчилсэн дотоод аудитыг хийсэн. /Нийт 22 байгууллага хамрагдсан./	70%
<b>ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУВЬ</b>				<b>95.2%</b>

Товчилсон үгийн жагсаалт

АШУУИС – Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль  
АНУ – Америкийн нэгдсэн улс  
АХБ – Азийн хөгжлийн банк  
БГД – Баянгол дүүрэг  
БЗД – Баянзүрх дүүрэг  
БМДИ – Багшийн мэргэжил дээшлүүлэх институт  
БМИҮЗ – Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл  
БНАСАУ – Бүгд найрамдах ардчилсан солонгос ард улс  
БНСУ – Бүгд найрамдах солонгос улс  
БНД – Багануур дүүрэг  
БСМТ – Боловсролын салбарын мастер төлөвлөгөө  
БСШУС – Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спорт  
БСУГ – Боловсрол, соёл урлагийн газар  
БТСГ – Биеийн тамир, спортын газар  
БҮТ – Боловсролын үнэлгээний төв  
БХД – Багахангай дүүрэг  
БХИС – Батлан хамгаалахын их сургууль  
ГЕГ – Гаалийн ерөнхий газар  
ЕБС – Ерөнхий боловсролын сургууль  
ЗГ – Засгийн газар  
ИДС – Их дээд сургууль  
МУБИС – Монгол улсын боловсролын их сургууль  
МУИС – Монгол улсын их сургууль  
МҮХАҮТ – Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим  
НД – Налайх дүүрэг  
НДШ – Нийгмийн даатгалын шимтгэл  
НҮБ – Нэгдсэн үндэсний байгууллага  
СБД – Сүхбаатар дүүрэг  
СУИС – Соёл урлагийн их сургууль  
СХД – Сонгинохайрхан дүүрэг  
СӨБ – Сургуулийн өмнөх боловсрол  
СӨББ – Сургуулийн өмнөх боловсролын байгууллага

СӨБС – Сургуулийн өмнөх боловсролын сургууль  
ТББ – Төрийн бус байгууллага  
ТӨИДС – Төрийн өмийн их дээд сургууль  
УБИС – Улаанбаатарын их сургууль  
УИХ – Улсын их хурал  
ҮАГ – Үндэсний аудитын газар  
ХААИС – Хөдөө аж ахуйн их сургууль  
ХБНГУ – Холбооны бүгд найрамдах герман улс  
ХБХ – Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд  
ХЗДХ – Хууль зүй, дотоод хэрэг  
ХНХ – Хөдөлмөр нийгмийн хамгаалал  
ХУД – Хан уул дүүрэг  
ХҮИС – Худалдаа үйлдвэрлэлийн их сургууль  
ХШҮ – Хяналт шинжилгээ, үнэлгээ  
ЧД – Чингэлтэй дүүрэг  
ШУА – Шинжлэх ухааны академи  
ШУТИС – Шинжлэх ухаан, технологийн их сургууль  
ШУТС – Шинжлэх ухаан технологийн сан  
ЭЕШ – Элсэлтийн ерөнхий шалгалт